

Монгол ноолуурын өртгийн сүлжээнд хийсэн шинжилгээ

Жон Мортон
Павел Котиза
Мэтью Вихн
Дашбалын Бурмаа

2024 оны 4 сар



Өртгийн сүлжээнд анализ хийх аргачлалыг Европын Комиссоос боловсруулсан нэгдсэн стандарт бөгөөд Агринатура (Agrinatura) байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг. Агринатура (Agrinatura) (<http://agrinatura-eu.eu>) нь Европын их, дээд сургуулиудын нэгдсэн, хөдөө аж ахуйн салбарын хөгжил, чадавх бэхжүүлэх чиглэлээр ажилладаг мэргэшсэн судалгааны төв.

Өртгийн сүлжээний судалгааны хүрээнд бий болсон мэдлэг, мэдээлэл нь Европын холбооны төлөөлөгч байгууллагууд тэдгээрийн түншлэгч талуудад бодлогын чиг баримжааг тодорхойлох, яриа хэлэлцээр хийх, нэмүү өртгийн сүлжээнд хөрөнгө оруулах, тэдний үйл ажиллагаатай холбоотой өөрчлөлтийн талаар илүү сайн ойлголт өгөхөд зориулагдана.

VCA4D нь хөдөө аж ахуй, мал аж ахуй, загас агнуур, усны амьтны үржүүлэг, ой үржүүлгийн аж ахуй дахь нэмүү өртгийн сүлжээг шинжлэхэд чиглэсэн системчилсэн олон улсын аргачлал юм. Судалгааны тайлан болон олон нийтэд зориулсан бусад дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор авах боломжтой: <https://europa.eu/capacity4dev/value-cGain-analysis-for-development-vca4d->

Энэхүү VCA4D судалгаанд зориулж COLEAD (<https://www.colead.link/>) нь үндэсний, бүс нутгийн болон олон улсын зах зээл дээрх зах зээлийн чиг хандлага болон шаардлагатай нэмэлт материал эх сурвалжийг дурдан ашиглалаа.

Судалгааны багийн бүрэлдэхүүн

Багийн ахлагч:

Жон Мортон (NRI Англи улсын Грийнийчийн их сургуулийн үндэсний судалгааны хүрээлэн) Нийгэм судлаач

Бусад судлаачид (нэрийн эхний үсгийн дарааллаар):

Павел Котиза (Прага хотын Чехийн ХААИС) – эдийн засагч

Мэтью Вихн (CIRAD-Франц улсын ХАА-н судалгаа, хамтын ажиллагааны байгууллага) – Байгаль орчны зөвлөх

Дашбалын Бурмаа (Үндэсний зөвлөх)

Тус тайланг Европын холбооны санхүүжилтээр боловсруулав. Зохиогчид зөвхөн тайлангийн эх хувьд хариуцлага хүлээх бөгөөд Европын холбооны үзэл бодлыг тусгаагүй болно.

Энэхүү тайланг Европын холбооноос (VCA4D CTR 2017/392-416) төслийн хүрээнд санхүүжүүлсэн.

Тайлангаас эш татах: Мортон, Ж., Котиза, П., Вихн, М., Дашбал, Б. 2024. Монгол улсын ноолуурын өртгийн сүлжээний шинжилгээний Европын Холбоонд (DG INTPA буюу Олон Улсын түншлэлийн газар) хүргэх тайлан, Өртгийн сүлжээг хөгжүүлэх шинжилгээ (VCA4D CTR 2017/392-416), 122х + хавсралтууд.

VCA4D Төслийн багийн дэмжлэг, туслалцаа

Фридрих Ланкон, Хэвал Юлдириим | Арга зүй, эдийн засгийн дүн шинжилгээний программ хангамж (AFA) Жоржий Мэй, Олимпиа Орландони, Сара Баумгарт | Төслийн менежмент болон График Дизайн

АГУУЛГА

АГУУЛГА.....	3
ТАЛАРХАЛ	7
ТОВЧИЛСОН ҮГС БОЛОН МОНГОЛ НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР (ҮСГИЙН ДАРААЛЛААР)	8
ЭДИЙ ЗАСГИЙН НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР	9
ХУРААНГУЙ	10
1. ТАНИЛЦУУЛГА	14
2. ФУНКЦИОНАЛ ДҮН ШИНЖИЛГЭЭ	17
2.1 ДЭЛХИЙН ТҮҮХИЙ НООЛУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ.....	17
2.1.1 Хятад улсын ноолуурын үйлдвэрлэл	17
2.1.2 Монгол улсын ноолуурын үйлдвэрлэл	18
2.2 НООЛУУРЫН ЧИГЛЭЛИЙН ЯМАА.....	21
2.2.1 Монгол улсын нийт мал болон ямааны тоо, толгой.....	23
2.3 МОНГОЛ УЛС ДАХЬ НООЛУУР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ.....	26
2.3.1 Монгол малчид.....	26
2.3.2 Дундын зуучлал.....	32
2.3.3 Угаах, боловсруулах үе шат.....	34
2.3.4 Будах, ээрэх үе шат.....	39
2.3.5 Сүлжих, нэхэх үе шат.....	40
2.4 ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ УРСГАЛ	42
2.4.1 Түүхий ноолуурын экспортын дэд сүлжээ	42
2.4.2 Босоо хамааралт дэд сүлжээ.....	42
2.5 ЗАСАГЛАЛ	43
2.5.1 Өртгийн сүлжээн дэх засаглалын дүн шинжилгээ	45
2.5.2 Стандарт ба шошгожуулалт	46
2.6 SWOT дүн шинжилгээ.....	50
3. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР?.....	51
3.1 АРГА ЗҮЙН ТАЙЛБАР	51
3.2 ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ТОГЛОГЧДЫН БҮТЭЭМЖ БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	52
3.2.1 Зуун ямаатай цөөн малтай малчин өрхийн санхүүгийн байдал, үндэсний дундаж үзүүлэлт 52	
3.2.2 Зуун ямаатай олон малтай малчин өрхийн санхүүгийн байдал	54
3.2.3 Ченж буюу зуучлагчдын санхүүгийн байдал.....	55
3.2.4 Ноолуур угаах экспортлогчдын санхүүгийн байдал.....	56
3.2.5 Ноолуурын анхан шатны ялгалт хийж экспортлогчдын санхүүгийн байдал	57
3.2.6 Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн санхүүгийн байдал58	
3.2.7 Улаанбаатарын жижиглэн худалдааны компаниудын санхүүгийн байдал	59
Дундаж хэмжээний тоглогчдын үйл ажиллагааны ашиг	59
3.3 ҮНДЭСНИЙ НИЙТ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	60
3.4 ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД ӨРСӨЛДӨХ БОЛОН ОРШИН ТОГТНОХ ЧАДВАР 63	
3.5 ДЭД СҮЛЖЭЭ БОЛО ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР	64
3.6 АСУУЛТ 1-ИЙН ХҮРЭЭНИЙ ХАРИУЛТУУД	65
4. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ НЬ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙЖ ЧАДАЖ БАЙНА УУ?	68
4.1 ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ЗАСАГЛАЛЫН ОРОЛЦОО	68
4.2 НЭМҮҮ ӨРТӨГ БОЛОН АШГИЙН ХУВИАРЛАЛТ	68
4.1 АЖЛЫН БАЙР БОЛОН ЦАЛИН ХӨЛС	70
4.2 АСУУЛТ 2-ЫН ХҮРЭЭНИЙ ХАРИУЛТУУД.....	73
5. ӨРТГИЙН СҮЛЖЭЭ НЬ НИЙГМИЙН АСУУДЛЫН ХУВЬД ТОГТВОРТОЙ ЭСЭХ?	76
5.1 АЖИЛЛАХ НӨХЦӨЛ	76
5.1.1 Ноолуур боловсруулах ажлын нөхцөл	76
5.1.2 Мал маллах нөхцөл.....	78
5.1.3 Ажлын нөхцлийн дүгнэлт	79
5.2 ГАЗАР, УСНЫ ЭРХ	80
5.2.1 Бэлчээр ашиглалтын эрх	80

5.2.2	Бэлчээрийн нүүдэл ба Бэлчээрийн менежментийн удирдлага	81
5.2.3	Отгор нүүдэл.....	82
5.2.4	Бэлчээрийн бус зориулалтын газар ашиглалтын асуудлууд	82
5.2.5	Усан хангамж	83
5.2.6	Газар, усны эрхийн талаарх дүгнэлт	83
5.3	ХҮЙСИЙН ТЭГШ БАЙДАЛ.....	84
5.3.1	Ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн жендэрийн тэгш байдал	84
5.3.2	Малчин өрх болон малчин ардын жендэрийн тэгш байдал	85
5.3.3	Жендэрийн тэгш байдлын дүгнэлт	88
5.4	Хүнс, шим тэжээлийн аюулгүй байдал	88
5.4.1	Хоол тэжээлийн болон хооллолтын олон янз байдлын үзүүлэлтүүд.....	88
5.4.2	Өр, зээл.....	89
5.4.3	Малын даатгал	89
5.4.4	Хүнс, шим тэжээлийн аюулгүй байдлын дүгнэлт	91
5.5	НИЙГМИЙН КАПИТАЛ.....	91
5.5.1	Үйлдвэрлэгч байгууллагуудын давуу тал	91
5.5.2	Мэдээлэл ба итгэлцэл	92
5.5.3	Нийгмийн оролцоо	93
5.5.1	Нийгмийн капиталын дүгнэлт	93
5.6	АМЖИРГААНЫ НӨХЦӨЛ.....	94
5.6.1	Эрүүл мэндийн үйлчилгээ	94
5.6.2	Орон байр, Ус, ариун цэврийн байгууламж.....	94
5.6.3	Боловсрол.....	95
5.6.4	Амжиргааны нөхцлийн бусад хүчин зүйлс	96
5.6.5	Амжиргааны нөхцлийн дүгнэлт.....	97
5.7	АСУУЛТ 3-ЫН ХҮРЭЭНИЙ ХАРИУЛТУУД.....	97
6.	ӨРТГИЙН СҮЛЖЭЭ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУВЬД ТОГТВОРТОЙ ЭСЭХ?.....	99
6.1	БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ.....	99
6.1.1	Амьдралын мөчлөгий судалгааны арга зүй.....	99
6.1.2	Системийн хил хязгаар, функциональ нэгж ба АМС-ны дүрэм	101
6.2	АМЬДАРЛЫН МӨЧЛӨГИЙН БҮРТГЭЛ	102
6.2.1	МАН-н үйлдвэрлэлийн анхан шатны тоон мэдээлэл	102
6.2.2	Үйлдвэрлэгчдийн талаарх анхан шатны тоон мэдээлэл	104
6.2.3	Тоон мэдээллийн чанар	104
6.3	БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХОМСДОЛ, ЭКОСИСТЕМИЙН ЧАНАР, ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ	104
6.4	УАӨ-д ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ	108
6.5	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ	109
6.6	АСУУЛТ 4-ЫН ХҮРЭЭНИЙ ХАРИУЛТУУД.....	111
6.6.1	Бэлчээрийн доройтолтой тэмцэх нь	112
6.6.2	Янз бүрийн түвшинд ХНХ-ийн ялгарлыг бууруулах нь	113
6.6.3	Боловсруулах үйлдвэрлэлд химийн бодис болон усны тогтвортой хэрэглээ.....	114
7.	СИНТЕЗ БА ЗӨВЛӨМЖ.....	116
7.1	СУУРЬ АСУУЛТУУДАД ХАРИУЛАХ НЬ	116
7.2	АЛДАГДАЛТАЙ БҮТЦЭЭС ҮР АШИГТАЙ ЦИКЛД ШИЛЖИХ НЬ	117
7.3	ЭРСДЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	118
7.4	ЗӨВЛӨМЖ.....	120
7.4.1	МАН-н үйлчилгээнд чиглэсэн зөвлөмж	120
7.4.2	Стандарт баримтлах зөвлөмж	120
7.4.3	Малчдын амжиргаа, МАН-н үйлдвэрлэлд чиглэсэн зөвлөмж	120
7.4.4	Малчид болон үйлдвэрийн түвшний маркетингийн зөвлөмж.....	121
7.4.5	Боловсруулах үйлдвэрлэл болон Худалдааны бодлогын түвшний зөвлөмж.....	121
	АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	122
	ХАВСРАЛТ 1: ТОМИЛОЛТЫН ХӨТӨЛБӨР БА УУЛЗСАН ХҮМҮҮС	128
	ХАВСРАЛТ 2: ДҮН ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАСАН НЭМЭЛТ МАТЕРИАЛУУД.....	130
	ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ЗАСАГЛАЛЫН ГОЛ ТОГЛОГЧИД	131
	Төрийн оролцоо.....	131
	Хувийн хэвшил	133
	Хөгжлийн болон харилцан туслалцах байгууллагууд.....	135
	Иргэний нийгмийн байгууллагууд.....	137

ХАВСРАЛТ 3: ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИЛЖИЛГЭЭНИЙ НЭМЭЛТ МАТЕРИАЛУУД	139
ХАВСРАЛТ 4: НИЙГМИЙН ДҮН ШИЛЖИЛГЭЭНИЙ НЭМЭЛТ МАТЕРИАЛУУД.....	144
ХАВСРАЛТ 5 – БАЙГАЛЬ ОРЧНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАСАН БОЛОВСРУУЛАХ ШАТНЫ СУУРЬ ДАТА	150

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2-1: Ноолуурын чанар	18
Хүснэгт 2-2: Хятадын түүхий ноолуурын боловсруулалт, тонн.....	18
Хүснэгт 2-3: Монголын түүхий ноолуурын боловсруулалт, тонн	19
Хүснэгт 2-4: Монгол ноолуурын чанарын стандарт	20
Хүснэгт 2-5: Монгол ямааны үүлдэрлэг байдал түүний шинж чанар (тарган эм ямааны үзүүлэлт)	21
Хүснэгт 2-6: Говь үйлдвэрт тушаасан Монгол ноолуурын микроны диаметр.....	23
Хүснэгт 2-7: Малын тоо толгойн өсөлт(мянгаар), Монгол улс (1970 – 2022)	23
Хүснэгт 2-8 Монголын бүс нутгийн малын популяцийн хувьсал: 1989-2022 оны харьцуулалт	25
Хүснэгт 2-9: Бүс нутгийн түүхий ноолуурын үйлдвэрлэл, үнийн зөрүү, 2022. Эх сурвалж: ҮСХ, 2023б	28
Хүснэгт 2-10: Цөөн болон олон малтай малчин өрхүүд (малын тоо ба самнасан ноолуурын хэмжээ)31	
Хүснэгт 2-11: Улаанбаатар хот болон аймаг хоорондын зай.....	33
Хүснэгт 2-12: Ямаа самнах машины онцлог.....	36
Хүснэгт 2-13: Монголын ноолуур боловсруулах үйлдвэрийн хүчин чадал, 2019 оны мэдээлэл	37
Хүснэгт 2-14: Монголын ноолууран хувцасны экспорт (HS 611012).....	42
Хүснэгт 2-15: Үндэсний стратегийн баримт бичгийн хураангуй.....	44
Хүснэгт 2-16: Ноолуурын өртгийн сүлжээний засаглал. ХХААБ болон ЮНИДО-с тогтоосон бүрэлдэхүүн хэсгүүдийн үндсэн дээр зохиогчдын өгсөн контент (2024)	4
6	
Хүснэгт 2-17: Малчин/хоршооны түвшний стандарт, шошгожуулалтын схем	47
Хүснэгт 2-18: Үйлдвэрийн түвшинд хэрэглэж буй Стандарт ба шошгожуулалтын схемүүд	48
Хүснэгт 2-19: Монгол ноолуурын газарзүйн заалт.....	49
Хүснэгт 3-1: Өрхийн судалгаанд үндэслэсэн нэг өрхөд ногдох зардал; инфляциар бууруулсан үнэ...51	
Хүснэгт 3-2: 100 ямаатай, цөөн малтай малчин өрхийн санхүүгийн боломж, бүсийн ялгаа, 2022, ₮....53	
Хүснэгт 3-3: 100 ямаатай, олон малтай малчин өрхийн санхүүгийн боломж, бүсийн ялгаа, 2022, ₮.54	
Хүснэгт 3-4: Дундын ченжүүдийн санхүүгийн боломжит байдал, 2022 (ТӨГ)	55
Хүснэгт 3-5: Боловсруулах үйлдвэр болон бүс нутгийн хоорондын тээврийн зардал 2022 (ТӨГ)	55
Хүснэгт 3-6: Түүхий ноолуур угаах явц, Санхүүгийн боломжит байдал 2022 (ТӨГ)	56
Хүснэгт 3-7: Ноолуур ялгах явц, Санхүүгийн боломжит байдал 2022 (ТӨГ).....	57
Хүснэгт 3-8: Ноолуур боловсруулах явц, том болон жижиг үйлдвэрүүдийн санхүүгийн боломж, 2022 (ТӨГ).....58	
Хүснэгт 3-9: Жижиглэн худалдаа, санхүүгийн боломжит байдал 2022 (ТӨГ)	59
Хүснэгт 3-10: Дундаж тоглогчдийн нэг жилийн ашиг, 2022	60
Хүснэгт 3-11: Дундын зуучлалд шингэсэн импортын болон нэмүү өртгийн коэффициентүүд (үр нөлөөг тооцоход ашигладаг) (ТӨГ)	6

Хүснэгт 3-12: Өртгийн сүлжээний шууд болон шууд бус нөлөөлөл (ТӨГ).....	62
Хүснэгт 3-13: Ноолууран эдлэлийн дундаж үнэ 2019 - 2022	64
Хүснэгт 3-14: Дэд сүлжээний шинж чанарууд.....	65
Хүснэгт 4-1: Тоглогч тус бүрийн цэвэр ашиг, Монгол улс, 2022.....	69
Хүснэгт 4-2: Монгол улсын цалин хөлсний мэдээлэл, 2022	70
Хүснэгт 4-3: Монгол улс дахь өртгийн сүлжээний тоглогч бүрийн цалин хувиарлалт, 2022	71
Хүснэгт 4-4: Хөдөлмөр эрхлэлтийн ангилалд хамаарах цалингийн хуваарилалт, Монгол, 2022	72
Хүснэгт 5-1: Бэлчээрийн тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага, талуудын оролцоо.....	81
Хүснэгт 5-2: Хүйсийн тэгш бус байдлын гол үзүүлэлтүүд (өөрөөр заагаагүй бол үндэсний хэмжээний)84	
Хүснэгт 5-3: Ноолууртай холбоотой үйл ажиллагаанд жилд зарцуулсан цаг, (эрэгтэй, эмэгтэй)	86
Хүснэгт 5-4: Мал аж ахуйн үйлдвэрлэлд өрхийн гишүүдийн шийдвэр гаргалт (% , n=215)..	86
Хүснэгт 5-5: Өрхийн санхүүгийн хариуцлага (% , n= 287).....	87
Хүснэгт 5-6: Малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр	90
Хүснэгт 5-7: Ямаатай өрхүүдийн ус, ариун цэврийн байгууламжийн үзүүлэлтүүд (n=3502)	95
Хүснэгт 5-8: Сургуульд хамрагдалт, гүйцэтгэлийн үзүүлэлтүүд. Эх сурвалж: ҮСХ 2018.....	95
Хүснэгт 5-9: Ямаатай малчин өрхийн сонгогдсон эд зүйл эзэмших хувь (n=3502).....	96
Хүснэгт 5-10: Өртгийн сүлжээнд тулгарч буй гол асуудлууд.....	97
Хүснэгт 6-1: Хүлэмжийн хийн ялгаруулалтад ашигласан лавлагаа	100
Хүснэгт 6-2: Байгаль орчны шинжилгээнд авч үзсэн сүргийн дундаж бүтэц, менежмент (жилийн мэдээлэл).....	103
Хүснэгт 6-3: Хүний эрүүл мэнд, экосистемийн чанар, байгалийн нөөц гэсэн гурван салбарт Монголын ноолуурын өртгийн сүлжээнээс үзүүлэх нөлөө (үйлдвэрээс гарсан ноолууран хувцасны кг тутамд)....	105
Хүснэгт 6-4: Тусгай хамгаалалттай газарт үзүүлэх нөлөөлөл ба тус нөлөөлөд оруулж буй өртгийн сүлжээний үе шат бүрийн хувь нэмэр (хар ногоон: 0-20%), цайвар ногоон: 21-40%, шар: 41-60%, улбар шар: 61-80%, улаан: 81-100% хүртэл.....	107
Хүснэгт 7-1: Гол эрсдлийн илтгэлүүд.....	119

Зургийн жагсаалт

Зураг 2-1: Түүхий ноолуурын үйлдвэрлэлийн дэлхийн хөгжил	19
Зураг 2-2: Монгол ноолуурын өнгө, УБ дахь Говийн үзэсгэлэнгийн танхим.(Эх сурвалж: Зохиогч....20	
Зураг 2-3: Монгол улсын нутаг дэвсгэр дээр монгол үүлдрийн ямааны эзлэх хувь.....	22
Зураг 2-4: Хар зүсмийн Монгол үүлдэр. Эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн төв (2017a) ..	22
Зураг 2-5: Малын өсөлт, 1970 – 2022 оны өсөлт	24
Зураг 2-6: Монгол улсын бүсийн зураг	25
Зураг 2-7: Аймгуудын ямааны тоо толгойн өөрчлөлт: 1989-2022 оны харьцуулалт.....	26
Зураг 2-8: Малын тоо, өрхийн орлогын хамаарал, Монгол, 2021.....	29
Зураг 2-9: Нийт орлогод ямааны эзлэх хувь ба ноолуурын эзлэх хувь хоорондын хамаарал.....	29
Зураг 2-10: Монгол уламжлалт орон сууц, гэр.....	30
Зураг 2-11: Угаасан ноолуурын экспорт, экспортын үнэ (HS 510211)	35
Зураг 2-12: Угаах, ялгах явцад гарах алдагдал	36
Зураг 2-13: Ноолуур самнасны дараах бүдүүн хялгас.....	36
Зураг 2-14: Монголд ноолуурын үс самнах машин (2022).....	37
Зураг 2-15: Монгол самнасан ноолуурын экспортын зах зээл (2018-2022 оны мэдээ), HS 510531)..	38
Зураг 2-16: Самнасан ноолуурын экспорт, экспортын үнэ (HS 510531).....	38
Зураг 2-17: Экспортод зориулж савласан ноолуур.....	39
Зураг 2-18: Самнасан ноолуурын үнэ (HS 510531).	39
Зураг 2-19: Монголын ноолууран хувцасны экспорт (HS 611012).	41
Зураг 2-20: Ноолуурын урсгалын диаграмм, 2022, Монгол	43
Зураг 2-21: Өртгийн сүлжээний засаглалын тоглогчид, Монгол	43
Зураг 2-22: 2030 Стратегийн зорилтууд	45
Зураг 3-1: Хөдөө аж ахуйн ДНБ-д малчдын үйлдвэрлэсэн ноолуурын оруулсан хувь нэмэр, 2022,	5
4	
Зураг 3-2: Дундын зуучлалын задаргаа, 2022, Монгол улс.....	60
Зураг 3-3: Зардлынг бүтэц, 2022, Монгол улс	61
Зураг 3-4: Өртөг нэмсэн хувиарлал, 2022, Монгол улс	63
Зураг 3-5: Дэд сүлжээний шинж чанар, 2022, Монгол улс	64
Зураг 4-1: Өртгийн сүлжээний тоглогчдын цэвэр ашгийн задаргаа, 2022, Монгол улс.....	69
Зураг 4-2: Бүс нутгийн нэмүү өртгийн задаргаа 2022, Монгол улс	70
Зураг 4-3: Үйл ажиллагааны цэвэр ашгийн задаргаа, 2022	70
Зураг 4-4: Өртгийн сүлжээнд оролцогсод ногдох цалин хөлс, Монгол улс, 2022	71
Зураг 4-5: Бүсчилсэн цалин хөлс, 2022, Монгол улс	73
Зураг 4-6: Тоглогчдын Лорензын хазайлт, 2022, Монгол улс.....	74
Зураг 6-1: ReCiPe2016 аргачлалд хамрагдсан нөлөөллийн ангиллын тойм, тусгай хамгаалалттай газрын	

хамаарал.....	
.....99	
Зураг 6-2: Судалгааны системийн хил хязгаар ба тооцоолсон үе шатууд (2030 оны Замын зургийн тайланга хэсэгчилэн авав).....	
.....101	
Зураг 6-3: Монголын ноолуурын өртгийн сүлжээнд үзүүлэх янз бүрийн үе шатны нөлөөлөл	105
Зураг 6-4: Хүний эрүүл мэнд, экосистемийн чанар, байгалийн нөөц гэсэн гурван салбарт Монголын ноолуурын өртгийн сүлжээнээс үзүүлэх нөлөө.....	105
Зураг 6-5: Монголын ноолуурын өртгийн сүлжээний янз бүрийн үе шатуудын хүлэмжийн хийн ялгаруулалтын эзлэх хувь (а) болон мал аж ахуйгаас ялгарах төрөл бүрийн хүлэмжийн хийн (б).108	
Зураг 6-6: Монгол улсын тусгай хамгаалалттай газрууд.....	111
Зураг 6-7: Аймгуудын ямааны нягтрал (толгой.га-1).....	111
Зураг 7-1: Одоогийн алдагдалтай мөчлөг	117
Зураг 7-2: Үр бүтээмжтэй мөчлөг	118

ТАЛАРХАЛ

Бидэнд өөрсдийн цаг заваа зарцуулж, мэдлэг туршлага, мэдээллээ хуваалцсан өртгийн сүлжээний бүх оролцогсод болон оролцогч талуудад талархаж буйгаа илэрхийлье. Төслийг хүрээнд уулзаж ярилцлагад хамрагдсан Монгол орны бүрд н малчин өрхүүд бидний асуултад тэвчээртэй, эелдэг байдлаар хариулж, найрсаг зочломтгой хандсанд нь бид онцгойлон талархаж байна. Эдийн засгийн болон функциональ шинжилгээг бэлтгэхэд тусалсан Бартломиеж Бажан, Эрдэнэбатын Эрдэнэбат, Оргилсайханы Гэрэлсайхан, нийгмийн шинжилгээг бэлтгэх явцад зөвлөгөө өгч, баримт бичгээр хангасан Даниел Мерфи, Элизабет Фокс нарт онцгойлон талархал илэрхийлье. Ажиллах орчноор хангасан Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоо болон жолооч Сурмаахоролын Батболд, Анхаа нартаа баярлалаа. Европын Холбооны Монгол дахь Төлөөлөгчийн газраас дунд шатны явцын илтгэлүүд болон тайлангийн төсөлд маш үнэтэй санал, зөвлөмжийг өгсөн. Мөн биднийг бүх талаар дэмжин ажилласан VCA4D Хөтөлбөрийн удирдлагын багт талархал илэрхийлье.

ТОВЧИЛСОН ҮГС БОЛОН МОНГОЛ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР (Үсгийн дарааллаар)

<i>Аймаг</i>	<i>Засаг захиргааны нэгж, Монгол улс 21 аймагтай бөгөөд аймаг бүр өөрийн нутгийн удирдлагын бүтэцтэй</i>
ХБ	Хамгааллын бүс (амьдралын мөчлөгийн анализ хийхэд ашиглах)
ХХМЭБА	Хил хязгааргүй Малын эмч нар ба Агрономчид
<i>Баг</i>	<i>Засаг захиргааны хамгийн баг нэгж, сум хэд хэдэн багаас бүрдэнэ</i>
<i>Ченжүүд</i>	<i>Дундын зуучлагчид</i>
<i>Зуд</i>	<i>Хахир хүйтэн, цас ихтэй байгалийн гамшигт үзэгдэл</i>
ЕХТ	Европын холбооны төлөөлөгчид
НҮБХХААБ	НҮБ-ын ХХААБ
ГШХ	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
<i>Гэр</i>	<i>Модон араг, эсгий бүрээс бүхий, зөөх боломжтой Монгол уламжлалт орон сууц</i>
ГЗЗ	Газар зүйн заалт
ИБУТЭТОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
ЭЗНСЭТОУП	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
ОУХБ	Олон лусын Хөдөлмөрийн байгууллага
МУОӨГ	Монгол улсын оюуны өмчийн газар
АМА	Амьдралын мөчлөгийн анализ
МТЭБ	Монголын түүхий эдийн бирж
МУСХЗГ	Монгол улсын стандарт, хэмжил зүйн газар
МХҮЭНХ	Монголын худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн холбоо
МБАНХ	Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоо
ТӨГ	Төгрөг
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
<i>Нээгдэл</i>	<i>Социализмын үеийн малчдыг нийгэмчилсэн бүтэц</i>
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
БАХ	Бэлчээр ашиглагчдын хэсэг
ХНБМААЗДС	Хариуцлагатай нүүдэлчин бэлчээрийн мал аж ахуйн зохистой дадлын стандарт
БАГ	Бэлчээр ашиглуулах гэрээ
ТНГХ	Тогтвортой ноолуурын гэрчилгээжүүлэлт
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ТНА	Тогтвортой Ноолуурын Эвсэл
Сум сумтай	Орон нутгийн засаг захиргааны нэгж: Аймаг бүр 15-25
<i>Т</i>	<i>тонн</i>
НҮБХАС	НҮБ-ын хүн амын сан

НҮБХИС	НҮБ-ын Хүүхдийг ивээх сан
НҮБАҮХБ	НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага
НӨ	Нэмүү өртөг
ӨС	Өртгийн сүлжээ
ӨСХШ	Өртгийн сүлжээг хөгжүүлэх шинжилгээ
ННХ	Ноос, ноолуурын холбоо

ЭДИЙН ЗАСГИЙН НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

Эдийн засгийн нэр томьёо	Тайлбар
Үйл ажиллагааны цэвэр ашиг (ҮАЦА) (гэр бүлийн ажлын хөлс тооцоогүй)	(Орлого– Зардал) – Элэгдэл
Шууд нэмүү өртөг (НӨ)	Өртгийн сүлжээнд тоглогчдын өртөг нэмсэн нийт дүн (боловсруулагчид болон өртгийн сүлжээний нийлүүлэгчид)
Шууд бус нэмүү өртөг	Өртгийн сүлжээний гаднах оролцогч талууд буюу нийлүүлэгчдийн өртөг нэмсэн нийт дүн (малчин, хоршоод үйлдвэр, дундын ченж)
Нийт нэмүү өртөг	Өртгийн сүлжээний шууд болон шууд бус нэмүү өртөг
Дотоодын эдийн засаг дахь оролцоо	Өртгийн сүлжээний үйлдвэрлэлийн үндэсний эдийн засагт оруулах нэмүү өртөг Интеграцийн хувь хэмжээ = Нийт нэмүү өртөг / бүтээгдэхүүн
Үр нөлөөний харьцаа	Нэмүү өртгийн сүлжээний үйл ажиллагаанд дахь дотоодын бизнес эрхлэгчдийн оролцоо, хувь нэмрийг тодорхойлдог. Үр нөлөөний харьцаа = Шууд бус нэмүү өртөг / Шууд нэмүү өртөг
Улсын төсвийн тэнцэл	Улсын төсөвт үзүүлэх үр нөлөө= Үр ашиг [<i>Нийт татвар + төрийн өмчит компанийн нийт үйл ажиллагааны ашиг</i>] - Зардал [<i>Татаас + бусад төрийн зардал</i>]
Худалдааны тэнцэл	Өртгийн сүлжээний худалдааны балансын үзүүлэх нөлөө = Өртгийн сүлжээний нийт экспорт – Өртгийн сүлжээний нийт импорт (орц/ бүтээгдэхүүн үйлчилгээ/дундын хэрэглээ)
Нэрлэсэн хамгаалалтын итгэлцүүр (НХИ)	Энэ нь нэмүү өртгийн сүлжээний бүтээгдэхүүн бүрийн үндэсний болон олон улсын үнийг харьцуулдаг. НХИ= Бүтээгдэхүүний дотоод үнэ / Олон улсын харьцуулсан үнэ
Дотоодын нөөцийн зардлын харьцаа (ДНЗХ)	Энэ нь (i) өртгийн сүлжээний хүрээнд бий болгосон дотоодод худалдаалагдах боломжгүй хүчин зүйлсийн (жишээ нь, хөдөлмөр, хөрөнгө, газар, байгаль орчны үйлчилгээ) эдийн засгийн бодит дотоод зардал, (ii) энэ хугацаанд бий болсон нэмэгдсэн цэвэр үнэ цэнийг олон улсын харьцуулсан үнийг ашиглан харьцуулдаг, өөрөөр хэлбэл олон улсын зах зээлийн боломж хир байгааг тооцоолдог.

	<p>ДНЗХ = Зах зээлийн үнээр худалдаалагдах боломжгүй дотоодын хүчин зүйлс (шилжүүлэг оруулаагүй) / (Олон улсын зах зээлийн үнэд нийцсэн үйлдвэрлэл – Олон улсад худалдаалагдах дундын зуучлалын бараа, үйлчилгээний үнэ)</p>
--	--


Валютын ханш 2022	
1 ам.доллар = 3,144 Монгол төгрөг (ТӨГ)	
1 евро = 3,302 Монгол төгрөг (ТӨГ)	

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Монголын нийт малчдын 87% буюу 190,700 орчим малчин өрх ямаа өсгөн ямааны ноолуураас орлого олон амьдарч байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг буюу социалист нийгэм таран бутарснаас хойш ямааны тоо толгой хурдацтайгаар эрс өссөн юм. Ямаан тоо толгойн хит өсөлт нь Монгол орны бэлчээрийн газрын доройтлын нэг үндсэн шалтгаан болж буй юм.

Ноолуурын өртгийн сүлжээний дүн шинжилгээгээр Монгол улсын түүхий ноолуурын үйлдвэрлэл 2020 он гэхэд 10,764 тонн болж өссөн хэдий ч Хятад Услын ноолуурын үйлдвэрлэлтэй харьцуулахад 2022 онд 14,649 тонн болж буурсан, 2016 оны хамгийн өндөр үйлдвэрлэл буюу 18,884 тонны үзүүлэлттэй байна.

Ноолуур бэлтгэл, боловсруулалтын ерөнхий тоймыг ямааны үүлдэр угсаа, тоо толгойн өсөлт, самнах явц, малчин өрхийн орлогод ноолуурын эзлэх хувь зэрэг үзүүлэлтээр аймаг тус бүрээр болон малчин өрхийн амьжиргааны түвшингээр ялган харуулахыг хичээсэн болно. Ноолуурын нэмүү өртөг шингэсэн үйл ажиллагаа буюу боловсруулалтын үеийн техник үйл ажиллагаа буюу хоёр гол дэд сүлжээний онцлох зарчмуудын тайлбарыг багтаасан. Хоёр дэд сүлжээ гэдэгт а) түүхий ноолуур экспортлох сүлжээ буюу угаасан түүхий ноолуурыг Хятад улс руу шууд экспортод гаргах, б) босоо хамааралт сүлжээ буюу угаагаад самнасан ноолуурыг олон улсын зах зээлд гаргах, бэлэн бүтээгдэхүүн экспортлох, дотоодын жижиглэн худалдаа багтдаг.



Монгол ноолуурын өртгийн сүлжээ нь нэлээд хэдэн сайн дурын үндэсний стандартуудыг олон байгууллага үнэлгээ баталгаажуулах ажлыг хийж байна. Малчны хотноос байгаль орчинд ээлтэйгээр бэлтгэгдэж, байгаль орчинд ээлтэйгээр тогтвортой боловсруулалт хийгдсэн, өндөр чанартай ноолуурыг дэмжих зорилготой бөгөөд ноолуурын өртгийн сүлжээг хөгжүүлэх нь маш чухал юм. Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хоёр төрлийн үндэсний стандартуудыг олон нийтэд таниулах ажлыг дэмжих, стандарт, схемүүд хоорондын уялдааг хангах нь зүйтэй байна.

Өртгийн сүлжээ нь эдийн засгийн хувьд, ялангуяа малчин өрхийн түвшинд үр өгөөжтэй, тогтвортой байх ёстой. Ноолуураас олох ашиг орлого нь бүс нутаг бүрд малын тоо толгойноос үл шалтгаалан бараг адилхан байна. Мал ихтэй малчид олон ямаа зарж борлуулдаг хэдий ч сүү цагаан идээ бага боловсруулах ба өрхийн орлогоо дан ганц ямаа биш бусад малаас авах ашиг шимээр арвижуулдаг байна. Нэг үгээр хэлбэл, мал ихтэй малчин өрх ямааны ноолуурын орлогоос төдийлөн хараат бус байна.

Гэхдээ ноолуурын боловсруулах шатны сүлжээг илүү нарийн судлахад эдийн засгийн үр ашиг нь нэлээд ярвигтай байв. Хамгийн бэрхшээлтэй зүйл нь томоохон ноос, ноолуур үйлдвэрлэгчдийн түвшний ашиг сонирхлоос үүдсэн зардал байв. Ченжүүд буюу дундын зуучлагчдын ашгийн зөрүү 0.8%, угаагаад экспортлох ашгийн зөрүү 4.6%, ангилж ялган экспортлох ашиг 15.4%, боловсруулан хувцас эдлэл үйлдвэрлэхэд гарах ашиг 5.6%, бэлэн ээрсэн утсаар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч жижиг бизнесүүдийн ашгийн зөрүү 21.8%, жижиглэн худалдааны ашгийн зөрүү 3.4% байна.

Ноолуур боловсруулах өртгийн сүлжээний салбар тэр чигтээ 100% зээлэн дээр тогтож байна. Орлогоосоо үндсэн зээл болон зээлийн хүүгээ төлдөг. Ногоон зээл, засгийн газрын болон олон улсын донор байгууллагын хөнгөлттэй зээлийн эс тооцвол нийт орлогын 20 хувийг зөвхөн зээлийн хүүгийн төлөлтөд зарцуулж байна. Зээлийг ихэвчлэн ноолуур авахад зориулж байна.

Ноолуурын өртгийн сүлжээний эдийн засгийн өсөлтөд үзүүлэх гол гол үр нөлөөг дор үзүүлэв.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ҮР ДҮН
Өртгийн сүлжээний үйлдвэрлэлийн үнэ цэн	2,108,676 сая.төг
Шууд нэмүү өртөг	1,851,338 сая.төг
Нийт нэмүү өртөг	1,919,139 сая.төг
Үе шат бүрийн нэмүү өртөг	Малчид: 73.9 % Боловсруулах: 21.6 % Жижиглэн худалдаа: 4.5%
ДНБ-д эзлэх нэмүү өртөг	3.6%
Эдийн засагт оруулах хувь хэмжээ (нийт нэмүү өртөг/өртгийн сүлжээний үйлдвэрлэл)	91%

Ноолуурын өртгийн сүлжээ нь ХАА-н салбарын ДНБ-д 27.4%-г эзэлж байна. Мөн улсын нийт төсөвт 62,056 сая төгрөгийн орлого оруулдаг бөгөөд нийт 1,210,020 сая төгрөгийн цэвэр ашгийг худалдааны тэнцэлд оруулдаг байна.

Ноолуур үйлдвэрлэлийн эдийн засгийн өсөлт нь хүртээмжтэй гэдгийг хэд, хэдэн баримтаар нотлогдож байна. Энэхүү өртгийн сүлжээ нь янз бүрийн насны эмэгтэйчүүдийг ажлын байраар хангахаас гадна

боловсруулах өртгийн сүлжээний цалингийн хэмжээ (сард 1,503,800 төг) нь улсын дундажтай ижил байгаа бөгөөд энэ салбарт ажиллах сонирхлыг ихээхэн төрүүлж байна. Жишиг болгон авч үзвэл боловсруулах үйлдвэрүүдийн цалин нийслэл Улаанбаатар хотын жижиглэнгийн дэлгүүрүүдийн худалдагч нарын цалингаас 50 орчим хувиар өндөр байна. Нийтдээ 7584 ажилтныг бүтэн цагаар ажиллуулж, 96,131 сая төгрөгийн цэвэр цалин олгосон гэсэн тооцоо гарчээ.

Цаашилбал, ноолуурын үнэ өндөр байгаа нь малчдад орлогоо нэмэгдүүлэх, улмаар хөдөөнөөс Улаанбаатарыг зорих шилжилт хөдөлгөөнийг бууруулж байна. Мөн ямаа самнах улиралд орон нутгийн ажилгүй иргэдийг ямаа самнах түр ажлын байраар хангаж, орлоготой болгодог тухай малчид дурдаж байв. Ноолуурын өртгийн сүлжээнд эмэгтэйчүүд түлхүү оролцдог ба малчид өртгийн сүлжээний засаглалд төдийлөн идэвхтэй бус оролцдог. Малчдын ноолуурын үнэд нөлөөлөх боломж хязгаарлагдмал. Ченжүүд урьдчилгаа төлбөр тараадаг байдал нь тэднийг үнэ тохиролцоо боломжгүй болгодог.

Ноолуурын нэмүү өртгийн сүлжээний нийгмийн үр нөлөөний дүн шинжилгээ нь үйлдвэрлэлийн үе шат ба боловсруулалтын үе шатуудын нийгмийн үзүүлэлтүүдээс шалтгаалан төвөгтэй байдаг боловч VCA4D шинжилгээг хийсэн буурай орнуудтай харьцуулахад нийгмийн үзүүлэлтүүд нь ерөнхийдөө эерэг байгааг харуулж байна.



Боловсруулах салбарт ажиллах орчин нөхцөл илт сайжирсан төдийгүй Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим, ажил олгогчдын зүгээс хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд ахиц дэвшил гарч буй нь энэ салбарыг бусад салбартай харьцуулбал ажил хайгчид ялангуяа эмэгтэйчүүдийн сонирхлыг татах гол салбар болгосон байна.

Мал аж ахуйн салбарт тулгарч буй гол асуудлын нэг нь жендерийн тэгш бус байдал, залуу үеийнхэн, тэр дундаа охидын мал маллах хүсэл сонирхолгүй болж байгаа явдал юм. Өртгийн сүлжээний гаднах асуудал ч гэлээ хүнсний олон

янз байдал нь хөдөөд болон жижиг хотуудад томоохон асуудал болж байгааг шийдэх хэрэгтэй. Бэлчээр ашиглагчдын хэсэг болон малчны хоршоод байгуулагдаж нутгийн иргэдийн түшиглэсэн байгууллагууд хөгжиж байгаа ч нутгийн иргэдийн цөөн хэсгийн хамарсан байна. Бэлчээр зохион байгуулах хууль эрх зүйн орчныг сайжруулах асуудлыг УИХ-р хэлэлцэгдэж байгаа нь сайн талтай. Ерөнхийдөө ноолуурын нэмүү өртгийн сүлжээнд цаашид хөрөнгө оруулалт хийхэд саад бэрхшээл болох нийгмийн томоохон хүчин зүйл байхгүй бөгөөд энэ салбарын хөрөнгө оруулалт нь нийгмийн сайн сайхан байдлыг улам бэхжүүлнэ гэдгийг харуулж байна.

Ноолуурын өртгийн сүлжээний байгаль орчинд үзүүлэх нөлөөн байдлын нөлөөг гурван хүчин зүйлээр буюу байгалийн нөөцийн хомсдол, экосистемийн чанар ба хүний эрүүл мэндийн нөлөөлөл гэсэн чиглэлээр тодорхойлсон.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дээрх гурван үзүүлэлт тэр дундаа экосистемд үзүүлэх нөлөөлөл нь 70 орчим хувь бөгөөд харин хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл нь 40 гаруй хувьтай байна. Байгаль орчинд үзүүлж буй гол нөлөө нь бэлчээрийн талхагдал юм. Ноолуур будах үйл явц нь нөөцийн хомсдолд үзүүлэх нөлөөллийн 36%, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн 26%, ялангуяа хүний биед хорт хавдар үүсгэгч хоруу чанарт бодис ашиглах, цэнгэг усны болон далайн экологид хор нөлөө үзүүлэх зэрэг багтана.

Мөн бид малын гаралтай метан хийн ялгарал нь уур амьсгалын өөрчлөлтөд (тодорхой болгоомжлолтойгоор), болон биологийн төрөл зүйлд тус тус нөлөө үзүүлнэ гэж харж байна. Бэлчээр ашиглагчдын институцыг сайжруулах замаар бэлчээрийн доройтлыг арилгах, ноолуур

боловсруулалтад сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, химийн гаралтай бодис болон усны нөөцийн тогтвортой хэрэглээг дэмжих, мал аж ахуйгаас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь талуудын оролцооны гол чиглэл юм.

Зөвлөмж

Ноолуурын зах зээлийг байгаль орчин болон ноолуур үйлдвэрлэж буй малчин өрхүүдэд ээлтэй, тогтвортойгоор хөгжүүлэх сонирхол дэлхий даяар нэмэгдэж байна. Энэ боломжийг Монголын оролцогч талууд зохистойгоор ашиглах ёстой гэдгээ ухамсарлаж байгаа. Монгол Улс, өндөр чанарын баталгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар үнээ өсгөх, малчид, бэлчээрийн зохистой ашиглалт руу чиглэсэн зөв бодлого, үйл ажиллагаа явуулснаар цөөн бүтээмж өндөртэй ямаанаас илүү орлоготой болох боломжтой. Ноолуурын өртгийн сүлжээнд хийсэн судалгаан үр дүнгээс гаргаж буй хамгийн чухал зөвлөмж нь: Олон улсын донор байгууллагууд Монгол ноолуурын өртгийн сүлжээг хөдөөгийн иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр, хот суурин газарт хамгийн том ажлын байр бий болгогч, улсын эдийн засгийн өсөлтөд томоохон хувь нэмэр оруулагч, эрдэс баялгийн экспортын орлогыг солонгоруулах боломж гэдэг утгаар нь ач холбогдлыг нь ойлгож үргэлжлүүлэн дэмжих хэрэгтэй.

Ноолуурын өртгийн сүлжээнд хийсэн судалгаан үр дүнгээс дараах зөвлөмжүүдийн хүргэж байна:

МАН-н үйлчилгээ

- Мал амьтны эрүүл мэндийн үйлчилгээ, малыг чанаржуулах чиглэлээр технологи, малын эрүүл мэндийн менежментийг малчдын түвшинд сайжруулах

Стандарт

Мал аж ахуйн салбарын зохистой дадлуудын стандартыг нэтрүүлэх ажлыг сайжруулах: үүнд малын эрүүл мэнд, малчдын тогтмол орлогыг баталгаажуулах, чанарт суурилсан урамшууллын тогтолцоог бий болгох, зохистой дадлын схемийг экспортлогч компаниудад таниулах замаар өндөр чанартай ноолуурын эргэлтийг сайжруулах

МАН-н үйлдвэрлэл ба малчдын амьжиргаа

- Засгийн газар, иргэний нийгмийн байгууллага болон олон улсын хөгжлийн байгууллагуудын зүгээс ноолуураас гадна малын гаралтай бусад бүтээгдэхүүний өртгийн сүлжээг дэмжиж хөгжүүлэх
- Бэлчээр зохион байгуулах хууль эрх зүйн орчныг сайжруулах
- Орон нутгийн удирдлага, төрийн албан хаагчид болон бэлчээр ашиглагчдын хэсгийг чадавхжуулах
- Ноолуурын өртгийн сүлжээнд оролцогчдын мөнгөн урсгалын боломжийг нэмэгдүүлэх механизмыг хөхүүлэн дэмжих

Малчин, үйлдвэрлэгч хоорондын маркетинг

- Малчдаар гишүүнчлэлээ бүрдүүлсэн хоршоодыг бодлогоор дэмжих, чадавхыг бэхжүүлэх
- Чанарт суурилсан үнийн тогтолцоог чангатгах зорилгоор дуудлага худалдааны загварыг малчдын түвшинд туршиж үзэх

Боловсруулалт ба худалдааны бодлого

- Байгаль орчны сөрөг нөлөөг багасгахын тулд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх
- Химийн бодисын зохистой ашиглалт, бохир усыг цэвэрлэхэд мөрдөж буй стандартуудыг мөрдүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ногоон гэрчилгээтэй химийн бодисуудыг түлхүү ашиглах
- Боловсруулах үйл ажиллагааны чанарыг дэмжих, ялангуяа самнах үйлдвэрийн хүчин чадлыг сайжруулах
- Улаанбаатар хотоос гаднах бүсэд байрлах боловсруулах төвүүдийг

хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

- Хөрөнгө оруулалт болон үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар зорилтод хөнгөлөлттэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ялангуяа байгаль орчны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн ногоон зээлийг тэлэх
- Малын гаралтай түүхий дэд, бүтээгдэхүүн боловсруулахад чиглэсэн илүү их Гадаад шууд хөрөнгө оруулалтыг бий болгохын тулд аж үйлдвэрийг дэмжих, хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулахад чиглэсэн засгийн газрын худалдааны дипломат харилцааг нэмэгдүүлэх
- Нэмүү өртгийг сүлжээний мэргэшсэн боловсон хүчнүүдийг бэлтгэх сургалтыг нэмэгдүүлэх
- ЖДҮ эрхлэгчдийн ханшийн хэлбэлзэлтэй холбоотой эрсдэлийг удирдах чадавхыг бэхжүүлэх

1. ТАНИЛЦУУЛГА

Ноолуур гэдэг нь ямааны унгарил ус ба тансаг, нарийн ширхэгтэй ноосны төрөл юм. Эдгээр нарийн ноолуурын ямаа нь Энэтхэг, Балба, Төвдийн Гималайн бүс нутгаас гаралтай боловч дэлхийн бусад хэсэгт ч нутагшсан байдаг.

"Cashmere буюу ноолуур" гэдэг нэр нь баруун Гималайн нуруунд оршдог "Кашмир" бүс нутгаас гаралтай. Энэ бүс нутагт нарийн ширхэгт ноолуурын үйлдвэрлэл одоогоор хязгаарлагдмал байгаа ч хойд Хятад, Монгол, Түвд, Афганистанд ноолуурын бага зэрэг үйлдвэрлэл явагдаж байна. Үүнээс гадна Төв Азийн орнууд, Иран, Австрали, Шинэ Зеландад бага хэмжээний ноолуур үйлдвэрлэдэг (Dalton & Franck, 2001).

"Пашмина" гэсэн нэр томъёог уран зохиолд ноолууран утаснуудын өөр нэг нэр болгон ашигладаг. Угтаа пашмина гэдэг нь Энэтхэгийн Ладак мужийн Чангра гэгддэг Чангтангийн ямаанаас гаргаж авсан нарийн ноолуурын тусгай төрлийг хэлдэг гэдгийг тодруулах нь зүйтэй. (Бхаттачарья, Мисра, Шейх, Кумар, Шарма, 2004). Жилийн үйлдвэрлэл нь маш доогуур байдаг. Пашминаг мөн "Энэтхэгийн ноолуур" гэж нэрлэдэг бөгөөд ноолуураас илүү нарийн микронтой (10-14 μm), зөөлөн, дулаан байдаг (Am5 sarappan et al., 2011).

Шинжлэх ухаанд *Capra hircus laniger* гэж тодорхойлогдсон ноолуурын чиглэлийн ямаа нь "шаалин алчуур ямаа" эсвэл "Төвөдийн ямаа" гэж нэрлэгддэг бөгөөд ихэвчлэн цагаан өнгөтэй, бүдүүн ширхэгтэй ноосоор бүрхэгдсэн, дотор талаараа зөөлөн, нарийн үстэй байдаг. Гадна бүрхсэн бүдүүн ширхэгтэй ноосыг хамгаалалтын үс гэж нэрлэгддэг бат бөх давхарга юм. Дотор давхаргын нарийн ширхэгтэй хялгас гэж нэрлэгддэг нарийн унгарил үсийг ноолуур гэнэ. Гадна бүдүүн ширхэгт хялгас нь бороо, бут сөөг, өргөс болон бусад гаднын хүчин зүйлсээс хамгаалах хаалт болдог (Hunter, 2020).

АНУ-ын ноосон бүтээгдэхүүний шошгын тухай актын дагуу ноолуурыг доорх байдлаар тодорхойлсон байна.

- Ноолуур нь ямаанаас (*Capra hircus laniger*) гаргаж авсан нарийн

ширхэгтэй (самнаж ялгасан) зөөлөн нарийн үс юм.

- Ноолуурын ширхгийн дундаж голч 19 микроноос хэтрэхгүй.
- Ноосон бүтээгдэхүүн дэх ноолууран утас нь 30 микроноос дээш дундаж диаметртэй 3%-иас ихгүй (жингийн хувьд) ноолуур агуулдаг.

Энэ тодорхойлолтын дагуу ямааны бүдүүн ширхэгтэй хялгасан үсийг ноолуур гэж тооцдоггүй (Hunter, 2020).

Ноолуурын өртгийн сүлжээ нь эрдэс баялгийн бус экспортыг бүрдүүлэгч чухал ач холбогдолтой салбар юм. Монгол улс БНХАУ-ы дараа орох дэлхийн хоёрдогч том түүхий ноолуур үйлдвэрлэгч төдийгүй ноолууран утас болон ноолууран хувцасны хоёрдогч том экспортлогч орон юм.

Өртгийн дэд сүлжээ нь анхан шатны түвшинд малчид, ченжүүд, хоршоодыг хамарсан, дотоодын үйлдвэрлэгчид ба тэдний үйлчлүүлэгч-олон улсын худалдан авагчид, Хятад уруу анхан шатны боловсруулалт хийгээд экспортолдог Хятад эзэнтэй жижиг угаах үйлдвэрүүд гэх мэт олон тоглогчидтой цогц систем юм. Монгол Улсад ноолууртаа илүү нэмүү өртөг шингээх маш их сонирхол бий.

Бэлчээрийн мал аж ахуй нь Монголчуудын гуравны нэгийг ажлын байраар хангадаг төдийгүй бусад салбараас илүү ажил олгогч салбар юм (2030 оны Замын зургийн тайлан).

Монголын нийт 190,700¹ малчин өрхийн дийлэнх нь буюу 87 хувь нь ямаа өсгөж, ноолуур борлуулж, амьжиргаандаа хэрэглэдэг. Ямааны ноолуур нь тэдний хувьд орлогын гол их үүсвэр болдог. Зөвлөлт засаглал² нуран, зах зээлд шилжсэнээс хойш ямааны тоо, толгой маш хурдтайгаар өссөн бөгөөд 2010 он гэхэд бараг хонин толгойтой тэнцүү хэмжээнд очсон. Хонь бол махны хэрэгцээний гол үүсвэр төдийгүй социализмын үед ноос, ноосон бүтээгдэхүүн нь экспортын гол түүхий эд байв. Ноолуурын үнийн хөөрөгдөлтэй хамааралтайгаар ямааны тоо, толгойг өсгөсөн нь Монгол орон даяар бэлчээрийн доройтол ихсэх нэг гол хүчин зүйл болсон гэж үздэг.

Ноолуурын өртгийн сүлжээг байгаль орчин болон ноолуурыг бэлтгэж буй малчин өрхүүдэд ээлтэй, тогтвортойгоор хөгжүүлэх сонирхол дэлхий даяар нэмэгдэж байна. Энэ боломжийг Монголын өртгийн сүлжээны оролцогч талууд зохистойгоор ашиглах ёстой гэдгээ ухамсарлаж байгаа. Монгол Улс, өндөр чанарын баталгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар үнээ өсгөх, малчид, бэлчээрийн зохистой ашиглалт руу чиглэсэн зөв бодлого, үйл ажиллагаа явуулснаар цөөн ямаанаас илүү орлоготой болох боломжтой. Хэдийгээр малчдын болон үйлдвэрлэгчдийн түвшинд стандартын гэрчилгээжүүлэх хэд хэдэн зохистой дадлын схем хэрэгжиж байгаа ч тэдгээрийн хоорондын уялдаа холбоог хангах, төрөөс дэмжлэг үзүүлэх ажил удаашралтай

¹ Үндэсний статистикийн хорооноос гаргасан статистик https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_1001_027V1

² 1924-1990 он хүртэл Монгол улс хэдийгээр тусгаар тогтносон улс боловч хөгжлийн бодлогыг ЗХУ-ын зааж, чиглүүлж, хянадаг байв. Тиймээс Зөвлөлт засгийн үе хэмээн оруулав.

байна. Мөн өртгийн сүлжээний бүх шатан дахь мөнгөн урсгалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зээл, санхүүгийн үйлчилгээг сайжруулахад анхаарах хэрэгтэй.

Ноолуурын өртгийн сүлжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлогын дүн шинжилгээ хийх энэхүү зөвлөх үйлчилгээг Европын Комиссын Олон улсын түншлэлийн (INTRA) захиргааны санхүүжилтээр, Европын Холбооны Монгол дахь Төлөөлөгчийн газрын (EUD) захиалгаар, Өртгийн сүлжээг хөгжүүлэх шинжилгээ (ӨСХШ) төслийн хүрээнд боловсруулсан аргачлалын дагуу гүйцэтгэв.

Өртгийн сүлжээний зураглалд мэргэжлийн дүн шинжилгээ хийсний дараа Өртгийн сүлжээг хөгжүүлэх шинжилгээний (VCA4D) арга зүй нь дараах дөрвөн гол асуултад хариулт олох зорилгоор боловсруулагдав. Үүнд:

- Өртгийн сүлжээний эдийн засагт үзүүлэх үр нөлөө юу вэ?
- Эдийн засгийн өсөлт нь хүртээмжтэй эсэх?
- Өртгийн сүлжээ нь нийгмийн хөгжлийн хувьд тогтвортой эсэх?
- Өртгийн сүлжээ нь байгаль орчны хувьд тогтвортой эсэх?

Судалгааг ӨСХШ -ны арга зүйн дагуу 2023 оны 5 дугаар сараас 12 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэсэн. Судалгааны явцад олон улсын экспертүүд (Morton, Kotyza and Vigne) 2 удаа буюу 6-7 сар, 9-10 саруудад тус тус Монголд ирж ажилласан. Үндэсний зөвлөх Дашбалын Бурмаа судалгааны туршид багийн бүх зөвлөхүүдтэй ажиллав. Судалгааны багийн аяллын хуваарь, уулзсан хүмүүсийн жагсаалтыг Хавсралт 1-т оруулав. Хоёр удаагийн томилолтоор ажиллах хугацаанд судалгааны багийнхан төрийн захиргааны байгууллагууд (тухайлбал ҮСХ), Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим, олон улсын байгууллагууд, ТББ, судлаачид, Улаанбаатар хот дахь дундын хоршоодтой хэд хэдэн уулзалтуудыг хийв. Үүний үр дүнд хангалттай хэмжээний хоёрдогч мэдээллийн бааз, тайлангуудтай танилцаж, салбартаа манлайлагч ноолуур боловсруулах гурван үйлдвэртэй уулзаж мэдээлэл солилцов.

Төв, Хэнтий, Баянхонгор, Архангай, Хөвсгөл аймгийн сонгогдсон сумдаар (бүс, бүслүүрийн хувьд ялагаатай) явж хээрийн судалгааг гүйцэтгэв. Сумдад ажиллахдаа сумын засаг дарга, холбогдох төрийн албан хаагч, мал эмнэлэг, бэлчээр хариуцсан мэргэжилтэн, малчдын хоршоодын дарга болон гишүүдтэй уулзаж ярилцан мэдээлэл цуглуулав. Түүнчлэн ноолуураа самнан, орон нутаг³ борлуулж буй малчин өрхүүдээр орж тэднээс ярилцлага авав. Орон нутгийнхантай уулзах үед олон улсын 3 зөвлөх урьдчилан бэлтгэсэн санал асуулгын дагуу Бурмаагийн орчуулгын тусламжтайгаар ярилцлага өрнүүлэх замаар мэдээлэл цуглуулж байв. Асуултын хатуу дараалал барилгүйгээр ярилцагчийн хариулт, ярианы нөхцөл байдлыг дагуулан харилцан ярилцах хэлбэрээр судалгааг хийв. Ингэснээр бид Монгол⁴ орны өргөн уудам бүс нутгийн ялгаа нь ноолуур үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлдөг, үйлдвэрлэгчдэд тулгардаг асуудлууд, зах зээл, малчдад тулгардаг бэрхшээлүүдийн талаар бодит мэдээлэл олох боломжтой болсон юм.

³ Нүүдэлчин Монголчуудын модон арагт, эсгий бүрээстэй, зөөж барих боломжтой орон сууц. Заримдаа Англи хэл уруу орчуулахдаа Түрэг хэлний “юрт” гэсэн үгийг ашигласан байдаг.

⁴ Малчдын амжиргаа нь доогуур, ноолуурын чанар нь муу гэгддэг баруун бүсэд ажиллах боломж томилолтын хугацаанд гараагүй. Монголын баруун бүсийн ноолуур үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг бид судалгааны материал, холбогдох тайлан мэдээнээс авав.

Гэсэн хэдий ч гурван шинжилгээг нэг уулзалтад багтаахад хүндрэлтэй байсан төдийгүй хоршооны даргын зааж өгсөн малчдаас ярилцлага авсан нь хоршооны гишүүн биш хэдий ч мал аж ахуйгаа амжилттай авч яваа сайн малчдыг хамруулах боломжийг хязгаарласан байж болох юм. Гэхдээ хээрийн судалгаа нь бидний уншиж танилцсан холбогдох тайлан, судалгааны бүтээлээс олж авсан ойлголтыг улам баяжуулж, илүү гүнзгий дүн шинжилгээ хийх боломж олгосон юм.

Хоёр дахь удаагийн томилолтоор судалгааны багийнхан ноолуурын боловсруулах үйлдвэрлэлийн шатны оролцогч талуудтай уулзаж ярилцлага хийсэн юм. Бид гурван жижиг үйлдвэр, ноос ноолуур үйлдвэрлэгчдийн холбоогоор очиж газар дээр нь танилцаж мэдээлэл авав. Мөн Төв аймгийн Баянхангай сумын ноолуураа хоршоогоор дамжуулахгүйгээр өөрсдөө борлуулдаг малчидтай бүлгийн ярилцлага хийсэн. Үүний үр дүнд бидний судалгааны цаашдын ажилд хэрэг болохуйц үнэтэй мэдээлэл олж авсан. Мөн судалгааны багийнхан Монголын нийгмийн талаарх сүүлийн үеийн эрдэм шинжилгээний судалгаануудтай танилцав. (жишээ нь: Снеат 2018)

2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1 Дэлхийн түүхий ноолуурын боловсруулалт

Дэлхийн ноолуурын үйлдвэрлэлийн дийлэнхийг буюу 90 гаруй хувийг Хятад, Монгол улсаас нийлүүлдэг (Hunter, 2020). Иран, Афганистантай нийлсэн ноолуур үйлдвэрлэл нь Хятад, Монголын дараа дэлхийд 3-т орох байр суурийг эзэлдэг. (Атав болон Хантэр, 2023). Ноолуурын үйлдвэрлэлд Энэтхэг, Балба, Пакистан, Түвд, Казахстан, Тажикстан, Киргиз зэрэг орнууд тодорхой байр суурь эзэлдэг ч эдгээр улсуудын үйлдвэрлэдэг ноолуур тун бага хэмжээг эзэлдэг.

1991 оны байдлаар дэлхийн ноолуур үйлдвэрлэл: Хятад 10,000 тонн, Монгол 3,450 тонн, Иран, Афганистан нийлээд 1,800 тонн, Пакистан 600 тонн, Шинэ Зеланд 150 тонн, Австрали 65 тонн байжээ. Харин 1999 онд Хятадын ноолуурын үйлдвэрлэл 20 мянган тонн, Монголын үйлдвэрлэл 5600 тонн болж тус тус нэмэгджээ (Атав болон Хантэр, 2023).

1990-ээд онд Казахстан, Киргизстан, Тажикистан улсын иргэд түүхий ноолуурыг голчлон Хятад худалдаачдад зарж эхэлсэн. Афганистаны үйлдвэрлэгчид ноолуурын борлуулалтад оролцсон он удаан жилийн түүхтэй. Хятад, Монголоос ялгаатай нь Төв Азийн болон Афганистаны үйлдвэрлэгчид ноолуураа ангилж ялгахгүйгээр, харьцангуй хямд үнээр борлуулдаг. Хэдийгээр дэлхийн зах зээлийн үнэд чанар ихээхэн нөлөөлдөг ч ноолуур худалдан авагчид чанарт нийцсэн ялгаатай үнэ төлдөггүй. Үүний үр дүнд үйлдвэрлэгчид боломжит үнэ цэнийг алддаг. Төв Ази, Афганистаны ямаа нь Хятад, Монголын ноолуурын шиг сайн чанарын, нарийн ноолуур үйлдвэрлэх боломжтой байдаг. (Кервен, МакГрегор, Тойгонбаев, 2009).

Дээр дурдсан орнуудаас гадна Австрали, Шинэ Зеланд, Их Британид ноолуур үйлдвэрлэдэг. Мөн АНУ, Өмнөд Африк болон Европын бусад орнуудад (Испани, Итали, Норвеги) нарийн ширхэгтэй ямаа үржүүлэх оролдлого хийж байв. (Dalton & Franck, 2001).

1980-аад оны сүүл, 1990-ээд оны нийгмийн тогтолцооны өөрчлөлтийн дараа Хятад улс түүхий ноолуурын зах зээлийн томоохон үйлдвэрлэгч төдийгүй томоохон импортлогч болов. 1990-ээд оны эхэн үе хүртэл бараг бүх ноолуурыг Европ, Японы үйлдвэрлэгчид боловсруулж бүтээгдэхүүн болгодог байсан бол одоо Хятадын ноолуур боловсруулагчид

дэлхийн ихэнх ноолууран бүтээгдэхүүнийг боловсруулж байна (Waldron, Brown, & Komarek, 2014).

Өндөр өртөг бүхий ажиллах хүч болон бусад зардлын улмаас түүхий ноолуурыг бүхэлд нь болон хэсэгчлэн боловсруулахад түүхэн оролцоотой байсан Европын улсууд, ялангуяа Итали, Бельги, Их Британи гэх мэт улсууд Европ дахь ноолуур боловсруулах үйлдвэрийн хүрээгээ хумьсан. Харин үр дүнд нь Европ болон АНУ-ын хэд, хэдэн компани Хятад, Монголын ноолуур боловсруулагч нартай хамтарсан үйлдвэрүүд байгуулжээ (Ансари-Ренани, 2014).

Дэлхийн ноолуурын дийлэнхийг аль улсаас гаралтайг үл хамааран БНХАУ-д бүрэн болон хэсэгчлэн боловсруулж байна. Ноолуурын үйлдвэрлэл, боловсруулалтын аль алиных нь хүчирхэг тогтолцоотой Монгол улсад энэ чиг хандлагын өөр систем байдаг (Waldron et al., 2014). Ноолуурын үйлдвэрлэл, боловсруулалтын аль алиных нь хүчирхэг тогтолцоотой Монгол улсад энэ чиг хандлага онцгой боломж олгож буй юм. (Waldron et al., 2014).

2.1.1 Хятад улсын ноолуурын үйлдвэрлэл

Хятадын ноолуурын дийлэнх хувийг баруун хойд мужууд буюу Өвөр Монгол улсын өөртөө засах оронд үйлдвэрлэдэг. Ноолуурыг 6-р сарын эхний хэдэн долоо хоногт ямааны ноолуурыг хяргах, самнах замаар авч, дараа нь самнах боловсруулах үйлдвэрүүдэд хүргүүлдэг. Хятад ноолуурыг⁵ дэлхийд хамгийн нарийн микронтой, хамгийн шилдэг нь гэж үздэг. 1980-аад оны дундуур Хятадын засгийн газар эдийн засгийг чөлөөлснөөр ноолуурын үнэ өссөн ч чанар нь буурч, ноолуур олж авахад нэлээд төвөгтэй болсон (Атав болон Хантэр, 2023). Хүснэгт 2-1-д үндсэн 2 үзүүлэлтээр Хятад, Монгол ноолуурын чанарын харьцуулан харуулав.

Улс	Микроны хэмжээ	Урт (мм)
Хятад ноолуур	13.5 – 14.5	33 - 35
Монгол ноолуур	15.5 – 16.0	38 – 43

Хүснэгт 2-1: Ноолуурын чанар

Эх сурвалж: Ёндонсамбуу, Алтанцэцэг (2003)

Ноолуурын хуваарилалтын өртгийн сүлжээг цэгцтэй болгох, чанарын стандартыг хангах, экспортод гаргаж буй барааны чанарыг сайжруулахад чиглэсэн цогц бодлого, журмыг Хятадын засгийн газар 1989 онд батлан журам хэрэгжүүлсэн. Эдгээр бодлого, журмын дагуу туршилтын байдлаар 1990 онд Ноолуурын гадаад худалдааны төвийг байгуулжээ. Тус төвөөс жил бүр дөрвөн удаа ноолуурын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, экспортын үнэд хязгаарлалт тавьж байв. Түүнчлэн 1991 онд Хятадын засгийн газраас Хятадад үйлдвэрлэсэн бүх нэхмэл бүтээгдэхүүн гарал үүслийг нь баталгаажуулсан шошготой байх ёстой, засгийн газраас олгосон квотын хязгаарлалтыг давж болохгүй, зөвхөн Хятадтай хоёр талын

⁵ Хэдийгээр Хятад ноолуур нарийн микронтой ч ноолуурын урт нь бас чухал параметр юм. Ноолуун үс урт байх тусмаа ээрэхэд илүү тохиромжтой байдаг ба энэ үзүүлэлтээрээ Монгол ноолуур өндөр үнэлэгддэг (Ёндонсамбуу, Алтанцэцэг, 2003).

худалдааны гэрээ байгуулсан орнуудад экспортлох зэрэг хэд хэдэн журмуудыг ажил хэрэг болгосон юм. Хятадын худалдааны бодлого ингэж нээлттэй болсноор ноолуурын зах зээлийн хяналт буурч, хүн бүрд нээлттэй болсон.

Он	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Үйлдвэрлэл (1,000т)	17,307	18,465	18,684	18,844	17,852	15,438	14,964	15,244	15,102	14,649

Хүснэгт 2-2: Хятадын түүхий ноолуурын үйлдвэрлэл, тонн

Эх сурвалж: Хятадын үндэсний статистикийн газар (2023)

Сүүлийн 10 жилийн хугацаанд Хятадын түүхий ноолуурын үйлдвэрлэл буурах хандлага ажиглагдаж байна (Хүснэгт 2-2). 2013 онд Хятадын малчид 17307 тонн ноолуур самнасан хэдий ч 2022 онд зөвхөн 14,649 тонныг цуглуулсан байна.

2.1.2 Монгол улсын ноолуурын үйлдвэрлэл

Монгол Улс дэлхийн ноолуурын салбарын гол нийлүүлэгч, экспортлогч орон ба 1970-аад оны дунд үеэс л ноолуурыг үйлдвэрийн аргаар боловсруулж эхэлжээ. 1945 оноос 1970-аад оны дунд үе хүртэл АНУ түүхий (боловсруулаагүй хэлбэрээр) ноолуурын хамгийн том худалдан авагч байв (Heritage Cashmere, 2003, Атав болон Хантэр, 2023).

1976 онд НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагын (ЮНИДО) туслалцаатайгаар Япон улсаас хамгийн сүүлийн үеийн технологиор тоноглогдсон туршилтын жижиг үйлдвэр ашиглалтад орсноор түүхий ноолуурыг үйлдвэрийн аргаар боловсруулах орчин цагийн үйлдвэрлэлийн үндэс суурь тавигджээ.

Үүний дараа, Японы засгийн газрын буцалтгүй тусламжаар 100 гаруй тонн ямааны ноолуур, 200 тонн тэмээний унгас боловсруулж 68 тонн бөмбөгөн ноолуур, 120 тонн ээрмэл, 400 гаруй ширхэг сүлжмэл үйлдвэрлэх хүчин чадалтай “Говь” үйлдвэрийг байгуулж, ашиглалт оруулжээ. Анхны туршилтын үйлдвэр (хожим Буян компани болсон) болон Говь үйлдвэрийг тус тус амжилттай ашиглалтад оруулсан нь ноолуурын салбарын хөгжилд маш том түлхэц өгсөн. Эхэндээ ноолууран бүтээгдэхүүнийг дэлхийн гуравдагч орнуудад экспортлох зорилготойгоор үйлдвэрлэж байв.

Зах зээлд шилжсэн эхний арван жилд ноолуурын салбарт гадаад (АНУ, Итали, Их Британи, Япон) болон дотоодын хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татсан бөгөөд удирдах ажилтан, мэргэжилтнүүд нь энэ салбарт өрсөлдөхүйцээр бэлтгэгдсэн байна. (Ёндонсамбуу, Алтанцэцэг, 2003).


1990-д онд Монгол улсад ноолуур боловсруулах хоёрхон үйлдвэр байсан бол 2003 он гэхэд энэ тоо 450 болж өсөн анхан шатны болон гүн боловсруулалт хийх үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдсэн юм. Эдгээр үйлдвэр, компанийн 10 орчим хувийг ноолууран түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийдэг Хятадын хөрөнгө оруулалттай жижиг цехүүд эзэлж байв. Үүний зэрэгцээ Хятадын хөрөнгө оруулалттай сүлжмэлийн үйлдвэрүүд олноор байгуулагдан Хятадаас импортолсон ээрмэл утсаар сүлжмэл хувцас үйлдвэрлэн “Монголд үйлдвэрлэв” гэсэн шошго хадан АНУ уруу экспортод гаргаж байлаа. Тухайн үед АНУ-аас Монголд олгосон квотыг ашиглах зорилготой байсан юм (Ёндонсамбуу, Алтанцэцэг, 2003)

Монгол орны төвийн бүсэд ноолуур самнах хугацаа нь Хятад улсын ноолуур самнах хугацаатай давхацдаг. Монгол ямааны ноолуурын ширхэгт нь Хятад ямааны ноолуурыг бодвол бүдүүн ч уртлаг, атираа сайтай байдаг. (de Weijer, 2007). Хаврын дунд болон сүүл сараас эхлэн цаг агаар дулаарах үед ямаагаа самнана. Үүний дараа нэгдсэн байдлаар цуглуулан Оросын агентуудаар дамжуулан дэлхийн зах зээлд нийлүүлдэг байв. АНУ хамгийн том худалдан авагч байжээ (Атав болон Хантэр, 2023).

Он	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Үйлдвэрлэл	5,472	6,326	7,010	7,727	8,053	8,591	9,330	9,967	9,972	10,764	10,092	9,672

Хүснэгт 2-3: Монголын түүхий ноолуурын үйлдвэрлэл, тонн
Эх сурвалж: ҮСХ (2023b)

Хүснэгт 2-3 болон Зураг 2-1-т Монголын ноолуур үйлдвэрлэлийн нийт хэмжээг харуулав. Хүснэгтэд харуулсан тооноос харвал 2011 онд 5.4 мянган тонн ноолуур үйлдвэрлэжээ. Түүнээс хойш нийт үйлдвэрлэлийн хэмжээ бараг хоёр дахин нэмэгдсэн байна. Хамгийн өндөр үйлдвэрлэл нь 2020 онд 10.7 мянган тоннд хүрсэн гэж бүртгэгджээ. Улмаар үйлдвэрлэл бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна. Монгол Улсын статистикийн үндэсний хорооны мэдээгээр 2022 онд 9672 тонн түүхий ноолуур үйлдвэрлэсэн байна. Монгол, Хятадын үйлдвэрлэлийг харьцуулж үзвэл 2016-2022 оны хооронд Хятадын ноолуурын үйлдвэрлэл 18,800 тонноос 14,600 орчим тонн болж буурчээ гэж дүгнэж болно. БНХАУ-ын ноолуурын үйлдвэрлэлийн буурах хандлага, харин Монгол улсын ноолуурын үйлдвэрлэлийн өсөлтийн чиг хандлага нь дэлхийн хэмжээнд Монголын ноолуурын эзлэх хувь 26-аас 36 болж 10 пунктээр нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлсэн байна.



Зураг 2-1: Дэлхийн түүхий ноолуурын үйлдвэрлэлийн хөгжил
Эх сурвалж: Хантэр, Хятадын үндэсний статистикийн хороо, Монголын ҮСХ-ны тоон мэдээлэл дээр үндэслэн тооцоолов.

Ерөнхийдөө ноолуурын 4 үндсэн өнгө байдаг. (Зураг 2-2):

Шаргал ба улаавтар (бор)

Шаргал, улаавтар ямаа нь говь, хээрийн бүс нутгийн бэлчээрийн нөхцөлд сайн зохицсон байдаг. Ноолуур нь цайвар өнгөтэй, бага зэрэг улбар шар өнгөтэй бөгөөд уян хатан, торгомсог байдлаараа ялгардаг.

Цагаан

Наран эвэртэй, тод хар нүдтэй, голдуу дунд зэргийн биетэй, цэвэр цагаан ямаа нь говь цөлийн хэт халуун, эрс тэс уур амьсгалд тэсвэртэй, дасан зохицсон байдаг.

Хөх саарал (цайвар)

Хөх саарал ямаа бол маш ховор юм. Монгол орны зөвхөн баруун бүсэд байдаг, нийт ямаан тоо, толгойн дөнгөж 2 хувийг эзэлдэг, тун ховор олдоцтой маш дулаан ноолууртай.

Хар саарал (буурал)

Хар саарал ямаа нь Монгол орны өндөр уулс, ойт хээрийн бүс нутагт бэлчээрлэдэг ба сайн чанарын урт ширхэгт ноолуур гаргадаг.



Зураг 2-2: Монгол ноолуурын үндсэн өнгөнүүд, Говь ХХК-ний үзэсгэлэнгийн танхим УЛААНБААТАР. (Эх сурвалж: Зохиогчид)

#	Чанарын зэрэг	Дундаж микроны диаметр	Дундаж урт мм	Бүдүүн ширхэгтийн эзлэх хувь %	Хогт хольц, хаг %	Тослогийн хэмжээ, %
					(-аас ихгүй)	(-ээс ихгүй)
А. Ялгаж боловсруулсан ноолуур						
1	Монголын хаан ширхэгт нарийн	12.0-15.5	36	0.2	0.2	0.8
2	Нарийн	15.51-16.2	38	0.25	0.25	0.8
3	I	16.21-16.8	40	0.3	0.3	0.8
4	II	16.81-17.50	40	0.3	0.3	0.8
5	III	17.51-19.0	40	0.3	0.3	0.8

Хүснэгт 2-4: Монгол ноолуурын чанарын үзүүлэлт

Эх сурвалж: МСХЗГ (2015)

Стандарт хэмжил зүйн газар (2015) ноолуурын чанарыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Самнасан ноолуурын чийглэгийн хэвийн хэмжээ 16% байна. Ноолуурын чанарын таван ангиллыг Хүснэгт 2-4-д харуулав. Монголын хамгийн тансаг зэрэглэлийн нарийн ноолуурт бүдүүн ширхэгт болон завсрын үсний агууламж маш бага байдаг.

2.2 Ноолуурын чиглэлийн ямаа

Ноолуурын чиглэлийн ямаа нь ихэвчлэн 7 хүртэл насалдаг, хүйтэн цаг агаар, болон өндөрлөг газарт дасан зохицсон байдаг. Ерөнхийдөө Ангор ямаанаас биеэр жижиг боловч үүлдэр угсаа, нутагшиж буй бүс нутгаасаа хамаарч өөр өөр байдаг. Ихэвчлэн 60-80 см өндөртэй байдаг ба хамгийн таатай бүсэд эр ямаа 60 кг, эм ямаа 40 кг орчим жинтэй байдаг. Говь нутгийн ямаа бие жижигтэй байдгийг тэмдэглэх нь зүйтэй (Dalton & Franck, 2001). Монгол ямаа нь сэргэлэн, цовоо, чийрэг бөгөөд хүйтнийг тэсвэрлэх чадвар сайтай. (Alvigni, 1979).

Ямааны үүлдэр угсааг Хүнс хөдөө аж ахуйн яамнаас баталдаг. Хүснэгт 2-5-д хүлээн зөвшөөрөгдсөн ямааны үүлдэр, тэдгээрийн үндсэн шинж чанарыг оруулав. (тарган эм ямааны жишгээр)

Эм ямааны үүлдэр	Жин кг		Ноолуур		
	5 сар	10 сар	Грамм	Диаметр микрон	Урт, см
Залаа Жинст Идрэн	28	40	300	≥16.0	≤5.0
Баяндэлгэрийн улаан ямаа	33	45	480	≥16.0	≤5.0
Алтайн улаан ямаа	38	48	420	≥15.0	≤5.0
Завханы буурал	33	45	330	≥15.0	≤5.0
Монгол ямаа	30	40	250	≥15.0	≤5.0
Уулын бор ямаа	29	42	600	≥18.0	8
Говь гурван сайхан	28	39	450	≥18.0	8
Өлгий улаан ямаа	30	45	320	≥14.5	≤5.0
Эрчмийн хар ямаа	31	45	285	≥15.0	≤5.0

Хүснэгт 2-5: Монгол ямааны үүлдэр ба тэдгээрийн гол үзүүлэлтүүд (тарга тэвээрэг сайтай эм ямаагаар жишиг⁶)


Эх сурвалж: (Мал эмнэлэг, үржлийн газар, 2017b)

Растеллийн (Restall 2001) судалгаанаас үзвэл нутгийн уугуул ямаа байгалиасаа олон өнгө бүхий нарийн ширхэгт ноолуурыг гаргадаг бөгөөд мал үржүүлгийн зохистой бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэн үүлдэр, омог бүрийн ноолуурын онцлог, нарийн голчийг хадгалахын зэрэгцээ нэг ямаанаас авах гарцыг нэмэгдүүлэх явдал чухал юм. Ингэснээр тэдний байгаль, цаг ууртаа дасан зохицох, тэсвэрлэх чадварыг хадгалж үлдэх боломжтой юм.

Монгол улсын малын удмын сангийн мэдээллээр (2017б) Монгол ямаа нь Монгол Улсын

⁶ Ухна болон ишигний ноолуурын микроны диаметрийг харуулав. Төл малын ноолуур илүү нарийн, зөөлөн байдаг.

нутаг дэвсгэрт хамгийн их тархсан мал юм (Зураг 2-3).



Зураг 2-3:

Монгол ямааны тархац

Эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар, 2017b

Ямаанаас зөвхөн ноолуур төдийгүй сүүг нь ашиглан үйлдвэрлэл эрхлэх боломжтой. Монгол ямаан нь Төв Азийн байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлтэй бэлчээрт дасан зохицсон байдаг. Монгол ямаа 1,5 нас хүртлээ эрчимтэй өсөж эхийнхээ биеийн жингийн 73,8%-д хүрдэг, цаашлаад өсөлт нь 4,5 нас хүртэл үргэлжилж, насанд хүрсэн ямааны амьдын жингийн 97,4%-д хүрдэг. Монгол ямаа зун, намрын улиралд тарга хүчээ дээд зэргээр авч, өвөл, хаврын улиралд тарга хүчнийхээ 25-27%-ийг хасаж онд ордог.

Монгол нутгийн ямаа нь бүс нутгийн онцлогоос шалтгаалан өөр өөр өнгөтэй байдаг. 1958 оноос хойш нутгийн ямааг бусад үүлдрээр эрлийзжүүлснээр 60 гаруй хувь нь хар зүсмийн болсон (Зураг 2-4). Оросын малын үүлдэр угсааг сайжруулах бодлогын үр дүнд нутгийн ямаа болон тэдгээрийн үр төл үүлдэрлэг болсон. Үүлдэр нь олон төрөл бөгөөд гарц ихтэй ч бүдүүн ширхэгт (17-22 микрон) ноолуур өгдөг. (Ресталл, 2001). Харин сүүлийн жилүүдэд ноолуурын чиглэлийн улаан ямааны үүлдрийг түлхүү ашиглаж байна. Ингэснээр монгол ямааны зүс өөрчлөгдөж, цайвар ноолуурын үйлдвэрлэл нэмэгдэж байна.



Зураг 2-4: Монгол хар ямаа
Эх сурвалж: Мал эмнэлэг, үржлтийн газар(2017А)

Монгол ямааны хөдөө аж ахуй, биологийн ашиг туст шинж чанарыг сайжруулан, хөгжүүлэх анхаарах нь чухал. Үүний тулд “өөрсдөөр нь” гэсэн зарчим баримтлан нутагшсан үржил шимт сайн үүлдрийн ямаагаар үржил селекцийн ажлыг хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй. Үүний тулд сайн үүлдрийн ямааны бүртгэл, гарал үүслийг баталгаажуулах ажлыг сайжруулж үржүүлэг селекцийг чангаруулах хэрэгтэй.

Хүснэгт 2-6-д харуулснаар 1993-2002 оны хооронд Монгол ноолуурын голч (бүдүүн) 2 микроноор нэмэгдсэн байна. Үүнийг гол шалтгаан нь гарц ихтэй (Говь гурван сайхан, Уулын бор)-ны үржүүлэг селекци газраа авснаар болж холимог үүлдрийн ямааны эзлэх хувь хэмжээ ихэссэн нь ноолуурын голч бүдүүрч байна. Мөн ямааны сүргийн бүтцэд нас бие гүйцсэн эр ямааны тоо толгой нэмэгдсэн.

	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Дундаж микро	15.4	15.5	16.0	16.2	16.1	16.6	16.7	17.0	17.4	17.1

Хүснэгт 2-6: Говь ХХК-д нийлүүлсэн ноолуурын дундаж микро
Эх сурвалж: Ёндонсамбуу, Алтанцэцэг (2003)

2.2.1 Монгол улсын нийт мал болон ямаан тоо толгой

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг буюу нэгдэл нийгмийн үед малын тоо, толгойг бэлчээрийн даацад тааруулж барьдаг байсан. 1970-1990 оны хооронд нийт малын тоо харьцангуй тогтвортой байсныг Хүснэгт 2-7-оос харна уу.

	1970	%	1990	%	2000	%	2010	%	2022	%
Адуу	2,318	9%	2,262	8%	2,661	8%	1,920	6%	4,821	7%
Үхэр	2,108	9%	2,849	10%	3,098	10%	2,176	6%	5,513	8%
Тэмээ	633	3%	538	2%	323	1%	270	1%	470	1%
Хонь	13,312	54%	15,083	54%	13,876	43%	14,480	42%	32,747	45%
Ямаа	4,204	17%	5,128	18%	10,270	32%	13,882	40%	27,569	38%
Нийт	24,545	100%	27,849	100%	32,227	100%	34,740	100%	73,142	100%

Хүснэгт 2-7: Малын тооны өсөлт (мянга), Монгол улс (1970 – 2022)
Эх сурвалж: ҮСХ, 2023

1970 онд Монгол Улс 24.5 сая малтай байсан бөгөөд хонь нийт малын 54 хувийг эзэлж байв. 1970-аад оны үед Монголд зөвхөн дөрвөн сая ямаа тоологдсон байдаг. 1990 он гэхэд нийт малын тоо 27.8 сая болж, хонь 54%, ямааны тоо толгой 5 саяас ялимгүй давсан байв. Малын нийт тоо толгойг 1990 оноос өмнө төрөөс зохицуулж байсан тул малын тоо толгой харьцангуй тогтвортой байв.


Мал аж ахуйн салбар Монгол улсын нийгэм соёл, эдийн засагт түүхэн байр суурь эзэлдэг хэдий ч гол нөлөө нь буурсаар байна. ЗХУ-ын үед газар тариалан, тэр дундаа үр тариаг хөгжүүлэх замаар хөдөө аж ахуй, газар тариалан хосолсон эдийн засгийг хөгжүүлэхийн тулд ихээхэн хүчин чармайлт гаргаж байсан (Goodland,

Sheehy, & Shine, 2009).

1990 онд социалист нийгэм нуран унасны дараа Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжиж, газар тариалан, мал аж ахуйн салбарт томоохон өөрчлөлт гарсан. Хөдөөгийн нэгдэл, улсын фермийн тогтолцоо тарж, уламжлалт мал маллах, амьжиргаагаа залгуулах хэлбэр уруу тодорхой хэмжээнд буцсан гэж болно. Энэ шилжилтийн эхэн үеийг маш сайн баримтжуулсан байдаг (Nixson & Walters, 2006). Төвлөрсөн тогтолцооноос зах зээлийн чөлөөт эдийн засагт шилжсэнээр хөдөөгийн нэгдэл, фермийн тогтсон дэд бүтэц нуран унаж, мал аж ахуйн үйлдвэрлэл уламжлалт хэлбэртээ эргэн шилжсэн юм. Зах зээлд шилжсэнээс хойш нийт ямааны тоо огцом өссөн юм. 2002 оноос хойш ямаа, хонины тоо тэнцүү болж, энэ хандлага 2015 он хүртэл үргэлжилсэн юм. 2015 оноос хойш хонин толгой ямааныхаас ялимгүй их байсан. Ямаа болон хонин тоо толгойн зохистой харьцааг барих нь чухал. Ямаа өвлийн хүйтэнд илүү бээрэг байдаг. Иймээс олон малчид өвөлжилт хүндэрсэн үед ямаан сүргээ онд өнтэй оруулахын тулд хонь тэжээдэг.

Дэлхийн банкны тайланд дурдсанаар зах зээлийн шилжилтийн үед мал аж ахуйн уламжлалт хэвшилд эргэн шилжсэн нь Монгол Улсын өнөөгийн мал аж ахуйн үйлдвэрлэл нь уламжлалт “нүүдлийн мал аж ахуйн” үргэлжлэл гэсэн буруу ойлголтыг түгээхэд хүргэсэн. Харин одоогийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн загвар нь: 1) социализмын нэгдлийн дэд бүтцийн задрал, 2) мал хувьчлал, 3) уламжлалт нүүдлийн болон мал аж ахуйг алтернатив байдлаар хөгжүүлэх боломж хязгаарлагдмал, 4) төрөөс үзүүлэх дэмжлэг багассан, 5) мал аж ахуй эрхлэгчид аажмаар зах зээлийн эдийн засагт ууссан зэрэг олон хүчин зүйлсийн үр дүнд бий болсон юм.

2022 онд Монгол Улс нийт 73 сая толгой мал тоолуулснаас 45 хувийг хонь, 38 хувийг ямаа эзэлж байна. Мөн 4.8 сая адуу, 5.5 сая үхэр, 470 мянган тэмээ тоологдсон байна.




Зураг 2-5: Мал тооллогын дүн 1970 - 2022

Эх сурвалж:ҮСХ, 2023b

Зураг 2-5-д үзүүлсэн хугацаанд малын тоо толгойд хоёр мэдэгдэхүйц өөрчлөлт

гарсан байна. Энэ нь зудын шууд үр нөлөө бөгөөд Зуд⁷ гэдэг нь Монгол улсад их хэмжээний цас орж энэ нь хэт хүйтрэлттэй зэрэгцсэн цаг агаарын гамшигт үзэгдлийг тодорхойлоход хэрэглэгддэг нэр томъёо юм. Их хэмжээний цас унаж, хүйтэрснээс малын бэлчээр цасанд дарагдаж, идэш тэжээлийн хомсдол үүссэнээс болж мал хорогддог. Монгол улсад хоёр том зуд нүүрлэсэн бөгөөд эхнийх нь 2002 оны өвөл, хоёр дахь нь 2009 оны өвөл тохиолдсон зуднаар олон тооны мал тэр дундаа ямаа, хонь их хэмжээгээр хорогдсон. Хамгийн сүүлд 2021 онд Монголд зуд болсон хэдий ч урьд өмнөх шиг олон тооны мал хорогдоогүй.

Доорх хүснэгтэд үзүүлсэн тоон шинжилгээг хийхийн тулд бид Монгол орныг баруун, хангай, төв (Улаанбаатарыг оруулаад) болон зүүн гэсэн үндсэн 4 бүсэд хуваасан. Бүс нутгийн хуваалтыг Зураг 2-6-д аймаг аймгаар нь харуулсан.



Зураг 2-6: Монголын бүс нутгийн газрын зураг
Эх сурвалж: (Xu, Zhang, Kinnucan, & Chen, 2022)

Нийт	1989	2022	Ялгаа	Эзлэх %
Төвийн бүс +УБ	5,588	17,414	11,826	212%
Зүүн бүс	3,344	13,064	9,720	291%
Хангайн бүс	7,584	24,513	16,929	223%
Баруун бүс	8,159	16,131	7,972	98%
Монгол ямаа	4,959	27,569	22,610	456%
Нийт	24,675	71,121	46,446	188%


Хүснэгт 2-8 Малын тоо толгойг бүс, бүслүүрээр харуулав, 1989-2022
Эх сурвалж: ҮСХ, 2023b,

Хүснэгт 2-8-д 1989 болон 2022 оны малын тоог (мянгаар) бүс тус бүрээр харуулсан бөгөөд тоон өөрчлөлтийг хувиар нарийвчлан харуулсан болно. Малын нийт тоо толгой бараг гурав дахин өссөнийг харж болно. Хамгийн их өсөлт нь зүүн бүсэд гарсан бөгөөд бараг дөрөв дахин өссөн байна.

Ямааны тоо толгой хурдацтай өссөн нь анхаарал татаж байгаа бөгөөд 1989 онд Монгол улс 6.9 сая ямаатай байсан бол 2022 онд 29.5 сая болсон байна. Ямаа нь ургамлын цэцэг үрээр ихэвчлэн хооллоог тул бэлчээрт сөрөг нөлөөтэй үзүүлдэг. Ноолуурын зах зээлийн

⁷ Хэдийгээр хэт хүйтрэл, их цастай гамшигт үзэгдлийг зуд гэх боловч зун нь ган болсны улмаас мал идэш хоолгой болохыг харын зуд гэж бас нэрлэдэг.

үнэ өндөр байгаа нь малчдын ямаагаа өсгөх сонирхлыг нэмэгдүүлж, улмаар бэлчээрийн доройтолд хүргэж байна (Мөнхзул нар, 2021). Орхон аймагт ямааны тоо толгойн эзлэх хувь харьцангуй өндөр байгаа төдийгүй хамгийн их өсөлт буюу 25 дахин өссөн байна. (Зураг 2-7). Мөн Хөвсгөл аймагт ямааны тоо бараг хоёр саяар буюу хамгийн их өссөн байна.



Зураг 2-7: Монголын аймгуудын ямааны тоо толгойн өөрчлөлт: Хоорондын харьцуулалт 1989 ба 2022

Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2023В)

2.3 Монгол ноолуурын үйлдвэрлэл

Ноолуурын ямаа нь гадуураа бүдүүн ширхэгтэй ноосоор бүрхэгдсэн байх бөгөөд түүний дотор талаар зөөлөн, нарийн үс байдаг. Ноолуурын чиглэлийн ямаа нь бусад энгийн ямаатай харьцуулбал ноолуурын гарц өндөр байдаг. (Атав болон Хантэр, 2023; Dellal et al., 2010).

Ишгийг 6 сартай болмогц самнаж эхэлдэг. Хавар дулаарч ноолуур нь хөөрч ирсэн үед самнадаг. Ноолуур нь хүзүүнээсээ эхэлж хөөрөөд нуруу дагуу дамнан ууц хүртэл хөөрч гүйцэхэд 5-6 долоон хоног болдог. (Ансари-Ренани, Ричковский, Мюллэр, Моради, 2013). Тиймээс нэг ямааг хэд хэдэн удаа самнах нь илүү сайн байдаг. (Antonini et al. 2016) Бүх ямааг нэг хугацаанд зэрэг самнаж, нас, зүс ялгаатай ямааны ноолуурыг нэг уутанд хольж савлах зэрэг нь ноолуурын чанарт нөлөөлдөг. Залуу ямааг эхэлж самнаад, дараа нь нас гүйцсэн ямааг самнах байдлаар хугацааг зохицуулах нь зөв. Хүзүү цээжнээс самнасан ноолуурыг биеийн бусад хэсгээс самнасан ноолуураас тусад нь савлах нь зүйтэй. Ингэвэл хог шороо багатай байдаг.

2.3.1 Монгол малчид

Малчид бол ноолуурын өртгийн сүлжээний хамгийн чухал тоглогчид юм. Ямаа бол малчин өрхийн сүргийн зөвхөн нэг хэсэг (зуугаас хэдэн мянга хүртэл) бөгөөд бүс нутгаас шалтгаалан хонь, үхэр, адуу, тэмээ, сарлаг гэх мэт бусад таван хошуу малтай нэгдэн сүрэг бүрдүүлдэг.

1990-оны эхээр нэгдэл тарж, малыг хувьчилснаас хойш мал аж ахуйн тогтолцоо, малчин өрхийн түвшинд маш том өөрчлөлт орсон юм. Бэлчээр газар улсын өмч хэвээр үлдсэн ч малыг хувьчилж, төрийн бэлчээрийн зохицуулалт алдагдаж, малчдад чиглэсэн нийгмийн үйлчилгээнүүд зогссон юм. Удирдан зохицуулах байгууллагууд байхгүй болж малчид

зөвхөн өөрсдөө мал, бэлчээрээ зохицуулах шаардлагатай болсон юм. Төрийн өмчит олон үйлдвэр, аж ахуйн нэгж хаалгаа барьж, олон хүн ажилгүй болсон учраас, хөдөө гарч малчин болцгоов.

Ямаа нь бэлчээрийн ургамлаар хооллох бөгөөд таримал болон хүчит нэмэлт тэжээл бараг хэрэглэдэггүй. Малчид бэлчээрийн соргогийг даган жилийн дөрвөн улиралд нүүдэллэн амьдрана. Өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа гэсэн хоорондоо бэлчээрийн заагтай 4 улирлын нутагтай.

Ямаа маллагаа ч энэ уламжлалт 4 улирлын хэмнэлийг дагана. Хавар бол мал төллөхийн зэрэгцээ, ямаа самнаж, хонио ноосолдог чухал хугацаа юм. Зун бэлчээр сэргэж, мал тарга хүчээ авах гол улирал юм. Харин намар бол тариаланчид ургацаа хурааж, өвлийн бэлтгэлээ хийнэ. Өвөл бол хамгийн хүнд улирал бөгөөд хэрэв зуд турхан болбол мал сүрэг эндэх эрсдэл өндөр болдог.

Ямаа өвлийн улиралд туурайгаараа цас малтан өвс олж идэх чадвартай амьтан. Харин цас их орж, зуд болох үед ингэж өвс олж идэх боломжгүй болдог. Тиймээс малчид өвөлд зориулж хадлан тэжээл бэлдэж авдаг. Нэг малд өдөрт 300 грамм өвс, 150 грамм ногоон тэжээл ногдохоор тооцдог. Гэвч ихэнх малчин өрх хангалттай хэмжээн бэлтгэл хангаж чаддаггүй. Тиймээс зөвхөн дор орж, турж эцсэн малаа нэмэлт өвс, тэжээлээр борддог.

Өвөлжилт хүндрэх нь малчдын эмзэг байдлыг улам нэмэгдүүлдэг. Олон малчид санхүүгийн боломжоосоо шалтгаалан өвс тэжээлээ хангалттай бэлдэж чаддаггүй. Тиймээс зуд болоход өвс, тэжээлгүйгээс болж мал ихээр хорогддог. Засгийн газар, ОУ-ын тусламжийн байгууллага, болон бусад иргэн, аж ахуйн нэгжүүд өвөлжилт хүндэрсэн үед өвс, тэжээлийн тусламж үзүүлэх нь бий. Засгийн газар улсын хэмжээний өвсний нөөцийн сан байгуулж, шаардлагатай тохиолдолд хөнгөлөлттэй үнээр олгодог. 2022 онд 25 кг-ын савлагаатай улаан буудайн хивэг 19 мянган төгрөг орчим байсан. Өвсний үнэ бүс нутгуудад харилцан адилгүй байдаг ба зүүн бүсийн аймгуудад хамгийн хямд (нэг боодол өвс нь 5000 орчим төгрөг, 20 кг орчим жинтэй) байдаг. Төв болон хангайн бүсэд нэг боодол өвс 8000-9000 төгрөгийн үнэтэй бөгөөд ингэж үнэ өсөхөд тээврийн зардал ихээхэн нөлөөлдөг. Хадлангийн талбай багатай баруун бүсэд өвс хамгийн үнэтэй байдаг.

Малын тоо толгой хурдацтай өсөж буй хэдий ч мал эмнэлгийн тусламж үйлчилгээ хүртээмжгүй, чанар муутай байсаар байна. Зарим мал эмнэлгийн үйлчилгээ тухайлбал эр малыг хөнгөлж засах ажлыг малчид өөрсдөө хийх боломжтой боловч мэргэшсэн малын эмчийн мэдлэг шаардах үйлчилгээ олон бий. Малын зарим халдварт өвчний вакцинжуулалтыг төрөөс үнэ төлбөргүй хийдэг ба бусад мал эмнэлгийн үйлчилгээний төлбөрийг малчид өөрсдөө хариуцах ёстой. Түүнчлэн малын паразит, шимэгчдээс хамгаалахын тулд хаврын угаалга хийх ёстой. Хуучин цагт мал угаалгын суурин ванн бэлдэн, угаалгын бодистой усанд малыг оруулж гаргадаг байсан бол сүүлийн үед тусгай шүршүүрийн машин ашиглан угааж байна. Хэрэв сум бүр мал угаах явуулын шүршүүртэй бол мал угаалгын явцыг ихээхэн хөнгөвчилж, малчид заавал малаа туун сумын төв орж угаалгах шаардлагагүй болно. Сумын төв рүү мал явах шаардлагагүй болж байна. Угаах зардал нь ямаа тутамд 200 төгрөг байна.

Ноолуурыг самнах, хяргах эсвэл хөөрсөн хэсгийг зулгаах аргаар авдаг. Монголд ноолуурыг

голчлон самнаж цуглуулдаг бөгөөд самнахаа ямаа бүрэн хөөрсөн үед нас, насаар нь нь богино хугацаанд самнах явдал юм. Ямаа самнах ажил маш их хөдөлмөр шаарддаг тул нутгийн хүмүүст ажлын хөлс өгч туслуулдаг тул малчид нэг дор бөөнд нь самнахыг илүүд үздэг. Ямааг самнасны дараа ноолуурыг бараг тэр даруй зардаг.

Ноолуурын гарц их байхыг бодвол ямааг өвлийн өвлийн сүүлээр самнах нь дээр хэдий ч энэ үед эцэнхий туранхай ямаа даарч өлддөг тул бага зэргийн үс ноолуур үлдээж самнах нь зүйтэй. (Ансари-Ренани нар, 2013). Малчидтай ярилцах үед хүйтний эрч хариагүй үед ямаагаа эрт самнах юм бол ямаа даарч осгох эрсдэлтэй тухай ярьж байв.

Бүс	Аймаг	Самнах хугацаа	Түүхий ноолуурын үнэ ₮	Боловсруулсан түүхий ноолуур (т)	Ямаатай малчин өрхийн тоо
Зүүн бүс	Дорнод	3 сар, 4 сар	128,500	299.14	7.798
Зүүн бүс	Хэнтий	3 сар, 4 сар	119,000	482.38	10.618
Зүүн бүс	Сүхбаатар	3 сар, 4 сар	131,000	464.23	9.758
Төвийн бүс	Дархан-Уул	4 сар, 5 сар	140,000	39.66	1.861
Төвийн бүс	Дорноговь	4 сар, 5 сар	105,000	471.07	5.015
Төвийн бүс	Дундговь	4 сар, 5 сар	96,250	594.33	7.608
Төвийн бүс	Говь-сүмбэр	4 сар, 5 сар	105,000	63.3	0.993
Төвийн бүс	Өмнөговь	4 сар, 5 сар	92,908	771.74	6.964
Төвийн бүс	Сэлэнгэ	4 сар, 5 сар	100,000	171.45	9.030
Төвийн бүс	Төв	4 сар, 5 сар	94,000	459.34	14.753
Улаанбаатар	Улаанбаатар	4 сар, 5 сар	102,083	40.36	4.461
Хангайн бүс	Архангай	4 сар, 5 сар	107,500	436.22	16.918
Хангайн бүс	Баянхонгор	4 сар, 5 сар	111,250	643.53	13.006
Хангайн бүс	Булган	4 сар, 5 сар	95,000	328.96	9.647
Хангайн бүс	Хөвсгөл	4 сар, 5 сар	105,000	748.67	18.671
Хангайн бүс	Орхон	4 сар, 5 сар	87,500	14.2	1.150
Хангайн бүс	Өвөрхангай	4 сар, 5 сар	104,500	605.56	16.807
Баруун бүс	Баян-Өлгий	5 сар, 6 сар	87,500	375.36	13.448
Баруун бүс	Говь-Алтай	5 сар, 6 сар	93,000	783.49	9.169
Баруун бүс	Ховд	5 сар, 6 сар	93,000	699.53	10.565
Баруун бүс	Увс	5 сар, 6 сар	95,000	672.38	11.488
Баруун бүс	Завхан	5 сар, 6 сар	93,750	506.66	11.819

Хүснэгт 2-9: Түүхий ноолуур бэлтгэл бүсүүдээр, үнийн ялгаа, 2022.

Эх сурвалж: ҮСХ, 2023В

Ямаа самнах ажил зүүн бүсэд 3 сараас эхэлж баруун бүсэд 6 сард дуусдаг. Энэ нь бүсийн цаг агаарын ялгаатай байдал буюу зүүн бүсэд баруун бүстэй харьцуулахад эрт дулаардагтай холбоотой юм. Ноолуурын үнэд самнах хугацаа бас чухал нөлөөтэй байдаг. Эрт самнахад ноолуур нь илүү чанартай байх ба зах зээл ноолуурын эрэлт их байдаг тул үнэ нь ч өндөр байдаг. Баруун аймгуудад дулаарсан хойно буюу ноолуурын хялгас үс


хөдөлсөн хойно самнадаг учир хялгас, хог, элс шороо ихтэй байдаг ба үнэ нь ч доогуур байдаг. 2022 онд ноолуурын үнэ төвийн бүсэд буюу Дархан хотод хамгийн өндөр(140,000 төг), хамгийн доод үнэ баруун бүсэд буюу Баян-Өлгий аймагт (87,500 төг) байжээ. (Хүснэгт 2-9).

Бүсүүдийн ноолуурын дундаж үнэ, 2022 он:


- Зүүн бүс (125,753 төг)
- Хангайн бүс (105,458 төг)
- Төвийн бүс part (96,080 төг)
- Баруун бүс part (92,888 төг)

Монгол орны зүүн бүс нь соргог бэлчээртэй, хадлан тэжээлийн нөөц боломж сайтай байдаг нь ноолуурын гарц, чанарт бас нөлөөлдөг. Судалгаанаас үзвэл ноолуурын ямааг хээлийн сүүлийн сарууд болон төл малыг эхний 10 сард чанартай өвс, тэжээлээр тэжээх нь ноолуурын гарц, чанарт эерэг нөлөөтэй байдаг байна. Дээр дурдсан хугацаанд хоол тэжээлийн дутагдалтай байх нь ямааны насан туршийн ноолуурын гарц болон чанарт муугаар нөлөөлдөг аж. (Ансар-Ренани 2013; Атав болон Хантэр, 2023).

Зураг 2-8-аас малчид өрхийн орлогоо нэмэгдүүлэх үүднээс малын тоогоо өсгөдөг болохыг харж болно. Мал олонтой малчид илүү орлого олох боломжтой байдаг. Тэр дундаа ямаан толгой олон байхын хирээр өрхийн орлого нэмэгддэг. Үүнийг Зураг 2-9-өөс харж болно. Гэхдээ олон малтай байх хирээр ноолуурын орлогоос хараат байх нь бага гэдгийг харж болно. Учир нь мал олонтой айл малын бусад түүхий эд, бүтээгдэхүүнээс (мах, сүү, ноос гм) нэмэлт орлого олох боломжтой байдаг. 2021 оны мал тооллогын дүнгээс харвал мал цөөтэй өрхийн орлогын 56%-г ноолуур бүрдүүлж байгаа бол мал олонтой айлын орлогын зөвхөн 43%-г бүрдүүлж байна. Зураг 2-8-т улбар шараар өрхийн малын тоо цөөн боловч орлого өндөр байгааг онцлон харуулсан байгаа. Тухайн жилд малчид малаа (бараг 570-1000 тоо толгойг) олноор нь борлуулсан нь өрхийн орлогын өсөлтөд нөлөө үзүүлжээ.



Зураг 2-8: Малын тоо болон өрхийн орлогын хоорондын хамаарал, Монгол улс, 2021
Эх сурвалж: 2021 оны мал тооллогод үндэслэв (ҮСХ, 2023а)



Зураг 2-9: Нийт сүрэгт эзлэх ямааны тоо, өрхийн нийт орлогот эзлэх ноолуурын орлого
Эх сурвалж: 2021 оны мал тооллогод үндэслэв (ҮСХ, 2023а)

Малчдын амьдрал энгийн боловч ярвигтай. Дээр дурдсан дагуу олон малчид уламжлалт нүүдэлчин ахуйгаа хадгалан үлдсэн ба одоо ч монгол гэртээ⁸ амьдардаг. Зарим малчид хоёр гэртэй байх ба илүү гэрээ эд агуур, хүнсээ хадгалах зориулалтаар ашигладаг. Гэр нь зөөж, угсарч барихад хялбар, ачаад нүүх боломжтой байдаг. Монгол гэр дотроо хоёр ортой, төв хэсэгтээ нэг зуухтай, 1-2 ширхэг авдартай, бурхан тахил, гэр бүлийн зураг, олон медаль гэх мэт зүйлээ өрдөг жижиг шүүгээтэй байдаг. Гэр нь улирал, цаг агаараас шалтгаалан давхарлаж эсхүл нимгэлж болдог эсгий бүрээстэй байдаг. Гаднаа нарны хавтан байрлуулж батарейд хурааж өрхийн хэрэгцээний цахилгааны асуудлаа шийддэг. Энэ цахилгаанаар гэрэл чийдэн асааж, утас гэх мэт цахилгаан хэрэгслээ цэнэглэж, телевизор үзэж, радио сондог байна.

Мал олонтой айл суудлын машинаар гадна ачааны машинтай байх нь элбэг. Ачааны машинаа гэрээ нүүлгэх, малаа тээвэрлэхэд ашигладаг. Өдөр тутмын ахуйн ажлаа явган, мориор, жижиг мотоциклоор (Хятадад үйлдвэрлэсэн, 125сс мотортой) гүйцэтгэнэ. Амны болоод малын усны эх үүсвэр ихэвчлэн зайтай байрлана. Зундаа малыг өдөрт 2 удаа тууж усална. Өвөлдөө тогтсон хугацаанд арай цөөн усална. Бэлчээр усжуулах зорилгоор төрөөс гаргасан худгийг ихэвчлэн хэрэглэнэ.



Зураг 2-10: Уламжлалт монгол гэр
Эх сурвалж: Монголын бэлчээр ашиглагчдын холбоо

Сүүлийн үед малчид ноолуураа самнасан даруйдаа ангилж ялгалгүйгээр ченжүүдэд зарах нь их байна. Орон нутгийн зах зээлд ченжүүд ноолуурын чанар, ангилалд төдийлөн анхаарч, ахиу үнэ төлдөггүй. Тиймээс малчид ноолуураа нас, өнгө, чанараар ангилж, ялгах сонирхолгүй байдаг. Тодорхой бүс нутгуудад зарим санаачилгууд гарч, ноолуурын ангилан, чанар дагасан өндөр үнэ төлж байгаа боловч энэ нь хязгаарлагдмал түвшинд байна⁹.

⁸ Монгол гэр нь агаар сэлгэлт хамгийн зөв явагддаг, нүүдэлчин ахуйд хамгийн тохирсон орон байр юм. (Brown & Fox, 2023).

⁹ Энд бид үндэсний болон ОУ-н ТББ-ууд, төсөл хөтөлбөрийн дундын хоршоо байгуулах санаачлагуудыг дурдсан ба эдгээр хоршоодын гол зорилго нь чанартай түүхий эдэд өндөр үнэ төлдөг тогтолцоог дэмжих, бэлчээрийн менежментийг сайжруулах зэрэг явдал юм.

Ямаа маллах нь хонь маллахаас илүү ярвигтай гэж малчид үздэг. Учир нь ямаа илүү их анхаарал, арчилгаа шаарддаг. Ялангуяа төллөх үед малчнаас илүү их ажиллагаа шаарддаг аж. Илүү илч дулаан, нөөлөгтэй байдаг учир ямааг хонин сүрэгтэй хамт байлгадаг. Тавин эм ямаа тутамд нэг хээлтүүлэгч ухна тавьдаг.

Сайн үүлдрийн хээлтүүлэгч ухна 300,000-400,000 төгрөг байна. Ухна 7 нас хүртлээ үржлийн идэвхтэй байна. Ямааны үүлдрийг сайжруулах үүднээс ухныг 2 жил тутамд солино. Ухна солилцоог ихэвчлэн солилцооны журмаар зохицуулна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн өртөг зардал өндөр тул малчид төдийлөн хөрөнгө оруулах дургүй. Мал аж ахуйд чиглэсэн үйлчилгээ маш өргөн хүрээний байдаг. Тиймээс тэр бүр малчид хөрөнгө зардал гаргаад байж чаддаггүй. Мал эмнэлгийн үйлчилгээ, малын даатгал, мал услахын тулд мотор асаах түлшний зардал, тээврийн зардал гээд урсгал зардал, өртөг ихтэй. Мөн ухна түрээслэх эсхүл худалдаж авах, машин мотоциклийн бензин, малын хашаа хороо гэх мэтээр хөрөнгө оруулалтын зардал мөн өндөр. Олон малтай айл туслах малчин авна, мөн ямаа самнах үеэр хүн хөлсөлж самнуулна. Өдөр тутмын болон урт хугацааны хөрөнгө оруулалтын иймэрхүү зардал чирэгдэл ихтэй тул малчид ямааны арчилгаа, маллагаанд төдийлөн анхаарч чаддаггүй.

Ямаа маллагаа, ноолуур үйлдвэрлэлийн хувьд бид бүх бүсүүдэд онцгой ялгаа олж хараагүй ч ноолуурын үнэ болон тээврийн зардлын хувьд зөрүү их байгааг тодорхойлж гаргаж ирэв. (Хүснэгт 2-10).

Бүс	0 - 600	600+	Нийт	0 - 600	600+	Нийт ноолуур
	Малчин өрхийн тоо		248,296	Самнасан ноолуур (мянган тонн)		
Ямаатай өрх	180,541	31,008	211,548	5,684	3,987	9,671
- Зүүн бүс	21,694	6,480	28,174	732	513	1,246
- Төвийн бүс	42,222	8,465	50,686	1,535	1,076	2,612
- Хангайн бүс	66,293	9,906	76,199	1,632	1,144	2,777
- Баруун	50,332	6,157	56,489	1,785	1,252	3,037

Хүснэгт 2-10: Цөөн болон олон малтай өрхийн тоо (өрхийн тоо, үйлдвэрлэсэн ноолуурын хэмжээ) Эх сурвалж: Өрхийн судалгаанаас зохиогч тооцоолон гаргав. (ҮСХ, 2023А)

Малчин өрхийн малын тооны хэмжээнээс шалтгаалан зарим нэг ялгаатай байдлууд ажиглагдаж байв. Ялгааг 600-с доош толгой малтай өрх болон 600-с дээш толгой малтай чинээлэг өрхийн хооронд харьцуулан гаргав. Дээрх хүснэгтэд үзүүлснээр 175,000 гаруй малчин өрх 600-с доош толгой малтай бол 36,000 малчин өрх 600-с дээш толгой малтай байна. Мал их байх тусам маллагаа, арчилгаа гээд хөдөлмөр их шаардах тул олон малтай айлууд туслах малчин авах, тэдэнд тусад нь гэр бэлдэж өгөх гэх мэт дагалдах зардал (5.1-р бүлэг) их гардаг. Малыг тоо, толгойноос шалтгаалан туслах малчныг байнгын хугацаагаар ажиллуулах, эсхүл цагийн байдлаас шалтгаалан улирлын чанартай ажиллуулах сонголтууд байдаг. Ялангуяа ямаа самнах үед хүн хүчний хэрэгцээ өсөж, дагаад зардал өсдөг тул энэ хүчин зүйлсийг эдийн засгийн загварчлал гаргахдаа ашигласан болно.

Малчид ноолуураа ангилан ялгах ажлыг нь үнэлж, ноолуур өндөр үнэлдэг бол тэд дургүйцэхгүйгээр ангилж ялгах байсан гэж онцолж байв. Үйлдвэрийн шатанд ноолуурыг урт богино, ширхэгтийн бүдүүн нарийн, өнгө зэргээр нь гараар ялгаж ангилдаг. Ингэснээр

сайн чанарын ээрмэл бэлдэх боломжтой болдог. (Dalton & Franck, 2001).

Нийт сүрэгт эзлэх ямааны тоо байнга нэмэгдэхийн зэрэгцээ сүргийн тоо толгойд шууд хязгаарлалт тавих боломжгүй тул Монгол Улсын Засгийн газар 2021 онд Малын хөлийн албан татварыг нэвтрүүлсэн. Үүний зорилго нь мал¹⁰ тус бүрээс жигд татвар ногдуулах явдал байв (Хүснэгт 2-12). Засаг дарга Татварын хэмжээг тогтоох эрх бүхий албан тушаалтан бөгөөд нэг толгой малд ноогдох татварын хэмжээг (0-ээс 2000 ММТ хооронд) тодорхойлдог. Бидний хийсэн ярилцлагаас харахад малын тоо толгойн татварыг 2021 онд малчид (эхний жилдээ) сайн хүлээж авч олон малчид төлөх хүсэлтэй байсан байна. Харин 2022 оноос хойш малчид төлбөр төлөхөөс татгалзаж эхэлсэн. Учир нь зарим сумдад малын татварын орлого 50%-иас доогуур байв. Зарим сумд арилжааны банкны салбартай гэрээ хийж татвараа төлсөн малчид л зээл авах боломжтой болгосон. Банкны зээл малчдын нэг гол найдвар болсон үед банкны зээлийг ашиглан малын тоо толгойн татварыг төлүүлэх хөшүүрэг болж байна. Малын татварыг сумын төсөвт авдаг бөгөөд хэрхэн зарцуулахыг иргэдийн хурлаас шийдэх боломжтой. Үүнд малчид шүүмжлэлтэй хандаж, малын татварын мөнгийг¹¹ тэр болгон үр ашигтай зарцуулдаггүй ба хуулийн дагаа зарцуулах ёстой зүйл зарцуулах байна гэж үздэг. Хэдийгээр сумын засаг захиргаанаас хөрөнгийг хэрхэн зарцуулах талаар тодорхой зааварчилгаа байдаг ч хяналт тавих боломж хязгаарлагдмал байдаг.

2.1.1 Дундын зуучлал

Нүүдлийн мал аж ахуй, түүнийг өсгөж адгуулах уламжлалт хэв маяг, улирлын цаг наргүй хөдөлмөр, хүн бүлгүй байдал, төвлөрсөн хот сууринаас хол нутагладаг, мал төхөөрөх хүн хүч хүрэлцээгүй зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан малчид зах зээлд өөрийн байр сууриа бэхжүүлэх боломж хязгаарлагдмал байдаг. Харин үйлдвэрүүд болон дундын зуучлагчид/ченжүүд зах зээлийг эзлэн өөрсдийн дуртай үнээр малчдаас түүхий эд, бүтээгдэхүүнийг нь худалдан авдаг. Өөрөөр хэлбэл зах зээлийн үнийг тэд тогтоодог.

Ноолуурыг ихэвчлэн сумын төвийн ченжүүд худалдан авч зах зээлд нийлүүлдэг. Ченж¹² гэдэг нь төрөл бүрийн бараа худалдаа, үйлчилгээний дунд зуучлал үзүүлэн ашиг олдог хэсгийг хэлдэг. Зөвхөн ноолуур биш, мах, сүү цагаан идээ, арьс шир, мах гээд малын гаралтай бүхий л түүхий эд үүнд багтдаг. Хоршоог татвараас чөлөөлсөнтэй холбоотойгоор ченжүүд хоршоо байгуулан ажиллаж эхэлсэн. Үүнтэй уялдан бид гурван төрлийн дундын зуучлагчид байгааг харж болно. Үүнд:

- Хувь ченжүүд: тэд газар дээрээс нь ноолуур худалдан авч цуглуулан автомашинаар тээвэрлэн Улаанбаатар хотод авчран түүхий эдийн нэгдсэн төвүүд эсхүл анхан шатны боловсруулах үйлдвэрүүдэд тушаадаг. Тээврийн зардал нь аймаг болон нийслэл хоорондын зайнаас шалтгаалан янз бүр байдаг. Үүнийг Хүснэгт 2-11-т харуулав. Бидэнд олдсон боломжит тоон мэдээллээс үндэслэн бид 1 кг ноолуурын тээврийн зардлын дунджаар 1200 төгрөг гэдэг тооцоог гаргав. Эндээс харахад тээврийн зардал нь ноолуурын үнэд тийм ч

¹⁰ Жил бүр мал тооллого явагддаг ба тооллогын бүртгэл нь орон нутгийн төрийн захиргааны байгууллагад хаагддаг. Мал тооллогын статистик нь малын тоо, толгой, төрлийн талаар маш нарийн мэдээлэл өгч чадна.

¹¹ Малаас авч буй татварын мөнгийг тухайлсан 13 зүйлд зарцуулахаар заасан. Үндсэн зорилго нь малын татварын мөнгийг малчдын эрх ашигт нийцсэн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт болгон зарцуулах ёстой. Тиймээс зарим сумд малын эм тариа авах, худаг үс гаргах, малын хашаа хороо барих гэх мэт зүйлд зарцуулдаг байна.

¹² Англи үгийг шууд галигласан нэр

өндөр нөлөө үзүүлдэггүй байна. Ноолуурын үнийн дөнгөж 1% нь л тээвэрт зарцуулагддаг байна. Малчид тээврийн зардалд төдийлөн ач холбогдол үзүүлдэггүй бөгөөд ноолуураа явдал суудал бололгүй шууд орон нутгийн ченжүүд эсхүл дундын хоршоонд борлуулах нь амар гэж үздэг. Ченжүүд болон дундын хоршоо ноолуурын зуучлалаас маш бага ашгийн зөрөө гаргаж авдаг. (1,000 – 3,000 төг/кг буюу 1–2.5%).

Аймаг	Аймгийн төв	Бүс нутаг	Улаанбаатар хотоос (Км)	Аймаг	Аймгийн төв	Бүс нутаг	Улаанбаатар хотоос (Км)
Дорнод	Чойбалсан	Зүүн бүс	655	Архангай	Цэцэрлэг	Хангайн бүс	453
Хэнтий	Өндөрхаан	Зүүн бүс	331	Баянхонгор	Баянхонгор	Хангайн бүс	630
Сүхбаатар	Баруун-урт	Зүүн бүс	560	Булган	Булган	Хангайн бүс	318
Дархан-уул	Дархан	Төвийн бүс	219	Хөвсгөл	Мөрөн	Хангайн бүс	671
Дорноговь	Сайншанд	Төвийн бүс	463	Орхон	Эрдэнэт	Хангайн бүс	371
Дундговь	Мандалговь	Төвийн бүс	260	Өвөрхангай	Арвайхээр	Хангайн бүс	430
Говь-сүмбэр	Чойр	Төвийн бүс	240	Баян-өлгий	Өлгий	Баруун бүс	1,636
Өмнөговь	Даланзадгад	Төвийн бүс	553	Говь-алтай	Алтай	Баруун бүс	1,001
Сэлэнгэ	Сүхбаатар	Төвийн бүс	311	Ховд	Ховд	Баруун бүс	1,425
Төв	Зуунмод	Төвийн бүс	43	Увс	Улаангом	Баруун бүс	1,336
Улаанбаатар	Улаанбаатар	Ulaanbaatar	40	Завхан	Улиастай	Баруун бүс	984

Хүснэгт 2-11: Улаанбаатар хотоос аймгуудын төв хүртэлх зай км-ээр

Эх сурвалж: GOOGLE MAPS

Ченжүүд

Дундын зуучлагч буюу ченж гэдэг нь мал аж ахуйн гаралтай бүх түүхий эд, бүтээгдэхүүнийг зуучлан борлуулж, ашиг олдог хувь хүнийг хэлдэг. Ченжүүдийн үүрэг оролцоо мал аж ахуйн эдийн засгийн эргэлтэд маш чухал байр суурь эзэлдэг. Тэд малчдад бэлэн мөнгөний урьдчилгаа төлбөр өгдөг, зарим тохиолдолд малчдад өвөл, хаврын эхэн саруудад малын нэмэгдэл тэжээл, бусад хэрэгцээний зүйлсийг зээлээр нийлүүлдэг. Ченжүүд тэдэнд үргэлж шударга ханддаггүй, зах зээлийн бодит үнийг нуух, төөрөгдүүлэх гэх мэт үйлдэл гаргадаг гэдгийг мэддэг ч санхүүгийн боломжгүйгээс шалтгаалан малчид одоог хүртэл тэдэнд ноолуураа зарсаар л байна. Бид ченжүүдтэй шууд ярилцах боломжгүй байсан ч сумын удирдлага, малчин өрхүүдтэй хийсэн ярилцлагаас тэдний талаар тодорхой хэмжээний мэдээлэлтэй болсон.

Хоёр төрлийн ченжүүд байна. Зарим нь шууд Хятадуудтай харилцаж ноолуурын шууд экспортод гаргадаг. Нөгөө хэсэг нь Монгол ченжүүдтэйгээ харилцаж, боловсруулах үйлдвэрт шууд нийлүүлдэг. (Holm-Olsen, 2021).

Татвар болон мал эмнэлгийн мэргэжлийн хяналтаас зугтах зорилгоор ноолуурыг албан бус ченжүүдээр дамжуулан борлуулж буй нь өртгийн сүлжээг бий болгож НӨАТ ногдуулах, гарал үүслийн ул мөрийг баримтжуулахад бэрхшээл үүсгэж байна. (Kimura, Sedik, & Ayurzana, 2022)¹³.

Хоршоод

Зах зээлийн тэгш бус, хүртэмжгүй байдлыг хоршоогоор дамжуулан шийдвэрлэх боломжтой. Гэвч орлого багатай малчид хоршооны гишүүд болоход хүндрэлтэй

¹³ Бодлого судлалын төвөөс мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний албан бус секторын НӨАТ-ын хэмжээ жилд 40 орчим тэрбум төгрөг байгааг тооцоолон гаргажээ. Энэ нь ченжүүдийн нийт ашгийн 10% буюу 400 тэрбум төгрөгөөр тооцогдоно (Кимура, Седик, Аюурзана, 2022).

байдаг. (Hilliova, Hejkrlik, Mazancova, & Tseren, 2017). Баримтаас үзвэл хоршооны хөгжлийн түүхэнд гишүүдийн тоо харьцангуй доогуур байсан ч 2013-2016 онуудад мэдэгдэхүйц өссөн байдаг. Энэ нь тухайн жилүүдэд төрөөс ноосны урамшууллыг хоршоогоор дамжуулан олгож байсантай холбоотой юм. 2020 онд ХХААХҮЯ-с гаргасан тайланд ихэнх хоршоод хоршооны хууль, дүрмийг дагаж мөрддөггүй тухай дурджээ. Ихэнх нь хоршоод гишүүдийн биш хэдхэн хүний өмчлөл, хяналт, оролцоотой байдаг нь хоршооны зарчмаасаа гажуудсан байгаа юм. (Кимура, Седик, Аюурзана, 2022). Ямаа малладаг малчин өрхийн дөнгөж 3/1 нь ямар нэг хоршооны гишүүнчлэлтэй байгааг судлаачид гаргажээ. (Carcamo-Diaz & Van de Ven, 2021). Гэвч энгийн малчин өрхийн малын тоо, жилийн борлуулалтын орлого болон хоршооны гишүүн малчин өрхийн малын тоо, түүнээс олон орлого хоёрын дунд ялгаатай өндөр зөрөө байхгүйг судалгаагаар гаргасан байна.

Бидний ажигласнаар орон нутагт хоёр төрлийн хоршоо байна. Нэг төрөл нь хэдийгээр хоршооны хэлбэрээр байгуулагдсан ч сонгодог компанийн журмаар ажилладаг. Хувьцаа эзэмшигч гишүүдтэй жилийн эцэст ноогдол ашиг хуваарилдаг. Зарим ченжүүд хоршооны нэрээр ийм байдлаар ажилладаг ба гол шалтгаан нь татвараас зайлсхийх явдал юм. Дараагийн төрлийн хоршоо бол жинхэнэ хоршоод Жинхэнэ гэдэг нь яг хоршооны дүрмийн дагуу ажилладаг ба хоршооны гишүүний татвараа төлсөн хэн ч гишүүнээр элсэх боломжтой, бүх гишүүдийн хурлаар асуудлаа шийддэг хоршоод юм.

Зарим хоршоод зөвхөн ноолуурын бизнес хийдэг бол зарим нь бүх төрлийн түүхий эдийн бизнес хийдэг. Уламжлалт хоршоодод үргэлж тулгардаг нэг асуудал бол эргэлтийн хөрөнгө байдаг. Ялангуяа ноолуур худалдаж авах улиралд тэдэнд ихээхэн хэмжээний бэлэн мөнгөний хэрэгцээ гардаг. Зарим хоршоодын ченжүүдээс ялгарах онцлог нь ноолуурын чанартай уялдсан үнэ төлдөг. Мөн дараагийн шатанд нийлүүлэхээс өмнө анхан шатны ангилан ялгалтыг хийдэг.

ШХА-аас авсан эх сурвалж дээр үндэслэн Холм-Олсэн хоршоод Монголын ноолуурын нийт борлуулалтын 10-г дангаараа хийдэг гэсэн тооцоо гаргасан байна.

2.3.2 Угаах, ялгах

Ноолуурыг угаах, ангилан ялгах процесс нь үйлдвэрийн шат дамжлагын нэг хэсэг бөгөөд өртөг нэмэх эхний үе шат юм. Ихэнх нь ноолуурыг угаах явцдаа ангилж ялгадаг. Хоёр төрлийн угаах процесс байдаг. Эхнийх нь нарийн угаалга буюу үс хялгаснаас нь ангил ялгахад бэлэн болгох. Хоёрдох нь зөвхөн тоос, хог шорооноос нь салгаад экспортод гаргах зориулалттай угаалга. Монгол Хятадын гэрээ хэлэлцээрийн дагуу Хятад талаас зөвхөн угаасан ноос импортоор авахыг зөвшөөрсөн байна¹⁴. Гэхдээ бидний олж мэдсэнээр угаасан ихэнх ноолуурыг импортолсны дараа дахин угаадаг байна. Учир нь Монголд угаасан ноолуур зарим технологийн шаардлагыг хангадаггүй байна.

Ноолуурыг ангилсны дараа тоос шорооноос нь салгах цэвэрлэх үе шат бий. Энэ нь

¹⁴ Гаалийн газартай хийсэн ярилцлагын үеэр авсан мэдээлэл.

ангилсан ноолуурыг сэгсрэгч машин дээр зулж дэвсэн эргэх хөдөлгөөнөөр сэгсэрч тоос, хогноос нь салгадаг. Үүний дараа угаах дамжлага уруу шилжинэ. Угаасны дараа хялгаснаас нь салгах дамжлага бий. (Атав болон Хантэр, 2023; Dalton & Franck, 2001).

Угаах дамжлагыг зарим тохиолдолд цэвэрлэх гэж нэрлэдэг. Цэвэрлэх нь боловсруулах үйлдвэрлэлийн процесс бөгөөд ноолуурыг гаднын бохирдол, тос, шороо болон бусад нэмэлт бохирдуулагч зүйлсээс салгахын тулд ноолуурыг угааж, цэвэрлэх үйл явц юм. (Нэхмэлийн мэргэжлийн үг хэллэгийн тайлбар толь, 2023). Угаахдаа эхлээд ноолуурыг натрийн гидроксид гэх мэт цэвэрлэгээний бодис бүхий уусмалд дэвтээнэ (дэлгэрэнгүй мэдээллийг 6-р хэсгээс үзнэ үү). Эдгээр бодисууд нь ноолуурыг бохирдуулагч элдэв хог хольцыг задалж, арилгахад тусалдаг.

Боловсруулалтын энэ явцад ноолуурыг халуун усаар угааж, дараа нь хатаах шаардлагатай. Ерөнхийдөө энэ үйл явц нь маш их эрчим хүч шаарддаг. Нэгдүгээрт, машинууд хөдөлгүүрийг ажиллуулахын тулд цахилгаан эрчим хүч шаарддаг бөгөөд үүний зэрэгцээ усыг шаардлагатай температурт халаах, ноолуурыг хатаах зэрэг бүхий л үйл явцад эрчим хүч шаардлагатай болдог. Эрчим хүч, усны дэд бүтцийн хувьд янз бүрийн эх үүсвэртэй байдаг. Зарим нь төвийн цахилгааны болон цэвэр бохир усны шугамд холбогдсон байдаг.


Зарим нь бие даасан халаалт, эрчим хүч, усны эх үүсвэртэй байдаг. Ноолуур угаах дамжлага нь бас их хэмжээний ус хэрэглэдэг. Ноолуур угаах усыг гүний худагар шийднэ. Угаасан бохир ус зайлуулах асуудлыг тусад нь хөндөх чухал сэдэв юм.

Ноолуурыг хэдэн шат дамжлагаар угаах тоо нь чанарын шаардлагатай шууд хамааралтай. Ноолуурын хамгийн нарийн угаалгын үед хог шороо, бусад нэмэлт бодисуудыг угааж зайлуулсны дараа нийт ноолуурын хэмжээ 70% болж буурдаг.

Зөвхөн экспортод зориулан ноолуур угаадаг үйлдвэрүүд нэр хүнд муутай байдаг. Учир нь тэд байгаль орчин, хөдөлмөрийн олон хууль тогтоомжийг зөрчдөг. Харин үйлдвэрийн дэргэдэх угаах цехүүд тухайн боловсруулах үйлдвэрт тавигддаг бүх стандарт, журмыг даган мөрдөж хатуу хяналтын дор үйл ажиллагаа явуулдаг.

Судалгааны явцад бид Хятад болон Япон улсад үйлдвэрлэсэн угаах машиныг харах завшаан олдсон юм. Угаасан ноолуурын тухайд доорх хэд хэдэн чухал баримтыг дурдах ёстой:

- Монголд ноос, ноолуур угаах бүрэн хүчин чадал бүхий нөөц бий.
- Ноолуур угаах зардал 4,000 – 7,000 төг/кг байна.
- Монгол улс нь боловсруулаагүй (угаасан) ноолуур экспортлогч хамгийн том орон юм (Harmonised System Code HS 510211). Сүүлийн таван жилийн хугацаанд дэлхийн ноолуурын экспортод Монголын нийт эзлэх хувь 94% байна.
- 2022 онд 6427 тонн угаасан ноолуур экспортолсон байна (Зураг 2-10).
- Экспортод гаргаж буй ноолуурын чийгшлийн норм 16-17% байна.
- Угаасан ноолуурын үнэ тогтворгүй бөгөөд 29.2 ам.доллар/кг (2020) болон 49.8 ам.доллар/кг (2019)-ын хооронд хэлбэлзэж байна.
- 2018-2022 онуудад экспортолсон угаасан ноолуурын 99.9 хувь нь Хятад улс уруу гарсан байна.



Зураг 2-11: Экспортолсон угаасан ноолуур ба үнэ (HS 510211)
Эх сурвалж: Зохиогчид

Ноолуурыг самнах дамжлага нь илүү технологи шаардсан ажил юм. Уламжлалаар бол ноолуурыг самнах (хялгасыг) гараар ялгадаг байсан боловч энэ нь маш нарийн бөгөөд өртөг өндөр ажиллагаатай. (Wang, Singh, & Wang, 2008).

Гараар ялгадаг байх үед 60 гр ноолуурыг ялгахад 2 цаг зарцуулдаг байсан байна. (Hunter, 2020). Үр ашиггүй хөдөлмөр, зардлыг бууруулахын тулд ноолуурыг 60%- 80%¹⁵ -н чийглэг орчинд ялгах ёстой.

Одоогоор маш бага хэмжээний ноолуурыг эх орондоо ялгаж ангилж байна. Бүх ноолуурыг дотооддоо самнах технологийн зохицуулалыг 2004 онд баталсан хэдий ч үйлдвэрийн технологи, хүчин чадлын дутагдалтай байдлаас шалтгаалан тус хуулийн хэрэгжилтийг хойшлуулсаар байна.



Зураг 2-12: Ноолуурыг угааж, цэвэрлэн ялгах явцын хорогдол

Самнах дамжлага нь удаан бөгөөд эрчим хүч их шаардсан үе шат. Машинаар ноолуурын 25%-н хялгасыг ялгадаг. Үүнээс харвал 1 кг түүхий ноолуур 525 грамм (52.5%) угааж ялгасан цэвэр ноолуур болдог. (Зураг 2-12).

¹⁵ ҮСХ (MNS 3683:2015) Ноолуурыг ялгаж ангилсны дараа дотоод чийг нь 16% байхыг стандартчилан заасан.

Угаах явцад хаягдал болж үлдсэн органик нэгдлүүд, эрдсийг бохир усыг цэвэрлэх явцдаа ялгаж авч үлддэг. Үүнийг газар тариалан, хүнсний ногоо тариалалтад бордоо болгон хэрэглэдэг. Ялгах дамжлага нь бүдүүн болон нарийн хялгасыг салгаж цэвэрлэдэг. (Зураг 2-13). Ялгасан хялгасыг мөн зах зээлд борлуулдаг. Тус хялгасаар эсгий, эсгий бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Мөн том жижиг сойз/шетка хийдэг үйлдвэрлэгчдэд ямааны ноолуураас ялгасан хялгасны эрэлт их өндөр байдаг. Ялгасан хялгасыг 1 кг-ыг 10,000 төгрөгөөр борлуулдаг.



Зураг 2-13: Ялгасан хялгас

Эх сурвалж: Зохиогчид

Ноолуурыг саманахад төрөл бүрийн машин ашиглана. Зарим үйлдвэрүүдэд бид хуучны Япон тоног төхөөрөмж харсан бол зарим үйлдвэрт Хятадын шинэ машин тоног төхөөрөмжтэй танилцсан. (Зураг 2-14). Хятад үйлдвэрлэгчдээс авсан мэдээллээр тус Хятад машин нь дараах үзүүлэлттэй байдаг байна. (Хүснэгт 2-12).

Загвар	YQ-A186
Моторын хүч	2.8 Кватт
Жин	4.1 тонн
Хүчин чадал	4–8 кг/ц

Хүснэгт 2-12: Самнах машин

Эх сурвалж: YUANQUAN MACHINE (2023)



Зураг 2-14: Монголд хэрэглэж буй самнах машин (2022)
Эх сурвалж: Зохиогчид

2019 оны мэдээ тайлангаар тус онд ноолуур ялгах үйлдвэрийн хүчин чадлыг хангахуйц хэмжээний ноолуур цуглараагүй байна. (Хүснэгт 2-13). 2023 оны 11-р сард ХХААХҮЯ-наас хийсэн судалгаагаар 1000 мм-ийн өргөнтэй нэг машин 4-8 кг орчим ноолуурыг самнах хүчин чадалтай гэж мэдээлжээ. Үүнээс харахад ноолуурыг самнах шат дамжлагын хүчин чадал, хурд нэмэгдэж байгаа ба 2022, 2023 онуудад ялгах ноолуурын хэмжээг урьдчилан тооцоолоход бэрхшээлтэй байж болох юм.

Боловсруулах шат	Шалгуур үзүүлэлт	2019 үр дүн (тонн)	Шаардагдах хүчин чадал (т ¹⁶)	Бүрэн ашиглалт, %
Бүтээмж	Түүхий ноолуур	9,972		байхгүй
Самнах	Суурилуулсан хүчин чадал	5,827	~ 7,000	26%
	Ашиглалт	1,520		
Утас үйлдвэрлэх, ээрэх	Суурилуулсан хүчин чадал	2,278	~ 5,500	31%
	Ашиглалт	717		
Сүлжих	Суурилуулсан хүчин чадал	2,329		28%
	Ашиглалт	644		
Нэхэх	Суурилуулсан хүчин чадал	4,593		65%
	Ашиглалт	2,976		


Хүснэгт 2-13: Монголын ноолуур боловсруулах үйлдвэрийн хүчин чадал, 2019
Эх сурвалж: STEPECOLAB төсөлТ (2022)

Самнасан ноолуурын тухай чухал баримтууд:

- Монгол улсад 2369 тонн (24.5%) түүхий ноолуур самнаж байна. Ялгах үе шат нь ойролцоогоор 1215 тонн байна.
- самнах процессын зардал 10000-15000 төгрөг/кг байна.
- Самнасан ноолуурыг ихэвчлэн Итали (79.5%), Их Британи (8.7%), Хятад (5.1%),

¹⁶ Дотоодын түүхий ноолуурыг 100 хувь боловсруулах хүчин чадалтай

Герман (3%), Өмнөд Солонгос (2.5%) улсууд уруу тус тус экспортолдог байна. (Зураг 2-15).



Зураг 2-15: Монгол боловсруулсан ноолуурын экспорт (2018 – 2022, HS 510531)
Эх сурвалж: НҮБ, Комтрэйд дээр үндэслэн өөрсдөө тооцов



Зураг 2-16: Монгол боловсруулсан ноолуурын экспортын үнэ (HS 510531).
Эх сурвалж: Түүхий эдийн биржийн мэдээлэл дээр үндэслэн өөрсдөө тооцов.

2012-2019 оны хооронд самнасан ноолуурын экспорт харьцангуй тогтвортой байсан бөгөөд нийт экспортолсон хэмжээ 500-630 тонны хооронд хэлбэлзэж байв. Гэвч 2020 онд COVID-19 цар тахлын улмаас үнэ огцом буурч, самнасан ноолуурын экспортын хэмжээ 260 тонн болж багассан байна. Тухайн үед түүхий ноолуурын үнэ хоёр дахин унасан бол самнасан ноолуурын үнэ 27 хувиар буурчээ. Харин 2022 онд самнасан ноолуурын үнэ нэг кг нь 108 ам.доллар давж, экспортын хэмжээ огцом нэмэгдэж, жилийн өөрчлөлт 100 гаруй хувьд хүрсэн байна (Зураг 2-16).


Самнасан ноолуурыг ихэвчлэн 75 кг-аар савлаж, экспортлоход бэлэн болгодог (Зураг 2-16). Ноолуур нь маш өндөр үнэтэй бүтээгдэхүүн учраас боодол бүрийг цоожтой агуулахад хадгалж,

цахим хяналтын системээр давхар хянаж хамгаалдаг байна.



Зураг 2-17: Экспортод гаргахаар бэлдэж савласан ноолуур
Эх сурвалж: Монголын бэлчээр ашиглагчдын үндэсний холбоо

Шнайдер групп нь ноолуурын худалдаа, боловсруулалт эрхэлдэг хувийн компани юм. Тэд зах зээлийн тайлан гарган, ноолуурын үнийн индексийг доорх графикт үзүүлсэнчлэн нийтэлдэг. Schneider Group-ийн (The Schneider Group, 2023) мэдээлснээр Хятадын ноолуур нь олон улсын зах зээл дээр хамгийн өндөр үнэлгээтэй байдаг. Индексийн дагуу Монголын ноолуур Хятадын ноолуураас 13%-иар хямд, харин Ираны ноолуур Хятадын ноолуураас 39%-иар хямд үнэтэй байгаа аж (Зураг 2-18).



Хүснэгт 2-18: Боловсруулсан ноолуурын үнэ (HS 510531).
Эх сурвалж: Шнэйдэрийн мэдээлэл дээр үндэслэн өөрсдөө тооцов. (2023).

Экспортод гаргах бараа, ажил, үйлчилгээнд НӨАТ-ыг 0 хувиар ногдуулдаг (Монголын Татварын алба, Азийн хөгжлийн банк, 2023).

2.3.3 Будах, ээрэх

Ноолуурыг хялгаснаас салгаж ангилсны дараа будах болон ээрэх процесс хийгдэнэ.

Атав болон Хантер нарын (2023) судалгаагаар ээрэх утасны 90% нь нарийн ноолуур, 10% нь ноосон утас байдаг байна. (Dalton & Franck, 2001; Hunter, 2020). Ноосны утас ээрэх үйл явц нь нарийн ноос боловсруулах машин дээр хийгддэг боловч тусгайлан ноолуурт тохируулсан тохиргоо шаардлагатай байдаг. Энэ тохиргооны параметруудийг ихэвчлэн нууцалдаг (Хантер, 2020).

Ээрэх үйл явц нь Монголд хамгийн нарийн төвөгтэй, хөгжлөөр хоцрогдож буй салбар юм. Ойролцоогоор 444 тонн ноолуурыг будах, ээрэх, нэхэх, сүлжих гэх мэт үйлдвэрлэлийн шат дамжлагаар дотооддоо боловсруулдаг. Энэ нь ойролцоогоор 845 тонн түүхий ноолууртай тэнцэх ба Монголын нийт үйлдвэрлэлийн 8.7%-ийг эзэлдэг. Одоогоор ээрэх хүчин чадлын зөвхөн 30% нь л ашиглагдаж байна.

Ээрэх үйл явц нь хамгийн сайн технологи болон өндөр хөрөнгө оруулалт шаарддаг процесс юм. Ээрэх машинууд нь үнэтэйгээс гадна нарийн мэдлэг, ур чадвар шаарддаг. Зарим компаниуд хуучин Япон машинуудыг ашигладаг бөгөөд эдгээр нь тэдний хэрэгцээг хангасаар байна. Бусад нь Европын машинуудыг, жишээлбэл, Bigagli (Итали)-г ашигладаг. Монголд үйлдвэрлэсэн утас нь хамгийн өндөр чанарын стандартуудыг хангаж чадахгүй байгаа тул тансаг зэрэглэлийн брэндүүд самнасан ноолуурыг Итали руу экспортолж, тэндээ Европт хамгийн өндөр чанарын стандартад нийцүүлэн утас үйлдвэрлэдэг.

Ээрэх явцад 5%-ийн хорогдол гардаг.


Судалгааны үеийн ярилцлагаар бид Монголын ээрэх компаниуд хамгийн нарийн утас болох ноолуур, торгоны хольцтой утсыг үйлдвэрлэж чадахгүй байгаа нь тогтоогдсон. Торгоны хольцтой ноолуурын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай утсыг БНХАУ-аас импортлох шаардлагатай болдог.

Эцсийн хувцас, эдлэл үйлдвэрлэдэг ноолуурын үйлдвэрүүд доороо өөрийн ээрэх үйлдвэр, цехтэй байдаг ба тэндээсээ ээрсэн утсаа авдаг. Түүнээс гадна бие даасан жижиг цехүүд утас ээрч үйлдвэрүүдэд нийлүүлдэг. Ээрэх үйлчилгээний үнэ 1 кг тутамд ойролцоогоор 35,000 төгрөг байдаг.

2.3.4 Нэхэх, сүлжих

Монголын ноолуурын сүлжих болон нэхэх үйл явц нь хэт төвлөрсөн биш байдаг. Ихэнх утсыг сүлжих байдлаар боловсруулна. Ноолуурын сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр мэргэшсэн олон жижиг, дунд үйлдвэрүүд Монголд байдаг. Сүлжих машинууд хэт их үнэтэй биш бөгөөд нэмүү өртөг шингээх боломжтой учраас сүүлийн жилүүдэд сүлжмэлийн үйлдвэрийн хүчин чадал тогтмол нэмэгдсээр байна. 2019 онд сүлжмэл үйлдвэрлэх 65%-ийг ашигласан бөгөөд энэ хүчин чадал тасралтгүй өргөжиж хөгжсөөр байна.

Зарим сүлжмэлийн компаниуд бүх үйл явцыг өөрсдөө гүйцэтгэдэг. Ноолуур худалдан авахаас эхлээд УБ хүртэл тээвэрлэх, угааж, самнах, утас болгон ээрэх хүртэлх бүх үйл явцыг өөрсдөө хянаж гүйцэтгэдэг. Харин зарим нэг жижиг сүлжмэлийн үйлдвэрүүд бэлэн утас авч ээрдэг. Эхний хэлбэр нь сүлжмэлийн үйлдвэрийн хүмүүс өөрсдөө хянаж, гүйцэтгэдэг учраас зардлын хувьд хямд байдаг. Тиймээс ээрсэн утсыг нэхэх хүчин чадалгүй жижиг, дунд компаниуд эхний хэлбэрийг илүү өргөн хэрэглэдэг болов уу гэж таамаглаж байна.




Сүлжмэл ихэвчлэн Япон, Герман тоног төхөөрөмжийг ашиглаж байна. Шима Сейки (Shima Seiki) загварын сүлжих машинуудыг өргөнөөр ашиглаж буйтай их таарав. Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль Шима Сейки компанитай хамтран "Шима Сейки Сургалтын төв"-ийг ажиллуулдаг. Энэ төв нь олон улсын стандартын дагуу хэрхэн дизайныг боловсруулж, тооцоолол хийх, тоног төхөөрөмжийн программыг ашиглах чиглэлээр экспертүүдийн мэргэжлийн ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулдаг. Ингэснээр мэргэжилтнүүд автомат сүлжих машины ажиллах горим, технологийн талаар мэдлэг, чадвартай болдог (Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, 2023). Харин нэхэх үйл явцын хувьд компаниуд түгээмэл биш ч ихэвчлэн Stäubli (Герман) тоног төхөөрөмжийг ашигладаг ба эдгээрийн зах зээлийн үнэ ойролцоогоор 150,000 ам.доллар байдаг.

Шима Сейки компани хоёр төрлийн машин санал болгодог.

- **Уламжлалт сүлжих машинууд:** Эдгээр нь хувцасны хэсгүүдийг (ханцуй, урд тал, ар тал) үйлдвэрлэдэг бөгөөд эдгээр хэсгүүдийг тусад нь нэхээд залгаж нийлүүлэх шаардлагатай болдог. Уламжлалт машинууд жилд ойролцоогоор 5,500 ширхэг хувцас үйлдвэрлэх боломжтой. Зарим Хятадын худалдаачид хуучин Шима Сейки сүлжих машиныг боломжийн үнээр¹⁷ санал болгодог ба олон жижиг сүлжмэлийн үйлдвэрүүд хуучин машинуудыг ашигладаг гэж бид үзэж байна.
- **Бүрэн хувцас сүлжих машинууд:** Эдгээр нь нэг хувцсыг бүхэлд нь нэг удаагийн үйл явцаар үйлдвэрлэдэг. Одоогоор эдгээр нь нийтлэг болоогүй байгаа ч зарим газар аль хэдийн ашиглагдаж эхэлсэн. Энэ төрлийн машин нь хөдөлмөрийн зардал болон эрчим хүчний зардлыг хэмнэх боломжтой ч өндөр үнэтэй байдаг. 2023 онд хуучин буюу ашиглаж байсан бүрэн хувцас сүлжих машины худалдах зарыг интернэт худалдааны сайтуудад олж чадаагүй.

Болормаагийн өгсөн (2023) мэдээллээс үзэхэд Монголд ойролцоогоор 34 угаах үйлдвэр, 46 ялгах үйлдвэр, 16 ээрэх үйлдвэр байдаг. Үүний зэрэгцээ, хувцас үйлдвэрлэлийн 80 орчим жижиг, дунд үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

¹⁷ Али Баба худалдааны сайт дээр маш боломжийн үнэтэй хуучин тоног төхөөрөмжүүд байдаг.



Зураг 2-19: Ноолууран бэлэн бүтээгдэхүүний экспорт (HS 611012).
Эх сурвалж: НҮБ-ын Комтрэйдийн мэдээлэл дээр үндэслэн өөрсдөө тооцоолов (2023).

Ноолууран хувцасны экспорт ихэвчлэн томоохон үйлдвэрлэгчдийн гарт байдаг, харин жижиг үйлдвэрлэгчид дотоод зах зээл дээр илүү идэвхтэй борлуулалт хийдэг. 2014-2022 онуудад НС 611012- од ын дагуу үйлдвэрлэсэн ноолууран хувцас, эдлэл (жишээлбэл, свитер, битүү захтай цамц, спорт цамц, бээлий, гэх мэт) нийт экспортлогдсон хувцасны хэмжээ 22 тонноос 165 тонн болж өссөн байна гэж (UN comtrade) НҮБ-ын түүхий эд, худалдааны мэдээллийн нэгдсэн сангаас мэдээлжээ (Зураг 2-19).

Бэлэн бүтээгдэхүүний гол импортлогчид нь Европын холбооны орнууд (голчлон Германаас, Итали, Нидерланд, Франц), АНУ, Их Британи, БНСУ гэх мэт улсууд байдаг. (Хүснэгт 2-14-г үзнэ үү).

Жин(Кг)			Валют (USD)		
Нийт	82,677	100.0%	Нийт	17,101,116	100.0%
Герман	18,848	22.8%	Герман	3,294,924	19.3%
АНУ	18,706	22.6%	АНУ	3,914,104	22.9%
Англи	12,820	15.5%	Англи	2,953,141	17.3%
Итали	6,538	7.9%	Итали	1,469,153	8.6%
Өмнөд Солонгос	5,258	6.4%	Өмнөд Солонгос	869,189	5.1%
Хятад	4,830	5.8%	Хятад	764,004	4.5%
Нидерланд	4,793	5.8%	Нидерланд	1,116,873	6.5%
Япон	3,800	4.6%	Япон	958,656	5.6%
Франц	1,752	2.1%	Франц	395,389	2.3%
Бусад	5,333	6.50%	Бусад	1,365,683	8.00%

Хүснэгт 2-14: Ноолууран бэлэн бүтээгдэхүүний экспорт (HS611012).

Эх сурвалж: UN COMTRADE (2022)

2.4 Өртгийн сүлжээний урсгал

Монгол улсын ноолуурын өртгийн сүлжээ нь хоёр гол дэд сүлжээнээс тогтож байна. i) түүхий ноолуур экспортлох дэд сүлжээ нь угаасан түүхий ноолуурыг Хятад улс руу шууд экспортод гаргах, ii) босоо хамааралт дэд сүлжээ нь боловсруулалтын янз бүрийн шатыг

хамарсан.

2.4.1 Түүхий ноолуур экспортлох дэд сүлжээ


Түүхий ноолуурыг малчдаас ченжүүд авч Хятад эзэдтэй угаах үйлдвэрт шууд нийлүүлдэг ба угаасны дараа ихэнхдээ Хятад улруу экспортлогддог. Нийт 8,828 тонн түүхий ноолуурыг энэ дэд сүлжээгээр дамжуулан экспортолдог. Энэхүү дэд сүлжээ нь түүхий эдийн экспортын тухай хуулийн зохицуулалтаар ихээхэн өөрчлөгдөх төлөвтэй байна. 2024 оноос эхлэн эхлээд зөвхөн үс хялгаснаас ялгаж цэвэрлэсэн ноолуурыг экспортолно.

2.4.2 Босоо хамааралт сүлжээ

Энэхүү дэд сүлжээ нь боловсруулах бүхий л үе шатыг хамардаг. Үүнд: ноолуур дундын



зуучлагчид (анхан шатны ба дундын хоршоод, ченжүүд), ангилах, угаах, самнах, будах, ээрэх, сүлжих, оёх буюу эцсийн бүтээгдэхүүн нэхэх гэх мэт. Ноолуурын эцсийн бүтээгдэхүүн нь олон улсын зах зээлд болон дотоод зах зээлд борлуулагдаж байна. Сүлжээний урсгал ба үнийн (мянган.төг/кг) мэдээллийг Зураг 2-20-т харуулав.




Зураг 2-20: Ноолуурын сүлжээний урсгал, 2022, Монгол улс

Эх сурвалж: UN COMTRADE болон ҮСХ-ноос гаргасан статистик дээр үндэслэн тооцоолов.

2.5 Засаглал

Ноолуурын өртгийн сүлжээний засаглалд гол тоглогчдоос гадна Засгийн Газрын байгууллагууд, хувийн болон иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллагууд оролцдог. Үүнийг Зураг 2-21-т харуулж илүү дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-рт оруулав.



Зураг 2-21: Өртгийн сүлжээний засаглалын тоглогчид, Монгол улс

Эх сурвалж: НҮБ-ын Тогтвортой ноолуурын платформоос зохиогчид боловсруулав. (НҮБ, 2024).

Холбогдох яам, агентлагууд нь Засгийн газар урт хугацааны бодлогын болон стратегийн баримт бичгүүдэд тусгагдсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдаг. “Алсын хараа-2050”, “Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, “МАН-н тогтвортой хөгжлийн төлөвлөгөө”, “Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг үндэсний урт хугацааны стратегийн баримт бичгүүдийн хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, хүнсний найдвартай хангамжийг бий болгох үүднээс мал аж ахуйн салбарыг тогтвортой, олон талт, эдийн засгийн үр ашигтай хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.


Хүснэгт 2-15-д ноолуурын өртгийн сүлжээнд хамааралтай гол заалтуудыг нэгтгэн харуулав.

Малын генетик нөөцийг тогтвортой ашиглах:	• Малыг генетик нөөцийг ашиглалтыг оновчтой болгох
	• Бэлчээрийн даацад тохирсон зохист сүргийн бүтцийг бий болгох, ноолуурын чанарын үзүүлэлтүүдийг анхаарах.
Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавхыг сайжруулах ба гамшгийн эрсдэлийг бууруулах:	УАӨ-д тэсвэртэй мал аж ахуйг хөгжүүлэх
	Гамшгийн эрсдэлийг бууруулах чадварыг сайжруулах
Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих ба экспортын өсөлт:	Ноолуур үйлдвэрлэлийг дэмжих
	Самнасан ноолуур болон бэлэн бүтээгдэхүүний экспортыг дэмжих
Боловсруулалт, үйлдвэрлэлийг өргөжүүлэх ба экспортын дэмжих:	бүрэн боловсруулсан арьс шир, ангийн арьс, ноос ноолуур
	Оёмол ба нэхмэл бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх.
Газрын нөөцийн үр ашигтай менежмент:	Газрын нөөцийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийг сайжруулах
	Хөрсний ус, бороо, цасны ус ашиглан усжуулалтын системийн үр ашгийг сайжруулах
Бэлчээрийн менежментийг сайжруулах, малын өвчний хяналтыг сайжруулах:	Бэлчээрийн доройтлыг бууруулах
	Малын өвчний хяналт, зохицуулалтын олон улсын стандартыг хэрэгжүүлэх.
	Олон улсын зах зээлд өрсөлдөхүйц чанартай мал, махны үйлдвэрлэлийг хөгжүүлэх.
Эрчимжсэн МАН-г хөгжүүлж, ашиг шимийг нэмэгдүүлэх:	Эрчимжсэн МАН-г хөгжүүлэх
	Мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
	Бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээврийн хөгжүүлэх
Эдийн засгийн зорилтууд:	2030 он гэхэд МАН-н үйлдвэрлэлийн Монгол Улсын ДНБ-д эзлэх хувийг 22% болгох
	МАН-н үйлдвэрлэлийн нийт хөрөнгө оруулалтыг 40%-иар нэмэгдүүлэх
	Хөрөнгө оруулалтын өсөлтийг жил бүр дунджаар 5%-иар өсгөх, хөрөнгө оруулалтын өгөөжийг 20-25%-иар өсгөх
Эрүүл манд, аюулгүй	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах
	Зооноз болон бусад халдварт өвчнийг устгах

байдлын арга хэмжээ:	Олон улсын болон дотоодын зах зээлд малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг нягтлах
Бэлчээрийн МАА-н үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх:	Монгол улсын зүүн бүсийн экосистемд тулгуурласан бэлчээрийн МАА-н бүтээмжийг нэмэгдүүлэх

Хүснэгт 2-15: Үндэсний стратегийн баримт бичгүүдэд тусгагдсан гол бодлогуудын нэгтгэл
Эх сурвалж: STeP EcoLab (2022)

STeP EcoLab төслийн хүрээнд боловсруулсан Монгол Улсын ноолуурын салбарыг 2030 он хүртэл тогтвортой хөгжүүлэх замын зураглал нь ноолуурын тогтвортой үйлдвэрлэл, ноолуурын бэлтгэл, үйлдвэрлэл, үйлдвэрлэлд тэргүүлэгч байх алсын харааг тодорхойлсон. Замын зураг нь хэд хэдэн үндсэн зорилтыг биелүүлэхэд чиглэсэн гурван үе шатыг тодорхойлсон. Үүнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, усны хэрэглээг багасгах, мал үржлийн технологийн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх, ноолуурын үйлдвэрлэлээр дамжуулан малчдын орлогыг нэмэгдүүлэх зэрэг багтаж байна. Боловсруулалтын түвшний стратеги нь (i) Тогтвортой технологид суурилсан боловсруулах компаниудын тоог нэмэгдүүлэх; (ii) Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, (iii) Химийн хэрэглээг бууруулах, (iv) Илүү ногоон санхүүжилтийг дэмжих, (v) Экспортод гаргаж буй ноолууран эцсийн бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх асуудлуудыг багтаасан.



Зураг 2-22: 2030 он хүртэлх стратеги
Эх сурвалж: STeP EcoLab (2022)

2.5.1 Өртгийн сүлжээний засаглалын дүн шинжилгээ

НҮБ-ын ХХААБ болон ЮНИДО (2024)-оос өртгийн сүлжээний засаглалын шинжилгээний үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг танилцуулсан. Хүснэгт 2-16-д энэхүү схемийн дагуу ноолуурын өртгийн гинжин хэлхээний үндсэн шинж чанаруудыг харуулав.

Бүрэлдэхүүн хэсэг	Монголын ноолуурын өртгийн сүлжээний онцлогууд
Босоо хамаарал	<ul style="list-style-type: none"> • Үнийг олон улсын зах зээл (ноос ноолуурын эрэлт, нийлүүлэлт) тогтоодог. • Малчид төрөл бүрийн хоршоод, БАХ-ны гишүүн болох эсвэл албан бус хэлбэрээр хамтран ажилладаг. Төв суурин газарт ойр малчид үнэ ханшийн мэдээллийг интернэтээр эсвэл ченжүүд уруу утасдах замаар олж авдаг. Илүү алслагдсан бүс нутагт үнэ нь тийм ч ил тод биш байдаг. Малчдын хоорондын уялдаа холбоо сул. • Малчид чанартай түүхий эд, ноолуурандаа илүү үнийн урамшуулал авч чаддаггүй. Нөгөө талд нь ноос, ноолуурын үйлдвэрлэгчид чанартай түүхий эдэд өндөр үнэ төлөхөд бэлэн байдаг. Малчид, үйлдвэрлэгчдийн хоорондын зохицуулалт сул. • Малчид ченжүүдээс хэт хамааралтай байдаг нь тэд бэлэн мөнгөний урьдчилгаа өгдөгтэй холбоотой. Хоршоодод ийм санхүүгийн чадавх байхгүй. Гэрээт нийлүүлэлтийн тогтолцоо хөгжөөгүй. • Үйлдвэрлэгчдийн түвшинд босоо хамааралт сүлжээ байдаггүй ч ихэнх нь Ноос ноолуурын холбооны гишүүн, бусад нь Худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүн байдаг.
Хөндлөн хамаарал	<ul style="list-style-type: none"> • Зарим малчид хоршоод нэгдсэн байдаг. Хоршоод нь хоршоодын ашиг сонирхлыг хамгаалдаг үндэсний дээвэр холбоонд нэгддэг. Малчид бие биедээ харилцан дэм болж амьдрах ба албан бус сүлжээ хамаарлыг бий болгосон байдаг. • Монголын ихэнх боловсруулагчдыг нэгтгэсэн Ноос ноолуурын холбоо тэдний эрх ашгийг хамгаалан ажилладаг. Тус холбоо нь олон улсын үзэсгэлэн худалдаа, бодлого шийдвэр гаргах түвшинд үйлдвэрлэгчдийг төлөөлдөг. Холбоо нь шинэ гишүүдэд нээлттэй, гишүүнчлэлийн татвартай байдаг. • Монголын тогтвортой ноолуурын брэнд/логог хөгжүүлэх хүчин чармайлт • Хэдийгээр жижиг, том боловсруулагчдыг өрсөлдөгчид

	<p>гэж үзэж болох ч жижиг сүлжмэлийн цехүүдэд зориулж ноолуур боловсруулах (угаах, самнах, ээрэх) хийх хүсэлтэй боловсруулагчид байдаг.</p>
--	---

Зах зээлийн хүчин чадал	<ul style="list-style-type: none"> • Малчдын түвшинд монопол худалдан авагчид байдаг. Малчид хэдхэн тогтсон ченжүүдэд л ноолуураа зарах боловч тэд өрсөлдөхүйц, шударга үнэ төлдөггүй. • Банкууд нөлөө бүхий байр суурь эзэлнэ. Төрийн банк, Хаан банк зэрэг улс орон даяар салбартай банкууд илүү нөлөөтэй бөгөөд малчид банкны зээлээс хамааралтай байдаг. • Ченжүүд нь ноолуураа борлуулах дотоодын үйлдвэрүүд болон экспортын зах зээл гэх мэт олон сонголттой. • Говь гэх мэт томоохон үйлдвэрүүд гэрээ хэлэлцээр хийх чадавхтай бөгөөд зээлийн илүү сайн нөхцөлийг (олон улсын байгууллагуудтай ч гэсэн) тохиролцох, төрөөс нэмэлт дэмжлэг авах гэх мэт боломж нь илүү байдаг • Угаах, ялгах бизнес эрхлэгчдийн дунд маш их өрсөлдөөн бий болох төлөвтэй байна (энэ нь 2024 оноос хойш зөвхөн угааж ялгасан ноолуурыг экспортод гаргах болсонтой холбоотой). Ээрэх нь технологийн хувьд төвөгтэй тул олон улсын өрсөлдөөнд Монголын компаниуд гологддог. • Ноолуур нь Монголын эдийн засагт маш чухал ач холбогдолтой учраас томоохон тоглогчид нь улс төрийн эрх мэдэлтэй байдаг.
Итгэл	<ul style="list-style-type: none"> • Малчид хоршоод болон БАХ-н үндэсний үйлдвэрлэгчдээ гэх мэтчилэн босоо хамааралт дэд сүлжээний тоглогчдын дунд итгэлцэл илүү бий болсон байна • Малчид аль байгууллагад хамгийн их итгэж байгаа талаар харилцан адилгүй хариулт өгсөн • Олон тоглогчид Хятадын компаниуд болон тэдний Монголын ченжүүдийн талаар сөрөг ойлголттой байдаг.
Нийгмийн үнэт зүйл	<ul style="list-style-type: none"> • Хоршоод, БАХ, багийн иргэдийн оролцоо харьцангуй шударга эрүүл байна • Малчид худгийн арчилгаа, тэжээлийн ургамал тариалах, хураах, зам гаргах, засварлах зэрэг үйл ажиллагаанд бие биеэ дэмжиж ажилладаг.
Албан болон албан бус дүрмүүд	<ul style="list-style-type: none"> • Монгол хүний үндсэн зан чанар, бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт зан заншил өртгийн сүлжээн дэх харилцан итгэлцлийг бий болгоход чухал нөлөө үзүүлдэг.

Хүснэгт 2-16: Ноолуурын өртгийн сүлжээний засаглал

2.5.2 Стандарт, үнэлгээ баталгаажуулалт

Монгол ноолуурын өртгийн сүлжээ нь олон байгууллагуудаас тогтоосон маш олон стандарт журмууд болон сайн дурын баталгаажуулалтын схемтэй байдаг. Эдгээрийн үндсэн гол

зорилго нь байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэлийг малчид, үйлдвэрлэгчдийн дунд нэвтрүүлж чанартай бүтээгдэхүүн гаргахад чиглэсэн байдаг. Хүснэгт 2-17-д томоохон стандартуудыг харуулсан бол хүснэгт 2-18-т үйлдвэрлэлийн түвшний стандартыг харууллаа.

Нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Хамрах хүрээ	Зорилт	Шалгуур үзүүлэлтүүд	2023 оны байдлаар
Нэхмэл, самнасан ноолуурын техникийн шаардлага (MNS 3683:2015)		Самнасан ноолуурын чанарын стандарт	Ноолуурын чанарын үзүүлэлт, шаардлагыг тодорхойлох	Өнгө, боловсруулалтын зэрэг, чанарын зэрэг, диаметр, урт, хялгас болон бүдүүн ширхэгт бусад үс, чийглэг байдал	
Хариуцлагатай нүүдэлчид Co P:RNS 6891:2020	МБАНХ	БАХ, Баг, Сум, хоршоо	Мөшгөх боломжтой ногоон эко бүтээгдэхүүн үйлдвэрлэх	5 бүлэг 118 үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • 15 хоршоо • 600 тн мах • 15 тн ноолуур
Бэлчээрийн менежмент CoP	ТННЭ	Хоршоо	Бэлчээрийн менежментийн стандарт	4 бүлэг 30 үзүүлэлт	
Мал CoP	ТННЭ	Хоршоо	Ямааны менежмент болон ноолуур бэлтгэх стандарт	10 бүлэг 74 үзүүлэлт	750 тн ноолуур
S3C	AVSF	Хоршоо	Бэлчээрийн менежмент	боломжгүй	Хариуцлагатай нүүдэлчин стандарттай нэгдсэн 2023

Хүснэгт 2-17: Малчдын түвшний стандарт, баталгаажуулалт хоршооны түвшний мэдээлэл

Эх сурвалж: Ярилцлага

Малчдын хоршооны Хариуцлагатай нүүдэлчин бэлчээрийн мал аж ахуйн зохистой дадлын стандарт болон S3C стандартыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдаг. Хариуцлагатай нүүдэлчин стандарт (ХНС)-ыг анх ШХА-ын Ногоон алт төслийн малын эрүүл мэндийн хөтөлбөрийн дэмжлэгээр боловсруулж Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоогоор дамжуулан хэрэгжүүлж, МАА-н тогтвортой үйлдвэрлэл болон мөшгөх тогтолцоог туршиж байна. 2017 оноос хойш хэд хэдэн сумдад туршиж, мөшгөх тогтолцоог сүү, мах, ноолуур, сарлагийн хөөвөр, торомны ноос зэрэгт түүхий эдийг хамруулж байв. Энэ нь дээрх түүхий эдийг байгалийн эрүүл бэлчээрт өссөн эрүүл малаас авсныг нотлох, гарал үүсэл, чанарыг нь баталгаажуулан хянах зорилготой. 2021 оны 2 сард Стандарт, Хэмжил зүйн газраар баталгаажин үндэсний MNS 6991:2020 стандарт болсон.

ХНС болон ТНГХ-ны хороо стандарт нь малчид, тэдний гишүүнчлэл бүхий байгууллагыг алхам тутамд нь чиглүүлэн зөвлөж, үе шат бүрд нарийн хянан шалгаж байв. Малчидтай хийсэн ярилцлагын үед Тогтвортой ноолуурын эвслийн (SFA) сайн дурын стандарт нь нягт нямбай биш, голчлон санал асуулгад тулгуурласан байсан гэдгийг зарим нь хэлж байв.

ХНС нь таван суурь шалгуур үзүүлэлттэй бөгөөд үүнийг МБАНХ болон гуравдагч байгууллага хянан шалгах боломжтой. Үүнд:

- Бэлчээрийн менежмент: Малчид нэгдэн БАХ байгуулах, бэлчээр ашиглалтын гэрээ хийх, хоршооны гишүүн болох, бэлчээрт ШУ-ны үндэслэлтэйгээр тогтсон хугацаанд системтэйгээр мониторинг хийх
- Малын эрүүл мэнд: Улмын Мал эмнэлгийн удирдах газар хянах
- Малын хүч, тарга тэвээрэг: МБАНХ хянах
- Байгаль орчны менежмент: Зэрлэг амьтан, ховор ургамлыг хамгаалах, МБАНХ-оос хяналт тавих
- Мөшгөх боломжтой, чанартай түүхий эд

2023 онд ХНС-ыг Олон улсын гуравдагч байгууллага болох Текстил эксченж (textile exchange) аудит хийж шалгав. Энэ нь анх удаа олон улсын хөндлөнгийн аудит хийлгэсэн явдал бөгөөд олон улсын стандартуудтай хэрхэн нийцэж буйг тодорхойлох зорилготой байсан юм.

Нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Хамрах хүрээ	Зорилт	Тулгуур үзүүлэлтүүд	2022 оны байдлаар
Тогтвортой нэхмэл MNS 6926:2021	WCA	Боловсруулах компаниуд	Нэхмэлийн хяналт, магадлан итгэмжлэл	13 тулгуурт 61 үзүүлэлт	4 компани
Хаан ширхэгт	WCA	Боловсруулах компаниуд	Нэхмэлийн хяналт, магадлан итгэмжлэл	13 тулгуурт 61 үзүүлэлт	4 компани
Ноолуур CoP	SFA	Боловсруулах компаниуд	Боловсруулах компани стандарт	9 тулгуурт 88 үзүүлэлт	308 тн угааж ялгасан ноолуур, 4500 хувцас

Хүснэгт 2-18: Үйлдвэрт хэрэгжиж буй стандарт болон баталгаажуулалтын схем

Эх сурвалж: Зохиогчдын ярилцлага

Бүтээгдэхүүн үйлдвэрлэх оёдлын үйлдвэрлэлийн хувьд Монголын Ноос, ноолуурын холбоо (МННХ) нь Тогтвортой нэхмэлийн стандарт (MNS 6926:2021) -ийг ашиглан компаниудад хяналт тавьж, аудит хийх эрх бүхий бие даасан баталгаажуулалтын байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн. Мөн Монголын Монголын Хаан ширхэгт барааны тэмдэг эзэмшигч. Одоогийн байдлаар 18 оёдлын компанитай хамтран ажиллаж байгаагийн 12 компани нь тогтвортой үйлдвэрлэлийн чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд MNS 6926:2021 стандартыг нэвтрүүлж, Монголын Хаан ширхэгт тохирлын гэрчилгээ эзэмшигчийн жагсаалтад багтсан байдаг. MNS 6926:2021 нь үйлдвэрлэлийн шатны эрчим хүч, хаягдал ус цэвэршүүлэх, химийн хэрэглээ, хөдөлмөрийн харилцаа, эрүүл аюулгүй байдал зэрэг үйл ажиллагааг хамарна. Энэ стандарт нь мөн ХНС-тай нягт холбоотой. MNS 6926:2021 стандартын дагуу ажиллаж буй компаниуд ХНС-ыг нэвтрүүлсэн малчид, малчдын байгууллагаас түүхий эдээ авах шаардлагатай. МННХ нь МБАНХ болон AVSF - той нягт холбоотой ажилладаг. МБАНХ-ны 79 хоршоо, AVSF-ны 7 хоршоог мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг хэрэгжүүлэх зорилготойгоор ажиллаж байна.

Олон улсад хувцас үйлдвэрлэл эрхэлдэг томоохон компаниудын вэб сайтуудтай танилцвал тэд өргөн хүрээний стандартуудыг (SFA Gold, MNS 6926:2021, Organic, Swiss OEKO-TEC, ISO 9001:2015, Woolmark) болон байгаль орчны тогтвортой байдал, ойг доройтол сүйтгэлээс хамгаалах, мөшгөх тогтолцоо, нийгмийн хариуцлага гэх мэт тогтвортой үйлдвэрлэлийн олон стандарт, шаардлагуудыг дагаж мөрддөг болохыг харж болно. Эдгээрээс нэг томоохон компани нь МБАНХ, Step-Ecolab болон THX-той хамтран

ажилладаг байна. Одоогоор нэг ч компани малчин, хоршооны түвшний стандартыг сурталчлаагүй байна.

<https://sustainablecashmere.ngo> вэб сайтад “Монгол Улсын Оюуны Өмчийн Газраас 2020-21 онд Тогтвортой ноолуур болон бусад Монголын Хаан ширхэгт (Noble Fibers) тохирлын гэрчилгээг ННХ-д олгосон”¹⁸ гэж бичжээ.

Итали улсын нэгэн компани цахим хуудсандаа Монголын ХНС-ын дагуу бэлтгэсэн түүхий эд бэлтгэж авдаг тухайгаа мөн дурдсан байна.

МБАНХ нь Монгол ноолуурын газар зүйн онцлогийг таниулахаар ажиллаж байгаа бөгөөд нийт газар зүйн онцлог бүхий 9 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна (Хүснэгт 2-19)¹⁹

Гэхдээ оролцогч талууд газар зүйн шалгуур үзүүлэлтийг бүхэлд нь стандарт гэж үзэх эсвэл Хариуцлагатай нүүдэлчин стандартаас хэрхэн ялгаж ашиглах талаар эргэлзэж байна. Энэ нь нэгдсэн зөвшилцөлд хүрч чадаагүй нарийн төвөгтэй асуудал байсаар байна.

Гэвч судалгааны үед энэ газар зүйн шалгуур үзүүлэлтийн талаар хүмүүс төдийлөн дурдаагүй ба судалгааны багийнхан аль ч стандарт норм нь эцэстээ чанартай, тогтвортой бүтээгдэхүүн үйлдвэрлэлд чиглэж буйг онцлон анхаарсан юм

Нэр	Эзэмшигч байгууллага	Аймаг
Монгол улаан ямааны тогтвортой ноолуур	МБАНХ	Төв
Монгол хар ямааны тогтвортой ноолуур	МБАНХ	Төв
Монгол цагаан ямааны тогтвортой ноолуур	МБАНХ	Говь
Алтай улаан ямааны тогтвортой ноолуур	МБАНХ	Говь-алтай
Баяндэлгэр улаан ямааны тогтвортой ноолуур	МБАНХ	Сүхбаатар
Завхан буурал ямааны тогтвортой ноолуур	МБАНХ	Завхан
Залаа жинст ямааны тогтвортой ноолуур	МБАНХ	Баянхонгор
Өлгий улаан ямааны тогтвортой ноолуур	МБАНХ	Баян-өлгий
Эрчим хар ямааны тогтвортой ноолуур	МБАНХ	Хөвсгөл

Хүснэгт 2-19: Монгол ноолуурын газар зүйн үзүүлэлт

Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, баталгаажуулалтын эцсийн хэрэглэгчдэд мэдээлэх, ойлгуулах, сурталчлах нь өртгийн сүлжээг хөгжүүлэхэд маш чухал юм. Одоогийн олон тооны стандарт нь хэрэглэгчдийн дунд төөрөгдөл үүсгэх эрсдэлтэй. Тиймээс судалгааны баг дараах зүйлийг зөвлөж байна. Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хоёр стандартыг хувцас үйлдвэрлэгчдэд шошго болгон сурталчлах; стандарт хоорондын уялдаа холбоо хангах, олон нийтэд сурталчлахын тулд үйлдвэрлэгчид болон экспортлогч компаниудын хамтын ажиллагааг сайжруулах

¹⁸ <https://sustainablecashmere.ngo/#pgi-certification>. Үүнийг ММА-ын цахим хуудасд 2023 оны 2 сарын 23-д мэдэгдсэн. <https://montsame.mn/en/read/313756>

¹⁹ МБАНХ-ны мэдээлэл

2.6 SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Үйлдвэрлэлийн нөөц арвин (өргөн удам газар нутаг, олон тооны ямаа) - Нутагшсан сайн үүлдрийн ямаа - Даван туулах, дасан зохицох чадвартай уугуул малчид - Үйлдвэрийн өртөг бага - Эрчим хүч хямд - Ур чадвартай ажилчдын нөөц сайтай - Ажиллах орчин, цалин хөлс сайн - Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт сайн - МСХЗГ-аас баталсан Тогтвортой байдлын стандарт 	<ul style="list-style-type: none"> - Бэлчээрийн менежментийг зохицуулах хуулийн орчин тодорхойгүй - Өвөл, хаврын улиралд малын тэжээлийн хомсдол нь ноолуурын чанарт сөргөөр нөлөөлдөг - Нутгийн үүлдрийн ямааны үүлдэр угсааг сайжруулах үржлийн ажил тогтсон систем, хяналтгүй - Малчид ноолуурын орлогоос хэт хараат байх - Хүн амын сийрэг нягтаршил нь тээвэр зуучийн хувьд өртөг өндөр болгодог - Чанарт суурилсан үнийн тогтолцоо бүрдээгүй - Малчид улирлын чанартай орлоготой учраас өртгийн сүлжээгээр дамжуулсан зээлийн үйлчилгээ байхгүй - Эргэлтийн хөрөнгө худалдан авах зээлийн хүү өндөр - Ноолуураас бусад түүхий эдийн өртгийн сүлжээ сул хөгжсөн. Ямааны мах, арьс үнэ бага - Боловсруулах үйлдвэрүүд УБ-д хэт төвлөрсөн - Боловсруулах шатны байгаль орчны стандарт шаардлагууд үр нөлөө багатай - Үнийн ил тод бус байдал. Монголын хөдөө ахуйн биржийн үйл ажиллагаа тогтворжоогүй.
Боломж	Эрсдэл

<ul style="list-style-type: none"> - БАХ-н хөгжил - Бэлчээрийн тухай хуульд оруулсан өөрчлөлт - Зөвхөн угааж , самнасан ноолуурыг экспортод гаргах шаардлага - Байгалийн органик ноолуурын хэрэгцээ өсөж байна - Нүүдэлчдийн соёл, онцлогийг ОУ-н зах зээлийн сурталчилгаанд ашиглах нь ихэссэн - Япон болон Европын өндөр хөгжилтэй орнуудаас орж ирж буй өндөр чанартай ээрэх, сүлжих тоног төхөөрөмж, тэдгээрийг дагасан технологийн нөү хау мэдлэг - Хоршоодоор дамжуулан менежментийг сайжруулах - Тогтвортой Нэхмэлийн MNS 6926: 2021 стандарт 	<ul style="list-style-type: none"> - УАӨ - Ямааны тоон өсөлт - Бэлчээрийн доройтол - Эдийн засгийн тогтворгүй байдал - Голланд өвчлөл: Уул уурхайн өндөр орлогод дулдуйдсан эдийн засгийн буруу хөгжил - Олон улсын тээвэр, ложистикийн сүлжээнд нэгдэхэд учрах бэрхшээл. Орос Украины дайнаас шалтгаалан Оросоор дамжин ЕХ-ны улсууд уруу тээвэрлэх боломжгүй болсон. - Хятадын эдийн засгийн нөлөө ихсэж байна
--	---

3. ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР ЮУ ВЭ?

3.1 Ашигласан арга зүй

Эдийн засгийн дүн шинжилгээ нь VCA4D арга зүйд тулгуурладаг бөгөөд дүн шинжилгээний зорилгыг тодорхой тусгаж, ашиглах үндсэн асуултуудыг тодорхойлсон байдаг.

Энд үзүүлсэн үр дүнг AFA программ хангамжийн тусламжтайгаар үүсгэсэн.

Дүн шинжилгээнд ашигласан дата өгөгдлийг янз бүрийн эх сурвалжаас цуглуулав. Үүнд:

- Монгол Улсын статистикийн хорооноос улсын нийт төсөв, дундаж үнэ, ноолуурын үйлдвэрлэлийн талаарх мэдээлэл.
- Өрхийн нийгэм, эдийн засгийн 2021 оны судалгаа (Үндэсний статистикийн хороо, 2023а)
- Оролцогч талууд, үйлдвэрлэгчид, боловсруулах компаниудтай хийсэн ярилцлага

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2021 оны судалгаанаас малчин өрхийн мал аж ахуйн орлого, зарлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авав. 2021 оны судалгааны мэдээллийг 2022 оны инфляцийн түвшинтэй (13.2%) болон үнийн өсөлтийн хувьтай харгалзуулан тооцоолж гаргав. Судалгаанд ямааны ноолуур самнаж, борлуулдаг нийт 4109 малчин өрхийн 3504-ийг хамруулж, сүргийн бүтэц, малын тоо толгой, орлого, зардлын талаарх ойлголтыг өгчээ. Ялангуяа мал, мах борлуулалт, малын гаралтай бусад түүхий тухайлбал ноолуур, ноос, арьс шир, цагаан идээ зэрэг орлогын эх үүсвэрийг нарийвчлан тодорхойлсон.

Мал эмнэлгийн үйлчилгээ, бензин тос гэх мэт нийтлэг зардлуудыг дан ямаанд ногдохыг тооцож гаргах нь ярвигтай учраас нарийн тооцооллыг дахин нягталж хийв. Европын холбооноос гаргасан Нэгж малын (НМЗ)²⁰ зардлыг суурь үзүүлэлт болгон тооцоолж гаргасан.

Санхүүгийн тооцооллыг хийхдээ малчин өрх тутмын 100 ямааг нэг бүлэг болгосон ба зөвхөн 1-с дээш настай ямааг оруулан тооцов. Энэ тооцооллоор 100 ямаа **11.55 НМЗ**-тэй тэнцэнэ. Зардлыг 1 НМЗ-аар тооцож 11.5-р үржүүлж тооцно. Малчид НӨАТ-аас чөлөөлөгдсөн ба харин орлогын албан татвар болон НД, ЭМД-ыг төлөх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 3-1-т үзүүлэв

Нэр төрөл	Ногдох зардал 1 НМН – Жижиг (n=2,922)	Ногдох зардал 1 НМН – Том (n=580)
Малын тэжээл	36,109 ₮	21,991 ₮
Мал эмнэлэг	3,028 ₮	2,200 ₮
Шатахуун	14,651 ₮	9,752 ₮
Цалин	3,876 ₮	5,172 ₮
Бусад (Ус, Г.м)	272 М₮	437 ₮
Мотоцикл	20,536 ₮	8,646 ₮
Ачааны машин	55,326 ₮	41,770 ₮
Машин	76,773 ₮	41,291 ₮
Гэр	•	8,298 ₮
Малчны зээл	54,133 ₮	42,371 ₮

Хүснэгт 3-1: Өрхийн судалгаанд суурилсан Монгол хүний зардал (Инфляцид суурилсан тооцоолол)
Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2023А)

²⁰ Дэлгэрэнгүй мэдээллийг Евростатын мал аж ахуйн нэгжийн тайлбар толь бичгээс харна уу (Евростат, 2023).

Өртгийн сүлжээний бусад тоглогчдын санхүүгийн байдлын талаарх судалгааг бусад хоёрдогч эх үүсвэр, ярилцлага, томоохон компаниудын санхүүгийн нээлттэй тайлан зэргээс ашиглан гаргав. (Lenzen et al., 2016).

3.2 Өртгийн сүлжээний тоглогчдын бүтээмж ба тогтвортой байдал

Энэ бүлэгт дээр дурдсан өртгийн сүлжээний тоглогчдын санхүүгийн байдлын талаар өгүүлэх бөгөөд эхний хэсэг цөөн болон олон малтай малчин өрхүүд дээр илүү төвлөрлөө. Сүүлийн хэсэгт бусад тоглогчид буюу ченжүүд, ноолуур угаах цехүүд, ноолуур самнах үйлдвэрүүд, болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн санхүүгийн байдлаарх мэдээллийг багтаав. Үйлдвэрийн түвшний зардлыг технологи, тоног төхөөрөмж гэх мэтчилэн цогц асуудал учраас нэг кг тутамд ногдох зардлаар тооцож гаргав.

3.2.1 Зуун ямаатай, мал цөөтэй малчин өрхийн санхүүгийн байдал, улсын дундаж

Цөөн малтай малчин өрх гэж 600-с доош малтай малчин өрхийг хэлнэ. Ийм өрхүүд дунджаар 95 ямаатай байдаг. goats. Арга зүйд дурдсанчлан бид малчидтай ярилцлага хийж мэдээлэл авснаас гадна Өрхийн ЭЗ-ийн судалгааны тайлан ашиглав. 100 ямаанаас дунджаар 87 ямааг самнадаг. Бусад нь самнах боломжгүй шинэ төл байдаг. Нэг ямаанаас авах ноолуурын гарц болон нэг кг ноолуурын үнэ бүс бүсээс шалтгаалан өөр өөр байна. Зүүн бүсийн аймгуудад 100 ямаанаас ойролцоогоор 30.9 кг ноолуур авдаг бол баруун аймгуудын ямааны ноолуурын гарц өндөр ч чанарын хувьд (хялгас, хог ихтэй) доогуур байдаг.

Малын тоо толгой хурдацтай нэмэгдэж байгаа нь мал эмнэлгийн тусламж үйлчилгээнд мөн хүндрэл үүсгэж байна. Зарим мал эмнэлгийн үйлчилгээ тухайлбал эр малыг хөнгөлж засах ажлыг малчид өөрсдөө хийх боломжтой боловч мэргэшсэн малын эмчийн мэдлэг шаардах үйлчилгээ олон бий. Малын зарим халдварт өвчний вакцинжуулалтыг төрөөс үнэ төлбөргүй хийдэг ба бусад мал эмнэлгийн үйлчилгээний төлбөрийг малчид өөрсдөө хариуцах ёстой. Түүнчлэн малын паразит, шимэгчдээс хамгаалахын тулд хаврын угаалга хийх ёстой. Хуучин цагт мал угаалгын суурин ванн бэлдэн, угаалгын бодистой усанд малыг оруулж гаргадаг байсан бол сүүлийн үед тусгай шүршүүрийн машин ашиглан угааж байна. Хэрэв сум бүр мал угаах явуулын шүршүүртэй бол мал угаалгын явцыг ихээхэн хөнгөвчилж, малчид заавал малаа туун сумын төв орж угаалгах шаардлагагүй болно. сумын төв рүү мал явах шаардлагагүй болж байна. Угаах зардал нь ямаа тутамд 200 төгрөг байна.

Малын олон, цөөнөөс үл шалтгаалан ямаа самнах үеэр малчид туслах ажилчин хөлсөлдөг. Одоогийн нөхцөл байдлаас дүгнэхэд ямааг 1-2 өдрийн дотор бөөнд нь самнадаг ба ямаа самнах туршлагатай хувь хүмүүсийг хөлсөөр самнуулдаг. Аймаг, сумын төвийн ажилгүй хүмүүст ямаа тутмаар тооцон ажлын хөлс олгон самнуулдаг. Хөлсөөр ажиллах гэрээ гэж байхгүй, амаар тохирон хийдэг.

Малчдын улсын төсөвт оруулж буй хувь нэмрийн тухайд малчдын ердөө 10-15 орчим хувь нь нийгмийн даатгалд идэвхтэй хамрагддаг. Ихэнх нь улсын нийт төсөвт хувь нэмэр

оруулдаггүй, татвар төлдөггүй. 2021 онд Монгол Улс малын тоог цөөрүүлэх зорилгоор малын хөлийн татвар хэрэгжүүлсэн. Дээр дурдсанчлан малчид эхний жилд татвар төлөхөд бэлэн байсан ч 2022 он гэхэд төлөлтийн хэдийн буурч эхэлсэн байна. Цөөн малтай малчдын хувьд, ойролцоогоор 50% нь малын хөлийн татвараа үнэн зөвөөр төлдөг гэж судалгаагаар гарчээ.

Малчид бэлэн мөнгөний гачаалаас шалтгаалан ченжүүдэд ноолуураа бага үнээр өгөх, урьдчилан зээлэх гэх мэт асуудлуудтай үргэлж тулгардаг. Санхүүгийн асуудлаа хийдэхийн тулд тэдэнд хөндлөнгийн зээлийн үйлчилгээ чухал хэрэгцээтэй байдаг. Малчид жилдээ 2 удаа бэлэн мөнгөтэй болдог. Нэг нь хавар ноолуур борлуулах үед, нөгөө нь намар мал зарах үед. Намар нэг ямааг 90,000 төгрөгөөр борлуулдаг. Мал, мах борлуулах явц нь бас төвөгтэй. Малчид мал нядалгааны газарт нэг мал тутамд 5000 төгрөг төлж гаргуулаад гулууз мах болон арьсыг сүүлд нь борлуулдаг. Ингэж мал гаргаж гулуузлан зарвал малчдад арай ахиу мөнгө олох боловч малчин бүр ингэж чаддаггүй. Зун, намар ямааны арьс зах зээлд ямар ч үнэгүй дөнгөж 1000 төгрөг байна. Харин өвөл, хавар ноолуур суусан үедээ 35000 төгрөг хүртэл үнэ нь өсдөг.


Цөөн малтай малчин өрхийн хувьд ямаа нь хүнс тэжээлийн гол эх үүсвэр болдог. Малчин өрх жилд дунджаар 30-40 мал (үүнээс 8 нь ямаа) ахуйн хэрэгцээндээ хэрэглэдэг.

Говь нутагт ямаагаа сааж, ааруул цагаан идээ боловсруулан зарж өрхийн орлогодоо нэмэрлэдэг. Харин бусад бүсэд үхэр, хонио сааж цагаан идээ хийдэг. Үхэр, хонины сүүний гарц ч ямааныхаас илүү байдаг. Судалгаагаар малчид ямааны сүүгээ ихэвчлэн өрхийн хэрэгцээндээ л хэрэглэнэ. Багахан хэсгийг борлуулдаг.

Цөөн малтай малчин өрх	Зүүн бүс	Төвийн бүс	Хангайн бүс	Баруун бүс
Үнэ(₮)	125,753	96,080	105,458	92,888
Ноолуурын гарц (Кг/Ямаа)	0.3090	0.3631	0.3118	0.4082
Үйлдвэрлэл ₮	6,198,696	5,801,593	5,601,108	6,104,616
Үйл ажиллагааны нийт ашиг (₮)	5,336,887	4,944,237	4,745,757	5,244,230
Үйл ажиллагааны цэвэр ашиг (₮)	4,679,341	4,286,691	4,088,211	4,586,684
Нэмүү өртөг (₮)	5,552,202	5,155,100	4,954,615	5,458,123
Ашгийн хэмжээ (₮)	75%	74%	73%	75%
Ямааны тоо (Мянган толгой мал)	2,369	4,226	5,235	4,373
Хөдөө аж ахуйн ДНБ-д оруулах хувь нэмэр	1.9%	3.1%	3.7%	3.4%

Хүснэгт 3-2: 2022 оны цөөн малтай малчин өрхийн 100 ямаа тутмын санхүүгийн үзүүлэлт, бүс нутгийн ялгаа

Экологийн дөрвөн бүсэд байх ямаанаас авах ашиг шим нь үүлдрээс үл шалтгаалан бараг адил байгааг Хүснэгт 3-2-аас харж болно. Зүүн бүсэд нэг ямаанаас авах ноолуурын үнэ нь өндөр ч хэмжээ нь бага байдаг. Нийт өрхөд тэнцэтгэн хуваавал ашгийн зөрүү төдийлөн байхгүй. Харин Хангайн бүсэд ашгийн зөрүү бага зэрэг гарч байна. Ямааны тоо толгойноос шалтгаалан цөөн малтай малчин өрхийн ХАА-н салбарын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь доогуур байдаг. Хангайн бүсийн олон ямаатай малчин өрхийн ХАА-н салбарын ДНБ-д оруулах хувь харьцангуй өндөр буюу 3.7% байна. Үүний зэрэгцээ цөөн малтай малчин өрхийн ямааны ноолуур ХАА-н салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд 12%-ийг эзэлдгийг тэмдэглэх хэрэгтэй.



Зураг 3-1: Хөдөө аж ахуйн ДНБ-д оруулах хувь нэмэр болон цөөн болон олон малтай малчдын үйлдвэрлэл. 2022

3.2.1 Зуун ямаатай, мал ихтэй малчин өрхийн санхүүгийн байдал

Мал ихтэй малчин өрхийн орлого, зарлага цөөн малтай айлынхаас тийм ч их ялгаатай биш. Нэг өрх дунджаар 338 ямаатай байдаг. Олон малтай зарим малчид туслах малчин авч цалинжуулдаг тул зардал тэр хирээр өсдөг. Гэхдээ Хүний эрхийн комиссын тайлангаар мал ихтэй малчин өрхийн дөнгөж 16 хувь нь туслах малчинтай байна. (Баттөр, 2022). Туслах малчин авсан тохиолдолд гэр орон, хоол хүнсийг нь бэлдэх, цалин өгөх, НД, ЭМД-ыг нь төлөх ёстой. Хэдий тийм ч олон малтай малчдын туслах малчнаар ажиллах хүсэлтэй хүмүүс цөөн, ажиллах хүн олдоггүй. Баттөрийн судалгааны тайланд дурдсанаар туслах малчид бэлэн мөнгөний цалин авах нь бараг үгүй, ихэнхдээ мал, мах, цагаан идээгээр цалингаа авдаг байна. Туслах малчны хөдөлмөр цаг наргүй, амралтгүй. Үүнтэй харьцуулбал хөдөлмөртөө нийцэхүйц цалин авч чаддаггүй байна. Олон малтай малчин өрхийн мал эмнэлэг, бензин тос, малын тэжээл зэрэг нэгж малд зарцуулах зардал гардаг. Мөн мал ихтэй малчин өрх арай бага зээл авсан байна.

Цөөн болон олон малтай өрхийн санхүүгийн байдлыг харьцуулан үзвэл олон малтай айлын ашгийн зөрүү бага зэрэг өндөр байгаа нь тийм ч их зөрүүтэй ялгаа биш юм. Олон малтай өрх олон ямаа зарна, бусад малаас авах ашиг шим нь арай их байдаг. Ерөнхийдөө олон малтай малчин өрх ноолуураас шалтгаалсан орлогоос төдийлөн хараат биш байдаг.

Олон малтай малчин өрхийн ХАА-н дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 7.7 байна. (Хүснэгт 3-3).

Олон малтай малчин өрх	Зүүн бүс	Төвийн бүс	Хангайн бүс	Баруун бүс
Үнэ (Кг/₮)	125,753	96,080	105,458	92,888
Ноолуурын гарц (Кг/Ямаа)	0.309	0.36	0.31	0.40
Үйлдвэрлэл ₮	5,497,116	5,100,013	4,899,528	5,403,036
Үйл ажиллагааны нийт ашиг (₮)	4,728,411	4,337,503	4,140,146	4,635,799
Үйл ажиллагааны цэвэр ашиг	4,149,942	3,759,034	3,561,678	4,057,331

(₮)				
Нэмүү өртөг (₮)	5,076,712	4,679,609	4,479,125	4,982,633
Ашгийн хэмжээ (₮)	75%	74%	73%	75%
Ямааны тоо (Мянган толгой мал)	1,662	2,965	3,672	3,068
Хөдөө аж ахуйн ДНБ-д оруулах хувь нэмэр	1.2%	2.0%	2.3%	2.2%

Хүснэгт 3-3:
2022 оны
олон малтай
малчин
өрхийн 100
ямаа
тутмын
санхүүгийн

үзүүлэлт, бүс нутгийн ялгаа

3.2.2 Дундын зуучлагч буюу ченжүүдийн санхүүгийн байдал

1 Кг тутамд		Үнэ / Кг	Нэгж	Эцсийн зардал/ Орлого
Орлого	Түүхий ноолуур	104,000	1.00	104,000
Нийт үйлдвэрлэл				104,000
Түүхий эд	Ноолуур (Кг)	102,000	1.00	102,000
Үйлчилгээ	Тээвэрлэлт	681	1.00	681
	Бусад	100	1.00	100
Цалин	Цалин	150	1.00	150
Татвар	Татвар	956	10.0%	96
Элэгдэл хорогдол	Элэгдэл хорогдол	104,000	0.1%	104
Нийт зардал				103,131
Ашигт ажиллагааны харьцаа				
Үйл ажиллагааны нийт орлого				973
Үйл ажиллагааны цэвэр ашиг				869
Нэмүү өртөг				1,219
Ашгийн зөрүү				0.8%

Хүснэгт 3-4: Зуучлагчийн санхүүгийн данс, 2022 (ТӨГ)

Дундын зуучлагч буюу ченжүүдийн талаар тайлангийн эхэнд илүү дэлгэрэнгүй багтаасан. Энд ерөнхийд нь товчлон оруулбал хоёр төрлийн ченжүүд бий. Уламжлалт хувь ченжүүд болон хоршоо болж нэгдсэн зуучлагчид гэсэн 2 төрөл бий. Хоршоо нь илүү албан хэлбэртэй, гишүүддээ үйлчилдэг бол ченж нь зөвхөн ашиг орлого олохын төлөө дангаараа ажилладаг, ноолуураа Хятад бизнесүүд эсхүл дотоодын үйлдвэрлэгчдэд нийлүүлдэг. Тэд татвар төлдөггүй. Хоршоод НӨАТ-аас чөлөөлөгдсөн байдаг. Аль алиных нь ашиг тун бага. Тэд ихэвчлэн сумаас ноолуур авч Улаанбаатар уруу тээвэрлэж дотоодын үйлдвэрлэгчдэд зардаг. Харин шууд Хятад худалдаачдад ноолуураа нийлүүлдэг ченжүүдэд эргэлтийн их мөнгө хэрэггүй байдаг. Хятад худалдаачид тэднийг ноолуур авах эргэлтийн мөнгөөр хангадаг. Харин нөгөө талдаа, хоршоод ноолуур авах эргэлтийн хөрөнгө мөнгөний хомсдолтой байдаг. Тиймээс арилжааны банкнаас зээл авдаг. Хүснэгт 3-4-т дундын зуучлагчдын санхүүгийн байдлыг харуулав.

Ноолуурын өртгийн сүлжээний тоглогчид зээл олгодог санхүүгийн байгууллагуудаас ихээхэн хамааралтай байдаг. Хүснэгт 3-5-д ноолуурын тээврийн зардлыг бүс нутгаар ялган харуулсан байна. Хамгийн бага тээврийн зардал Улаанбаатар хот тойрсон нутагт, хамгийн өндөр зардал баруун бүсэд байна. Ченжүүд болон хоршоодод байнгын ажилчид цөөн байдаг бөгөөд ноолуур болон түүхий эдийн наймаа нь хир тогтвортой байхаас шалтгаалан байнгын орон тооны ажилчидтай байх эсэхээ шийддэг. Ноолуур

тээвэрлэлтийг ихэвчлэн гэрээт машинаар тээвэрлэдэг ба ноолуураа харж, хянаж явах нэг хүн жолоочийг дагалдан явна.

Бүс нутаг	Зай (Км)	Тээвэрлэлтийн зардал (₮/Кг)
Зүүн бүс	331 - 655	633
Төвийн бүс	40 - 553	413
Хангайн бүс	318 - 671	595
Баруун бүс	984 - 1636	1084

Хүснэгт 3-5 Бүс нутаг хоорондын зай болон тээврийн зардал, 2022

3.2.3 Боловсруулсан ноолуур экспортлогчдын санхүүгийн байдал

1 кг түүхий ноолуур тутамд		Үнэ		Эцсийн зардал/орлого
Үйлдвэрлэл	Ноолуур	140,000	0.88	123,200
	Зээлийн татаас	1,000	1.00	1,000
Нийт үйлдвэрлэл				124,200
Хэрэглээний материал	Ноолуур	104,000	1	104,000
	Уур	200	1	200
	Хатаах эрчим хүч	80	1	80
	Цахилгаан	102	1	102
	Бусад	700	1	700
Үйлчилгээ	Хил хүртэл тээвэрлэх	200	1	200
	Бусад	500	1	500
Цалин	Ангилах	200	1	200
	Угаах	400	1	400
	Нэмэгдэл цалин	1,000	1	1,000
Зээлийн хүү	Зээл	124,200	7%	8,694
Татвар	Хөдөлмөрийн татвар, даатгал	1,600	0.31	496
	MCSE лиценз	994	1	994
	ААНОАБ татвар (10%)	6,335	10%	634
Элэгдэл	Угаах, ялгах	300	1	300
Бусад зардал		118,499		
Ашигт ажиллагааны харьцаа				
Үйл ажиллагааны нийт орлого				6,001
Үйл ажиллагааны цэвэр ашиг				5,701
Нэмүү өртөг				18,418
Ашгийн зөрүү				4.6%

Хүснэгт 3-6: Ноолуур угаах үйл ажиллагааны 2022 оны санхүүгийн бүртгэл (MNT)

Ноолуур самнах хугацаа 3 сараас 6 сарын хооронд байдаг. Ноолуурыг үйлдвэрт нийлүүлсний дараа агуулахад хадгалах, ангилах, цэвэрлэх, угаах, экспортод бэлдэн савлах гэх мэт дамжлагуудаар боловсруулдаг. Ноолуур угаах дамжлага нь 50 хэм хүртэл халаасан усаар угааж хатаадаг тул эрчим хүч их шаарддаг үе шат юм. Ноолуур угаах том том суурин машинууд нь тог цахилгаан их хэрэглэнэ. Гэвч ноолуурын өртгийн сүлжээний нийт зардлыг задалж харвал эрчим хүч, тог цахилгаан, дулаан нь харьцангуй бага хэсгийг эзэлнэ. Хөдөлмөр хөлс, тээвэр ч бас их зардал эзэлдэггүй. Хамгийн гол зардал ноолуур өөрөө байдаг. Ноолуур угаах үйлдвэрийн ашгийн зөрүү маш бага буюу 5% байгаа нь урт хугацаандаа энэ салбарыг хүнд байдалд оруулж мэдэх юм. Ноолуурын хэмжээ ихсэх тусам угаах хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай болж тэр хирээр зээл авах, хөрөнгө оруулалт оруулах хэрэгцээ үүснэ.

Хүснэгт 3-6-д экспортод гаргахаар угаасан ноолуурын зардлыг харуулав.

3.2.4 Ноолуур ялгаж боловсруулах шатны санхүүгийн байдал

1 кг түүхий ноолуур тутамд		Үнэ		Эцсийн зардал/орлого
Үйлдвэрлэл	Ноолуур	345,000	0.53	182,850
	Бүдүүн ширхэгт хялгас	10,000	0.15	1,500
	Зээлийн татаас	1,000	1	1,000
Нийт үйлдвэрлэл				185,350
Хэрэглээний материал	Ноолуур	104,000	1	104,000
	Уур	300	1	300
	Эрчим хүч	100	1	100
	Цахилгаан	302	1	302
	Бусад	1,000	1	1,000
Үйлчилгээ	Хил хүртэл тээвэрлэх	50	1	50
	Бусад	3,000	1	3,000
Цалин	Ангилах	200	1	200
	Угаах	400	1	400
	Ялгах	800	1	800
	Хөдөлмөрийн нэмэгдэл зардал	2,000	1	2,000
Зээлийн хүү	Зээл	185,350	14%	25,949
Татвар	Хөдөлмөрийн татвар, даатгал	3,400	0.31	1,054
	MCSE лиценз (0.8%)	1,483	1	1,483
	ААНОАТ (10%)	31,738	0.1	3,174
Элэгдэл	Угаах, ялгах	185,350	7%	12,975
Нийт зардал				156,786
Ашигт ажиллагааны харьцаа				
Үйл ажиллагааны нийт орлого				41,539
Үйл ажиллагааны цэвэр ашиг				28,564

Нэмүү өртөг		76,598
Ашгийн зөрүү		15.4%

Хүснэгт 3-7: 2022 оны ноос, ноолуур самнах үйл ажиллагааны санхүүгийн бүртгэл, төгрөг

Ноолуурын самнах дамжлага нь хамгийн зардал ихтэй, өндөр мэргэшил ур чадвар шаардсан ажил байдаг. Энэ шатанд ноолууран хамгийн их өртөг нэмэгддэг. Ихэнх ноолуурыг гаднын зах зээл тухайлбал Европын орнуудад зориулан үс хялгаснаас ялгаж боловсруулдаг. Үндэсний үйлдвэрүүд ноолуурыг худалдан авч бэлтгэн боловсруулж экспортод гаргадаг. Орос Украины дайны нөхцөл байдлаас шалтгаалан Оросоор дамжуулан Европын орнууд уруу газраар тээвэрлэх боломж хязгаарлагдмал болж байна. Тиймээс багахан хэмжээтэйг онгоцоор тээвэрлэж байна.

Хөдөлмөрийн хуваарийн хувьд ноолуур нь ангилах, угаах, будах, самнах дамжлагууд байдаг. Дунджаар 1 кг ноолуур 500 гр нарийн ноолуур болдог. Үйлдвэрийн хүчин чадал сайтай үйлдвэр илүү ашиг олдог.

Зардлын бүтцийн хувьд ноолуурын өөрийн үнэ болон зээлийн хүү энэ салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх хамгийн чухал нөлөөтэй. Тог цахилгаан, дулаан эрчим хүч, ажиллах хүчний зардал өртөг зардлын бага хувийг эзэлдэг.

Ноолуурын өртгийн сүлжээ зээлээс ихээхэн хамааралтай байна. Орлогоо 100 хувь зээл болон зээлийн хүү төлөхөд зарцуулж байна. Ногоон зээл, ЗГ-ын хөнгөлөлттэй зээл, гаднын хөрөнгө оруулалтыг эс тооцвол орлогын 20 хувийг зөвхөн зээлийн хүү төлөхөд зарцуулж байна.²¹ Зээлийн дийлэнхийг ноолуур худалдаж авахад зориулж байна.

3.2.5 Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн санхүүгийн байдал

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний кг тутамд үнэ (сүлжмэл бүтээгдэхүүн, ихэвчлэн)		Жижиг үйлдвэрлэгч	Том үйлдвэрлэгч
Үйлдвэрлэл	Нэхэх (Кг тутамд)	754,000	754,000
	Зээлийн татаас	1,000	1,500
	Бүдүүн ширхэгт хялгас	0	1,500
Хэрэглээний материал		249,910	272,600
Үйлчилгээ		55,000	135,990
Цалин		83,050	113,325
Зэлийн хүү		105,700	105,770
Татвар		44,020	39,791
Элэгдэл		52,850	46,086
Нийт зардал		590,530	713,561
Харьцаа	Үйл ажиллагааны нийт орлого	217,320	88,024
	Үйл ажиллагааны цэвэр ашиг	164,470	41,939
Нэмүү өртөг		505,090	482,900
Ашгийн зөрүү		22%	6%

Хүснэгт 3-8: Ноолуур боловсруулах үйл ажиллагаа, жижиг болон том боловсруулагчдын санхүүгийн бүртгэл, 2022 (MNT)

²¹ Говь компанийн жилийн тайланг (2022 он) Шаравдэмбэрэлийн Энхтуулын Докторын ажлын судалгаатай харьцуулан судлав. (ШАРАВДЭМБЭРЭЛ, 2023)

Ноолууран бэлэн бүтээгдэхүүн, хувцас эдлэл үйлдвэрлэл Монголд сайн хөгжсөн.Ноолуураар сүлжмэл бүтээгдэхүүн илүү олноор үйлдвэрлэж байгаа нь зах зээлд ашиглаж байсан хуучин сүлжмэлийн машин элбэг хүртээмжтэй байдагтай холбоотой.

Малчдаас ноолуур худалдан авч ангилж, цэвэрлэн угаагаад ээрч утас болгож үйлдвэрт нийлүүлдэг гэр бүлийн хүрээний жижиг үйлдвэрүүд олон бий. Үйлдвэрүүд ээрсэн утас авч сүлжмэл бүтээгдэхүүн хийнэ.

Одоогоор Монголд 18 орчим жижиг үйлдвэрүүд нийлээд нэг том үйлдвэрийн үйлдвэрлэх хэмжээний хүчин чадлаар ажиллаж байна. Эдгээр компаниуд түүхий ноолуур худалдан авч, бэлэн хувцас үйлдвэрлэн зах зээлд борлуулдаг. Ноолуурын салбарын босоо хамааралт сүлжээнд нэгдсэн хамгийн том оролцогч нь Монголын хөрөнгийн бирж юм. Тус бирж нь арилжаалсан түүхий эдийн борлуулалт, эргэлтийн хөрөнгө, өр төлбөр, мөнгөн гүйлгээ, орлогын талаарх мэдээллийг багтаасан тогтвортой байдлын тайланг жил бүр гаргадаг. 2022 оны санхүүгийн жилийн тайлангийн мэдээлэлд үндэслэн зардлын бүтцийг тооцож үзэв. Түүхий эдийн бирж нь ноолуур боловсруулах бусад олон компаниудын нэгэн адил 2021, 2020 онуудад алдагдал хүлээсэн. Хэдийгээр компанийн нийт үйл ажиллагаа нь ашигтай гарсан ч санхүүгийн их хэмжээний зардлаас үүдэн жилийн нийт үр дүн нь багцалж харвал алдагдалтай гарсан байна.

Монголын нэхмэлийн компаниуд түүхий ноолуур боловсруулж эцсийн бэлэн бүтээгдэхүүн хийх өртгийн сүлжээнээс өндөр ашиг хийх боломжтой хэдий ч санхүүгийн эх үүсвэр нь өндөр өртөгтэйгөөс шалтгаалан үр ашиггүй ажиллаж байгааг хэд хэдэн компанийн тайлангаас харж болно. Хүү багатай зээлийн эх үүсвэртэй болох нь үйлдвэрлэлийн салбарын ашиг нэмэгдэхэд томоохон дэмжлэг болох юм.

3.2.6 Улаанбаатар хотын ноолуурын жижиглэн худалдаачдын санхүүгийн байдал

Эцсийн ноолууран хувцасны 1 кг тутамд		Үнэ / кг	Нэгж	Эцсийн зардал/орлого
Орлого	Бүтээгдэхүүн борлуулалтын үнэ (кг тутамд НӨАТ орсон)	1,129,000	1.00	1,129,000
Нийт үйлдвэрлэл				1,129,000
Материал	Ноолуур (Кг)	754,000	1.00	754,000
	Бусад	1,129,000	0.5%	5,645
Үйлчилгээ	Түрээс	1,129,000	4.7%	53,063
	Үйлчилгээнүүд	1,129,000	2.0%	22,580
Цалин	Цалин	1,129,000	3.0%	33,870
Зээлийн хүү	Зээл	1,129,000	8.0%	90,320
Татвар	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал + бусад	1,129,000	1.1%	12,927
	НӨАТ	1,026,364	10.0%	102,636
	Хотын татвар	42,669	10.0%	4,267
Элэгдэл	Элэгдэл	1,129,000	1.0%	11,290
Нийт зардал				1,090,598
Ашигт ажиллагааны харьцаа				
Үйл ажиллагааны нийт орлого				49,692
Үйл ажиллагааны цэвэр ашиг				38,402
Нэмүү өртөг				293,712
Ашгийн зөрүү				3.4%

Хүснэгт 3-9 Жижиг худалдаа, үйл ажиллагааны санхүүгийн данс (MNT)

Ноолууран бүтээгдэхүүний жижиглэн худалдааны өртгийг Улаанбаатар хотоос авсан мэдээлэлд үндэслэн, борлуулсан бүтээгдэхүүний нэг кг-д ногдох зардлыг өмнөх аргачлалыг ашиглан тооцов. (Хүснэгт 3-9). Бидний тооцоогоор нэг бүтээгдэхүүний жин дунджаар 288 грамм, борлуулалтын үнэ нь 300-350 мянган төгрөгийн хооронд хэлбэлздэг. Улаанбаатар хотод дэлгүүрийн түрээс, НӨАТ, худалдагчийн цалин зэрэг зардал нэлээд өндөр байдаг.

Ноолуур бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа нь харьцангуй өндөр өртгийн сүлжээ бий болгож чадах ч цэвэр ашгийн хувьд мөн адил доогуур байна. Төхижилт сайтай ноолуурын нэрийн дэлгүүр ажиллуулах нь зардал ихтэйн дээр ноолууран бүтээгдэхүүний ихээхэн нөөцтэй байх шаардлагатай тул зайлшгүй зээл авдаг. Эндээс харахад ноолуурын өртгийн сүлжээний салбар бүхэлдээ зээлээс ихээхэн хамааралтай болж байна. Жижиглэн худалдааны салбарын хувьд зээлийн тооцоолсон хүү нь дэлгүүрийн орлогын ойролцоогоор 8%-тай тэнцэж байгаа нь өртгийн сүлжээний дунджаас доогуур байна. Гэхдээ бэлэн мөнгөтэй хүмүүс ноолуурын дэлгүүр нээх хандлага нэмэгдэж байна.


Өртгийн сүлжээний дундаж хэмжээний тоглогчдын үйл ажиллагааны ашиг

ӨС-ний тоглогч	ҮА-ны цэвэр ашиг	Ямааны тоо
Зүүн бүсийн цөөн малтай өрх	5,070,042	95 ямаа
Төвийн бүсийн цөөн малтай өрх	4,697,025	
Хангайн бүсийн цөөн малтай өрх	4,508,469	
Баруун бүсийн цөөн малтай өрх	4,982,018	
Зүүн бүсийн олон малтай өрх	14,026,805	338 ямаа
Төвийн бүсийн олон малтай өрх	12,705,536	
Хангайн бүсийн олон малтай өрх	12,038,470	
Баруун бүсийн олон малтай өрх	13,713,777	
Ченжүүд	10,927,148	11.2 тн ноолуур зарагдсан
Экспортлогч-угаасан ноолуур (Кг түүхий ноолуур тутмын ҮАЦА)	1,077,538,140	189 тн түүхий ноолуур
Экспортлогч -ялгах (Кг түүхий ноолуур тутмын ҮАЦА)	942,620,580	33 tons of raw cashmere
Том хэмжээний хувцас үйлдвэрлэгч (Үйлдвэрлэсэн хувцас/кг тутамд)	453,568,663	10.8 тн эцсийн хувцас
Жижиг хэмжээний хувцас үйлдвэрлэгч (Үйлдвэрлэсэн хувцас/кг тутамд)	345,387,000	2.1 тн эцсийн хувцас
Жижиглэнгийн худалдаачин (Борлуулсан хувцас/кг тутамд)	92,164,047	2.4 тн эцсийн ноолууран бүтээгдэхүүн

Хүснэгт 3-10: Өртгийн сүлжээний тоглогчдын үйл ажиллагааны цэвэр ашиг, нэг жилээр 2022

3.3 Үндэсний эдийн засагт үзүүлэх нөлөө

Зардлын үүднээс авч үзвэл малчин өрхийн хэрэглээ нь өртгийн сүлжээний зардлыг ихээхэн хэсгийг эзэлнэ. Хэдийгээр эдгээр зардал нь нэг малчдын түвшинд тийм ч өндөр харагдахгүй байж болох ч сүлжээн дэх нийт малчдын (210 мянга гаруй) хэрэглээний зардлыг нэгтгэвэл ихээхэн тоо гарна. Боловсруулах үйлдвэрүүдийн үйлчилгээг нарийн заагаагүй ч нэмүү өртгийн сүлжээнд гаднын тоглогчид чухал үүрэг гүйцэтгэдэг нь илт байна. Үүнд мэргэжлийн үйлчилгээний хөлс, тээвэрлэлт, засвар үйлчилгээ, даатгал, түүнчлэн мэдээлэл сурталчилгааны зардал ч үүнд багтана.




Зураг 3-2:

Хэрэглээний зардлын хэмжээ, 2022, Монгол улс

Гэсэн хэдий ч өртгийн сүлжээний завсрын хэрэглээний зардал нь нийт өртгийг багахан хэсгийг эзэлдэг. Зураг 3-3-аас харвал хамгийн өндөр зардлыг НӨАТ, цалин, татвар хураамж, элэгдэл хорогдол эзэлж байна. Олон малчин өрхийн элэгдэл хорогдлын нийлбэр дүн нь нийт зардалд тодорхой хувийг эзэлж байна. Элэгдэл хорогдолд ихэнхдээ малын өвөлжөө, хаваржааны хашаа хороонд тооцогдож байна. 2022 оны байдлаар 200 малын багтаамжтай хашаа 7 сая төгрөгийн үнэлэмжтэй байна. , Малын хашааны ашиглалтын хугацаа 10-15 жил байдаг.

Өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулбал ажиллах хүчний хөлс тийм ч өндөр биш. Гэвч дундаж цалингийн хэмжээ жил ирэх бүр өсөж байгаа нь цаашдаа цэвэр ашгийн хэмжээнд нөлөө үзүүлж болох юм. Монгол ноолуурын өртгийн сүлжээнд өндөр технологи, өндөр үнэ бүхий техник тоног төхөөрөмж (хувцсыг бүтнээр нь нэхэх машин г.м) шаардахаас илүү хүний хөдөлмөр шаардсан боловсруулалтын үе шат олон тул цаашид илүү эрчимжүүлэх, хөгжүүлэх орон зай их бий.



Зураг 3-3: Зардлын бүтэц, 2022, Монгол

	Газар тариалан / Үр тариа ²	Санхүүгийн үйлчилгээ	Тээвэрлэлт	Эрүүл мэнд	Эрчим хүч	Бөөний үнэ	Засвар үйлчилгээ
Импорт(IMP1)	33%	0.5%	6.7%	18.6%	3.5%	7.5%	69%
Нэмүү өртөг (VA1)	45%	64%	17%	35%	73%	42%	5%
Ажилчдын цалин (Wag1)	18.3%	15.8%	39.4%	49.7%	21.7%	37.0%	37.0%
Үйлдвэрлэлийн татвар (Tax1) ¹	0%	0%	0%	0%	0%	0%	0%
Үйлдвэрлэлийн татаас (-Татвар1)	0%	0%	0%	0%	0%	0%	0%
Ашиг (Net1)	65%	70%	51%	43%	47%	56%	56%

Элэгдэл (Dep1)	16%	14%	10%	8%	31%	7%	7%
----------------	-----	-----	-----	----	-----	----	----

Хүснэгт 3-11: Импортын итгэлцүүр ба дундын хэрэглээнд нэмэгдсэн өртөг (Төг)

Эх сурвалж: Зохиогчид өмнөх судалгаан дээр тулгуурлан тооцов. (Lenzen, Kanemoto, Moran, & Geschke, 2012).

Хүснэгт 3-12-т харуулсанчлан ноолуурын өртөг нэмэх ихэнх нь явц нь өртгийн сүлжээн дотроо явагдаж байна. Багахан буюу зөвхөн 3% орчим нь сүлжээний гадна буюу шууд бус өртөг нэмэх процесс байна. Санхүүгийн хүснэгтээс шалтгааныг тодорхой харж болно. Өртгийн сүлжээний өөрийнх нь завсрын хэрэглээний зардлын ихээхэн хэсгийг ноолуур өөрөө тэргүүлж, татвар, зээлийн хүү дараагийн байруудад орж байна. (Хавсралт 3-аас санхүүгийн дэлгэрэнгүй тооцооллыг харна уу).

	Шууд нөлөөлөл	Шууд бус нөлөөлөл	Нийт нөлөөлөл
Импорт		110,915	102,596
IC not disaggregated		78,455	76,403
Өртөг нэмсэн			
Цалин	96,206	16,505	112,711
Татвар	93,319		96,112
Татаас	34,056		34,056
Татвар (+) Татаас (-)	59,263	2,793	62,055
Зээлийн хүү	185,215	1,769	186,982
Газрын төлбөр	0	242	242
Элэгдэл	125,960	9,113	135,073
Үйл ажиллагааны цэвэр ашиг	1,384,693	37,322	1,422,015
Задаргаа ороогүй нэмүү өртөг	0	60	60
Нийт нэмүү өртөг	1,851,336	67,802	1,919,139

Хүснэгт 3-12: Өртгийн сүлжээний шууд ба шууд бус нөлөөлөл (ТӨГ)

Ноолуурын өртгийн сүлжээ нь ХАА-н салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд 27.4%-г эзэлдэг.


Улсын төсөвт жилдээ 62,056 сая төгрөгийн орлого оруулж худалдааны тэнцэлд 1,210,020 сая төгрөг төвлөрүүлж байна. Өртгийн сүлжээ нь улсын эдийн засагт маш чухал хувь нэмэр оруулдаг (интеграцийн хувь = 91%).

ХАА-н салбар нь төр засгаас их дэмжиж, татаас өгдөг салбарын нэг юм. Татвар, бусад хураамжийн таамаглалыг доор оруулав.

Татвар/татаас	Justification
Хувь хүний орлогын албан татвар	Тавин сая хүртэл орлоготой малчин өрхөд 1%, түүнээс дээш 10%-ийн ХАОАТ ногддог. Бодит байдал дээр 10 саяас дээш орлоготой малчин өрх цөөхөн байдаг. Тиймээс өртгийн сүлжээн дэх малчин өрхийн татварыг дундажлан жигнэж 1.56% гэж тооцов.
Нийгмийн даатгалын шимтгэл	Өртгийн сүлжээн дэх ажилчин бүрд 11.7%-иар НД шимтгэл тооцогдоно. Малчдын дөнгөж 10% нь сайн дураар нийгмийн даатгалын шимтгэл төлдөг. ¹

Ажил олгогчоос төлөх НД шимтгэл	13%
Экспортын НӨАТ	ХАА болон нэхмэл бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүнд 10% Үр өгөөж 0%.
Дотоодын жижиглэн худалдааны НӨАТ	10%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	АНОАТ 10% (1%, 10%, 25% гэсэн шатлалтай)
Малын тоо, толгойн татвар	2022 оны байдлаар татвар төлөлт 50% байсныг үндэслэн МБАНХ-ноос гаргасан тооцооллоо нэг ямаанд ногдох татвар 617 төг.
Малчдад өгсөн татаас	ХХААБ-ын статистик мэдээгээр хөдөө аж ахуйд үзүүлэх дэмжлэгийн нийт хэмжээг 121 тэрбум төгрөг (Засгийн газрын төсвийн 1 орчим хувь) гэж гаргажээ. Үүнийг үндэслэн нэг ямаанд ногдох зардлыг 900 төгрөгөөр тооцов.
Монголын түүхий эдийн бирж	Түүхий эдийн биржээс экспортод гаргаж буй бүх түүхий эд барааг бүртгүүлэх ёстой байдаг. Үйлчилгээний зардалд ²² 0.8% гэж тооцов.

Боловсруулах шатанд түүхий ноолуурын эрэлт тийм өндөр биш, өртгийн сүлжээний завсрын хэрэглээний зардал их биш учраас сүлжээн дотроо нэмэгдсэн өртгийн ашгийн дийлэнх нь малчдад ноогддог байна.



Зураг 3-4: Нэмүү өртгийн хуваарилалт, 2022, Монгол улс

²² Зарим хүмүүс хэлэхдээ маш олон түүхий эд биржийн бүртгэлгүй гарч байгаа гэсэн учир үйлчилгээний зардлыг тохиролцох боломжтой.

3.4 Олон улсын зах зээлд өрсөлдөх болон оршин тогтнох чадвар

Өртгийн сүлжээний олон улсын зах зээлд амьдрах чадварыг нэрлэсэн хамгаалалтын итгэлцүүрээр (NPC) үнэлдэг. Жишиг үнэ гэдэг нь ижил газар зүйн цэгээс, яг ижил хэлбэрээр импортлох, эсхүл экспортлох боломжит алтернатив хувилбарыг харьцуулан гаргасан үнэ юм. Дүн шинжилгээг дотоодын өртгийн сүлжээг бүхэлд нь хамруулан хийсэн тул бид хилийн үнийг жишиг үнэ болгон ашиглав. Дараах тооцоололд татвар, санхүүгийн урсгал зардлыг хасаж, арилжаалах боломжтой бараа, үйлчилгээг олон улсын үнээр жишиг болгон, бусад зардлуудыг дотоодын зах зээлийн бодит үнийг жишиг болгон тооцов.

Ноолуурын жишиг үнийг хамгийн том экспортлогч орнууд болох Хятад, Киргиз, Монгол улсуудын үнийг дундажлан тооцов. Иран улсын 2022 оны үнэ ханшийн мэдээ бидэнд олдсонгүй.

	Самнаж ялгаагүй ноолуур (510211) =угаасан=	Ялгаж, самнасан ноолуур (510531) =боловсруулсан=	Ноолууран хувцас (611012)
Монгол	31.9	86.5	197.8
Турк	35.2		
Киргиз	42.4		83.4
Узбекистан	72.0		
Хятад	120.7	74.1	108.7
Итали		42.1	489.0
Иран		48.3	

Хүснэгт 3-13: Ноолууран бүтээгдэхүүний дэлхийн дундаж үнэ 2019 - 2022

Эх сурвалж: UN COMTRADE (2023)

Монгол улс бол ноолуурын экспортын зах зээлд томоохон байр суурь эзэлдэг ба дээрх 3 орны дунд хамгийн чухал түүхий эдийг бэлтгэн нийлүүлдэг орон юм. (Хүснэгт 3-13). Хятад улс угаах ялгасан түүхий ноолуур экспортлохоос татгалзаж эхлээд байна. Харин Монгол улс өрсөлдөхүйц үнэ бүхий угаагсан ноолуурыг бусад түншүүдийн тогтоосон үнээс доогуур борлуулж байна. Хятад улс боловсруулаагүй түүхий ноолуур экспортлохыг хориглосны төдийгүй, боловсруулсан ноолуураа харьцангуй өндөр үнээр борлуулж байна.

Нэрлэсэн хамгаалалтын илтгэлцүүрийг (Nominal Protection Coefficient) 1 гэж тооцсон бөгөөд энэ нь олон улсын үнээр тооцох тохиолдолд цалин ижил байна гэсэн үг юм.


Түүхий эдийн экспорт нь үндэсний мөнгөн тэмдэгтийн үнэ цэнийг өсгөхөд чухал нөлөөтэй ч уул, уурхайгаас бусад эдийн засгийн салбаруудын өрсөлдөх чадварыг бууруулахад сөргөөр нөлөөлж болох юм. Үүнийг “Голланд өвчин” гэж нэрлэх ба нь их хэмжээгээр баялгаа экспортолсноос үүдэн, тухайн улсын валютын ханш огцом өсөж, түүнээс үүдэн экспортлогч аж үйлдвэрийн салбарын хувьд ашиггүй болж, улмаар улс доторхи үйлдвэрлэлт нь уналтад орох үзэгдэл юм. Монгол Улс бол ДНБ-ий 70 орчим хувийг экспортолдог, экспортын дийлэнх хувийг түүхий эд, эрдэс баялгийн экспорт бүрдүүлдэг нээлттэй эдийн засагтай орон юм. Дагыс нарын судлаачид (Dagys et al. 2020) Монголын эдийн засагт Голланд өвчний шинж тэмдэг илэрсэн гэж тодорхойлсон.

Дотоодын нөөцийн зардлын харьцаа нь 0.08 бөгөөд олон улсын эдийн засгийн харьцангуй

давуу тал, тогтвортой чадварыг илэрхийлдэг. Тиймээс, олон улсын зах зээл, дотоодын хүчин зүйлсийн цалин хөлсийг харгалзан үзэхэд өртгийн сүлжээний үйл ажиллагаанд ашигладаг дотоодын хүчин зүйлсийн үнэ цэнэ нь тэдний үйлдвэрлэсэн үнэ цэнээс доогуур байна. Дотоодын нөөцийн зардлын харьцаа бага байх тусам харьцуулах давуу тал өсдөг.

3.5 Ноолуурын дэд сүлжээ ба өртгийн сүлжээний үе шатанд оруулах хувь нэмэр

Монгол улсын ноолуурын өртгийн сүлжээ нь хоёр гол дэд сүлжээнээс тогтож байна. i) түүхий ноолуур экспортлох дэд сүлжээ нь угаасан түүхий ноолуурыг Хятад улс руу шууд экспортод гаргах, ii) босоо хамааралт дэд сүлжээ нь боловсруулалтын янз бүрийн шатыг хамарсан.



З у р а г 3-5: Дэд сүлжээний үзүүлэлтүүд, 2022, Монгол

Зураг 3-5-д харуулснаар Экспортын дэд сүлжээ нь илүү их хэмжээний түүхий ноолуурыг хэрэглэхийн зэрэгцээ илүү олон тоглогчдыг хамардаг. Малчид энэ дэд сүлжээний хамгийн чухал тоглогчид юм.

Экспортын дэд сүлжээнд оруулж буй өртгийн үнэ цэн нь тонн тутамд 178 сая төгрөг байгаа бол босоо хамааралт дэд сүлжээнд нэг тонн ноолуурын өртгийг бараг нэг дахин нэмэгдүүлж тонн тутамд 340 сая төгрөг болж байна. Үйлдвэрлэл өндөр байх тусам газар зүйн онцлогийн индикатор өсөж, ажиллах хүчний хэмжээ нэмэгддэг. Өртгийн сүлжээний сүлжих, нэхэх шатанд илүү их ажиллах хүч шаарддагийг ажигласан. Ноолуур самнах шатанд цалинтай ажиллах хүчний хэрэгцээ тийм өндөр биш бөгөөд хязгаарлагдмал байдаг. Ноолуур угаах үйлдвэр тийм ч их биш, 40 орчим байна гэж судалгаагаар гарсан. Ноолуурыг үс хялгаснаас ялгах, ээрэх, нэхэх сүлжих үе шатанд хамгийн их ажиллах хүч шаарддаг байна. Хувь хүний орлогын албан татвар, эрүүл мэндийн даатгалын татвар, нийгмийн даатгал, НӨАТ зэрэг нь улсын төсөв бүрдүүлэгч чухал хүчин зүйлс юм.

	Нэгж	Өртгийн сүлжээний экспорт	Өртгийн сүлжээний нэгдмэл	Нийт өртгийн сүлжээ
Түүхий ноолуурын орц	Тн	7,303	2,369	9,672
Үйлдвэрлэл	Сая төгрөг	1,302,371	806,305	2,108,676
• Үйлдвэрлэлд оруулах	Сая төгрөг/тн	178	340	218
Газар зүйн үзүүлэлт	Сая төгрөг	129,867	127,471	257,338
Цалин	Сая төгрөг	34,262	61,944	96,206
Татвар	Сая төгрөг	34,168	59,151	93,319
Зээлийн хүү	Сая төгрөг	77,199	108,016	185,215
• Үйлдвэрлэлийн зээлийн хүү	%	5.9%	13.4%	8.8%
Элэгдэл	Сая төгрөг	63,615	62,345	125,960
• Үйлдвэрлэлийн элэгдэл	%	4.9%	7.7%	6.0%
Үйл ажиллагааны цэвэр ашиг	Сая төгрөг	989,298	395,395	1,384,693
• ҮА-ны цэвэр ашгийн хувь	%	76%	49%	66%
Шууд өртгийн сүлжээ	Сая төгрөг	1,172,504	678,834	1,851,338
Өртгийн сүлжээ/Бүтээгдэхүүн	%	90%	84%	88%
ӨС-ний тоглогчид	Нэгж	161,140	52,493	213,634
Ажилчид	Хувь хүмүүс	2,073	5,511	7,584

Хүснэгт 3-14: Дэд сүлжээний санхүүгийн нэгдсэн үзүүлэлт

Боловсруулалтын түвшин нэмэгдэх тусам хэрэглэж буй техник технологийн хэрэгцээ, зэрэглэл нэмэгддэг. Экспортын дэд сүлжээнд элэгдэл хорогдол 4.9%, зээлийн хүү 5.9%-ийг тус тус эзэлж байна. Харин босоо хамааралт дэд сүлжээ үйлдвэрлэлийн зардалд зээлийн хүү 13.4%, элэгдэл хорогдол 7.7%-ийг эзэлдэг. Хятад ченжүүдээр дамжуулсан, илүү шат дамжлага багатай угаасан ноолуурын экспортоос олох ашиг нь арай илүү байдаг. Экспортын дэд сүлжээнд Үйл ажиллагааны цэвэр ашиг (NOP) нь 76% хүрдэг. Харин босоо хамааралт дэд сүлжээний үйл ажиллагааны цэвэр ашиг нь 49%²³ байна. Боловсруулалтын шат, эргэлтийн хөрөнгөний эрэлт, бараа материалын эргэлт удаан зэргээс шалтгаалсан эрсдэлийн давхар тооцох хэрэгтэй. Говь компанид тохиолдсон жишээ 2 жилээс ч илүү хугацаанд үргэлжлэх магадлалтай²⁴. the Монголын ноолуурын салбар нь малчдаас түүхий ноолуур худалдан авч, үндсэн боловсруулалт хийгээд Хятад руу экспортлох үе шатаар маш оновчтой ажиллаж байна. Энэ нь эргэлтийн хөрөнгийн хэрэгцээг багасгаж, эрсдэлийг бууруулж, илүү их ашиг авчирдаг бүтээмжтэй тогтолцоо юм.

²³ Ноолуурын өртгийн сүлжээний нийт ашиг өндөр байгаа нь малчдын хөлсгүй өдөр тутмын хөдөлмөрийн хүчээр ноолуур бэлтгэх шатны зардал бага байгаатай холбоотой гэдгийг анхаарах хэрэгтэй.

²⁴ 2021 онд бараа материалын нийт эргэлт 708 хоног байсан бол 2022 онд 504 хоног болж буурчээ. Ковидын улмаас 2020 онд бараа материалын эргэлт 950 хоногоос дээш гарсан байна. Бараа материалын эргэлтийн хугацаа нь ихэвчлэн үйлдвэрлэлийн шатны хүчин чадлаас шалтгаалдаг. Түүхий эдийг 1-3 сарын хугацаанд худалдаж авдаг ч боловсруулалтын зарим үе шатууд нь цаг хугацаа шаардсан байгаг тул эцсийн бүтээгдэхүүн бэлэн болох хүртэл хугацаа их ордог.

3.6 АСУУЛТ 1-ИЙН ХҮРЭЭНИЙ ХАРИУЛТУУД

Монгол ноолуурын өртгийн сүлжээний эдийн засаг, санхүүгийн үр дүнг нэгтгэн доорх хүснэгтэд үзүүлэв. Өртгийн сүлжээний дүгнэлтээс харвал энэ нь эдийн хувьд үр өгөөжтэй мөн тогтвортой гэдгийг харж болно. Ялангуяа малчин өрхийн түвшинд илүү ашигтай байна. Гэхдээ бид боловсруулалтын үе шатыг сайн шинжилбэл эдийн засгийн үр өгөөж нь илүү ээдрээтэй байна. Хамгийн бэрхшээлтэй хэсэг нь сүлжмэл/нэхмэл эдлэл үйлдвэрлэгчид 2022 онд санхүүгийн зардал өндөр байснаас шалтгаалан алдагдалтай ажилласан явдал байна.

Гэсэн хэдий ч ноолуурын өөрийн үнэ, Монголын ДНБ болон ХАА-н ДНБ-д үзүүлэх нөлөө зэргээс шалтгаалан анхаарлын төвд байсаар байна.

Асуулт 1-ийн хүрээний асуудлыг нэгтгэсэн нь (Эдийн засгийн нэр томъёоны тайлбарыг судалгааны эхэн хэсгээс харна уу)

Асуулт 1: Өртгийн сүлжээний эдийн засагт үзүүлэх хувь нэмэр юу вэ?		Шалгуур үзүүлэлтүүд	Үр дүн
A1.1	Өртгийн сүлжээ нь оролцогч аж ахуйн нэгжүүддээ хир өгөөжтэй вэ?	Бүх тоглогчдын санхүүгийн байдал	Тайлбарыг дээрх хэсгээс авна уу.
		Бүх тоглогчдын үйл ажиллагааны цэвэр ашиг	Цөөн малтай малчин: 4,152,000 (95 ямаа) Олон малтай малчин: 12,980,000 (338 ямаа) Ченж: 869/кг Угаасан ноолуурын экспорт: 5,700/кг Ялгасан ноолуурын экспорт: 28,500/кг Нэхмэлийн үйлдвэр (Том): 42,000/кг Нэхмэлийн үйлдвэр (жижиг): 164,470 /кг Жижиглэн худалдаа: 38,400 /кг
		Бараа материалын эргэлт (үйл ажиллагааны/үйлдвэрлэлийн)	Цөөн малтай малчин: 74 %Олон малтай малчин: 74% Ченжүүд: 0.8% Угаасан ноолуурын экспорт: 4.6% Ялгасан ноолуурын экспорт: 15% Нэхмэлийн үйлдвэр (Том): 5.6% Textile Нэхмэлийн үйлдвэр (жижиг): 22% Жижиглэн худалдаа: 3.4%
	Малчдын цэвэр орлогын жишиг үзүүлэлтүүд (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, амьжиргааны хэрэгцээ, ажлын байр ...)	Цалингийн хамгийн доод жишиг (2022) • 420,000 ТӨГ Дундаж цалин (2022), улсын дундаж • 1,503,800 ТӨГ	

Асуулт 1: Өртгийн сүлжээний эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмэр юу вэ?	Шалгуур үзүүлэлтүүд	Үр дүн	
A1.2	Өртгийн сүлжээний ДНБ-д үзүүлэх нөлөө юу вэ?	Өртгийн сүлжээний эцсийн бүтээгдэхүүний үнэ цэнэ	2,108,676 сая MNT • 1,302,371 сая төг (Экспортын дэд сүлжээ) • 806,305 сая төг (Босоо хамааралт дэд сүлжээ)
		Шууд нэмүү өртөг	1,851,338 сая төгрөг • 1,172,504 сая төг (Экспортын дэд сүлжээ) • 678,834 MMNT (Integrated VC)
		Нийт нэмүү өртөг	1,919,139 сая төгрөг • 1,237,049 сая төг (Экспортын дэд сүлжээ) • 682,049 сая төг (Экспортын дэд сүлжээ)
		Үе шат бүрийн нэмүү өртөг	Малчид: 73.9 % Үйлдвэрлэгчид: 21.6% Худалдаачид: 4.5 %

		Нийт нэмүү өртөг ба бүрэлдэхүүн хэсэг:	Цалин хөлс: <ul style="list-style-type: none"> 96,202 сая төг Санхүүгийн шимтгэл: <ul style="list-style-type: none"> 185,215 сая төг Үйл ажиллгааны татвар: <ul style="list-style-type: none"> 93,319 сая төг Элэгдэл: <ul style="list-style-type: none"> 125,960 сая төг Малчдын ҮА-ны орлого: <ul style="list-style-type: none"> 1,392,655 сая төг Үйлдвэрлэгчдийн ҮА-ны орлого: <ul style="list-style-type: none"> 1,211,406 сая төг Худалдаачдын ҮА-ны орлого <ul style="list-style-type: none"> 2,713,490 сая төг
		ДНБ дэх ӨС-ний хувь	3.6%
		Эдийн засагт оруулж буй интеграци (Нийт нэмүү өртөг/нөмүү өртгийн сүлжээ)	91%
A1.3	Өртгийн сүлжээний ХАА-н ДНБ-д үзүүлэх нөлөө юу вэ?	Өртгийн сүлжээний тоглогчдын ХАА-н ДНБ-д оруулж буй хувь нэмэр	27.4%
A1.4	Өртгийн сүлжээний улсын төсөвт үзүүлэх нөлөө юу вэ?	Улсад татан төвлөрүүлж буй татвар, шимтгэл	96,112 сая төг
		Засгийн газраас олгож буй татаас дэмжлэг	34,056 сая төг
		Public Funds Balance	62,056 сая төг
A1.5	Өртгийн сүлжээний худалдааны тэнцэлд үзүүлэх нөлөө юу вэ?	ӨС-ний экспорт	1,320,935 сая төг ӨС-ний экспорт: Нийт экспортын 3.6%
		ӨС-ний экспорт (бараа үйлчилгээ)	110,915 сая төг ӨС-ний экспорт: Нийт импортын 3%
		Худалдааны тэнцэл	1,210,020 сая төг
Асуулт 1: Өртгийн сүлжээний эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмэр юу вэ?		Шалгуур үзүүлэлтүүд	Үр дүн
A1.6	Өртгийн сүлжээ нь ОУ-ын зах зээлд амьдрах чадвартай юу?	Нэрлэсэн хамгаалалтын итгэлцүүр	1.000
		Дотоодын нөөцийн зардал	0.08

4.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ НЬ ХҮРТЭЭМЖТЭЙ ЭСЭХ?

4.1 Өртгийн сүлжээний тоглогчдын засаглал

Өртгийн сүлжээний малчдын түвшинд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү үүрэг гүйцэтгэдэг. Тэд шийдвэр гаргах, мал түүхий эд борлуулах, өрхийн орлогын зарцуулалт зэрэг дээр илүү эрх мэдэлтэй байдаг. Сум, багийн түвшний бэлчээр ашиглалтын хэсэг, хоршоодын гишүүд илүү ил тод, тэгш оролцоотой (Бүлэг 5.3.3-г хар). байдаг байна. Бэлчээрийн шинэ хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор БАХ-үүд бэлчээр ашиглалт, сүргийн менежмент, ноолуур үйлдвэрлэлийн процесст илүү нөлөөтэй болох хандлагатай байна.

Малчид ноолуурын үнэ тогтооход нөлөө үзүүлэх чадамжгүй. Дундын зуучлагч буюу ченжүүд л ноолуурын үнийг тогтоодог. Тэд өдөр тутмын амьдрал ахуйд нь шаардлагатай бэлэн мөнгө, бараа бүтээгдэхүүний зээлийг малчдад урьдчилж олгодог учир малчид тэдэнтэй ноолуурын үнэ өсгөх талаар ярилцах, шийдэлд хүрэх боломж байдаггүй. Монголын газар нутаг өргөн, иргэд нь тархан суусан байдаг тул сумын түвшинд цөөн хэдэн ченж монополчлох нь их. Үйлдвэрлэгчидтэй ярилцах үед тэд ченжүүдтэй үнэ тохиролцох боломж байдаггүй тухай ярьж байв. Тиймээс үйлдвэрлэгчид хоршоо, малчдын бүлгээр дамжуулан шууд малчидтай харилцан ноолуураа авах нь илүү найдвартай гэж үздэг.


Ноолуур, боловсруулах үйлдвэрлэх шатны хамгийн нөлөө бүхий тоглогчид нь томоохон үйлдвэрүүд байдаг. Тэд шийдвэр гаргагч нар, Засгийн газар болон ерөнхийлөгчийн түвшинд нөлөөлөл үзүүлэх чадамжтай. Тиймээс тэд түүхий эд бэлтгэх, шинэ технологи, тоног төхөөрөмж оруулж ирэх зэрэгт зориулан бага хүүтэй зээлийн эх үүсвэр, төрийн татаас дэмжлэг илүү авах боломжтой байдаг.

4.2 Нэмүү өртөг болон ашгийн хуваарилалт

Ноолуурын өртгийн сүлжээний тоглогчдын үйл ажиллагааны цэвэр ашгийн тооцооллыг хүснэгт 4-1-т харуулав. Үйл ажиллагааны цэвэр ашгийн хэмжээнд малчид маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Цөөн малтай малчин өрхүүдийн өртгийн сүлжээн доторх үйл ажиллагаанаас олж буй цэвэр ашгийн 56%-ийг бүрдүүлж байхад олон малтай малчин өрхүүд 34%-ийг бүрдүүлж байна. Ноолуурыг эцсийн бүтээгдэхүүн болгох шатны тоглогчид өртгийн сүлжээний нийт ашгийн дөнгөж 10% -г бүрдүүлж байна. Малчдын түвшинд ҮА-ны цэвэр ашгийн оролцоо яагаад ийм өндөр байгааг дээр тайлбарласан билээ. Үүнд ноолуурын үнэ өндөр байх шалтгаалсан гэхээс илүү ноолуур бэлтгэх малчдын хөдөлмөр хямд байдагтай холбоотой юм.

Тоглогч	Үйл ажиллагааны цэвэр ашиг	Үйл ажиллагааны цэвэр ашгийн хувь (%)	
Зүүн бүсийн цөөн малтай өрх	122,467	8.8%	Цөөн малтай өрх (56%)
Төвийн бүсийн цөөн малтай өрх	196,932	14.2%	
Ханган бүсийн цөөн малтай өрх	233,512	16.9%	
Баруун бүсийн цөөн малтай өрх	216,883	15.7%	
Зүүн бүсийн олон малтай өрх	76,556	5.5%	Олон малтай өрх (34%)
Төвийн бүсийн олон малтай өрх	121,513	8.8%	
Хангайн бүсийн олон малтай өрх	143,247	10.3%	
Баруун бүсийн олон малтай өрх	134,879	9.7%	
Зуучлагч	8,399	0.6%	
Угаах экспорт	42,139	3.0%	
Боловсруулсан ноолуурын экспорт	41,345	3.0%	
Том үйлдвэрүүд	10,585	0.8%	
Жижиг үйлдвэрүүд	27,497	2.0%	
Жижиглэн худалдаа	8,739	0.6%	
Нийт	1,384,693	100.0%	


Хүснэгт 4-1: 2022 оны ӨС-ний тоглогч бүрийн үйл ажиллагааны цэвэр ашиг



Ноолуур үйлдвэрлэлээс олж буй ашиг.

Зураг 4-1: 2022 оны тоглогчдын үйл ажиллагааны цэвэр ашгийн задаргаа

Нэмүү өртөг болон үйл ажиллагааны цэвэр ашгийг бүсээр ялгаж гаргав. Монгол улсын төвийн бүсэд хамгийн өндөр өртгийг нэмж, ашиг олсон байна. Энэ нь магадгүй ноолуурын үйлдвэрлэл, боловсруулалт Улаанбаатар хотод илүү төвлөрсөн байдагтай холбоотой байж болох юм. Нийслэл хот болон хот тойрсон ойр орчимд ноолуур хадгалах, угаах, ялгах дамжлагууд явагддаг. Гаалийн ерөнхий газрын төв лаборатори нь экспортод гаргах ноолуурын шинжилгээг хийдэг. Мөн мэргэшсэн ажилчид бэлтгэх сургалтын төвүүд нь Улаанбаатар хотод байрладаг. Ингэснээр боловсруулах үйлдвэрүүд өндөр ур чадвартай мэргэжлийн ажилтнуудтай болох боломж бүрдэж буй юм. Тээвэр жуулчлалын болон бусад үйлчилгээ үзүүлэгч компаниуд нь хотод төвлөрдөг тул тээврийн зардал өсөх нэг шалтгаан болдог.



Зураг 4-2 Монгол улсын 2022 оны бүс нутгийн нэмэгдсэн үнэ

Зураг 4-3: 2022 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн хямрал

4.1 Ажил олголт ба цалин хөлс

Монголд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн цалингийн ялгаа илт харагдаж байна. Доорх хүснэгтэд дурдсанчлан, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүйсийн цалингийн зөрүү бага (3%), харин мэргэжилгүй ажиллах хүчний хувьд арай илүү (13%) байна. Энэ ялгааны тайлбар нь маш энгийн байж болох юм. Малчид эрэгтэй хүүхдээ малчин болгохоор үлдээж, охидоо боловсрол эзэмшүүлэхээр их дээд сургадаг. Өндөр албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөлөл өндөр байгаа нь ерөнхийдөө цалингийн зөрүүг багасгахад тодорхой хэмжээнд нөлөөлж байна. Мөн дээр дурдсанчлан ажил олгогч нь цалингаас гадна нийгмийн даатгалын шимтгэл, орлогын албан татвар төлдөг.

Хөдөлмөрийн төрөл	Нийт цалин	Цэвэр цалин	НД болон ЭМД-д оруулсан нийт шимтгэл	Цалингийн зөрүү	Өдрийн цалин (20.5 өдөр/сард)
Байнгын орон тоо, мэргэжилтэй эмэгтэй*	1,853,400.0	1,451,212	643,130	3%	70,791
Байнгын орон тоо, мэргэжилтэй	1,910,400.0	1,495,843	662,909		72,968

эрэгтэй*					
Байнгын орон тоо, мэргэжилгүй эмэгтэй*	1,058,700.0	828,962	367,369	15%	40,437
Байнгын орон тоо, мэргэжилгүй эрэгтэй*	1,234,300.0	966,457	428,302		47,144
Түр зуурын орон тоо, эмэгтэй					38,000
Түр зуурын орон тоо, эрэгтэй					45,000

Хүснэгт 4-2: 2022 оны Монгол улсын цалингийн үндсэн мэдээлэл


Мэргэшилтэй эрэгтэй, мэргэшилтэй эмэгтэй, мэргэшилгүй эрэгтэй, мэргэшилгүй эмэгтэй, түр ажилчдын дундаж цалин дээр үндэслэн бид өртгийн сүлжээний янз бүрийн түвшний цалингийн талаарх мэдээллийг цуглууллаа. Улирлын чанартайгаар авсан түр ажилчдад төлсөн ажлын хөлсний цалин гэж тооцоход хүндрэлтэй. Нөгөөтээгүүр, зарим чинээлэг малчид туслах туслах малчин авч ажиллуулсан нь төлөх цалингийн хэмжээ нэмэгдэхэд нөлөөлж байна. Туслах малчны гэр бүлийн дундаж цалин жилд ойролцоогоор 5.4 сая төгрөг (ихэвчлэн мөнгөн бус хэлбэрээр төлдөг) бөгөөд үүний зөвхөн тодорхой хэсгийг ямаатай холбоотой зардал гэж (20%) тооцов.

Мөн ченжүүд ноолуур цуглуулах, тээвэрлэх үедээ түр ажилчид авч ажиллуулдаг ч ажлын хөлс тийм ч өндөр биш байдаг. Ажиллах хүчний хамгийн их зардал үйлдвэрлэлийн шатанд, тэр дундаа эцсийн хувцас, бүтээгдэхүүн хийх шатанд илүү их байдаг. Сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх шат нь хэдийгээр өндөр технологи бүхий машин техник хэрэгдэж байгаа ч хүний хүч хөдөлмөр их шаардсан хэсэг юм. Мөн боловсруулалтын дунд шат буюу угаах, ялгах, ээрэх шатанд хүүчин техник төхөөрөмж²⁵ ашиглаж буй нь ажиллах хүчний хэрэгцээг мөн нэмж байна.

Тоглогчид	Цалин (сая төгрөг)	Хувь(%)
Зүүн бүсийн цөөн малтай өрх	1,221	1.3%
Төвийн бүсийн цөөн малтай өрх	2,179	2.3%
Хангайн бүсийн цөөн малтай өрх	2,698	2.8%
Баруун бүсийн цөөн малтай өрх	2,254	2.3%
Зүүн бүсийн олон малтай өрх	2,979	3.1%
Төвийн бүсийн олон малтай өрх	5,313	5.5%
Хангайн бүсийн олон малтай өрх	6,581	6.8%
Баруун бүсийн олон малтай өрх	5,498	5.7%
Зуучлагч	1,177	1.2%
Угаах экспорт	11,683	12.1%
Ялгах экспорт	5,196	5.4%
Том нэхмэл	27,938	29.0%
Жижиг нэхмэл		14.3%
Жижиглэнгийн худалдаа	13,781	8.01%
Нийт	96,206	100%

Хүсн 4-3: 2022 оны тоглогчдын цалингийн хуваарилалт


²⁵ Хэд хэдэн боловсруулах үйлдвэрүүдээр зочлохдоо хуучин машинуудад засвар үйлчилгээг тогтмол зөв хийснээр үйл ажиллагаа нь хэвийн байгаа талаар мэдээлэл авав. Эгээр машинууд нь ихэвчлэн Японоос оруулж ирдэг ашиглаж байсан хуучин машинууд байв. Ноолуур угаах, ялгах, ээрх гэх мэт боловсруулалтын шинэ технологиуд нэвтэрсэнтэй холбоотойгоор машин тоног төхөөрөмж авах шаардлагатай болсон ч санхүүгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хуучин машинуудыг сонгосон байна. Санхүүгийн нөөц боломжтой бол дэвшилтэт машинуудад хөрөнгө оруулахад бэлэн байгаа нь Wholegarment Shima Seiki зэрэг технологийг нэвтрүүлснээр нотлогдож байна.



Зураг 4-4: 2022 оны тоглогчдын цалингийн хувиарлалт

	Цагаар (Өдрүүд)	Бүтэн цагийн тэнцүү (жилийн 245 өдөр)		Цалингийн үнэ цэнэ (сая төгрөг)	
Түр зуурын, эрэгтэй	211,926	865	11%	9,537	10%
Түр зуурын, эмэгтэй	21,996	90	1%	8,358	9%
Байнгын, мэргэжилгүй эрэгтэй	502,926	2,053	27%	23,688	25%
Байнгын, мэргэжилгүй эмэгтэй	825,476	3,369	44%	33,349	35%
Байнгын, мэргэжилтэй эрэгтэй	115,690	472	6%	8,445	9%
Байнгын, мэргэжилтэй эмэгтэй	180,140	735	10%	12,754	13%
Түр ажлын байр, нийт	233,922	955	13%	17,895	19%
Байнгын, мэргэжилгүй нийт	1,328,402	5,422	71%	57,037	59%
Байнгын, мэргэжилтэй нийт	295,830	1,207	16%	21,199	22%
Нийт эрэгтэй	830,542	3,390	45%	41,670	43%
Нийт эмэгтэй	1,027,612	4,194	55%	54,462	57%
Малчдын түвшинд ажлын байр	538,310	2,197	29%	28,724	30%
Нэмүү өртгийн сүлжээний түвшиний ажлын байр	1,319,844	5,387	71%	67,483	70%
Нийт ажиллах хүч	1,858,153	7,584	100%	96,131	100%

Хүснэгт 4-4: 2022 оны Монгол улсын хөдөлмөр эрхлэлтийн ангилалд цалингийн хувиарлалт



Зураг 4-5: 2022 оны монголын бүс нутгийн цалингийн задаргаа

Ноолуурын өртгийн сүлжээнд ойролцоогоор 7,584 бүтэн орон тооны ажлын байр бий болгож нийт 96 тэрбум төгрөгийн цалин хөлс олгож байна. Үүнд ажил олгогчоос төлдөг НД болон ЭМД-ын шимтгэл ороогүй. Өртгийн сүлжээнд оролцож буй нийт ажилчдын 55% нь эмэгтэй, 45% нь эрэгтэй байна. Цалингийн дийлэнх хувийг бүтэн орон тооны нарийн мэргэшилгүй ажилчдад олгож байна. Мэргэшсэн ажиллах хүчний нэлээд хувийг эмэгтэйчүүд эзэлдэг тул тэдний авч буй цалингийн эзлэх хувь нь ӨС-ний нийт ажил эрхлэлтэд нэлээд хувийг эзэлж байна. Экспортын дэд сүлжээний ажиллах хүчний эрэлт тийм ч өндөр биш байв. Ченжүүд болон ноолуур угаах шатны үйлдвэрлэлд нийт 1,050 бүтэн орон тооны ажилчид байгаа бол боловсруулах үйлдвэрийн салбарт 4,300 орчим ажлын байр бий болгож байна. Нийт өртгийн сүлжээгээр нийлүүлж буй ноолуурын хэмжээнд (2,369 тонн) харьцуулан тооцвол 1 тонн ноолуур 1.5-1.8 хүний ажлын байр бий болгож байна гэсэн үг юм. Тиймээс хэрэв Монголын ноолуурын салбар 10,000 тонн ноолуур боловсруулж эхэлбэл багцаагаар 18,000 ажлын байрыг бий болгох юм.

Нийт ажлын байрны дийлэнх нь төвийн бүсэд бий болсныг мөн төвлөрсөн үйлдвэрлэл, дэд бүтэцтэй холбож тайлбарлаж болно. Энэ хэт төвлөрөл нь бүсэд алслагдсан бүс нутгийн хөгжил, хүн ардын амьжиргаанд сөргөөр нөлөөлдөг төдийгүй төв суурин чиглэсэн шилжилт хөдөлгөөний нэг шалтгаан болдог.


4.2 Асуулт 2-н хүрээний хариултууд

Ноолуурын өртгийн сүлжээний эдийн засагт оруулах үр нөлөө нь хүртээмжтэй байна гэдгийг олон зүйлээр нотолж болно. Өртгийн сүлжээ нь янз бүрийн насны олон эмэгтэйчүүдэд ажлын байр бий болгож байгаа төдийгүй энэ салбарт ажиллагсдын хүйсийн харьцааны ялгаа тийм ч их байна. Энэ салбарын цалин хөлсний хэмжээ улсын дундажтай ижил ба боловсруулах үйлдвэрт ажиллагсдын цалин Улаанбаатар хотод байгаа жижиглэн худалдааны дэлгүүрийн худалдагчдын цалингаас 50%-иар өндөр байна.

Ноолуур, ноолууран бүтээгдэхүүний үнэ өндөр байх нь малчдын орлого тогтвортой өсөх, улмаар хот суруин газар уруу шилжих хөдөлгөөний сааруулахад хувь нэмэр оруулна. Цаг агаар, байгалийн хүчин зүйлээс хараат байдаг нүүдлийн МAA-нь малчдыг нийгмийн эмзэг, эрсдэлд өртөмхий болгодог хэдий ч ноолуурын өртгийн сүлжээ нь тэднийг орлогоо өсгөх, мал аж ахуйгаа тогтвортой өсгөх, оршин тогтноход нь хувь нэмэр оруулж байна. Ноолуур самнах хугацаанд тэд ажилгүй иргэдийг хөлсөөр ажиллуулж түр хугацааны ажлын байрыг бий болгоход хувь нэмэр оруулдаг.

Малчдын хоршоог НӨАТ-аас чөлөөлж, малчдыг тодорхой хэмжээнд хүн амын орлогын албан татвараас хөнгөлж байгаа нь тэднийг төрөөс дэмжиж буй нэг хэлбэр юм. Хэдийгээр малчдын нийгэм, эдийн засаг, мал эмнэлгийн үйлчилгээний хувьд өртгийн сүлжээ нь эерэг нөлөө үзүүлж байгаа ч нөгөө талаар малын тоо хурдацтай өсөж буй нь байгаль орчны сөрөг нөлөөллийг бий болгож байна. Малын тоог хязгаарлах зорилготой малын тоо толгойн татварын бодлого хэрэгжүүлж буй ч зарим бэрхшээлүүд гарсаар байна.

Орлогын хуваарилалтыг доорх графикаар харуулав. GINI коэффициентыг тооцоолох суурь болох Лоренцийн муруй нь 45% градусын шугамд ойрхон байна. Энэ нь орлогыг өртгийн сүлжээний тоглогчдод илүү тэгш хуваарилдаг гэсэн үг юм. GINI коэффициент нь 0.3510-тай тэнцүү байх бөгөөд энэ нь орлогын илүү тэгш хуваарилалтыг харуулж байна.



Зураг 4-6: 2022 оны ноолуурын өртгийн сүлжээний тоглогчдын лорензын муруй

Асуулт 2-ын хүрээний хариултуудыг доорх хүснэгтэд нэгтгэн харуулав.

Асуулт 1: Өртгийн сүлжээний эдийн засгийн үр нөлөө нь хүртээмжтэй эсэх?		Шалгуур үзүүлэлтүүд	Үр дүн
A2.1	Өртгийн сүлжээний орлого хуваарилалт ямар вэ?	Нэмүү өртгийн задаргаа	1,834,243 сая ТӨГ
		Малчдын үйл ажиллагааны цэвэр ашиг	1,245,989 сая ТӨГ
		Цалин хөлс (бүх шатанд, бүх үйл ажиллагаа)	Нийт цалин, хөлс: 96,131 сая ТӨГ
		Эмзэг бүлгийнхэнд ногдох цалин, хөлс	Малчдын түвшний түр ажиллагсад олгосон цалин: 12,427 сая ТӨГ (цалингийн 12%) Туслах малчдын цалин: 16,296 сая ТӨГ (16%) Үйлдвэрийн эмэгтэй ажилчид: 42,972 сая ТӨГ (47%)
A2.2	Орлого хуваарилалт өртгийн сүлжээний засаглалд ямар нөлөө үзүүлж байна вэ?	Өртгийн сүлжээний тоглогчдод ногдох орлого	Үйл ажиллагааны орлогын хуваарилалт: <ul style="list-style-type: none"> • Зүүн бүсийн цөөн малтай малчид 8.8% • Төвийн бүсийн цөөн малтай малчид 14.2% • Хангай бүсийн цөөн малтай малчид 16.9% • Баруун бүсийн цөөн малтай малчид 15.7% • Зүүн бүсийн олон малтай малчид 5.5% • Төвийн бүсийн олон малтай малчид 8.8% • Хангай бүсийн олон малтай малчид 10.3% • Баруун бүсийн олон малтай малчид 9.7% • Ченжүүд 0.6% • Угаасан ноолуур экспортлогчид 3% • Ялгасан ноолуур экспортлогчид 3% • Нэхмэлийн том үйлдвэр 0.8% • Нэхмэлийн жижиг үйлдвэр 2.0% • Жижиглэн худалдаа 0.6%

		Нийт борлуулалтын үнэд эзлэх хувь (%)	Малчны хотны үнэ: 102,000 төг/кг Зуучлан борлуулж буй ченжийн хувь: 98% Угаасан ноолуур экспортлогчдын хувь: 87 % Ялгасан ноолуур экспортлогчдын хувь: 56% Эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувь: 18%
A2.3	Өртгийн сүлжээнд ажлын байр бий болгосон байдал?	Ажлын байрны тоо (гэр бүл, хувиараа хөдөлмөр гм өртгийн сүлжээнд бий болгосон урт болон богино хугацааны, ур чадвар шаардсан болон шаардаагүй ажлын байр)	Бүтэн орон тооны ажлын байр: 7,584 Тогтмол ажлын байр: 6,630 (87%) Түр хугацааны ажлын байр: 954 (13%)
		Эмэгтэйчүүдэд зориулсан ажлын байр Gini итгэлцүүр	Нийт бүтэн орон тооны ажлын байрны 55%, цалингийн 57% 0.3510

5. ӨРТГИЙН СҮЛЖЭЭ НЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУВЬД ТОГТВОРТОЙ ЭСЭХ?

Энэ бүлэг нь VCA4D төслийн хүрээнд боловсруулсан өртгийн сүлжээ нь байгаль орчинд ээлтэй, тогтвортой эсэхийг үнэлэх 6 үзүүлэлтүүдийн дагуу хийсэн дүн шинжилгээний тоймыг багтаасан. Үүнд: Ажлын нөхцөл, Гар, усны эрх, Жендерийн тэгш байдал, Хоол, шит тэжээлийн аюулгүй байдал, Нийгмийн үнэ цэнэ, ба Амьдрах нөхцөл. Малчдын өр зээлтэй эсэх, малын даатгал, амьжиргааны баталгаа зэрэг асуудлыг Хоол тэжээлийн аюулгүй байдал хэсэгт нэмэлтээр оруулав.

5.1 Ажиллах нөхцөл

Энэ дэд бүлэгт ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн ажилчдын болон ноолуур бэлтгэдэг малчдын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хамтад нь авч үзнэ. Хөдөлмөр эрхлэлтийн талаарх үндэсний бодлого, хууль эрх зүйн орчин, боловсруулах үйлдвэрүүдийн эвсэл, холбоо, хамтын гэрээ хэлэлцээр, тэдгээрийн зохицуулалт, ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй зэрэг асуудалд хийсэн дүн шинжилгээний үр дүнг энд эхэн хэсэгт багтаав. Малчин өрхийн хөдөлмөр, тэр дундаа цалинтай туслах малчдын асуудлыг бүлгийн сүүл хэсэгт оруулав.

5.1.1 Ноолуур үйлдвэрлэлийн ажиллах орчин

Монгол улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан 8 конвенцид нэгдэж, 1969-өөс 2005 онуудын хооронд тус тус соёрхон баталсан байдаг. Улс төр, иргэний эрхийн конвенц (ICCPR) болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн конвенцыг (ICESCR) 1974 онд соёрхон баталсан. ОУХБХ-ны Конвенц, зөвлөмжийг хэрэглэх шинжээчдийн хорооны сүүлийн үеийн тайланд (CEACR 2020, 2021, 2022) конвенцуудыг хэрэгжүүлэхэд гарч буй асуудлуудыг тусгасан бөгөөд энэ нь ноолуурын салбартай шууд хамааралгүй²⁶.

Хуулиар олгогдсон эрхийн дагуу монгол ажилчид чөлөөтэй эвлэлдэн нэгдэж, хамтын гэрээ хэлэлцээр хийх эрхтэй. Монголд хөдөлмөрийн хуулийн дагуу ноолуур боловсруулах салбар нь хөнгөн үйлдвэрийн ангилалд багтдаг. Улсын хэмжээнд хөнгөн үйлдвэрийн салбарт нийт 40,000 ажилчид байгаагийн 12,000 нь ноос, ноолуурын салбарт харьяалагдаж байна. Монголын үйлдвэрчний эвлэл²⁷ нь ажил эрхлэгч хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалдаг хамгийн том холбоо бөгөөд Хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрчний эвлэлийн холбоо нь тус холбооны гишүүнчлэлтэй байдаг. МҮЭ-ийн холбооноос өөрийн үйл ажиллагааны талаар болон бусад оролцогч талууд тухайлбал төр, хувийн хэвшил, олон улсын түншүүдийн харилцаа хамтын ажиллагааны талаар маш хэрэгтэй мэдээллийг бидэнд өгсөн. МҮЭ нь ноолуурын томоохон компаниудыг хамарсан гурван салбартай. Хивс үйлдвэрлэгчдийн салбарыг оролцуулбал нийт 4 салбар байгаа бөгөөд үүнд нийт 3000 орчим ажилчид хамрагддаг

²⁶ Барилгын салбарт Хятад, Хойд Солонгосын цагаач ирнэгдийг албадан хөдөлмөр эрхлүүлсэн зарим тохиолдол нь Адил тэгш цалин хөлсний тухай конвенцийн зарим зүйл заалтыг зөрчсөн, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хүүхдээр хурдан морь унуулах гэх мэт зарим асуудлууд.

²⁷ МҮЭХ нь ЗХУ-ын үеэс эхтэй, засгийн газар болон намаас дэмжиж ирсэн байгууллага боловч 1990 оноос хойш бие даан үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Шведийн үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний талаарх мэдээллийг дараах холбоосоор орж үзнэ үү (<https://web.archive.org/web/20080516013147/>; / <http://www.lotcobistand.org/country/136>) Одоогийнх шиг Монгол Ардын Нам засгийн эрх барьж байх үед Засгийн газар үйлдвэрчний эвлэлд илүү таатай ханддаг гэсэн ойлголт байдаг ч энэ нь бодитой мэдээлэл бус.

байна. МХҮАҮЭ болон ОУХБ-ын ажилтнуудтай хийх ярилцлагын үеэр тэд зарим үйлдвэрүүд дээр шинээр үйлдвэрчний эвлэл байгуулахад хүндрэлтэй байдаг тухай дурдав. Учир нь зарим үйлдвэрүүд дөнгөж шинээр байгуулагдсан зарим нь гэр бүлийн өмчлөлийн шинж чанартай байх зэрэг шалтгаанууд байдаг байна. Мөн Хятад эзэдтэй үйлдвэрүүдэд үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалт хийхэд маш хэцүү, удирдлага нь үйлдвэрчний эвлэлүүдээ ажилчидтайгаа уулзуулдаггүй байж магадгүй тухай яриу.

Судалгаанд хамрагдсан томоохон компаниудын нэг нь үйлдвэрчний эвлэлийн салбартай, нэг нь бие даасан ажилчдын холбоотой байв. Мөн өөр нэг компани үйлдвэрчний эвлэл эсхүл ажилчдын нэгдсэн эвсэл холбоо байхгүй бөгөөд үүнийгээ захирал нь ажилчдынхаа талаар мэдээлэл сайтай байдаг, мөн "нээлттэй хаалганы бодлого"-оор зохицуулдаг тухай яриу. Ноолуур угаах болон ялгах дунд оврын үйлдвэрүүдийн (нэг нь Хятад эзэнтэй) хэд хэдэн захирал мөн ажилчдаа сайн мэддэг, мэдээлэл нээлттэй байдаг тул ийм эвсэл холбоо байх шаардлагагүй гэж үздэг тухайгаа яриу.

МХҮАҮЭ нь Фредрих Эбэртийн сангийн²⁸ дэмжлэгтэйгээр Монголын ноос, ноолуурын холбоотой хамтран Ноос ноолуурын салбарын цалин хөлсний доод хэмжээг тогтоох аргачлалыг боловсруулж байна. Тус аргачлалыг боловсруулах үед хэд хэдэн бэрхшээл тулгарч буйг дурдвал а) өмнө нь ийм ажил хийгдэж байгаагүй. Хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарт одоо мөрдөгдөж буй цалин, хөлсний журам нь тодорхой бус, б) компани хоорондын ажлын цаг, цалин, албан тушаалын зэрэглэл зэрэг нь хоорондоо хол зөрөөтэй байх зэрэг асуудлууд гэх мэт. Энэ аргачлалыг боловсруулж дууссаны дараа нэг жил туршилтын байдлаар хэрэгжүүлэх бөгөөд энэ нь салбарыг бүхэлд нь хамарна гэж найдаж байна.

Энэ аргачлал хэрэгжиж эхлээгүй байгаа тул МХҮАҮЭ үйлдвэрийн түвшинд илүү нарийн орж ажиллах боломжгүй байна. МХҮАҮЭ-ийн үндсэн үүрэг нь хөдөлмөрийн зөрчил маргааныг шийдвэрлэх, ганцаарчилсан зөвлөгөө өгөх (гишүүддээ үнэ төлбөргүй, бусдад бага хэмжээний төлбөртэй), Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт болон ажлын байрны орчин, аюулгүй байдлын тухай шинэ хуулийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу Зөрчил маргаан шийдвэрлэх хороог дэмжих, болон залуучуудын оролцоог хангах чиглэлийн ажлууд юм.

2021 онд батлагдаж 2022 оны 1 дүгээр сараас мөрдөгдөж буй Хөдөлмөрийн тухай хуульд ажилд орж буй бүх хүн дор хаяж албан тушаалын нэр, цалин хөлс, ажлын байрны байршил оруулсан мэдээлэл бүхий хөдөлмөрийн гэрээг бичгээр хийнэ гэж заасан төдийгүй хөдөлмөрийн бүх харилцааг хуулийн дагуу зохицуулна гэж заасан байдаг. Боловсруулах үйлдвэрүүдийн ажилчид одоогоор ямар хэмжээнд бичгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

- Нэг томоохон компани 500 үндсэн ажилтантай боловч хөдөлмөрийн гэрээ хийгээгүй байсан тохиолдол гарч байсан. Хэдийгээр менежер нь "компани тэднийг хэзээ ч явуулахгүй" гэж хэлсэн (өөрөөр хэлбэл тэд ажлаас гарахгүй байх хэмжээний цалин урамшуулал олгодог) гэж хэлсэн ч ажлаас халах/гарах

²⁸ Германы нийгмийн ардчилсан намын бие даасан сан

тохиолдолд нэг сарын өмнө мэдэгдэл өгөх тухай яриандаа дурдсан. Ковид цар тахлын үед олон үйлдвэрүүд хаагдахад бичгээр гэрээ байгуулах нь ямар чухал байсныг олон хүн ойлгосон гэж МХҮАҮЭ-ийн ярилцагч онцлон хэлэв. Үйлдвэрийн менежерүүд ажилчдын тогтвортой байдалд хөдөлмөрийн гэрээнээс илүү цалин өндөр байх нь чухал нөлөөтэй тухай хэлж байв. Өөр нэг томоохон компанид нийт ажиллагсдын 50% нь таваас дээш жил, 30% нь арав гаруй жил ажилласан, 20% нь компанийн байранд үнэ төлбөргүй амьдардаг гэж захирал онцолсон. Мөн бүх үйлдвэрүүд ноолуур худалдан авах үед ажил ихэсдэг тул түр ажилчин ажиллуулдаг тухай мэдээлсэн.

Ноолуурын салбарын цалин нь бусад хөнгөн үйлдвэрүүдийнхээс харьцангуй өндөр байна.²⁹ Сарын үндсэн цалин 1.5 сая төгрөг бөгөөд энэ зарим үйлдвэрүүдээс өндөр байгаа юм. Энэ нь улсаас тогтоосон үндсэн цалингийн доод хэмжээнээс хамаагүй өндөр ба ажилчид бусад нэмэлт урамшуулал, сургалт, аялал, орон сууцны хөнгөлөлт, зээл, эрүүл мэндийн үйлчилгээ, сувиллын эрх гэх мэт олон боломжийг олгодог. Нэг томоохон боловсруулах үйлдвэр ажилтнуудын нийт эргэлтийг 20% хүртэл бууруулах зорилттой байгаа бөгөөд одоогоор 30% хүрч байна. Цалин, урамшууллыг залуучуудын сонирхлыг татахуйд хэмжээнд хүргэх, ажиллах орчныг таатай болгохоор зорин ажиллаж байна. Хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн салбар нь ерөнхийдөө ажиллах хүчний дутагдалд орсон. МХҮАҮЭ, МННХ хамтран дунд сургууль төгсөгчдийн дунд ноос, ноолуурын мэргэжил олгох сургуульд суралцах, төгсөөд энэ салбарт ажиллахыг уриалах төрөл бүрийн араг хэмжээ зохион байгуулж байна.

Албадан хөдөлмөр, болон хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгийн асуудал энэ салбарт байхгүй. Албадан хөдөлмөр эрхлэлт нь ихэвчлэн барилгын салбарт тохиолддог байна. Ярилцлагын үед ажилчдын эрхийн талаар асуудал хөндөгдөх үед зарим үйлдвэрүүд ажилчдын хувийн баримт бичиг, тухайлбал диплом зэргийг хураан авдаг тухай гомдоллож байв. Энэ нь тэднийг ажлаас гаргахгүй барихын тулд хийж буй үйлдэл юм. Ястан, үндэстний ялгаварлал төдийлөн их биш³⁰. Энэ талаар ямар нэг мэдээлэл ирээгүй.

Монголд хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль эрх зүйн орчин сайн учраас үйлдвэрт 18 нас хүрээгүй хүүхэд ажиллахыг хориглосон байдаг. Үйлдвэрийн менежерүүд ч 18 нас хүрээгүй хүнийг ажилд авдаггүй тухайгаа ярилцлагын үеэр хэлж байв.

МХҮАҮЭ-тэй хийсэн ярилцлагын үеэр хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын хувьд хөнгөн үйлдвэрийн салбар нь уул уурхай, барилга, цахилгааны ажлын дараа орох хамгийн доогуур үзүүлэлттэй 4 салбарын нэг гэдэг мэдээллийг авсан юм. Үйлдвэрийн осол болдог ч түүнийг ихэнхдээ нуун дарагдуулдаг байна. Мөн аюулгүй ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа нь энэ салбарыг “ослын эрсдэлтэй” салбар болгож байна. МХҮАҮЭ нь ОУХБ-ын дэмжлэгтэйгээр *Нэхмэл, хувцас, арьс шир, гутлын аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны дүрэм*³¹-ийг орчуулж

²⁹ YCX https://1212.mn/en/statistic/statcate/48171320/table-view/DT_NS0_0400_022V1 2022 оны сарын үндсэн цалингийн дундаж эмэгтэй ажилтных 1,306,400 төг, эрэгтэй ажилтных 1,554,200 төг байна.

³⁰ Хүн амын 85 хувийг Халх монголчууд, үлдсэн хувийг үндэстний цөөнх буюу бусад ястнууд эзэлдэг.

³¹ Англи хувилбарыг эндээс авна уу: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_dialogue/---sector/documents/normativeinstrument/wcms_828429.pdf

байна. Ингэснээрээ тухайн салбарын ажилчдын мэдлэг сайжирч, осол аюулын эрсдэл буурна гэж үзэж байна. Зарим үйлдвэрүүд сайн туршлага, үлгэр жишээ арга хэмжээ хэрэгжүүлдэг. Тухайлбал, нэг үйлдвэр 500 тогтмол ажилчидтай бөгөөд 100 ажилчин тутам нэг ХААБ инженер ажиллуулдаг байна. Эдгээр инженерүүд нь өглөө бүр аюулгүй ажлын зааварчилгаа өгч, сургалт зохион байгуулж, ажлын байрны даатгалыг нэвтрүүлж ажилладаг. Үүний үр дүнд тус үйлдвэрт осол гараагүй ба ганц гарсан тохиолдол нь гэрээсээ ажилдаа ирэх замд тохилдсон байна. Хэдий тийм ч компаниас тус ажилчинд 10 төгрөгийн нөхөн олговор өгсөн байна.

5.1.2 Малчдын ажлын нөхцөл

Малчин өрхийн хувьд ажиллах хүн хүчний асуудал маш чухал. Бог мал тэр дундаа ямаа маллах нь уйгагүй ажиллагаа шаарддаг. Ямаа нь ихэвчлэн хонь дагуулаад өндөр уулын хэц, хяр дагаж бэлчээрлэдэг учир байнгын дагаж хариулах шаардлагатай болдог. Ямааны нялх төл мөн илүү арчилгаа маллагаа шаардана. Нэгдэл тарсны дараа мал хувьчилж малчид дор хаяж 4 хошуу мал малладаг болсон. Жилдээ 4-5 удаа нутаг бэлчээр сэлгэж нүүх шаардлагатай хүн хүчний хөдөлмөр их шаарддаг. Улирлын чанартайгаар (хавар ямаа самнах, мал төллөх гм), өвөлдөө цаг хатуу болсон үед илүү их хүн хүч хэрэг болдог. Сургууль соёлд явсан хүүхэд, залуус эргээд малчин болохоор ирэхгүй байгаа тул малчны залуу халаа бэлдэх асуудал тун чухал. Энэ байдлаар үргэлжилбэл мал аж ахуйн салбар ажиллах хүчний дутагдалд орохоор байна. Малчдын хөдөлмөрийн хөнгөлөх, илүү бүтээмжтэй байх үүднээс ноолуурын гарц нь буурсан нас гүйцсэн ямааг зарж борлуулж цөөлж байх нь зүйтэй гэсэн зөвлөмжийг зарим мэргэжилтнүүд өгдөг.

Малчид энэ хүн хүчний дутагдлыг олон янзаар шийддэг. Сүүлийн 20 жил автомашин, мотоциклийн хэрэглээ ихэссэн. Үндэсний статистикийн мэдээгээр ямаатай малчин өрхийн 34% нь хувийн ачааны машинтай, 40% нь суудлын тэрэгтэй, 45% нь мотоциклтой байна.

Энэ нь тэдэнд олон төрлийн малын нэг дор адгуулж маллах хөдөлмөрийг нь хөнгөлдөг. Сургууль амарсан үеэр сургуулийн асны хүүхдийг тус маш их нэмэр болдог учраас зун цагт хүн хүчний хэрэгцээ тийм ч их биш байдаг. Малчид тус тусдаа өвөлжөө, хаваржаандаа нутаглах ба зарим цаг хүндэрсэн үед хамтдаа өвөлжиж хүчээ нэгтгэдэг. (Хөвсгөл аймгийн жишээ).

Цалинтай малчин буюу туслах малчин нь энэ асуудлыг шийдэх хамгийн чухал стратеги бөгөөд малчид голдуу өөрийн хүүхэд, хамаатан саднаа туслах малчнаар авдаг. Үүнийг малчид шударга, аль алиндаа хэрэгтэй зүйл гэж үзэж байна. Гэвч Мёрфи 2015 онд хийсэн судалгаандаа туслах малчид өдрийн хоол иддэггүй, зарим нэг ахуйн хүчирхийлэлд өртдөг гэж дурдсан байна.

Нэг өрхийг малын тоо 500-с давсан үед л туслах малчны хэрэгцээ бий болдог гэж зарим эх сурвалж хэлж байна. Хэнтий аймагт туслах малчнаар жил тойрон ажиллаж байгаа нэг малчинтай ярилцах боломж олдсон юм. Тэрээр хэлэхдээ туслах малчин тогтдоггүй, ирээд буцаад явчихдаг, хотод авдгаас өндөр цалин өгсөн ч нэмэргүй явчихдаг, хамгийн гол нь тэд амьдралын хэв маягт дасаж чаддаггүй гэж яриу. Тэр өвөлд сард 1 сая, зун 800,000 төгрөгийн цалин авдгаа хэлэв. Мөн шинэ төлийн 50%-ийг өөр дээрээ өмчилж малжиж буйгаа хэлсэн юм. Үнээс гадна туслах малчинд гэр орон бэлдэж, хоол хүнсийг нь хангаж, НД болон ЭМД-ыг нь ч төлдөг байна. Архангай аймгийн 1300 толгой малтай малчин 5 жилийн хугацаагаар бүтэн орон тооны туслах малчин гэрээ хийж ажиллах

сонирхолтой байдаг ч зөвхөн 3-5 саруудад л ажиллах хүсэлтэй хүмүүс олон байдаг тухай хэлж байв. Төв аймагт бид туслах малчны хөлсийг 2 төрлөөр өгдөг. Бэлэн мөнгөөр цалинжуулах эсвэл төл мал төлийг өгөх гэсэн хоёр хэлбэр байдаг ч аль аль нь төвөгтэй болсоор байна.

Ноолуур самнах цагаар аймаг, сумын төвийн ажилгүй хүмүүсийг цалинжуулан ямаагаа самнуулдаг. Хөвсгөл аймгийн жишгээр нэг эр ямаа самнахад 10,000 төгрөг, эм ямаа самнахад 8,000 төгрөг байдаг байна.

Мал аж ахуйд хүүхдийн хөдөлмөр их дэм болдог. “Хөнгөн ажил” (яг ямар ажил нь тодорхой бус) гэдэг нэрийн дор 13–15 насны хүүхдийг мал аж ахуйд туслуулдаг ба тэдний хичээл сургуульд сөрөг нөлөө үзүүлдэггүй. Малчдын хүүхэд 6 настайгаа сургуульд орж сумын төвд хамаатан садныдаа³² амьдардаг. Охидын 96% нь дунд сургуулиа төгсдөг бол хөвгүүдийн 89% нь төгсдөг байна. Харин ахлах сургуулийг охидын 75% нь төгсдөг бол хөвгүүдийн дөнгөж 66% нь төгсдөг байна. Биднийг судалгаагаар явж байх үед нэг ч сургуулийн хүүхэд малчны хотонд таараагүй. Сургуулийн амралтаар 13-аас доош насныхан “хөнгөн ажил” хийж байгаа ч энэ нь сургуулийн боловсролд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэсэн тоо баримт байна. Анхаарах ёстой нэг зүйл бол туслах малчны хүүхдүүд бөгөөд эцэг эхдээ туслах ёстой бөгөөд энэ нь цаашид асуудал үүсгэж болох юм.

НҮБ-ын ХХААБ-ын RIMA тайлан (FAO 2022) болон ШХА-ын МБАНХ-ны жендерийн тайланд (Voltolini et al. 2018) залуу үеийнхэн, ялангуяа охид мал маллах дургүй болж байгаа тухай дурджээ. Үүнийг малчидтай хийсэн ярилцлага, бусад мэдээллүүд ч нотолж байна.

5.1.3 Ажиллах орчин нөхцөлийн тухай дүгнэлт

Өртгийн сүлжээн дэх ноолуур бэлтгэх мал аж ахуй болон ноолуур боловсруулалтын шатны ажлын байрны хоорондоо эрс тэс ялгаатай ч хөдөлмөрийн нөхцөл аль алинд нь харьцангуй сайн байна. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх эрхийг дээдлэх байдал харьцангуй өндөр бөгөөд хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал харьцангуй сайн. Боловсруулах салбар дахь ажил нь өндөр цалинтай, ажиллах орчин сайтай учир ажиллах сонирхлыг ихээр татдаг. Мал аж ахуйг уламжлалт амьжиргааны хэлбэр хэмээн нийтээрээ эергээр хүлээн авдаг ч залуу хойч үе, ялангуяа охид, эмэгтэйчүүдийн сонирхлыг татахгүй байгаа нь илт байна.

³² Зарим тохиолдолд ээж 6 настай хүүхдээ харан сумын төвд амьдардаг. Энэ нь мөн мал маллах хүн хүчний дутагдалд оруулдаг төдийгүй, сэтгэл зүйн хувьд давхар стресс бий болгодог.

Ажиллах нөхцөл	
Хөдөлмөрийн эрхийг хүндлэх	
Хүүхдийн хөдөлмөр	
Ажлын байрны аюулгүй байдал	
Үйлдвэрлэлийн салбарын сонирхол татах байдал	
МАН-н сонирхол татах байдал	

5.2 Газар, усны эрх

Өртгийн сүлжээн газрын эрхийн асуудал нь бэлчээрийг хэрхэн зохистой ашиглах, бэлчээрийг хэрхэн сэргээх, доройтлыг хэрхэн бууруулах, малчдыг уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, байгалийн эрсдэлт хүчин зүйлст хариу үйлдэл үзүүлэх чадамжтай байлгах цогц зүйл юм. Энэ дэд бүлэгт бэлчээрийн хууль эрх зүйн орчин, түүнд шинэчлэл хийх оролдлогууд, бэлчээр ашиглалтын одоогийн хэв маяг, бэлчээрийн менежментийг сайжруулахад чиглэсэн малчдын өөрөө удирдах байгууллагуудын үр нөлөө, мал ахуйн бус салбарын бэлчээрт үзүүлж буй эрсдэл, аюул зэрэг асуудлуудыг багтаав.

5.2.1 Бэлчээр ашиглах хуулийн үндэслэл

1991, 1992 оноос нэгдэл тарж бутарснаас шалтгаалан малчид нэгдсэн зохион байгуулалтгүй болж дор дороо малаа хувьчлан, өмнө нь ашиглаж байсан бэлчээр нутагтаа үлдсэн. Энэ нь бэлчээрийн хуваарилалт, хэрхэн ашиглах талаар тодорхойгүй байдалд хүргэсэн төдийгүй малчид бараг анх удаа өөрийн малтай болж бэлчээрийг эрх чөлөөтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн³³. Анх 1994 газрын тухай хууль батлагдаж 2002 онд шинэчлэн найруулсан. Газрын тухай хууль нь ихэвчлэн төв суурин газрын асуудлыг хамарсан бөгөөд бэлчээрийн асуудал бараг ороогүй. Зөвхөн ганц бүлэгт (Бүлэг 52) бэлчээрийн талаар багтаасан боловч эзэмших, ашиглах эрхийг хольж, нарийн ялгааг тодорхой оруулаагүй байна. (Morton and Ridgway 2003). Гэвч байгаль орчны олон төслүүдэд Газрын тухай хуулийн 52-р бүлгийг суурь болгож ирсэн. Малчдын хувьд бэлчээр ашиглалтын асуудал аман зөвшилцөл буюу хоорондоо тохиролцож шийдсээр ирсэн. Малчдын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг сумын ИТХ-аар хэлэлцэж баталдаг. Малчид газрын тухай 5.2.2-т заасан дагуу бага хэмжээний бэлчээр нутагт нүүдэллэх шаардлагатай.

Бэлчээрийн тухай зүйл заалтыг шинэчлэн найруулж, малчдын ахуй амьдралд нийцүүлэх шаардлага тулгарч байгаа. Бэлчээрийн тухай хуулийн зүйл заалтыг шинэчлэн найруулахдаа хэд хэдэн зүйлсийг анхаарах ёстой. Үүнд:

- Бэлчээрийн менежментийн хамгийн зохистой хувилбарыг дэмжих, тэгснээр бэлчээр сэргэж, малчид хангалттай хэмжээний бэлчээрийн талбайг сэлгэж ашиглах боломж бүрдэнэ
- Малчдын бүлэгт өвөлжөөний газар эзэмших эрх олгох, тэгснээр бусад улиралд өвөлжөөний бэлчээрээ өвөлд зориулан нөөцлөх, бусад малчид малаа идүүлэхээс сэргийлэх боломж бүрдэнэ.
- Зудын үед өөр нутаг бэлчээрт отор нүүдлээр явах боломж олгох буюу малчид

³³ ЗХУ-ын өмнөх үеийн малчдын дийлэнх нь феодал, сүм хийдүүдийн хараат байсан тул бие даан өрх толгойлсон мал маллах уламжлал маш бага байсан.

хоорондоо тохиролцох, гэрээ хийх боломжийг бүрдүүлэх

Газрын агентлагаас Газрын тухай хуулиас 52-р заалтыг тэр чигт хасах санал гаргасан ч үүнийг малчид эсэргүүцэн улмаар УИХ-н лобби бүлэг татгалзсан³⁴. УИХ-ын Байгаль орчин, Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон НҮБХХААБ-ын дэмжлэгтэй Ажлын хэсэг байгуулан оролцогч талуудын дунд зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан. УИХ-ын гишүүдээр ахлуулан нийт 4 бүсийн зөвлөгөөн, малчидтай 3 удаагийн нүүр тулсан ярилцлага хийв. Дээрх зөвлөгөөн, уулзалтуудын хамгийн чухал (Др. Энх-Амгалан 2023) үр дүнгүүдийн доор Хүснэгт 5-1-т нэгтгэн оруулав. (малчид болон бусад оролцогч талуудын санал)³⁵

Асуулт	Хариулт
Танай нутагт бэлчээр доройтсон уу ?	Тийм 97.7%
Бэлчээрийг хамгаалах, илүү хариуцлагатай ашиглахад чиглэсэн хууль эрх зүйн зохицуулалт байх ёстой юу?	Тийм 90.6%
Улирлын бэлчээрийг тодорхой гэрээний үндсэн дээр ашиглах ёстой гэдэгт санал нийлэх үү?	Тийм 73.6%
Бэлчээр ашиглалтыг хариуцлагатай болгох хуулийн орчин хэрэгтэй юу?	Тийм 86.4%
Бэлчээр ашиглалтын хариуцлагыг сайжруулахад аль арга хэмжээ нь илүү тохиромжтой вэ? (зөвхөн нэгийг сонгоно уу)?	Бэлчээр ашиглах гэрээ 46.8% Өндөр татвар 27.3%
Баг, сум, аймгийн нийт бэлчээрийн 10 хувийг отрын нөөц нутаг болгох нь зөв үү?	Тийм 73.6%
Малчдын бүлгүүд бэлчээр ашиглалтын гэрээг орон нутгийн засаг захиргаатай хийх асуудлыг Газрын тухай хуульд оруулж хуульчлах нь зөв үү?	Тийм 86%

Хүснэгт 5-1: Бэлчээрийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар оролцогч талуудын үзэл

бодол

Эх сурвалж: Энх-Амгалан нар2023

Дээрх хариултаас дүгнэхэд зөвлөгөөнд оролцогсдын дийлэнх олонх нь бэлчээр ашиглалтын асуудлыг хуульчлах, сум орон нутагтайгаа гэрээ хийж ашиглах, отрын бүс нутаг гаргах зэргийг дэмжиж байгааг харж болно. Энэ тайлан боловсруулж байх үед газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг их хурлын дараагийн чуулганы үед олон нийтээр хэлэлцүүлэхээр тогтов.

Газрын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтөд оруулах саналын нэгтгэлийг Хавсралт 4-рт оруулав. Гол зүйл нь 2002 оны Газрын тухай хуулийн “Өмчлүүлснээс бусад газар нь төрийн өмч мөн, бэлчээрийг “өмчилж” болохгүй гэсэн заалтыг өөрчлөхгүй байхаар оруулсан. Бэлчээр ашиглалтыг янз бүрийн түвшний байгууллагууд (Бэлчээр ашиглагчдын бүлэг, малчид, малчин өрхүүд) хянах ба энэ нь нутгийн удирдах байгууллага болон бэлчээр ашиглагчдын хооронд гэрээгээр зохицуулагдахаар заасан. Эдгээр санал болгож буй нэмэлт өөрчлөлтүүд нь Бэлчээр ашиглагчдын хэсгүүдийг (БАХ) дэмжих, бэлчээрийг хамгаалах хууль эрх зүйн үндсийг бий болгохын зэрэгцээ орон нутгийн түвшинд отор хийх уян хатан байдлыг бий болгоно гэж үзэж байна.

5.2.2 Бэлчээрийн нүүдэл ба бэлчээрийн менежментийн байгууллагууд

³⁴ Албан нэр нь Улсын их хурал гэх боловч бид энд ойгомжтой байх үүднээс Парламент гэж оруулав.

³⁵ Ямар асуулт вэ гэдгээс шалтгаалан 652 ба 689-ын хооронд

Монгол малчдын бэлчээр нутгийн уламжлалт хэлбэр нь жилийн турш улирал цаг уураа даган дор хаяж 4 удаа нүүдэг, өвөлжөө, хаваржаа, намаржааны малын байртай байдаг. Мөн хадлан өвс авах жижиг газар эзэмшдэг. Өвөлжөө, хаваржааны газрын гэрчилгээ нь ихэвчлэн гэрийн эзний буюу нөхрийн нэр дээр байдаг.

Бид өртгийн сүлжээний хоршоод байдаг сум орон нутгийн удирдлагуудтай ярилцлага хийсэн. Зарим сумд бэлчээр ашиглах хэсгүүдээр дамжуулан бэлчээрийн зохистой менежментийг хийж чадаж байгаа бол зарим газар энэ ажил сул байна. Бэлчээрийн доройтол, түүнийг хэрхэн сэргээх, бэлчээрийн зохистой менежмент, зохицуулалтын байгууллагуудын талаар олон янзын үзэл, саналууд ярилцлагын үед гарч байв. Үүнийг Хавсралт 4-т илүү дэлгэрэнгүй оруулав.

5.2.3 Отор нүүдэл

Монгол Улс эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө зуд, зундаа ган гачиг гэх мэт байгалийн гамшигт өртөмхий. ҮСХ-ны мэдээллээс харахад сүүлийн 12 сарын хугацаанд малчдын 9.9 хувь нь

зудын, 8.7 хувь нь ган гачигт өртсөн байна. Тухайн жилийн цагийн байдлаас шалтгаалан зарим нутагт зудтай, зарим нутагт өнтэй өвөл болдог. Харин бүхий л газар нутгийг дамнасан томоохон зудыг бид гамшигт үзэгдэл гэж нэрлэдэг. Тухайлбал 2009-2010 оны өвөл болсон улсын хэмжээний зудад нийт 10.3 сая орчим мал буюу улсын нийт малын 25 хувь нь хорогдсон. Мөн 2018 онд улсын хэмжээний зуд болсон. Ган, зуд хоёр хоорондоо салшгүй холбоотой. Зун ган болж өвс ургамал муу гарсан бол өвөл нь зайлшгүй зуд болдог.

Ган зудын үед хэрэглэхээр нөөцөлсөн идэш өвс сайтай алс нутгийг отор гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл бэлчээрийн сайныг даган нүүдэллэхийг отор нүүдэл гэж нэрлэдэг. Отрын нутаг нь суман дотроо, аймаг дотроо, эсхүл аймаг хооронд гэсэн хэлбэртэй байдаг. Гэхдээ отор нүүдэл нь тухайн орон нутгийнхаа малчдын эрх ашгийн хөндөхгүй, тэдний бэлчээр ашиглалтад нөлөөлөхгүй байхаар зохицуулагдах ёстой. 2002 оны газрын тухай хууль, одоо хийхээр зорьж буй хуулийн нэмэлт өөрчлөлт нь энэ зохицуулалтыг мөн хамарсан байгаа. Одоогийн байдлаар отрыг сумын удирдлага, малчид өөрсдийн түвшинд зохицуулж байгаа ч хууль эрх зүйн хувьд тодорхойгүй зүйлүүд байсаар байна. Мёфи 2018 онд Хэнтий аймагт хийсэн судалгаандаа отрын бүс нутгийн талаарх одоогийн хууль, эрх зүйн орчин болон зохицуулалтын журмуудын талаар нэлээд оруулсан. Тэрээр судалгаандаа отрыг илүү албан бус байдлаар танил тал, ах дүү, хамаатан садны хүрээнд тохиролцон ашигладаг. Жишээ нь энэ жил отроор авсан малчнаа ирэх жил дахиад авах, эсхүл отроо ашиглуулсан газраа эргээд дараа жил оторлох гэх мэт албан бус хэм хэмжээ тогтсон тухай дурджээ. Энэ тохиолдолд чинээлэг малчид отроор нүүх боломж ихтэй, улмаар малын хорогдол багатай байдаг байна. Хавсралт 4-т отрын бүсийг хэрхэн ашигладаг талаар малчид, орон нутгийнхаас авсан мэдээллээ нэгтгэн оруулав. Бидний судалгаанд хамрагдсан сумдын хувьд сумын түвшний отрын нөөц нутгийн заагийг сумын захиргаанаас тогтоож, харин тусгай хамгаалалттай газар нутгийн бэлчээрийг зайлшгүй тохиолдолд зөвшөөрөлтэйгээр ашигладаг тухай яриу.

5.2.4 Бэлчээрийн бус газар ашиглалт, түүний зохицуулалт

Монголын өргөн уудам бэлчээр нутгийг дан МАА ашигладаггүй. Бэлчээр, ус ашиглах өөр олон талууд бий. Уул уурхайн компаниудад бэлчээр ашиглах лиценз олгох, тухайн компаниуд байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулдагтай холбоотой олон маргаан, зөрчил бий болдог. Тухайлбал 2013 онд Баянхонгор аймагт гарсан бэлчээрийн маргаантай холбоотой малчдын хөдөлгөөнийг дурдаж болно. (Бум-Очир 2020). Уул уурхайн лицензийн төрийн төв байгууллагаас олгох ба сум орон нутаг, малчдаас санал, зөвшөөрөл авдаггүй тухай Шинэжинст³⁶ сумын удирдлага бидэнд хэлж байв. Иргэний нийгмийн идэвх зүтгэлийн үр дүнд 2009 оны “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ыг баталсан ба үүнийг ихэвчлэн Урт нэртэй хууль гэдгээр нь хүмүүс мэддэг. Энэ хуулиар уул уурхайн олборлолтын компаниудыг голын эрэг болон ойн захаас 200 метр дотор үйл ажиллагаа явуулахыг хориглосон. Үүний үр дүнд хэд хэдэн компаниуд

³⁶ БАХ-ээр дасжуулан бэлчээр ашиглах гэрээ хийх нь бэлчээрийг түрээслэхээс сэргийлж магадгүй гэж тэрээр нэмж хэлсэн ч энэ нь өөр газар гарсан хэрэг дээр үндэслэсэн ам дамжсан яриа байж болзошгүй.

үйл ажиллагаагаа зогсоосон. 1995 онд баталсан Байгаль орчныг хамгаалах хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар энэ "урт нэртэй хууль"-ийг дагаж мөрдөж, хэрэгжүүлээгүйн төлөө Засгийн газрыг шүүхэд өгөх боломжтой болсон. 2015 онд урт нэртэй хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Энэ өөрчлөлтөөр гол мөрөн, ой модны хамгаалалтын бүс 200м байсныг 50м болгон өөрчилснийг Бум-очир (2020) онцолж, энэ нь "урт нэртэй хуулийг" бүхэлд нь ач холбогдолгүй болгож байна гэж үзэж байгаагаа илэрхийлэв. Lexology³⁷ вэбсайтын хийсэн нарийвчилсан дүн шинжилгээнд хэрэв уул уурхайн компаниуд байгаль орчинд учирсан хохирлыг арилгаж чадвал гол мөрөн, ой модны ойролцоо үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах эрхийг сэргээх боломжийн талаар хэлэлцүүлэг, маргаан гарч буй тухай дурджээ.

Гэхдээ энэ хэлэлцүүлэг, маргаан нь малчдын бэлчээргүй болгох, тэднийг нүүлгэн шилжүүлэх хүртэл хохирол учруулж буй талаар биш илүү уул уурхайгаас үүдсэн байгаль орчинд учирсан хохирлын тухай яригдаж байна.

Тариалангийн газрын түрээсийг орон нутгийн түвшинд шийдвэрлэх эрхтэй байдаг. Зарим газар тухайлбал Хэнтий аймгийн Биндэр суманд урьд нь ашиглаж байсан атаршсан талбайг хэрэв нутгийн малчид эсэргүүцэхгүй бол тариалан эрхлэх зориулалтаар ашиглаж байна. Мөн зарим тариалангийн уринш талбайг отрын зориулалтаар ашиглаж байна. Төв аймгийн Баянхангай суманд тариалангийн газрын эрх зүйн асуудал, журмыг хоршоогоор дамжуулан зохицуулж байна. Гэвч малчид, тариаланчдын хооронд үүссэн маргаан, зөрчлийг шийдвэрлэх тал дээр дутагдалтай, сэтгэл ханамжгүй асуудал байсаар байна. (Мардесик 2018).

Онцгой тохиолдолд тусгай хамгаалалттай газар нутгийг отроор ашиглаж болох талаар дээр дурдсан. Хөвсгөл аймгийн Алаг Эрдэнэ сумын ой мод ихтэй дархан цаазат газарт бэлчээрлэхийг хориглоогүй, малыг бэлчихийг асуудалгүй гэж үздэг. Байгаль орчны яамны шууд зөвшөөрлөөр тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын бааз байгуулах боломжтой бөгөөд шийдвэр гаргалтад сумын Засаг дарга, малчид оролцдоггүй.

5.2.5 Усны эрх

Мал усан хангамжийн асуудал бол тийм чухал биш. (малчдын ундны усны асуудлыг тусад нь 5.6-д багтаасан). Өвөлдөө цаснаас гадна мал услах задгай горхи булаг шанд олон бий. Тухайлбал, Өлзийт суманд өвөл мал усалдаг горхи, Алаг Эрдэнэ сумын халуун рашаан, Баянхангай, Шинэжинст сумдад худаг гэх мэт. Бусад улиралд тэр дундаа зуны улиралд газрын гадарга дээрх олон гол, горхи, булаг шанд гээд мал услах нөөц боломжууд их бий. Гар болон гүний өрөмдмөл худгуудыг малчин өрх дангаараа эсхүл бүлэг хоршоогоороо эзэмшдэг. БАХ, бүлэг, хоршоогоороо худаг ашиглаж байгаа тохиолдолд урсгал зардал, засвар үйлчилгээг хамтран хариуцдаг. Зарим худаг бүр социализмын үеэс ашиглагдаж ирсэн ба үйл ажиллагаа нь муудсан, усны ундарга нь доошилсон байдаг. Зарим сумд сумын төсвөөр шинээр худаг ухуулдаг. Жишээ нь Алаг-Эрдэнэ сум орон нутгийн төсвөөр 10 гүний худаг гаргуулсан байна.

5.2.6 Газар усны эрхийн тухай дүгнэлт

³⁷ <https://www.lexology.com/library/detail.aspx?g=924fef95-7ef5-4e1a-81f2-dcc5f8387112>

Бэлчээр болон байгаль орчны доройтлын асуудал нь Монгол улсад байнгын маргааны нэг сэдэв болдог хэдий ч малчид болон холбогдох талуудтай хийсэн ярилцлагаар энэ талын асуудал тийм ноцтой гэж шатанд хүрсэн гэж харагдсангүй. Малчдыг бэлчээрээ зөв зохистой ашиглах талаар орон нутгийн түвшинд дэмжихийн зэрэгцээ байгаль цаг уурын хүнд үед отроор явах, нөөц бэлчээр ашиглах тал дээр уян хатан бодлого барьж ажиллах нь чухал гэдэг нь харагдаж байна. Хууль эрх зүйн орчны өнөөгийн тодорхой бус нөхцөлд малчдын бүлгүүд сумын удирдлагатай бэлчээр ашиглалтын гэрээ хийн ажиллаж эхэлж байгаа нь бэлчээрийн хууль батлах, эсвэл газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага бий болж байгааг баталж байна.

Газар усны эрх	
Дүрэм журмыг дагаж мөрдөх	
Ил тод байдал, Орлоц, зөвлөлдөх	
Тэгш эрх, Нөхөн олговор, шударга ёс	

5.3 Хүйсийн тэгш харьцаа

Энэ бүлэгт жендерийн асуудал үндэсний түвшинд, үйлдвэрлэлийн түвшинд, малчдын түвшинд ямар байгааг нэгтгэн багтаав. Дундаж болон доогуур орлоготой олон орнуудтай харьцуулахад Монгол улс жендерийн тэгш байдлын хувьд маш мэдрэмжтэй орон юм. Үүнийг эмэгтэйчүүд ажил эрхлэлтээр эрчүүдээс илүү байгаагаас харж болно. (Empson 2020). Боловсрол эзэмшиж буй охидын тоо хөвгүүдээс өндөр байдаг. (5.6-р хэсгийг харна уу) Эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших байдал өндөр байгаа нь хөдөө орон нутгийн малчдын түвшинд жендерийн тэгш бус байдлыг бий болгож байгааг олон мэдээллийн эх сурвалжаас харж болно.

Нийгмийн асуудлын түүвэр судалгаанаас (ҮСХ 2018)³⁸ хэд хэдэн үзүүлэлтээр (зарим нь илүү хувийн чанартай) эмэгтэйчүүд эрчүүдтэй эн тэнцүү эсхүл давуу, цөөн хэдэн үзүүлэлт дээр бүр илт доогуур байгааг харж болно.

Үзүүлэлт	Эмэгтэй	Эрэгтэй
<i>Хүүхэд, өсвөр насныханд хамаарах үзүүлэлтүүд</i>		
Хөдөлмөр хийдэг (гэрийн ажлыг оролцуулахгүй), 5-17 нас	13%	20%
Хортой нөхцөлд хөдөлмөр эрхэлж буй хүүхэд, 5-17 нас	5.4%	10.0%
Сэтгэл ханамжийн оноо, 15-17 нас	7.0/10	7.0/10
Сэтгэл ханамжийн оноо, 18-19 нас	6.4/10	7.1/10
15 наснаас өмнө гэрлэсэн	0.9%	0.0%
18 наснаас өмнө гэрлэсэн	12.0%	2.1%
<i>Бүх насныханд зориулсан үзүүлэлт, 15-49 нас</i>		
Долоо хоног бүр ТВ үздэг	89.6%	89.1%
Сүүлийн 3 сард гар утас ашигласан	97.2%	94.5%
Сүүлийн гурван сар интернэт ашигласан	73.6%	63.9%
Сүүлийн гурван сар компьютер ашигласан	32%	30%
Эмэгтэйчүүдийн эсрэг ахуйн хүчирхийлэл (үндэсний)	9%	5%
Эмэгтэйчүүдийн эсрэг ахуйн хүчирхийлэл (хот)	7%	7%
Эмэгтэйчүүдийн эсрэг ахуйн хүчирхийлэл (хөдөө)	15%	4%
Амьжиргаа нь сайжирсан гэж үзэж байгаа	64%	63%
Сэтгэл ханамжийн оноо (үндэсний)	6.7/10	6.7/10
Сэтгэл ханамжийн оноо (хот)	6.6/10	6.6/10
Сэтгэл ханамжийн оноо (хөдөө)	6.8/10	6.8/10
Ялгаварлан гадуурхалт эсвэл хүчирхийлэл мэдэрсэн (үндэсний)	16%	15%
Ялгаварлан гадуурхалт эсвэл хүчирхийлэл мэдэрсэн (хот)	17%	12%
Ялгаварлан гадуурхалт эсвэл хүчирхийлэл мэдэрсэн (хөдөө)	14%	16%
Жирэмслэлтээс хамгаалах орчин үеийн аргыг хэрэглэдэг гэрлэсэн эсвэл хамтрагч эмэгтэйчүүд	45%	
Гэр бүл төлөвлөлтийн хэрэгцээ шаардлага хангасан гэрлэсэн эсвэл хамтрагч эмэгтэйчүүд	48%	

Хүснэгт 5-2: Жендерийн тэгш бус байдлын гол үзүүлэлтүүд

Эх сурвалж: ҮСХ 2018.

5.3.1 Ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн шатны хүйсийн тэгш эрх

³⁸ НҮБ-ын Хүн амын сан, ЮНИСЕФ-тэй хамтран гаргасан судалгаа.

Боловсруулах үйлдвэрийн ажиллах хүчний 90%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Голчлон ээрэх, нэхэх, сүлжих дамжлагууд дээр эмэгтэйчүүд түлхүү ажилладаг. Ноолуур угаах, ялгах шатанд цөөн тоогоор ажилладаг байна. Түүхий эд, бараа буулгах, уурын хүнд индүү зэрэг дээр эрчүүд ажилладаг. Дунд болон ахлах шатны удирдлагад эмэгтэйчүүдийн эзлэх тоо өндөр байдаг. ХЭҮК-оос мэдээлснээр эмэгтэйчүүд болон залуу ажилчдыг ажлын байран дээр дарамтлах нь “харьцангуй нийтлэг” бөгөөд бага мэдээлэгддэг байна.

5.3.2 Малчдын жендерийн тэгш байдал

Өрх гэрийн дотоод ажил, хүүхдээ асарч өсгөх, сүү цагаан идээ боловсруулах зэрэг ажилд эмэгтэйчүүдийн үүрэг роль өндөр. Ноолуур бэлтгэн нийлүүлэх бүхий л шатанд эмэгтэйчүүдийн оролцоо маш их. Өдөр тутмын мал хариулга, арчилгаанд эмэгтэйчүүд илүү оролцдог бол мал мах зарах борлуулах гэх мэт ажилд эрчүүд илүү эрх мэдэлтэй байдаг. Мөн байгаль орчиндоо анхаарч хамгаалах, энэ талын мэдлэгээ дамжуулах тал дээр эмэгтэйчүүд илүү санаа зовж оролцдог тухай онцолсон байна. (Ыханибай 2006, Волонини 2015).

Хөдөлмөрийн хүйсийн хуваарилалт ба ажлын ачаалал

Энэ бүлэгт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваарилалт, ачааллын талаарх гол мэдээлэл, дүгнэлтийг нэгтгэн оруулав. Эмэгтэйчүүд дунджаар өдөрт 11.1 цаг ажилладаг бол эрчүүд 9.2 цаг ажилладаг байна. Хамгийн их ачаалалтай ажилладаг үе нь зуны сарууд бөгөөд эмэгтэйчүүд 8 сард өдөрт 14.1 цаг, 7 сард өдөрт 13.6 цаг ажилладаг байна. Энэ нь мал саах, цагаан идээ боловсруулахад ихэнх цагаа зарцуулдаг байна. Харин эрчүүдийн хувьд хавар буюу мал төллөх, ямаа самнах үеэр 3 сард өдөрт 13.5 цаг, 4 сард 11.6 цаг ажилладаг байна.

Өртгийн сүлжээний үе шатуудад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоо нь олон хүчин зүйлээс шалтгаалан янз бүр байдаг. Тухайлбал мал үржлийн хугацаа, бүс нутаг, малын төрөл зүйл, томоохон зах зээлд ойр эсэх зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан өөр өөр байдаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн үүргийн талаар илүү нарийвчилсан танилцуулга, Волтолини нар (2015)-ын судалгааны тайлангаас авсан эшлэл зэргийг хавсралт 4-т үзүүлэв. Волтолини нар (2015)-ын судалгаагаар мал үржлийн ажил нь эрчүүдийн хамгийн их оролцдог гурван ажлын нэг гэжээ.

Судалгаанд хамрагдсан 8 аймгаас 5 аймагт нь отор нүүдэл хийдэг ба бараг бүх эрчүүд отор нүүдлийн ажлаа хариуцан харин эмэгтэйчүүд гэртээ үлдэн бусад аж ахуйгаа хариуцдаг байна. Отор нүүдэлд эрчүүд эмэгтэйчүүдээс даруй 1.2- 8.9 дахин их цаг зарцуулдаг гэжээ.

Хүснэгт 5-3-т эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ямаа самнах болон ноолуур зарах ажилд зарцуулах цагийг жилээр нь тооцож оруулав. Аймаг болон нутгийг онцлогоос шалтгаалан зарим тохиолдолд эрчүүд эмэгтэйчүүдтэй адил эсвэл бага цаг зарцуулдаг бол зарим газар эрчүүд ноолуур зарах ажилд эмэгтэйчүүдээс илүү цаг зарцуулдаг байна.

Аймаг	Ноолуур самнахад зарцуулсан цаг		Ноолуур зарахад зарцуулсан цаг	
	Эрчүүд	Эмэгтэйчүүд	Эрчүүд	Эмэгтэйчүүд
Баян-Өлгий	е	60.0	5.7	0.8
Завхан	79.4	58.7	6.2	2.1
Говь-Алтай	68.6	58.7	5.2	2.1
Ховд	68.5	46.1	3.0	2.6
Мандал	63.8	64.3	8.6	7.7
Төв	102.2	67.2	4.0	4.3
Дундговь	126.5	107.6	7.0	10.4

Хүснэгт 5-3: Ноолууртай холбоотой ажилд зарцуулсан цаг, эрэгтэй, эмэгтэй
Эх сурвалж: Волтонини нар (2015)

Мөн мал аж ахуйгаас гаднах бусад үйл ажиллагаанаас олдог орлогын ихэнхийг эрчүүд бүрдүүлдэг байна. Судалгаанд хамрагдсан 52 өрхийн 38.5% нь эрчүүд, 19.2% нь эмэгтэйчүүд, 25.0% нь эр, эм хоёр хамтдаа, 15.4% хүүхэд, 1.9% нь эхнэр хүүхэд мал аж ахуйгаас гадна орлого олдог гэж хариулжээ.

Өрхийн шийдвэр гаргалт

Мал аж ахуйн үйл ажиллагааны үе шат бүр дэх өрхийн гишүүн бүрийн (аав, ээж, хүү, охин), шийдвэр гаргалт ямар байдаг тухай асуултын хариултыг Хүснэгт 5.4-т оруулав. Өрхийн тэргүүнүүд ихэвчлэн мал аж ахуй тойрсон томоохон асуудлууд дээр шийдвэр гаргадаг. Өрхийн насанд хүрсэн эрэгтэй хүүхдийн шийдвэрийг өрхийн тэргүүний шийдвэр дээр нэмж тооцож харвал эрчүүдийн шийдвэр гаргах түвшин илүү өндөр байна. Ялангуяа урт хугацааны бэлчээр ашиглалт эсвэл отроор явах шийдвэр дээр эрчүүд илүү эрх эдэлдэг.

Шийдвэр гаргалт	Нөхөр	Эхнэр	Хөвгүүд	Охид
Сүргийн менежмент (жишээ нь: үүлдэр угсаа сайжруулах, сүргийн бүтэц, хэмжээ)	47.6	32.2	15.4	4.8
Улирлын чанартай бэлчээрийн нүүдэл	44.2	28.8	21.7	5.3
Бэлчээрийн менежмент, бэлчээр амраах	63.9	20.3	10.5	5.3
Отгор нүүдэл	45.0	23.5	24.0	7.5
Малын гаралтай бүтээгдэхүүн борлуулах зах зээлийг сонгох	43.0	31.1	15.7	10.2

Хүснэгт 5-4: Малчин өрхийн гишүүдийн шийдвэр гаргалт (% , N=215)
Эх сурвалж: Волтонини нар (2015)

Өрхийн худалдан авалт дээр хэн илүү шийдвэр гаргаж байгаа талаар судлахад эрчүүд хүнс, хувцас худалдан авахаас бусад бүх худалдан авалтын шийдвэрийг гаргаж байна. Зээл авах шийдвэрийг эхнэр, нөхөр хамтдаа гаргадаг гэж 54.1% нь, нөхөр дангаа гаргадаг гэж 32.4% нь, эхнэр дангаараа гаргадаг гэж 13.5% нь хариулсан байна. (Волтолини 2015)³⁹ Мөнгө захиран зарцуулах эрх харьцангуй тэгш байна. (Хүснэгт 5.5). Зарим аймагт өрхийн санхүүгийн захиран зарцуулах эрх бага зэргийн ялгаатай байна. Тухайлбал Баян-Өлгий аймагт судалгаанд хамрагдсан нийт өрхийн 51.2% нь эрчүүд өрхийн мөнгө санхүүг захиран зарцуулах шийдвэр гаргадаг гэжээ. Харин завхан аймагт дөнгөж 12.5% нь эрчүүд энэ тохиолдолд шийдвэр гаргадаг гэжээ. Малын тоо 1000-аас дээш, эсвэл 60-аас дээш

³⁹ Энэ асуултын талаар хоёр өөр хариулт ирсэн боловч илүү найдвартай гэж үзсэнийг энд орулав.

настай⁴⁰ бол нөхрүүд мөнгө захиран зарцуулах магадлал өндөр гэх санал байгаа ч үүнийг нотлох түүвэр маш бага байна.

Нөхөр	Нөхөр, хүү хамтран	Нөхөр, эхнэр хамтдаа	Эхнэр давамгайлан	Эхнэр дангаараа	Ээж, хүүхдүүд
33.4	8.0	21.6	2.8	33.8	0.3

Хүснэгт 5-5: Гэр бүлийн санхүүг захиран зарцуулах байдал (% , N= 287)

Эх сурвалж: Волтонини нар (2015)

Өрхийн өмчийг ерөнхийдөө зөвхөн нөхрийнхөө нэр дээр бүртгэдэг. Энэ нь өвөлжөө (85.5%), мал (87.2%), мотоцикл болон ачааны машинд (77.8% ба 81.8%) хамаарах боловч машин, тракторын хувьд бага байна (Волтолини 2015).

Бидний ярилцлагад эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүд илүү хамрагдаж оролцож, саналаа өгсөн. Шийдвэр гаргалттай холбоотой бидний асуултад өгсөн хариулт нь шударга, ил тод байсан ба энэ нь өмнө хийгдсэн судалгааны үр дүнг баталж байна.

Олон нийтийн ажил дахь оролцоо

ШХА болон МБАНХ-ноос багийн иргэдийн нийтийн хурал, хоршоо, БАХ-ийн хурал дахь эмэгтэйчүүдийн оролцооны талаар тайландаа тусгасан байна. Дээрх хурлуудад эрчүүд жилдээ 1.23 давтамжтай ордог бол эмэгтэйчүүдийнх 0.72 байна. Хуралдаанд оролцох ирцийн хувьд эрэгтэй, эмэгтэй оролцогсдын тоо бараг ижил тэнцүү байдаг хэдий эмэгтэйчүүд зарим нэг ээлжит хуралд оролцож чадахгүй байгаа нь энэ тоо зөрүүтэй гарахад нөлөөлж байна. БАХ хэсгийн хуралд эмэгтэйчүүдийн оролцоо сул байна. Шалтгааныг нь тодруулахад ар ажлыг нь хариуцаад үлдэх хүнгүй (33%), машин унаагүй (21%), хугацаа байршлын хувьд боломжгүй байсан (20%) бусад уламжлалт шалтгаанууд (16%) байсан байна.

БАХ-ийн хурал дахь эмэгтэйчүүдийн ирц Багийн хурал, хоршооны бүх гишүүдийн ирцээс доогуур байгаа бусад шалтгаан нь зарим нэг хурал, үйл ажиллагаа нэгдсэн гадаа бэлчээрт зохион байгуулагддаг тул мал хариулж яваа эрчүүд түлхүү оролцдог, зарим БАХ биеийн хүчний ажил хамтарч хийдэг, БАХ-н бүртгэлд зөвхөн гэрийн эзний нэр байдаг тул уригддаг гэх мэт шалтгаанууд байна. БАХ-ийн ахлагч нар голдуу эрчүүд байдаг. Малчид БАХ, хоршооны даргын хувьд эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүдээс илүүд үздэг ч судалгаанд оролцогсдын (БАХ 34%, хоршооны хувьд 41%) олонх нь эрэгтэй, эмэгтэй даргын аль нь ч ялгаагүй гэж хариулжээ. Малчдын бүлэг, хоршоодын эмэгтэй дарга нарын хувьд тулгамдаж буй гол асуудал нь өрх гэрийн их ажлын хажуугаар цаг зав хомс байх, үргэлж айлаар явж чадахгүй зэрэг бэрхшээл юм. Бидний хийсэн ажиглалт, ярилцлага ерөнхийдөө дээр дурдсан үр дүнг баталж байна. Харин хавсралт 4-рт бидний очсон гурван суманд хоршооны манлайлалд эмэгтэйчүүдийн оролцоо маш их байгаа талаар оруулсан.

Жендер ба боловсрол

Жендертэй холбоотой дараагийн чухал асуудал бол боловсрол юм. Нийт малчдын тун бага хувь (10%) нь гэрийн эзэгтэй хүүхдээ харан сумын төвд амьдрах хэрэгтэй гэж үзсэн байна. Бидний ярилцлагаас харахад олон малчид хүүхдийг хэт бага байхад нь сургуульд элсүүлж

⁴⁰ Өрхийн тэргүүний нас гэж таамаглаж байгаа боловч энэ талаар заагаагүй байна.

байгаа нь тохиромжтой биш гэж үзэж байна. Сургуульд орох насыг 8 байсныг 6 болгосон нь малчдын хувьд хүндрэл авчирсан. Малчдын бас нэг санаа зовоож буй асуудал нь мал дээр үлдэж малчин болох хүүхдүүд байхгүй болж байгаа явдал гэдгийг онцолж байв. Ялангуяа охид малчин болох дургүй, эрэгтэй хүүхдээ л малчин болох байх гэсэн итгэл өвөрлөж байна. Зарим малчид (38%) охин хүүхдээ эмч эсвэл багш болоосой гэж хүсдэг ч өөрсдөө мэргэжлээ сонгосон нь дээр хэмээн шийдвэрийг хүү, охиндоо үлдээх эцэг эх олон байна. (Волотонин 2015).

5.1.1 Жендерийн тэгш байдлын дүгнэлт

Ноолуурын өртгийн сүлжээн дэх жендерийн тэгш байдлыг нэгтгэн дүгнэх амаргүй. Ноолуур боловсруулах дэд салбар нь эмэгтэйчүүдийн гол ажил олгогч бөгөөд таатай цалин урамшуулал, ажиллах орчинтой төдийгүй, салбартаа эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих боломжтой. Малчны түвшинд эмэгтэйчүүд ноолуурын үйлдвэрлэлийн бүхий л шатанд ажилладаг. Малчин эмэгтэйчүүд газар, мал, өрхийн томоохон хөрөнгийн хууль ёсны өмчлөгч байх, эсвэл шууд зээл авах эрхийн боломж бага байдаг ч гэр бүлийн гишүүний хувиар эдгээр хөрөнгөөс ашиг шим бүрэн хүртдэг. Малчин эмэгтэйчүүд өрх дотроо шийдвэр гаргах, малчдын байгууллагыг удирдах, ажлын ачаалал зэргээр ялгаварлагддаг мэт харагддаг ч энэ нь онцгой нөхцөл байдал, малчдын амьдралын онцлог, тусгай ур чадвар шаардах гэх мэт хүчин зүйлүүдээс шууд хамааралтай гэдгийг харгалзан үзэж, энэ нь жендерийн тэгш бус байдал биш юм гэдгийг гэдгийг ойлгох нь чухал юм. (Дэ Фариа 2023).

Ажлын нөхцөл	
Эдийн засгийн үйл ажиллагаа	Зөв
Нөөц, үйлчилгээний хүртээмж	Зөв
Шийдвэр гаргах	Хэцүү
Манлайлал ба Эрх мэдэл	Хэцүү
Бэрхшээл, хөдөлмөрийн хуваагдал	Зөв

5.2 Хоол, шим тэжээлийн аюулгүй байдал

Энэ бүлэгт зөвхөн хоол хүнсний аюулгүй байдал төдийгүй Монгол Улсын хувьд байнга хөндөгддөг хоол тэжээлийн олон янз байдлын талаарх асуудлыг багтаасан. Мөн малчдын амьжиргааны аюулгүй байдлын хоёр чухал асуудал болох өр зээл, малын даатгалын⁴¹ асуудлыг энд оруулав.

5.2.1 Хоол тэжээл түүний олон янз байдал

Хоол тэжээлийн аюулгүй байдал нь VCA4D судалгаа хийгдсэн бусад олон оронтой харьцуулбал Монгол улсад харьцангуй гайгүй. Улсын хэмжээнд хүнсний аюулгүй байдлын ноцтой асуудал (жишээ нь, хоолгүй хонох) хүн амын ердөө 5% -иас багад тохиолддог бол, дунд зэргийн хүнсний аюулгүй байдал (хэрхэн хоол хүнстэй болох талаар сэтгэл зовох) хүн амын 25% -иас бага хувьд тохиолдож байна. Энэ 2 үзүүлэлт хот суурин газар болон хот орчмын бүсэд хөдөө орон нутгийн хүн амынхаас хамаагүй өндөр байна. (ХХААБ-ын

⁴¹ Энд өгүүлсэн сэдвүүдээс гадна малчдын 11 орчим хувь нь сайн дурын нийгмийн даатгалд хамрагдаж, бүгд тэтгэвэр тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамрагдах боломжтой гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

ажилтнуудтай хийсэн ярилцлага). Үндэсний хэмжээнд ҮСХ, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сангаас гаргасан Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанаас үзэхэд өсөлтийн хоцрогдол тав хүртэлх насны хүүхдийн дөнгөж 9.4%, туранхай 0.9%, тураал ердөө 1.8%, харин илүүдэл жин 10.5% байна (ҮСХ 2018). Гэсэн хэдий ч цаг уурын эрс тэс үзэгдлүүд нь хүүхдийн хоол тэжээлийн байдалд (ялангуяа тэднийг сургуульд элсэхэд) урт хугацааны туршид нөлөөлдөг гэсэн нотолгоо байдаг (ХХААБ 2022).

Хоолны төрөл зүйл дутмаг, хязгаарлагдмал, баяжигдаагүй, зөвхөн "мах, гурил"-ын хоолны дэглэмтэй холбоотойгоор шим тэжээлийн дутагдалтай болох эрсдэлийн талаар санаа зовниж байна (FAO 2022, FAO, EU and CIRAD 2022). Малчин өрхүүд уураг, өөх тос ихтэй мах, цагаан гурил, будаа өдөр тутамдаа хэрэглэхээс гадна өрхийн төсөв боломж гарвал чихэрлэг шүүс, ундаагаар хэрэглэдэг. Таргалалт хүүхэд, насанд хүрэгчдийн дунд нэмэгдэж, цусны даралт ихсэх, чихрийн шижин, цус харвалт, хорт хавдар зэрэг халдварт бус өвчний эрсдэл нэмэгдэж байна. Малчдад өвөлжөөнийхөө газар бага хэмжээгээр хүнсний ногоо тарьж хүнсэндээ хэрэглэх гэх мэт хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх талаар зөвлөмж өгөх нь маш бага байдаг (ХХААБ 2022).

Өр зээл

Өртгийн сүлжээнд оролцогсдын өр зээлийн асуудлын талаар сүүлийн үед академик судалгааны түвшинд нэлээд яригдаж байна (Снийт 2012, Вотэрс 2023). Ялангуяа тэд өрөө багцалж, үнэлж чадаж байгаа эсэх, нэг өрөө нөгөө өрөөр дарж албан болон албан бус өрийн дарамтад өртөж буй байдал 2015-2016 оны эдийн засгийн уналтаас хойш хэрхэн дордож буй талаар нэлээд ярьж, бичиж байна. Төв, Хэнтий, Баянхонгор аймгуудад бидний хийсэн ярилцлагаас дүгнэхэд орон нутагт зээл авах нь хэвийн үзэгдэл бөгөөд тэр дундаа малчдын зээлийн асуудал тийм ч их хүндрээгүй байна. Харин Архангай аймагт нэг малчин зээлээ төлж чадахгүй байх байдалд орох вий гэдгээс маш их айдаг гэдгээ хэлж байв. Зээлийн хүү 1.8%-аас 2.4% болж өссөн ба олон хүн хувь хүнээс хүүтэй (6%) мөнгө зээлэх нь их байна. Хөвсгөл аймагт өр зээлийн асуудал анхаарахуйц түвшинд хүрсэн байна.

ҮСХ-ны 2021 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллээс түүвэрт хамрагдсан 3502 малчин өрх (ямаатай) сүүлийн 12 сарын хугацаанд дунджаар 6.94 сая төгрөгийн нийт 1508 зээлийг (нэг хүн олон зээлтэй байх боломжтой) авчээ. Түүврийн 29 хувь нь банкнаас авсан малчны зээл бөгөөд зээлийн хэмжээ дунджаар 7.62 сая төгрөг байна. Энэ статистик судалгаатай харьцуулбал бидний судалгаанд хамрагдсан аймгуудад (ноолуурын өртгийн сүлжээ хөгжсөн, хүнд сурталтай шат дамжлагыг сайн мэддэг) зээлийн нөхцөл, хүртээмж илүү сайн байсан байна. Түүврийн 4%-иас дээш хувь нь өөр төрлийн зээл (цалингийн зээл, тэтгэврийн зээл гэх мэт) аваагүй байна.

Малчны зээл нь 1-2 жилийн хугацаатай байдаг нь малаас олох орлогоо зээлийн эргэн төлөлттэй уялдуулах зохицуулах боломжийг олгодог. Уламжлалт цагаан сарын баяраар малчны зээлийн эрэлт нэмэгддэг. Мөн зарим малчид намар 9 сард хүүхдүүдээ сургуульд явахад оюутны төлбөр төлөх зориулалтаар зээл авдаг байна. Долоо юм уу найман сард шинээр зээл авах тоо өсдөг. Малыг зээлийн барьцаанд авдаг. Арилжааны банкнууд сумын ЗДТГ-тай холбоотой ажиллаж малын А дансны бүртгэлийг үндэслэн олгох зээлийн хэмжээг тогтоодог. Зээлийн эргэн төлөлтийг сар бүр биш малчдын орлогод нийцүүлэн ихэвчлэн жилд 2 хуваан (намар мал борлуулах, хавар ноолуур борлуулах цаг) төлөхөөр гэрээ хийх

боломжтой байдаг.

Вотэрс 2023 онд хийсэн судалгаандаа хөдөөгийн Монголчуудын “овоорсон өр”-ийн талаар хөндсөн асуудалдаа малчдын зээлийг оруулаагүй. Учир нь малчдын зээл хэвийн хэмжээнд явж байгаа учир тэдэнд өрийн дарамт үүсгэдэггүй гэж үзжээ. Мөн Мёрфи 2018 оны судалгаандаа Ноолуур үйлдвэрлэгчдэд албан ёсны зээл олгох нь зөв цагтаа хөрөнгө оруулах, эсвэл зээлийн хэрэгцээтэй үед асуудлаа шийдэх, бүс нутгийн ялгааг бууруулах, баялаг бүтээх, чанартай ноолуур үйлдвэрлэх байгалийн нөхцөл бүрдүүлэхэд чухал дэмжлэг болдог тухай дурдсан байна. ҮСХ-ны мэдээллээс (2021) малчны зээл авсан (ямаатай) малчдын 97.3 хувь нь зээлээ төлөх боломжтой гэж хариулсан байна.

5.2.2 Малын даатгал

Малын индексжүүлсэн даатгалыг амжилттай хэрэгжүүлж буй цөөхөн орны нэг нь Монгол (Хойд Кени улсын хамт) юм. Малын индексжүүлсэн даатгал нь нөхөн төлбөрийг тооцохдоо зөвхөн нэг өрхийн хорогдсон малын тоонд биш сумын түвшний бүх малын хорогдлын дунжийг үндэслэн тооцох систем бөгөөд даатгалтай холбоотой ямар нэг үндэслэлгүй өндөр төлбөр нэхэмжлэх, зүй ёсны биш үйлдэл гарахаас урьдчилан сэргийлдэг. (Махул 2009).

МИД-г анх 2000 оноос эхлэн сонирхон хэрэгжүүлж эхэлсэн ба 2004 оноос хууль эрх зүйн орчин бүрдэж, Дэлхийн банкны санхүүжилтээр 2006 оноос эхлэн 3 жилийн туршилтын төсөл хэрэгжүүлсэн. (ДБ төслийн цаашдын хэрэгжилтэд оролцоогүй). Цаашид даатгалын 5 компанийг оролцуулан 2013 он хүртэл сунгагдан хэрэгжсэн. 2009-2010 оны зуд малын даатгалын ач холбогдлыг малчдад ойлгуулж, МИД-д хамрагдах сонирхол нь илүү нэмэгдсэн. МИД-г одоо Монголын 9 даатгалын компанийн Хаан банк, Төрийн банкны салбарт байрлах 2611 төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж байна. Малчид даатгуулах малын тоогоо өөрсдөө гаргадаг (үүнийг сумын малын А данстай тулгаж үздэг) ба нөхөн төлбөрийг малын төрөл зүйл, тоо толгойг үндэслэн олгодог. Малын хорогдлын бүртгэл мэдээллээс харахад нөхөн олговрын хэмжээ сум, сумаар ялгаатай байна. Тухайлбал, – нэг ямаанд ногдох шимтгэлийн доод хэмжээ Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл, Дархан-Уул аймгийн хэд хэдэн суманд 75 төгрөг байсан бол Баянхонгор суманд дээд тал нь 745 төгрөг байна. Энэ нь даатгуулсан хэмжээ болон малын нийт хорогдлын зэргээс шалтгаалдаг. Даатгалын загвар схемээс хамаараад сумын хэмжээний малын хорогдол 6% юм уу 10%-иас хэтэрсэн тохиолдолд нөхөн олговор олгодог.

Гэсэн хэдий ч МИД-д хамрагдаж буй малчдын тоо 20%-иас доош байсаар байна. Үүнийг Sendai Framework-н дунд шатны тайлангаас (УОБГ 2022)⁴² харж болно. Мөн Хүснэгт 5.6-д нэгтгэж оруулав. Энэ тайлангаас харахад УБ хот орчмын малтай өрхийн (малын эзэн нь өөрөө малчин бус) МИД-д хамрагдах байдал нэмэгдэж байна.

Жил	Даатгуулсан малчин өрхийн дугаар	Нийт малчин өрхийн %	Даатгалд хамрагдсан малын тоо (сая)	Нийт малын %	Шимтгэлийн орлого (тэрбум)	Нөхөн төлбөр (сая төгрөг)
-----	----------------------------------	----------------------	-------------------------------------	--------------	----------------------------	---------------------------

⁴² 2022 оны НҮБ-ын ХХААБ-ын тайланд бага зэрэг өндөр 22% гэж байгаа ч бусад ярилцлагад оролцогчид ОБЕГ-ын мэдээлэлтэй санал нэг байна.

					төгрөг)	
2016	18738	11.7	4.2	7.5	1.77	79.6
2017	24148	15.3	5.7	9.2	2.33	1091.9
2018	33719	19.8	7.8	11.8	3.46	323.3
2019	32337	18.8	7.4	11.2	3.85	600.9
2020	28527	16.6	7.1	10.2	3.48	2593.3
2021	34709	19.2	7.4	11.0	3.92	(Боломжгүй)
Нийт	172178		39.6		18.81	4689.0

Хүснэгт 5-б: МИД-ын хүртээмж

Эх сурвалж: ОБГ 2022

Манай ярилцлагад оролцогчид ерөнхийдөө даатгалд хамрагдаагүй, даатгалд хамрагдсан хүмүүсийг таньдаг нь цөөхөн байсан. Учир нь сумын дундаж хорогдлын 6%-ийн босгыг давах нь тун ховор гэж үзсэн. Өлзийтийн нэг малчин даатгалын үнэлгээний системийг “хуурамч”, “зүгээр л бизнес” гэж нэрлэжээ. 6%-ийн хорогдлын түвшин нь отор нүүдэл хийж чадах чинээлэг малчид гэхээс илүү боломж чадалгүй эмзэг бүлгийн малчдын хохирлыг барагдуулахад чиглэсэн байж болох талаар ДБ-ны мэргэжилтэн тайлбарлаж байв. Энэ санааг Мерфи, Ичинхорлоо нар судалгааны тайландаа (удалгүй гарах) нар мөн адил илэрхийлж байгаа бөгөөд тэд индексийн тогтолцооны талаарх ойлголт дутмаг, итгэл үнэмшилгүй, МИД-ийн зарчим ба малчдын ёс суртахууны хоорондын уялдаа холбоо, нийцэл сул байгаа зэрэг өргөн хүрээтэй асуудлуудыг онцолсон байна.

Малчны зээлийн шаардлагад МИД-ийн гэрээ хийсэн байхыг тусгадаг. Малчид даатгуулсан гэдгээ мэдэхгүй байж болзошгүй учир үүнийг зээлийн өргөдөлд хавсралт болгон оруулсан байдаг. Жишээ нь Хөвсгөл аймагт нэгэн ярилцлагад малчин өрхийн нөхөр нь МИД-тэй гэдгээ мэдээгүй байсан бол эхнэр нь мэдэж байв. Харин малчны зээл авахад МИД хийлгэсэн байх шаардлага нь зээл авахгүй байхад нөлөөлөх хүчин зүйл биш юм. ҮСХ-ны тоо баримтаас харахад зээл авсан 29% малчин өрхийн 20% нь л МИД хийлгэсэн⁴³ байв. Онолын хувьд малчны зээл авч буй малчин өрх МИД хийлгэх шаардлагатай боловч зарим аймаг, сумын банкны салбарууд зээлийн сайн түүхтэй малчдад МИД шаардахгүйгээр зээл олгосон тохиолдлууд байв. (Архангайн нэгэн сум, ДБ-ны судалгаанд оролцогч, Даниел Мерфи-н судалгаа)

5.3.3 Хүнс, хоол тэжээлийн бүлгийн дүгнэлт

Энэ бүлэгт хөдөө орон нутгийн Монголчуудын хүнс, хоол тэжээлийн дутагдал, аюулгүй байдлын талаар хийсэн судалгааны дүгнэлтийг багтаав. Хөдөө орон нутагт хоол тэжээлийн дутагдлын асуудал бага ч гэлээшим тэжээлийн олон янз байдал дутмаг, таргалалт илүүдэл жингийн асуудал ихсэж байна. Мөн зээлийн өрийн дарамт, малын даатгалын асуудлыг ч энэ бүлэгт хамтатган багтааж дүн шинжилгээ хийв. Ахуй амьдралынхаа багахан хэрэгцээг хангах үүднээс малчны зээл авдаг ба энэ хот суурин газарт тулгардаг шиг өрийн сүлжээ үүсгэж дарамт болдоггүй байна. МИД-н талаар малчид сэтгэл хангалуун биш байв.

Хоол хүнс, хоол тэжээлийн аюулгүй байдал	
Хүнсний хүртээмж	
Хүнсний хүртээмжтэй байдал	
Хэрэглээ ба хоол тэжээлийн	

⁴³ Бидний ашигласан ҮСХ-ны тоо нь зөвхөн ямаатай малчин өрхүүдэд үндэслэсэн нь энэ гажуудлыг тайлбарлахад учир дутагдалтай юм.

зохистой байдал	
Тогтвортой байдал	

5.4 Нийгмийн баялаг

5.4.1 Үйлдвэрлэгчдийн давуу тал

Бидний явсан газруудад ноолуурын өртгийн сүлжээ нь БАХ, эсвэл малчдын хоршоо сайн хөгжсөн газруудад илүү түлхүү хөгжсөн нь харагдаж байв. Хоршооны тухай Бүлэг 2-рт дэлгэрэнгүй өгүүлсэн. Ямаатай малчин өрхийн 3/1 нь ямар нэг байдлаар хоршоонд элссэн байсан бөгөөд цөөн малтай орлого багатай малчин өрхийн гишүүд хоршоонд элсээгүй байх магадлал өндөр байна. Яг энэ талаар баталж нотолсон судалгааны тайлан материал олдоогүй. Хуулиараа хоршоо гишүүдийн өмчлөлтэй боловч маш олон хоршоо хэдхэн хүний өмчлөл, удирдлага дор үйл ажиллагаа явуулж байна. Волотинийн (2018) судалгаагаар сүүлийн 12 сарын хугацаанд эрэгтэй малчдын зөвхөн 14%, эмэгтэй малчдын 13% нь хоршооны хуралдаа оролцог байна. Нийт хуралд оролцсон давтамжийн дунджийг тооцвол эрэгтэй малчин 2, эмэгтэй малчин 1.5 байна.

Бидний газар дээр нь очиж уулзаж ярилцсан хоршоодын үйл ажиллагаа сайн, малчдын сэтгэл ханамж сайн, үнэ тохирдог, ногдол ашиг тараадаг зэрэг нь малчдад таалагддаг байна. Яг сонгодог хоршооны зарчмаар үйл ажиллагаа явуулж буй хоршоодод гишүүнээр элсэх эрх нээлттэй байна.

БАХ болон ижил төстэй малчдын байгууллагууд бэлчээр ашиглалтын менежментийн өргөн хүрээнд амжилттай хэрэгжүүлж байна. БАХ-г нэгтгэн зохион байгуулдаг удирдах дээд байгууллага нь Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо⁴⁴ бөгөөд нийт 1575 БАХ, 91,000 гишүүдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Багийн түвшинд нэг БАХ байх ба тухайн нутаг дэвсгэрт байх малчин өрхүүдээ сайтар хамарсан байдаг. Сумын ЗДТГ-тай бэлчээр ашиглалтын гэрээ хийн нягт хамтран ажилладаг бөгөөд бусад холбогдох хууль, дүрэм журмыг даган мөрддөг.

МБАНХ- нь нийт 18 аймгийн 169 (330 сумын) сумыг хамран үйл ажиллагаа явуулж байна. МБАНХ нь Хариуцлагатай нүүдэлчин стандартыг хэрэгжүүлэх үүднээс өөрийн гишүүнчлэлийн БАХ-үүдээ бэлчээрийн тогтвортой менежмент хэрэгжүүлэх, малын эрүүл мэндийг сайжруулах, түүхий эдийн чанарыг сайжруулахад нь дэмжлэг үзүүлэн ажилладаг.

БАХ-тэй ижил төстэй бүтэцтэй малчдын бүлгүүд НҮБ гэх мэт олон улсын байгууллагуудын санаачилга, дэмжлэгээр бий болж байна. БАХ-ууд нь тэгш оролцоо, хүртээмжийг эрхэмлэдэг хэдий ч дээрх 5.3-т дурдсанчлан хүйсийн тэгш оролцоо алдагдсан байна. Сүүлийн 12 сарын хугацаанд эрэгтэй малчдын 18%, эмэгтэй малчдын 7% нь БАХ-ын хуралд оролцсон бөгөөд оролцсон уулзалтын дундаж тоо эрэгтэй 2, эмэгтэйчүүдийн хувьд 1,9 байна.

5.4.2 Мэдээлэл ба итгэл

ХХААБ (2022)-ын судалгаанд хамрагдсан малчдын дөнгөж 4.6% нь сүүлийн 12 сарын хугацаанд мал аж ахуйн чиглэлээр ямар нэгэн сургалтад хамрагдсан гэж тэмдэглэсэн бөгөөд энэ нь бидний хийсэн ярилцлагын үр дүнтэй ерөнхийдөө нийцэж байна.

Зарим малчид зөвхөн өөрсдийн мэдлэг, туршлагадаа итгэж найдан мал малладаг тухай яриу. Мөн улсаас барьж буй ямар нэг бодлогын талаар мэдээлэл бага байдаг тухай зарим нь яриу. Малчид малын эрүүл мэндийн талаарх мэдээлэл эсвэл мал эмнэлгийн үйлчилгээний үр дүн өндөр байгааг нотлох баримт бага байна. Үүнийг бидний судалгааны ярилцлагуудын үр дүн ч бататгав. Малчид хөдөө аж ахуйн технологи, газар тариалангийн бодлого, зах зээлийн үнийн талаар мэдээлэл олж авахдаа олон төрлийн эх сурвалж, хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авдаг бөгөөд орон нутгаас шалтгаалан өөр өөр байдаг байна. Мэдээллийн эх сурвалжуудыг дурдвал:

- Телевиз (ХХААБ-ын дасан зохицох чадвартай холбоотой Волтолини нарын 2018 онд хийсэн

⁴⁴ Манай судалгааны багийн нэг гишүүн нь МБАНХ-ны гүйцэтгэх захиралаар ажилладаг гэдгээ мэдүүлж, ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ баталсан юм.

судалгаагаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн мэдээллийн гол эх сурвалж гэдгийг гаргаж ирсэн, ҮСХ 2018 онд үндэсний хэмжээнд хүн амын 89% нь телевизор үздэг болохыг тэмдэглэжээ)

- Олон нийтийн сүлжээ (нэг малчин ихэнх малчин өрх Facebook ашигладаг гэж хэлсэн)
- Хөгжлийн төслүүд (бэлчээрийн менежмент, мал аж ахуй, тэжээлийн талаарх сургалтаас гол мэдээллээ авдаг)
- Сумын захиргаа болон сумын төв (янз бүрийн мэдээллийн хувьд)
- Багийн хурлын хурал (ялангуяа шинэ хууль тогтоомж, бодлогын хувьд)
- Найзууд (үнийн мэдээлэл авах)
- Ноолуурын ченжүүд (үнийн мэдээлэл авах)
- Үйлдвэрүүдтэй шууд холбоо барих (үнийн мэдээлэл авах бол - ялангуяа Төв аймагт).

Малчид 10 жилийн өмнөхийг бодвол мэдээллийг харьцангуй сайн авдаг болсон тухай нэг малчин яриу.

Бидний хийсэн ярилцлагаас харахад Босоо хамааралт дэд сүлжээн дэх оролцогчдын хоорондын итгэлцэл, тухайлбал малчдын хоршоо, БАХ-д итгэх итгэл, хоршоодын ноолуур боловсруулах томоохон үйлдвэрүүдэд итгэх итгэл зэрэг боломжийн түвшинд байна. Харин Хятадын компаниуд болон тэдний төлөөлөн ноолуур худалдаж авдаг монгол ченжүүдийн талаар малчид, хоршооны гишүүд, боловсруулах үйлдвэрүүдийн менежерүүд ерөнхийдөө сөрөг ойлголттой байсан ч энэ нь тийм ч анхаарал татахуйц түгээмэл биш байсан ба зарим малчид тэднийг урьдчилгаа зээл өгдөгт талархаж байв.

Бид хээрийн судалгаанд оролцсон малчдаас харилцаж байсан байгууллагуудаас аль нь хамгийн их итгэдэг болохыг асуусан. Хариултууд нь маш ялгаатай байв. Хоёр хүн орон нутгийн хоршоодоо найдвартай, шаргуу хөдөлмөрлөдөг, цагаан идээ ноолуур аль алиныг нь борлуулдаг, ногдол ашиг хуваарилдаг, томоохон ноолуурын брэнд үйлдвэрүүдтэй урт хугацааны гэрээтэй зэрэг олон зүйлээс шалтгаалан илүү итгэдэг гэдгээ хэлж байв.

Малчдын итгэлийн авсан бусад байгууллагуудыг жагсаавал:

- ЕХ-ны санхүүжилттэй төсөл
- МБАНХ
- Аймгийн төв дээр байдаг ноолуурын жижиг үйлдвэр

Харин нэг малчин дээрх байгууллагуудын алинд ч итгэдэггүй харин багийн даргадаа илүү итгэдэг гэжээ.

5.4.3 Нийгмийн оролцоо

Хүн амын нягтаршил бага, бэлчээр нүүдлийн хэв маягийг эс тооцвол орон нутаг, ялангуяа сум, багийн түвшний өртгийн сүлжээний байгууллагууд дахь оролцоо харьцангуй эрүүл тогтолцоотой. Иргэд, малчид өөрсдийн амьдрал ахуйтай холбоотой шийдвэр гаргалтад идэвхтэй оролцдог. Зөвхөн ганц малчин төр татвараас бусад үед малчдад хүрч ажилладаггүй гэж хэлснийг эс тооцвол сум, аймгийн түвшний удирдах байгууллагуудын талаар томоохон шүүмжлэл гараагүй. Бэлчээрийн тухай хуулинд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар хийгдэж буй хэлэлцүүлэг нь (Энх-Амгалан 2023 – Бүлэг 5.2-г харах) цаашид олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр малчдын дуу хоолойг шийдвэр гаргагч нарт хүргэж болно гэдгийг харуулж байна. БАХ, хоршоо гэх мэт малчдын байгууллагуудыг бодвол багийн иргэдийн нийтийн хуралд оролцох оролцоо арай өндөр байна. Волтолиний судалгаанаас харахад сүүлийн 12 сард болсон БИНХ-д эрэгтэй малчдын 26%, эмэгтэй малчдын 25% нь оролцсон байна. Оролцсон хурлын тоог дунджаар тооцвол эрэгтэй малчид 2.3, эмэгтэй малчид 1.6 байна.

Бид өөрсдийнх нь мал аж ахуйн мэдлэг хир үнэлэгдэж буй талаар асуухад 4 хүний 3 нь үгүйсгэсэн бол 1 нь эерэг хариу өгсөн байна. Малчид хэдийгээр бэлчээрийн мониторингийн олон үйл ажиллагаанд хамрагддаг ч энэ нь өөрийн уламжлалт мэдлэг туршлага дээрээ үндэслэсэн биш төсөл хөтөлбөрөөс хийгдэж буй судалгаа, хяналтын ажил давамгайлсан ажлууд байна.

Ямаа самнах ажлыг хэдийгээр хөлс өгч хийлгэдэг ч малчдын дунд нэг нэгэндээ тусладаг бичигдээгүй хууль бий. (Волтолини нар 2015) БАХ-ын үйл ажиллагаа тухайлбал худаг ухах, засах, усны эхийг хамгаалах, малын тэжээл тарих, хадлан бэлтгэх, хураах, зам гаргах, засах зэрэгт биеийн хүч шаардсан ажлуудад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү ихээр оролцдог байна.

5.5.1 Нийгмийн баялгийн талаарх дүгнэлт

Монгол даяар өрнөж буй хоршооллын хөдөлгөөн малчдын гуравны нэгд хүрч байгаа ч манай ярилцлагад оролцогчдын хэлснээр БАХ-ууд улам хүчтэй болж байна. Хөдөө аж ахуйн технологи, бодлого, практик, итгэлцлийн талаарх мэдээллийн урсгал байдал дэд сүлжээний дотор янз бүр байгаа боловч ерөнхийдөө таатай дүр зураг гарч байна. Ялангуяа багийн хурлын ирц, оролцоо өндөр байна.

Нийгмийн Баялаг	
Үйлдвэрлэгч байгууллагуудын хүч чадал	
Мэдээлэл ба итгэл	
Нийгмийн оролцоо	

5.5 Амьдралын нөхцөл байдал

Амьдралын нөхцөл байдлын талаарх дүгнэлтийг үндсэндээ ҮСХ, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сангаас хамтран нийтэлсэн 2018 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны инфографик (NSO 2018) болон ҮСХ-ны 2021 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэлд үндэслэн гаргав. Үндэсний хэмжээний хот, хөдөө орон нутаг төлөөлсөн 14000 өрхийн түүвэр судалгааны үр дүн ба ямаатай малчин өрхөд хамааралтай статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийв. Түүнчлэн НҮБХХААБ-ын 2022 оны Монгол малчин өрхийн дасан зохицох чадавхын шинжилгээний зарим үзүүлэлтийг тус дүгнэлтэд ашигласан болно.

5.5.1 Эрүүл мэндийн үйлчилгээ

Монгол Улсын хөдөө орон нутагт эрүүл мэндийн үйлчилгээ маш сайн зохион байгуулалттай, үр дүнтэй байдаг. Ялангуяа хүн амын нягтрал багатай газруудад хүртээмж нь илүү сайн байдаг. Бидний судалгаанд хамрагдагсдын бараг бүгд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжид сэтгэл ханамжтай байв. Бүх суманд багийн түвшинд мэргэжлийн эмч нар⁴⁵ ажилладаг ба дийлэнх нь эмэгтэй эмч нар байдаг. Сумын хэмжээнд жижиг, дунд хэмжээтэй эмнэлгүүд ажилладаг. Эмэгтэйчүүд, хүүхдэд зориулсан эрүүл мэндийн үйлчилгээний хувьд нярайн болон төрөхийн өмнөх үзлэгийг 5 сараас эхлэн хийдэг. Эмэгтэйчүүд ихэвчлэн сум, аймгийн эмнэлгүүдэд хүүхдээ төрүүлдэг. Хөдөө орон нутгийн эхчүүдийн 86% нь 4 ба түүнээс дээш удаа жирэмсний хяналтад хамрагдаж, хөдөө орон нутаг, хотыг нэгтгэн авч үзвэл төрөлтийн 99% нь мэргэжлийн эмч нарын гар дээр төрсөн байна. Эх нярайн аль аль нь (94%) төрсний дараа 2 хоног дотор мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөөг авсан байна. (ҮСХ 2018)

5.5.2 Орон байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж

Малчин өрхийн 76 хувь нь өөрийн Монгол гэрт амьдардаг (ҮСХ 2021). Судалгааны багийнхан гэрээс доогуур нөхцөл байдалтай амьдрах орон байртай малчидтай таараагүй. Зарим газар, ялангуяа Буриадад малчид дүнзэн байшинд амьдардаг.

Ямаатай малчин өрхүүдийн талаар ҮСХ-ны (2021) статистикаас авсан мэдээллийг Хүснэгт 5-7-д багтаасан ба ахуйн хэрэглээний усны эх үүсвэр, ундны ус хүртэлх зай, ариун цэврийн байгууламжийн төрөл зэргийг харуулав. Үзүүлэлтийн түвшин доогуур мэт харагдаж болох ч хүн амын нягтрал бага, улирлын шинжтэй нүүдэл суудал нь ус, ариун цэврийн байгууламжид оруулах хөрөнгө оруулалтын зардлын өсгөдөг. Ялангуяа ариун цэврийн байгууламжууд нь энгийн задгай жорлон байдаг ба айл саахалт хоорондын зай хол байдаг учир жорлон, ариун цэврийн байгууламжийн хэрэгцээ төдийлөн их биш байдаг.

⁴⁵ Олон улсын жишгээр сувилагч, эмч нарын харьцаа бага байдаг ч энэ нь хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ юм

Үзүүлэлт	Ямаатай өрхийн %
Усны эх үүсвэр	
Хоолой/Цооног	23.3
Ус түгээх худаг	15.7
Хашаалсан гар худаг	14.6
Хашаалсан булаг	1.5
Бусад өндөр зэрэглэлийн байгууламжууд	3.2
Хашаалаагүй гар худаг	7.1
Хашаалаагүй булаг	4.1
Гадаргуугийн ус	29.8
Борооны ус	0.9
Ундны ус хүртэлх зай	
<200 м	24.4
200 – 1000 м	35.3
>1000м	32.7
Хариулт байхгүй	7.7
Ариун цэврийн байгууламжийн төрөл	
Бохир усны системд холбогдсон	2.4
Агааржуулалттай сайжруулсан нүхэн жорлон	10.1
Зориулалтын шал, гишгүүртэй нүхэн жорлон	26.6
Зориулалтын бус шал, гишгүүртэй нүхэн жорлон	20.5
Даавуугаар хаасан түр жорлон	15.4
Жорлон байхгүй	24.3
Бусад	0.7
Жорлонгоо хувааж хэрэглэдэг үү?	
Үгүй	78.9
Тийм	21.1

Хүснэгт 5-7: Ямаатай малчин ус, ариун цэврийн байгууламжийн хэрэглээний үзүүлэлт
Эх сурвалж: ҮСХ 2021

5.5.3 Боловсрол

Монгол улс сургуульд хамрагдалт болон дүүргэлтээр маш сайн үзүүлэлттэй, ялангуяа охидын боловсрол эзэмшилтийн хувь маш өндөр байдаг. Сумын түвшинд өмнө нь анхан шатны бага боловсрол 4 жилийн сургалттай байсан бол шинэ системээр 5 жил болсон. Ахлах сургуулийн боловсролыг ихэвчлэн томоохон сумын төв эсхүл аймгийн төвд суралцаж байж авна. Суурь боловсролд хамрагдагсдын түвшин маш өндөр бөгөөд нийт элсэлтийн түвшин охидын хувьд 103%, хөвгүүдийн хувьд 106%⁴⁶ байна. Дунд сургуулийн сурагчдын болон төгсөлтийн хувь хэмжээг Хүснэгт 5-8-д үзүүлэв.

Үзүүлэлт	Эмэгтэй	Эрэгтэй
Бага болон дунд сургуульд суралцагсад (Хөдөө)	96.6	90.1
Бага болон дунд сургуульд суралцагсад (Хотын)	92.9	92.9
Бага болон дунд сургууль дүүргэсэн (Үндэсний)	95.6	89.3
Бүрэн дунд боловсролд хамрагдагсад (Хөдөө)	86.1	66.7
Бүрэн дунд боловсролын хамрагдагсад (Хотын)	93.5	89.9

⁴⁶ Элсэлтийн нийт хувь нь сургуульд сурч буй хүүхдүүдийг сургуулийн боловсролын түвшинд хамаарах насны хүүхдийн тоонд хуваасан тул 100%-иас хэтэрч болно. Эдгээр нь Боловсролын бодлого, мэдээллийн төвөөс гаргасан (2018) тайлангаас иш татсан ЮНЕСКО-гийн 2017 оны тоо баримтууд юм. https://www.epdc.org/sites/default/files/documents/EPDC_NEP_2018_Mongolia.pdf

Бүрэн дунд боловсрол дүүргэсэн (Үндэсний)	75.0	65.9
---	------	------

Хүснэгт 5-8: Сургуульд хамрагдсан болон төгссөн үзүүлэлтүүд, Эх сурвалж: ҮСХ 2018.

Монгол Улс хүн амын нягтаршил багатай, бэлчээрийн мал аж ахуйн эрхээр байнга нүүдэллэн амьдрах тул хөдөө орон нутагт боловсрол олгохдоо сургуулийн дотуур байранд хүүхдүүдээ суулгадаг. Олон газарт дотуур байрны хүрэлцээ, нөхцөл муу, барилга нь муу чанартай байдаг. Эдгээр хүчин зүйлс болон хүүхдийн сургуульд орох насыг 8-с 6 нас болгож өөрчилснөөс шалтгаан ээжүүд бага насны хүүхэдтэйгээ сумын төвд амьдрах болсон. Энэ нь улмаар залуу гэр бүлүүд салахад хүргэж байна. Боловсрол нь үнэ төлбөргүй, ном сурах бичгийг үнэгүй олгох боловч дотуур байрны болон бусад амьжиргааны зардал, унаа, дүрэмт хувцасны зардал үүнд ороогүй болно. Багш нарын ур чадвар муу байна гэсэн саналыг хоёр газарт хийсэн ярилцлагын үед хэлж байв.

Төрийн өмчийн хоёр сургуульд (Улаанбаатар дахь Солонгос-Монголын Техникийн коллеж, Эрдэнэт хот дахь Технологийн Дээд Сургууль) ноос ноолуур боловсруулах зэрэг хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 16-с дээш насны сурагчдыг элсүүлэн авч сургадаг. Мэргэжлийн боловсролын сургалт үнэ төлбөргүй, оюутны тэтгэмжид хамрагдах боломжтой байдаг. Түүнчлэн ШУТИС-ийн дэргэд Ноос ноолуурын салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор Японы хөнгөн аж үйлдвэр, тэр дундаа дэвшилтэт сүлжмэлийн машин үйлдвэрлэлээр тэргүүлэгч Шима Сейки компанийн санхүүжилтээр сургалтын төв байгуулсан. Тус сургалтын төвд олон улсын зах зээлийн шаардлагад нийцсэн загвар, чанартай ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Япон улсын дэвшилтэт технологи ашиглах ур чадварыг олгодог⁴⁷.

Тус сургалтад ахисан шатны сургалтад хамрагдсан мөн Япон улс уруу туршлага судлах сургалтад хамрагдсан менежерүүд манай судалгааны ярилцлагад багтсан.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, хууль тогтоомж, зах зээлийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг авах боломжийн талаар дээр Бүлэг 4.5-д өгүүлсэн.

5.5.4 Амьдрах орчин нөхцөлийн талаарх бусад хүчин зүйлс

Хүснэгт 5-9-д малчин өрхийн өдөр тутмын ахуйн хэрэглээний эд зүйлсийн жагсаалтыг оруулав.

Эд зүйл	%
Дизель мотор	9.5
Нарны зайн хавтан	67.6
Салхин сэнж	0.3
Мотоцикл	44.9
Машин	40.0
Ачааны машин	34.2
Ухаалаг утас	0.9
Бусад гар утас	74.0
Интернэт сүлжээ	13.3

Хүснэгт 5-9: Сонгогдсон хэрэглээний эд зүйлс ба малчин өрхийн хувь
Эх сурвалж: ҮСХ 2021

ХХААБ (2023) нь хөдөө аж ахуйн багаж хэрэгсэл (жишээ нь, хадлан бэлтгэх тоног төхөөрөмж, трактор, хашаа хороо) болон тээврийн хэрэгсэлтэй байх нь малчин өрхийг байгалийн бэрхшээлийн даван туулах, дасан зохицох чадавхыг нэмэгдүүлдэг гэдгийг онцолж байна. Дээр дурдсанчлан авто машин ашиглалт ихэссэн нь мал маллах хөдөлмөрийн хэв маягийг өөрчилсөн. НҮБХХААБ-аас (2023) малчдын ердөө 14% нь төвийн цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдсон тухай тайландаа тусгасан байна. Бидний судалгаа болон ҮСХ-ны мэдээллээр нарны үүсгүүр болох батарей нь маш түгээмэл хэрэглэгддэг байна. Энэ нь малчдад гар утас, интернэт ашиглах боломжийг олгодог.

⁴⁷ <http://www.sitech.edu.mn/en/page/78>

Бидний ажигласнаар ухаалаг утасны хэрэглээ, ҮСХ-ны тоо баримтаас хамаагүй илүү байна. Малчид гар утас ашиглан олон нийтийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл авч байна.

5.5.5 Амьдрах орчин нөхцөлийн дүгнэлт

VCA4D төслийн хүрээний өртгийн сүлжээний тоглогчдын амьдралын нөхцөл байдал харьцангуй сайн байна. Ялангуяа, 6 настай хүүхдийн сургуулийн асуудлыг эс тооцвол боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, орон гэрийн асуудал маш сайн байна. Ундны ус, ариун цэврийн байгууламжийн нөхцөл ОУ-н стандарттай харьцуулбал доогуур нөхцөл байдалтай ч хүн амын сийрэг нягтаршил, нүүдлийн мал ахуйн нөхцөл нь түүнийг сайжруулахад хүндрэл үүсгэж байна.

Амьдралын нөхцөл	
Эрүүл мэндийн үйлчилгээ	
Орон байр	
Боловсрол, сургалт	

5.6 Асуулт 3-ын хүрээний хариулт

Ноолуурын өртгийн сүлжээний нийгмийн асуудлуудыг малчдын болон үйлдвэрлэгчдийн түвшинд хэд хэдэн төрлийн үзүүлэлтээр шинжилгээ хийж үзэв. VCA4D төслийн үнэлгээ хийсэн дунд болон бага орлоготой бусад орнуудтай харьцуулбал Монгол улсын ноолуурын өртгийн сүлжээн дэх нийгмийн үзүүлэлтүүд эерэг үр дүнтэй байв.

Боловсруулах үйлдвэрлэлийн шатанд ажлын нөхцөл гарцаагүй сайжирсан нь МХҮАҮЭ, ажил олгогч нарын хүчин зүтгэлийн үр дүн бөгөөд тухайн салбар нь бусад салбарыг бодвол хүмүүсийн сонирхлыг татах нь илүү байдаг нь бас нөлөөлсөн гэж үзэж байна. Малчдын түвшний нийгмийн үзүүлэлтүүдэд хийсэн дүн шинжилгээг Хүснэгт 5-11-д харуулав.

	ӨС-н дэхь асуудлууд	Шийдвэрлэх арга зам
Ажлын нөхцөл	* Залуу охид малчин болох сонирхолгүй байна * Туслах малчны хөдөлмөрийн мөлжлөгийг бууруулах	Интернэт гэх мэт нийгмийн хөгжилд оролцох боломжийг бүрдүүлэх Хууль журмыг сайжруулах
Ус, газрын эрх	* Хуулийн тодорхойгүй байдал	* Хуулийн өөрчлөлтийг дэмжих
Хүйсийн тэгш байдал	* Эмэгтэйчүүд ажлын хүндийг хийдэг ч шийдвэр гаргалтад бага оролцдог	* Жендерийн тэгш байдлын талаар сургалт, мэдээлэл сайн өгөх
Хоол, тэжээлийн аюулгүй байдал	* Хүнсний олон янз байдал муу * Даатгалын тогтолцоо сул	* Хүнсний тухай хууль * Ган зудын үеийн даатгалын бус өөр арга хэмжээ

Нийгмийн баялаг	Хоршооны хөгжил сул Хууль эрх зүйн талаар ойлголт мэдлэг сул	* Гишүүнийн өмчит хоршоодын стандарт, баталгаажуулалтын урамшууллыг нэмэгдүүлэх * Хоршоо, БАХ-аар дамжуулан мэдээлэл, сургалт өгөх
Амьжиргааны нөхцөл	* Ноцтой асуудал байхгүй	

Хүснэгт 5-10: *Өртгийн сүлжээн дэх гол асуудлууд*

Мал аж ахуй нь нийгэм, соёл, түүхийн өвөрмөц онцлогтой. Эдийн засаг, байгаль орчны асуудлуудтай нягт уялддаг төдийгүй дээр дэлгэрэнгүй тусгасанчлан ажлын нөхцөл, жендерийн харьцаа гэх мэт нийгмийн чухал асуудлууд хөндөгддөг. Малчдын залуу халаа, ялангуяа охид малчин болохоос зайлсхийж байгаа зэрэг нь анхаарлаа хандуулах цаг болсон байна. Хүнс, хоол тэжээлийн олон төрлийн хэрэглээ, сонголтын дутагдалтай байдал зөвхөн өртгийн сүлжээний хүрээнд бус нийтэд нь анхаарч, арга хэмжээ авах хэрэгтэйг харуулж байна. Малчдын түвшний олон нийтэд тулгуурласан байгууллагуудын тухайлбал БАХ, хоршоодын хөгжилд ахиц гарч байгаа ч малчдын цөөнхийг хамарч байна. Бэлчээрийн менежментийг хуульчлах асуудал олон жил яригдаж байгаа ч их хурлаар хэлэлцэгдэх болсон нь дэвшилтэй. Хэдийгээр өртгийн сүлжээний хүрээнд бид шийдэж чадахгүй ч олон малчид, нутгийн иргэдийн чухалчлан хэлж байсан зүйл бол малын эрүүл мэндийн асуудал юм. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж муу байгааг тэд онцолж байв. Дүгнэхэд, өртгийн сүлжээний тоглогчдын хувьд нийгмийн талын ноцтой асуудал, тухайлбал ОУ-н Донор байгууллагуудын хөрөнгө оруулалтыг зогсоох хэмжээний асуудлууд байхгүй ба харин ч хөрөнгө оруулалт, дэмжлэг нь малчид, үйлдвэрлэгчдийн нийгмийн сайн сайхан байдлыг улам дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

6.ӨРТГИЙН СҮЛЖЭЭ НЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУВЬД ТОГТВОРТОЙ ЭСЭХ?

6.1 Байгаль орчны үнэлгээний арга зүй

Энэ дүн шинжилгээний хүрээнд Монгол ноолуурын өртгийн сүлжээ нь байгаль орчинд ээлтэй, тогтвортой эсэх гэсэн асуултад хариулахын зорив. Байгаль орчны үнэлгээ хийхийн тулд бид судалгааны хоёр арга зүйг ашиглав. Үүнд: (i) Амьдралын чанарын мөчлөгийн тоон мэдээлэл цуглуулах үнэлгээ (хүний эрүүл мэнд, эко систем, байгалийн нөөц) болон уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлж буй нөлөө, (ii) биологийн олон янз байдалд учруулж буй эрсдэлийн үнэлгээ багтана.

Дээрх ерөнхий асуултад хариулахын тулд 5 дэд асуултыг бэлдэж ашиглав:


- Өртгийн сүлжээний Байгалийн нөөцийн доройтолд үзүүлэх хор нөлөө юу вэ?
- Өртгийн сүлжээний эко системийн чанарт үзүүлэх сөрөг нөлөө юу вэ?
- Өртгийн сүлжээний хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө юу вэ?
- Өртгийн сүлжээний УАӨ-д үзүүлэх сөрөг нөлөө юу вэ?
- Өртгийн сүлжээний биологийн олон янз байдалд үзүүлж буй нөлөөллийг тусад нь судлах шаардлага байгаа юу?

6.1.1 Амьдралын мөчлөгийн дүн шинжилгээ

Байгалийн нөөцийн хомсдол, экосистемийн чанар, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

Өртгийн сүлжээний байгаль орчны нөлөөллийн дүн шинжилгээг хийхдээ **Байгалийн**

нөөцийн хомсдол, экосистемийн чанар, хүний эрүүл мэнд гэсэн гурван хамгаалалтын талбар (ХТ) үзүүлэлтийн дагуу хийв. Ингэхдээ амьдралын мөчлөгийн үнэлгээ хийх ReCiPe 2016 арга зүйг ашиглав. Энэ арга зүй нь дээрх гурван үзүүлэлтийн хүрээнд суурь шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулсан эцсийн шалгуур үзүүлэлтийг гаргадаг учраас хамгийн тохиромжтой нь байв. Байгаль орчны механизмын дунд цэгийн үзүүлэлт болон хамгаалалтын талбарын 3 үзүүлэлт хоорондын уялдаа холбоог Зураг 6-1-т харуулав.



Зураг 6-1: Нөлөөллийн категориуд, тэдгээрийг тооцох арга зүй
Эх сурвалж: Huijbregts et al. (2016)

ХТ-ыг олон янзын нэгжээр харуулсан. Эрүүл мэндийн үзүүлэлтийг DALYs (хөгжлийн бэрхшээлийг харгалзан тохируулсан амьдралын жил), буюу нийт амьдралын хугацаанд өвчин, ослоос шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй болсон хугацааг харгалзуулан тооцдог аргачлалаар тооцсон.

Экосистемийн чанарын нэгжийг урт хугацааны явцад устаж үгүй болсон амьтан, ургамлын төрөл зүйлийн тоонд харгалзуулан тооцдог. Байгалийн нөөцийн хомсдолын нэгж нь ам.долларын (\$) буюу ирээдүйд олборлох эрдэс баялаг, малтмал түлшинд зарцуулах зардлын тооцооллоор хэмжигддэг. Шаталсан иерархи (H) аргачлалыг сонгосон бөгөөд учир нь энэ нь нөлөөллийн механизмын цаг хугацааны хамрах хүрээ, үнэмшилтэй байдлын холбоог шинжлэх ухаанд үндэслэн боловсруулсан арга зүй юм. (Goedkoop et al. 2013).

Мөн хамгаалалтын талбарын гурван үзүүлэлтийг “points” (Pt) буюу онооны системээр үнэлсэн. Ингэснээр өртгийн сүлжээний үе шат бүр нь дэлхийн байгаль орчны хохиролд хир нөлөө үзүүлж буйг мэдэх, хэмжих боломж олгодог. Өртгийн сүлжээний явцад байгаль орчинд хор хөнөөлтэй хамгийн халуун цэгийг тодорхойлж өгөх ба энэ сөрөг нөлөөллийг бууруулахын тулд ямар арга хэмжээ авах ёстойг тодорхойлж өгдөг.

Уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөлөл

Уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг мөн Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын зөвлөлөөс гаргасан (IPCC 2021) аргачлалын дагуу тооцоолж, IPCC-ийн Үнэлгээний 6-р тайланд үндэслэсэн болно. Энэ аргачлал нь IPCC-ийн 2013 боловсруулсан аргачлалын шинэчилсэн хувилбар юм. Энэ нь IPCC-ээс гаргасан 100 жилийн хугацаанд Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс (GWP) дээр үндэслэсэн. Энэ 100 хүчин зүйлсийг ашиглах саналыг Frischknecht нар анхлан 2016 онд санал болгож нэвтрүүлсэн байна. Биоген CO₂-ийн шингээлт, ялгаралт нь богино мөчлөгтэй бөгөөд цэвэр ТЭГ ялгаралтайг харгалзан энэхүү аргачлалын тооцооллоос CO₂ шингээлт болон биогенийн CO₂ ялгаруулалт, шингээлтийг хассан болохыг тэмдэглэх нь зүйтэй. Төрөл бүрийн хийн ялгарлын хүчин зүйлсийн лавлагааг Хүснэгт 6-1-д үзүүлэв.

Хий	Хий ялгаруулах салбар	Лавлагаа
Метан хий CH ₄	Хивэгч малаас ялгарах фермент	IPCC 2019 Tier 2
	Бууц	IPCC 2019 Tier 1
	Түүхий нүүрс шатаах	IPCC 2019 Tier 1
Азотын давхар ислийн хий N ₂ O	Байгалийн хий	IPCC 2019 Tier 1
	Нүүрс шаталтаас шууд бусаар ялгарах	IPCC 2019 Tier 1
		IPCC 2019 Tier 1
		IPCC 2019 Tier 1
Нүүрсхүчлийн хий CO ₂	Төрөл бүрийн тээврийн түлш	IPCC 2019 Tier 1
	Нүүрс шатаах	IPCC 2019 Tier 1

Хүснэгт 6-1: ХХЯ-ыг тооцсон эх сурвалжууд

Энэ судалгаанд нүүрстөрөгчийн (C) шингээлтийг тооцож үзээгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Өмнө хийгдсэн судалгаанууд нь экосистемийн төрөл зүйл бүрээр ялгаатай олон янзын тооцооллыг гаргасан байна. Жишээ нь

– Шао нарын судалгаагаар CO₂-ийн шингээлт жилд 160-аас 187 гC.м⁻². (2017) байна.

Гэвч ижил төрлийн экосистемийн хувьд ч эдгээр утгууд нь ихээхэн ялгаатай байж болно. Жишээлбэл, хялгана давамгайлсан хээрийн жилийн С баланс нь – 41 гэсэн тооцооллыг хийсэн байна. (Li et al., 2005), 68 (Wang et al., 2008) болон 187 (SГao et al., 2017)


Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөлөл

Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг тогтоохын тулд хоёр удаагийн хээрийн судалгааны аяллын үед хийсэн ярилцлагаар олж авсан тоон болон чанарын мэдээллийг ашиглав.

6.1.2 Системийн хязгаарлалт, функциональ нэгж ба амьдралын мөчлөгийн хуваарилалтын дүрэм

Системийн хязгаарлалт

Системийн хязгаарлалт нь **амьдралын мөчлөгийг** гол суурь юм. Энэ хязгаарлалтууд нь цаг хугацаа, орон зай, технологийн гэж ангилагддаг. Түр хугацааны хязгаарлалт нь 2022 оны нөхцөл байдлыг илэрхийлж чадах хамгийн бодит ойр тоон өгөгдөл юм. Орон зайн хязгаарлалт нь үндэсний хэмжээний өртгийн сүлжээг хамардаг. Өртгийн сүлжээний шат дамжлага бүрийн тоглогч нарын үйл ажиллагааны нарийн тоон мэдээлэл цуглуулахад хүндрэлтэй тулгарсан тул системийн технологийн хязгаарлалтыг үйлдвэрийн анхан шатны орцоос эхлээд дотоодын зах зээлд зориулж үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн хүртэлх үе шат хооронд байхаар тогтов. (Зураг 6-2).



Зураг 6-2: Системийн хязгаарлалтууд (2030 замын зураг тайлангаас ашиглав)

Малчны хотонд ноолуур үйлдвэрлэх буюу ямаа самнахаас эхлээд эцсийн бүтээгдэхүүн болох хүртэлх бүх үйл явцад хэрэглэгдэж буй үйлчилгээ тухайлбал эрчим хүч, тээвэрлэлт (дотооддоо болон гадагшаа) гэсэн бүх шатыг хамарсан үнэлгээ юм. Технологийн хязгаарлалтыг функциональ дүн шинжилгээтэй хамтатган дараах үе шатаар тооцдог.

- Зөвхөн ямаа самнахтай холбоотой процесс
- Түүхий ноолуур бэлтгэх үе шат, ангилах ялгах
- Ноолуур будах үе шат
- Ээрэх, утас бэлдэх
- Нэхмэл, сүлжмэл бэлдэц үйлдвэрлэл, эсгэх оёх дамжлага
- Бүх шат дамжлагыг холбосон тээвэрлэлт

Жижиглэн худалдааны сав, баглаа боодол, үйлдвэрийн хог хаягдлыг дахин ашиглах болон устгалын талаар мэдээлэл хомс учир энэ үе шатуудыг тооцоогүй.

Функциональ нэгж гэж үйлдвэрээс гарч буй ноолууран хувцасны кг-н хэмжээ юм.

Хуваарилалт

Хуваарилалт гэдэг нь тухайн системийн хүрээлэн буй орчинд үзүүлж буй ачааллыг өөр өөр бүтээгдэхүүнд эсвэл дагалдах бүтээгдэхүүнд хуваах үйл явц юм. Жишээлбэл, мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцооны хувьд байгаль орчинд үзүүлж буй ачааллыг сүү, мах, бууц, ноос гэх мэт өөр өөр гарц бүтээгдэхүүн хооронд хуваарилах ёстой. Амьдралын мөчлөгийн шинжилгээтэй уялдуулан хуваарилах үндсэн аргачлалыг ISO 14041-д тусгасан болно. Хуваарилалтад физик хэмжигдэхүүнийг (жишээ нь кг, м², м³ гэх мэт) ашиглах боломжгүй учир үйлдвэрлэлийн орцыг бүтээгдэхүүн болон функцүүдийн хооронд тэдгээрийн хоорондын бусад харилцааг тусгасан байдлаар хуваарилах ёстой. Жишээлбэл, хүрээлэн буй орчны орц, гарцын өгөгдлийг тухайн бүтээгдэхүүний эдийн засгийн үнэ цэнтэй пропорциональ хамаарлаар бүтээгдэхүүн хооронд хуваарилж болно.

Судалгаандаа бид бүтээгдэхүүн хоорондын нөлөөллийг хуваарилахдаа эдийн засгийн үр өгөөжийн хуваарилалт (өөрөөр хэлбэл жинг өөр өөр салбарын зах зээлийн үнээр үржүүлсэн) дээр үндэслэн загварчилсан. Загварчлалд ашигласан үнэ нь эдийн засгийн шинжилгээнд ашигласан үнэтэй ижил байна (3.2-р хэсгийг үзнэ үү). Суурь өгөгдлийн тухайд (өөрөөр хэлбэл амьдралын мөчлөгийн мэдээллийн санд байсан) сонголт нь хэрэглэгчдээс хамааралтай тул эдийн засгийн хуваарилалтын аргыг хэрэглэх илүү гэж үзсэн.

6.2 Амьдралын мөчлөгийн судалгаа

Төрөл бүрийн үе шатны үйл явцыг харуулахын тулд амьдралын мөчлөгийн бүртгэлийг хийв.

(Зураг 6-2).

6.2.1 МАА-н үйлдвэрлэлийн суурь дата

Сүргийн бүтэц, тоо толгойн мэдээллийг жил бүрийн мал тооллогын дүн дээр үндэслэв. МАА-н үйлдвэрлэлийн суурь дата мэдээллийг үндэсний хэмжээнд гарган Хүснэгт 6-2-рт үзүүлэв.

Дата мэдээлэл	Параметр	Нэгж	Үнэ	Эх сурвалж
Сүргийн бүтэц	Малын нийт тоо	10 ³ Толгой	27 569	ҮСХ
	Бие гүйцсэн эм мал (>2 нас)	10 ³ Толгой	11 579	Мал тооллогын дүн
	Ухна (>2 нас)	10 ³ Толгой	232	Мал тооллогын дүн
	Бусад нас гүйцсэн мал (>2нас)	10 ³ Толгой	9 329	Мал тооллогын дүн
	Шинэ төл (0-1 нас)	10 ³ Толгой	7 144	Мал тооллогын дүн
	Эр мал, эм мал (1-2 нас)	10 ³ Толгой	6 430	Мал тооллогын дүн
Малы	Нас гүйцсэн эм мал	Кг	28	Цэвэгмид (2016)
	Ухна	Кг	45	Ярилцлага

н жин	Бусад эр мал	Кг	38	Цэвэгмид (2016)
	Төл мал	Кг	20	Ярилцлага
Сүргийн динамик	Нас гүйцсэн эм малын хувийн жин	%	42	Мал тооллогын дүн
	Нэг ухнад ноогдох ямаа	толгой	50	Цэнд-Аюуш
	Төллөсөн хувь	%	62	ҮСХ
	Хорогдлын хувь (Нас гүйцсэн мал)	%	5	ҮСХ
	Хорогдлын хувь (төл мал)	%	10	Ярилцлага
	Борлуулсан нас гүйцсэн эр малын нас	Жил	6	Ярилцлага
	Борлуулсан нас гүйцсэн эм малын	Жил	7	Ярилцлага
Тоног төхөөрөмж	Нарны хавтан	ашиглах хоног	35	Мал тооллогын дүн ^а
	Цахилгаан дизель мотор	ашиглах хоног	2	Мал тооллогын дүн ^а
	Машин	ашиглах хоног	11	Мал тооллогын дүн ^а
	Ачааны машин	ашиглах хоног	12	Мал тооллогын дүн ^а
	Мотоцикл	ашиглах хоног	14	Мал тооллогын дүн ^а
	Түлшний амбаар	м ²	84,020	Ярилцлага
	Худаг	ашиглах хоног	180	Ярилцлага
Орц	Малын амны ус	м3	1,861	Тооцоолол ^б
	Бензин шатахуун	литр	165,414	Мал тооллогын дүн ^а
	Аргал түлэх	Кг	1,700	Мал тооллогын дүн ^а
	Малын тэжээлийн биомасс	кгMS	8,050,148	Нэг хонин толгой тутамд жилд 292кг
	Газар ашиглалт-Цөл	Га	2,312,442	Өөрсдийн тооцоолол ^е
	Газар ашиглалт – Цөл хээр	Га	4,037,333	Өөрсдийн тооцоолол ^е
	Газар ашиглалт – Тал хээр	Га	3,573,681	Өөрсдийн тооцоолол ^е
	Газар ашиглалт – Ойт хээр	Га	1,461,614	Өөрсдийн тооцоолол ^е
	Газар ашиглалт – Өндөр уулын бүс	Га	264,525	Өөрсдийн тооцоолол ^е
	Газар ашиглалт – Тайга	Га	454,980	Өөрсдийн тооцоолол ^е
	Хадлан	тонн	248,121	Ярилцлагаас тооцоолол хийв ^с
	Улаан буудай тариалалт	Тонн	104,211	Ярилцлагаас тооцоолол хийвс
	Түүхий ноолуур	Тонн	9,672	ҮСХ
	Ухна	10 ³ Толгой	46	Тооцоолол хийв

Гарц	Бусад нас гүйцсэн эр мал	10 ³ Толгой	2,572	Тооцоолол хийв
	Нас гүйцсэн эм мал	10 ³ Толгой	2,488	Тооцоолол хийв
	Сүү	Тонн	81,068	Тооцоолол хийв

Хүснэгт 6-2: Байгаль орчны үнэлгээ хийхийн тулд дундаж сүргийн бүтэц, тоон дээр үндэслэн тооцоолол гаргав. (Жилийн мэдээ)

^a Нийт ямаан сүргээс олох орлогын хэмжээ, ашиглалт ^b Малын амны ус: нэг малд өдөрт 0,250 литр ус, 9 сарын турш (өвлийг хасаад) (эх сурвалж: Ярилцлага). ^c өдөр бүр 300 гр өвсөөр ядруу мал тутмыг өвлийн 3 сард тэжээнэ гэж тооцов (нийт сүргийн 1/3) (эх сурвалж: Ярилцлага). ^d Улаан буудай хивэг: Өдөрт 150 гр хивгийг нэг ямаанд өвлийн сүүлийн 2 сар өгнө (эх сурвалж: Ярилцлага). ^e Экологийн ялгаатай бүс бүрээр газар зүйн мэдээллийн сан ашиглан бэлчээрийн доройтлын түвшин, га тутмаас авах биомассын тооцоо (эх сурвалж: Дэнсамбуу 2018). ^f Ярилцлага дээр үндэслэн зөвхөн цөлөрхөг болон өндөр уулсын бүсийн саалийн малын тоо, нэг ямаанаас жилд авах сүүний дундаж хэмжээг 60 л гэж тооцов (Нарангэрэл 2016). ХХААБ-аас 2021 онд гаргасан Үндэсний сүүний үйлдвэрлэлийн тайлангаар сүүний жилийн үйлдвэрлэл 115 007 тонн гэжээ.

6.2.2 Боловсруулагчдын суурь дата

МАН-н үйлдвэрлэлийн системийн нэгэн адил боловсруулалтын салбарын мэдээллийг үндэсний хэмжээнд тооцоолон гаргав. Тоон мэдээлэл дутмаг байсан учир боловсруулах үйлдвэрлэлийн олон янз байдлыг нарийн гаргах боломжгүй байв. Үйлдвэрлэлийн шат тус бүрийн суурь дата мэдээллийг Хавсралт 5-аас харна уу. Боловсруулсан ноолуурын кг тутамд зарцуулах эрчим хүч, усны олон улсын түвшний мэдээллийг StepEcoLab төслийн зохицуулагч нараас авав. Гэсэн хэдий ч бид үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулж буй нийт ноолуурын 70 хувийг боловсруулдаг 13 боловсруулах үйлдвэрээс тоон мэдээлэл цуглуулан ашиглав. Гэвч компани тус бүрийн дотоод мэдээлэл тул энд нэг бүрчлэн оруулаагүй. Усны ашиглалтыг тооцохдоо STeP EcoLab-аас гаргасан тайланд тусгагдсан бүх тоо мэдээг үйлдвэрлэлийн нийт боловсруулах үе шатуудад хувааж гаргав. (STeP EcoLab project, 2022). Харин ашигласан эрчим хүчний тооцоог гаргахдаа UNEP-ийн 2020 онд гаргасан Дэлхийн нэхмэлийн үйлдвэрлэлийн УАӨ-д оруулж буй нөлөөллийн үнэлгээний эрчим хүчний хэсгийг ашиглав. Усны алдагдлын тооцоог олдсон судалгаа мэдээллийн хүрээнд тооцоолон гаргав.

6.2.3 Тоо мэдээллийн чанар

Амьдралын мөчлөгийн тооцоолол хийхэд зарим алдаа, тодорхойгүй байдал гарсныг үгүйсгэхгүй. Учир нь:

- Ямааны ноолуур үйлдвэрлэлийн олон талт байдлыг бүрэн хамарч чадаагүй байх
- Боловсруулалтын үе шат бүрийн утгыг эргэлзээтэй итгэлцүүр ашиглан тооцоолсон байх боломжтой
- Хятадын компаниудын талаар мэдээлэл авахад хүндрэлтэй, ялангуяа хүлэмжийн хийн ялгарлын талаар мэдээлэл авч чадаагүй гэх мэт хүчин зүйлүүд нөлөөлсөн байх боломжтой.

Дээрх тодорхой бус байдлын үр дүнд үзүүлэх болзошгүй хүчин зүйлийг үнэлэх, мөн тодорхойгүй байдлын бүрэн дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байгааг харгалзан ILCD-н гар авлагын зөвлөмжийн дагуу багц дата өгөгдлийн чанарыг үнэлэв (Европын Комисс нар, 2011). Энэхүү үнэлгээ нь технологийн төлөөлөл (TeR), газарзүйн төлөөлөл (GeR), цаг хугацааны төлөөлөл (TrR), бүрэн гүйцэт байдал (C), нарийвчлал ба тодорхойгүй байдал (P), арга зүйн тохиромжтой байдал, уялдаа холбоо (M) гэсэн 6 мэдээллийн чанарын үзүүлэлтэд үндэслэсэн болно. Үзүүлэлт тус бүрийн хувьд 1-ээс 5-ын хоорондох оноог (1-ийг хамгийн сайн, 5-ыг хамгийн муу гэж тооцно) өгнө. Дараа нь өгөгдлийн чанарын ерөнхий төлөөллийг доорх тэгшитгэлийн дагуу тооцоолно.

$$DQR = (TeR + GeR + TrR + C + P + M + Xw*4) / (i + 4)$$

Xw: бүх үзүүлэлт дотроос хамгийн доод чанарын оноо (эсвэл хамгийн өндөр оноо)

i: Дата мэдээллийн чанарын үзүүлэлтийн тоо (0-тэй тэнцүү биш)

Манай судалгааны мэдээллийн багцын хувьд өгөгдлийн чанарын янз бүрийн үзүүлэлтүүдэд өгсөн утгууд нь: TeR = 3; GeR = 3; TrR = 1; C = 3; P = 4; M = 2. Үүний үр дүнд "үндсэн" чанарын

түвшинд (1.6-аас 5-ын хооронд) харгалзах DQR-ийн олон улсын зэрэглэлийн 4,0 гэсэн оноо гарна.


6.3 Байгалийн нөөцийн хомсдол, экосистемийн чанар, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

Монгол ноолуурын өртгийн дэлхийн байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг 44.74 гэсэн оноогоор дүгнэсэн. Хамгаалалтын гурван талбарт нөлөөллийг Хүснэгт 6-10-д үзүүлэв.

Хамгаалалтын бүсүүд	Нэгж	Үнэлгээ
Хүний эрүүл мэнд	DALY	1,85E-03
Экосистем	Зүйлийн төрөл.жил	7,98E-05
Байгалийн Нөөц	Доллар 2013	3,65


Хүснэгт 6-3: Монгол ноолуурын өртгийн сүлжээний нөлөөлөл Хамгаалалтын гурван талбараар: Хүний эрүүл мэнд, Экосистемийн чанар, Байгалийн нөөц (Үйлдвэрээс гарсан бэлэн хувцасны ноолуурын кг тутамд)

Дээрх дэлхийн түвшний үр дүнгээс гадна эдгээр нөлөөллийн үе шат бүрийн нөлөөллийг судлах нь сонирхолтой юм. Нэг оноогоор илэрхийлсэн бүх нөлөөллийн тухайд мал аж ахуйн үйлдвэрлэл нь байгаль орчны нөлөөллийн ихэнхийг хувийг эзэлдэг (70%), дараа нь ноолуур Будах үйл явц (14%) орно. (Зураг 6-3). Бусад үе шатууд нь 10% -иас бага хувийг эзэлдэг.



Зураг 6-3: Монгол ноолуурын өртгийн сүлжээний нөлөөлөл янз бүрийн үе шат бүрээр

Мал аж ахуй болон будах үе шатууд нь нэг хамгаалалтын гурван талбарт бүгдэд нь ижил өндөр нөлөөлдөггүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй (Зураг 6-4). Будах үйл явц нь хүний эрүүл мэнд, байгалийн нөөцийн хомсдолд (26% ба 36%) томоохон хувь нэмэр оруулж байгаа бол мал аж ахуйн үйлдвэрлэл нь хүний эрүүл мэнд 44% болон байгалийн нөөцийн байдалд 13%-ийн нөлөө үзүүлж байгаа хэдий ч экосистемийн чанарт хамгийн өндөр буюу 99%-ийн нөлөөлөл үзүүлж байна. Бусад үе шатууд нь байгалийн нөөцийн хомсдолд (жишээ нь сүлжмэл 19%, ээрэх 17%), хүний эрүүл мэндэд (жишээ нь сүлжмэл 12%) бага хэмжээний нөлөө үзүүлдэг.



Зураг 6-4: Монгол ноолуурын өртгийн сүлжээний хамгаалалтын гурван талбар үзүүлэх нөлөөлөл: Хүний эрүүл мнд, Экосистемийн чанар, Байгалийн нөөц

Эдгээр үр дүнгүүд нь Хамгаалалтын 3 талбарт үзүүлэх янз бүрийн нөлөөлөл болон өртгийн сүлжээний өөр өөр үе шатуудын үзүүлэх нөлөөллийн хэмжээг илүү нарийвчлан судлахад дахин батлагдсан болно (Хүснэгт 6-4). Мал аж ахуй нь газар ашиглалт 100% нөлөө үзүүлж байгаа бөгөөд яг мал аж ахуйд ашиглагдаж буй бодит газрын хэмжээ болон түүнээс шалтгаалсан болзошгүй нөлөөлөл хоорондын хамаарал тодорхойгүй байна. Гол холбоо хамаарал нь мал аж ахуйн зориулалтын аливаа үйл ажиллагаанд ашиглаж буй газар нь өртгийн сүлжээний бусад үе шатны хөгжлийг дэмжиж, цаашдын тогтвортой байдлыг хангах гол эх үүсвэр болдогт оршино. Монгол улсын нутаг дэвсгэрийн 80 орчим хувь нь бэлчээрийн зориулалттай. Энэ нь цөөн хүн амтай холбоотойгоос гадна алсдагдсан байдал, газар зүйн онцлог гэх мэт хүчин зүйлээс шалтгаалан бусад үйл ажиллагаанд ашиглагдаагүй байгаатай холбоотой юм. Хэдийгээр өргөн уудам бэлчээр нутагтай ч мал аж ахуйн байгаль орчинд үзүүлж буй гол сөрөг нөлөө нь бэлчээрийн доройтол юм. Мал аж ахуй нь дэлхийн дулааралтай холбоотой бүх хүчин зүйлүүдэд сөрөг нөлөө үзүүлдэг. Ноолуур үйлдвэрлэлийн тогтолцоо нь дэлхий даяар мал аж ахуйн өртгийн сүлжээний нэг том бүрэлдэхүүн хэсэг учир уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх хамаарлыг энд нэгтгэн тооцсон. (илүү дэлгэрэнгүйг дараагийн хэсгээс үзнэ үү) (Gerber et al., 2013).

Ноолуур будах явц нь хүний эрүүл мэнд, экосистем, байгалийн нөөцөд ихээхэн нөлөө үзүүлдэг. Ноолуур будах үе шат нь хүний биед хорт хавдар үүсгэдэггүй хорт бодис ялгаруулах (70%), цэнгэг ус эко бохирдуулагч ялгаруулах (66%), Далайн экологийг бохирдуулах (67%) гэх мэт сөрөг нөлөө ихтэй. Энэ нь ноолуурын будагч бодис нь бохирдуулагч химийн хаягдал их ялгаруулдагтай холбоотой гэж бид үзэж байна. Мөн зарим ярилцлагад оролцогчид будах үе шат нь ашиглаж байгаа будгийг усны нөөцийн хомсдолын улмаас шууд байгальд хаяж байгаа нь байгаль орчинд болоод хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж талаар байгаа анхааруулж байв. Нэмж дурдахад, ноолуур будах үйл явцын эрчим хүчний хэрэглээ өндөртэй ба ялангуяа нүүрсний хэрэглээнээс үүдэлтэй бохирдолд өндөр нөлөө үзүүлж байна. Дэлхийн дулааралтай холбоотой янз бүрийн нөлөөллийн хувьд МАА-н дараа хоёрдугаарт ордог. Үүнийг ихэнх боловсруулах үйлдвэр төвийн эрчим хүч хэрэглэж байгаа ч төв эрчим хүчний үйлдвэрлэлийн (93 хувь) нь нүүрс хэрэглэж байгаа учраас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө өндөртэй гардагтай холбон тайлбарлаж болох юм.

Нөлөөлөл				Эзлэх хувь							
Хамгаалалтын талбар	Ангилал	Нэгж	Үнэ цэнэ (AOP-ийн %)	Эсгэх оёх	сүлжих	ээрэх	будгах	Ялгах	угаах	мал	
Хүний эрүүл мэнд	Дэлхийн дулаарал, Хүний эрүүл мэнд	DALY	9,87E-53	53	2	4	4	8	0	0	80
	Стратосферийн озоны цоорхой	DALY	9,04E-07	0	0	1	1	1	0	0	97
	Ионжуулагч цацраг	DALY	1,38E-08	0	11	20	18	39	2	1	9
	Озон, Хүний эрүүл мэнд	DALY	4,48E-07	0	12	21	19	40	2	2	5
	Нарийн тоосонцор үүсэх	DALY	6,60E-04	36	12	23	19	42	2	1	1
	Хүний хорт хавдар үүсгэгч бодис	DALY	5,30E-05	3	12	22	18	41	2	1	5
	Хүний хорт хавдар үүсгэдэггүй бодис	DALY	1,38E-04	7	6	11	9	70	1	1	2
	Усны хэрэглээ, Хүний эрүүл мэнд	DALY	8,97E-06	0	11	28	13	45	1	0	2
Экосистемийн чанар	Дэлхийн дулаарал, хуурай газрын экосистем.	зүйлийн төрөл.жил	2,98E-06	4	2	4	4	8	0	0	80
	Дэлхийн дулаарал, Цэнгэг усны экосистем.	зүйлийн төрөл.жил	8,12E-11	0	2	4	4	8	0	0	80
	Озоны үүсэх, хуурай газрын экосистем.	зүйлийн төрөл.жил	6,42E-08	0	12	21	19	40	2	2	6
	Газрын хүчиллэгжилт	зүйлийн төрөл.жил	2,26E-07	0	12	22	18	40	2	1	5
	Цэнгэг усны эвтрофикаци	зүйлийн төрөл.жил	2,10E-07	0	11	19	16	49	1	1	2
	Далайн эвтрофикаци	зүйлийн төрөл.жил	6,73E-11	0	5	10	10	45	1	1	29
	Хуурай газрын эко	зүйлийн	2,51E-0	0	9	16	14	32	1	1	26

	бохирдуулагч	төрөл.жил	09								
	Цэнгэг усны эко бохирдуулагч	зүйлийн төрөл.жил	1,15E-08	0	6	11	9	66	1	1	7
	Далайн эко бохирдуулагч	зүйлийн төрөл.жил	2,41E-09	0	6	10	9	67	1	1	7
	Газар ашиглалт	зүйлийн төрөл.жил	7,62E-05	96	0	0	0	0	0	0	100
	Усны хэрэглээ, хуурай газрын экосистем.	зүйлийн төрөл.жил	5,59E-08	0	11	27	13	44	1	0	4
	Усны хэрэглээ, Усны экосистем	зүйлийн төрөл.жил	7,43E-12	0	5	12	7	20	1	0	55
Байгалийн нөөц	Эрдэс баялгийн нөөцийн хомсдол	USD2013	3,40E-02	1	7	12	11	27	1	2	41
	Ашигт малтмалын нөөцийн хомсдол	USD2013	3,62	99	10	19	17	37	2	2	12

Хүснэгт 6-4: Монгол ноолуурын өртгийн сүлжээний хамгаалалтын гурван талбар үзүүлэх нөлөөлөл: хүний эрүүл мэнд, Экосистемийн чанар, Байгалийн нөөц


(Тод ногоон: 0-20%, цайвар ногоон: 21-40%, Шар: 41-60%, Улбар шар: 61-80%, Улаан: 80-100%)

6.4 Уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөө

Монгол ноолуурын өртгийн сүлжээ нь хүлэмжийн хийн ялгаралд тодорхой хувь нэмэр оруулдаг. Нэг кг ноолууран хувцас үйлдвэрлэхэд нийт 904.9кг CO₂—той тэнцэх хүлэмжийн хий ялгардаг. Энэ нь бусад нэхмэл хувцас үйлдвэрлэхэд ялгардаг хийнээс бага зэрэг өндөр байгаа юм. Бусад судалгааны эх сурвалж тоо мэдээтэй харьцуулахад төвөгтэй байсан бөгөөд ноолуурын өртгийн сүлжээний амьдралын мөчлөгийн судалгаа (АМС) бага байгаа нь үүнд бас нөлөөлж байна. Малын гаралтай бусад түүхий эд бүтээгдэхүүний хүлэмжийн хийн ялгарлыг судалж байхдаа би нэг литр сүү 7,8 кг CO₂-той тэнцэх, нэг кг мах 25.7кг CO₂-той тэнцэх хүлэмжийн хийг тус тус ялгаруулдаг гэдэг тооцооллыг хийсэн. Энэ тооцоолол нь Gerber нарын 2013 онд хийсэн хүлэмжийн хийн дэлхийн тооллогын үеэр гаргасан ямааны нэг литр сүү 6.13 кг CO₂-той тэнцэх, нэг кг мах 24.23 CO₂-той тэнцэх хүлэмжийн хий ялгаруулж байна гэсэн дүнтэй дүйцэж байна.

Мэдээж ноолуурын өртгийн сүлжээний үе шат бүрд ялгаруулах хүлэмжийн хийн хэмжээ өөр өөр. Үүнийг Зураг 6-5А-д харуулав. МАА бол өртгийн сүлжээн дотроо хамгийн өндөр хүлэмжийн хий ялгаруулагч салбар нь юм. (нийт хүлэмжийн хийн 77%).

Зураг 6-5: Монгол ноолуурын өртгийн сүлжээний үе шат бүрийн ялгаруулж буй хүлэмжийн хийн хувь (А) МАА-с ялгарч буй төрөл бүрийн хий (В)



МАА-аас ялгарч буй хүлэмжийн хийн дийлэнхийг буюу 96%-ийг метан хий эзэлдэг. Малын гүзээ, өтөг бууцнаас метан хий ялгарах ба үүнийг Зураг 6-5В-д харуулав. Гэхдээ үүнийг бүрэн судалгаа, баримтгүйгээр дан МАА-н үр нөлөө гэж үзэж болохгүй юм. Уг бэлчээр нутагт мал байхгүй, бэлчихгүй байсан ч бусад зэрлэг амьтад тухайлбал цагаан зээр гэх мэт амьтад нутаглаж, бэлчих л байсан. (Ривера Ферра 2016 болон Христов 2013 нарын тайланг харна уу)

Ноолуур будах процесс нь нүүрс шатааснаас үүдэлтэй CO₂ ялгаралд тодорхой хувь нэмэр оруулдаг. Гэвч энэ нь шууд түүхий нүүрс түлдэг гэсэн үг биш бөгөөд нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцын үйлдвэрлэж буй эрчим хүчийг үйлдвэрлэлдээ ашигладаг тул үүнд тодорхой хувийг эзэлдэг гэж үздэг. Цахилгаан эрчим хүч хэрэглэснээс энэ өртгийн сүлжээнээс

ялгарах хүлэмжийн хий нь 22 хувьтай байна.

6.5 Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөө

Социалист нийгмээс ардчилсан нийгэмд шилжин мал хувьчлагдсанаас хойш малчид мал сүргийн тоогоо өсгөхийг зорьж ирсэн. Бэлчээр нутгаа сэлгэн ашиглаж, амраан нүүдэллэдэг уламжлал үндсэндээ алга болж, олон малтай, цөөн малтай малчдын дунд ялгаа ихсэж, өмнө нь төрөөс үнэгүй үзүүлдэг байсан мал эмнэлгийн үйлчилгээ хувьд шилжив. (Фернандез-Гименез, 2000). Олон малчин өрх хот суурин бараадан шилжиж, төвлөрсөн газрын ойролцоох хүн амын төвлөрөл нэмэгдэв. (Гунин, 1999). Дээрх олон хүчин зүйлсийн нөлөөгөөр бэлчээрийн даац хэтэрч, доройтол явагдаж эхэлсэн.

Нийгэм эдийн засгийн нөлөөллөөс⁴⁸ гадна тухайн бэлчээр нутгийн биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлснийг олон судалгааны өгүүллэг, тайлангаас харж болно. Бэлчээрийн талхагдлаас болж ургамлын бүрхэвч буурч, төрөл зүйл нь цөөрсөн. (Дашбал, Торсон 2010, Дэнсамбуу 2018, Мөнхзул 2021, Сайннэмэх 2022 нарын судалгааны тайлан). Тухайлбал судлаач Сайннэмэх 2022 онд Монголын зүүн бүсэд хийсэн Болиогийн олон янз байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар хийсэн судалгаандаа тухайн бэлчээр дэх биологийн төрөл зүйлийн баялаг байдал муудаж цөөрснийг онцолсон бол Шанон Виенэр тайландаа мөн олон янз байдлын индекс буурсан тухай дурджээ. Бид малын тоо нэмэгдэж, бэлчээр нутгийн даац хэтэрсэн нь Монголын зүүн бүсийн тал хээрийн ургамлын биологийн төрөл зүйлийн доройтолд нөлөөлж байна гэж үзэж байна. Энэ дүгнэлт нь 2018 онд Мардэсик нарын малчдаас авсан судалгаагаар бэлчээрийн ашиг шимт нарийн өвс ургамал устаж оронд нь шим тэжээлгүй бүдүүн өвс ургамал ургадаг болсон тухай тайлантай нийцэж байна. Үүнээс гадна бэлчээрийн даац хэтэрснээс хүн, малд хэрэгтэй эмийн ургамал устаж үгүй болж байгаа тухай онцолж байв. Энэ асуудал нь хоёр талтай. Хэдийгээр бэлчээрийн МАА нь олон мянган малчин өрхийн орлогын эх үүсвэр болдог ч нөгөө талдаа хөдөөгийн хүн амын эмзэг өртөмхий байдлыг нэмэгдүүлж байна. Энэ асуудал нь олон улсын хөгжлийн байгууллагууд төдийгүй үндэсний болон орон нутгийн түвшний шийдвэр гарагч нарын үеийн үед санаа зовоосон, анхаарал татсан сэдэв байсаар байна.

Ойн бүсийн бэлчээрт хэрхэн нөлөөлж буй талаар нарийн мэдээлэл, судалгаа бага байна. Сүхбаатар нарын 2021 оны судалгаанд мал аж ахуй нь ойд экологит сөрөг нөлөөтэй тухай дурдсан ч тэдний судалгааны талбар нь улсын тусгай хамгаалалттай бүс нутаг өөрөөр хэлбэл мал бэлчээхийг хориглосон зөвхөн зэрлэг амьтад буга, хандгай бэлчдэг нутаг байв. Цогтбаатар (2013) ойн мод цөөрөхөд нөлөөлж буй “хяналтгүй бэлчээр”-ийн бүс газрын жагсаалт гаргасан боловч энэ нь мод бэлтгэл, уур амьсгалын өөрчлөлт зэрэг бусад хүчин зүйлүүдийн дэргэд тийм ч чухал ач холбогдолтой бишийн дээр шууд нотолгоо болж чадахгүй байна. Мөн тэрээр ойд мал бэлчээх нь ургаж гүйцсэн том модонд бус ойн нөхөн сэргээлтийн гол суурь болсон зулзаган модонд аюул учруулж

⁴⁸ Бэлчээрийн доройтолд нөлөөлж буй эдгээр хүчин зүйлсийн нөлөө нь 1990-ээд оны сүүлчээр ажиглагдаж эхэлсэн. (Гунин нар, 1999; UNEP, 2002). 1999-2003 онуудад гурван жил дараалан тохиолдсон зудын улмаас улсын нийт мал сүргийн 30% хорогдож, олон тооны малчид хот руу шилжсэн. Энэхүү гамшиг нь Монголын малчдын байгалийн гамшигт бэлэн бус, өртөмхий, эмзэг байгааг харуулсныг онцлон тэмдэглэжээ. Хишигбаяр нар, 2015.

байна гэсэн дүгнэлт гаргасан байна. Ой мод ихтэй Хөвсгөл аймагт хийсэн бидний судалгааны үед малчид, орон нутгийн удирдлагуудтай ярилцаж байхад тэд ойд мал бэлчээх нь сөрөг нөлөөтэй тухай ярьж байв. Харин судалгаанд хамрагдсан бусад аймгуудад энэ талын асуудал бага байв. Гэхдээ бид ойн мэргэжилтэй, эсвэл байгаль хамгаалагчидтай ярилцаагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.


Цаашилбал, бэлчээрийн доройтол нь амьтны биологийн төрөл зүйлд хэрхэн нөлөөлж болох талаар сайтар судлах хэрэгтэй. Мал аж ахуйн бүсэд бэлчээрийг дан ганц мал биш бусад зэрлэг ан амьтад, ялангуяа бусад хивэгч амьтад ч идэж ашигладаг гэдгийг мартаж болохгүй.

Бергер нар 2013 онд ноолуурын ямааны тоо нэмэгдсэнээс үүдэлтэй экосистемийн доройтол нь тухайн нутаг бэлчээрийн уугуул амьтдын төрөл зүйл цөөрч, амьдрах чадвар буурч, улмаар том зэрлэг хөхтөн амьтдын тоо толгой цөөрч байгаа талаар тайландаа тусгажээ. Хэдийгээр энэ хамаарал нь маргаантай сэдэв ч (Вон Вердем нар, 2015), манай судалгаанд оролцогчид ч энэ талаар тоймтой зүйл илэрхийлээгүй ч энэ талаар цаашид илүү гүнзгий судлах боломжтой.

Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийг хамарсан ямааны нягтралыг өөр өөр масштабээр давхцуулах боломжтой газарзүйн лавлагаа олдсонгүй. Гэсэн хэдий ч төрөл бүрийн тусгай хамгаалалттай газар нутаг (дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар)-ын байршил (Зураг 6-6) болон аймгийн түвшний ямааны нягтрал (Зураг 6-7) хоёрын хооронд газарзүйн харьцуулсан шинжилгээ хийснээр дараах хоёр энгийн уялдаа холбоог харуулж байна. Үүнд:

- Дархан цаазат газар ихтэй уулархаг бүс, цөл, цөл хээр газар ямааны тоо толгойн нягтаршил бага байна
- Дархан цаазат газар багатай, тал хээр, ойт хээрийн бүсэд ямааны тоо толгой их байна.

Дээр хоёр тохиолдлыг бид дүгнэхдээ цөл, цөлөрхөг хээр, уулархаг газарт малын хоол бага, мөн тусгай хамгаалалттай газарт малаа бэлчээх боломжгүй тул эдгээр газруудад ямааны тоо цөөн байгаа ч мал идэх өвс ургамал сайтай газар ямаан толгой их, бэлчээрийн өрсөлдөөн их байж болох юм гэж үзэж байна. Тухайлбал, Хустайн нурууны байгалийн цогцолбор газар 1993 онд байгуулагдсантай холбоотойгоор бэлчээрийн ашиглалт өөрчлөгдсөн, бэлчээрийн хүртээмж муудсан талаар ойр орчмын зарим малчид гэрчилдэг. Мөн газар томоохон компаниудын газар тариалангийн зориулалтын газар нэмэгдэх хирээр малын бэлчээр хумигддаг тухай малчид ярьж байна. Тиймээс малчид болон тусгай хамгаалалттай газар нутгийн хоорондын харилцааны талаар илүү өргөн хүрээтэй судалгаа хийх нь зүйтэй бөгөөд эдгээр тусгай хамгаалалттай газрын төлөвлөлтөд малчид хир хэмжээнд оролцдог талаар судлах хэрэгтэй.



Зураг 6-6: Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг

Эх сурвалж: <https://www.ccneglobal.com/2020/02/28/building-capacity-for-the-second-generation-of-protected-area-management-plans-in-Баруун-бүс-mongolian/>



Зураг 6-7: Ямаан тоо толгойн нягтаршил (1 га-д ноогдох тоо толгой) аймаг тус бүрээр

Эх сурвалж: ҮСХ 2022

6.6 Асуулт 4-ийн хүрээний хариултууд

Асуулт 4-ийн хүрээний хариултыг боловсруулахын тулд бусад эх үүсвэрээс авсан мэдээллүүдийг харьцуулан шинжлэх шаардлагатай. Гэсэн хэдий ч ноолуурын салбарын байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг судалсан томоохон судалгаа байхгүй нь энэ харьцуулалт хийхэд бэрхшээл учруулж байв. Нөгөө нэг арга нь нэхмэлийн бусад салбарын өртгийн сүлжээтэй харьцуулах явдал боловч ажлын

хүрээ, зорилго, ашигласан арга зүй, түүхий эдийн гарвал өөр байх зэрэг нь мөн дүгнэлт хийхэд хүндрэлтэй байв. Тиймээс энэ хэсгийн дүн шинжилгээг хийхдээ өртгийн сүлжээний үе шат бүрийн байгаль орчны нөлөөллийн тухай мэдээ, судалгааг нэгтгэн шинжлэх нь хамгийн зөв хувилбар байв. Тиймээс бид ноолуурын өртгийн сүлжээнээс байгаль орчинд хамгийн их нөлөө үзүүлдэг хоёр үе шатыг тухайлбал МАА, болон ноолуур угаах үе шатыг түлхүү авч үзлээ. Ноолуурын ямааны байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөө нь метан хийн ялгарал ба бэлчээрийн доройтол гэдгийг илүү ухамсарлан ойлгох нь чухлаар тавигдаж байна. Ноолуур будах үйл явцын тухайд усны хаягдал, эрчим хүчний хэрэглээ, ялангуяа нүүрсний хэрэглээнээс үүдэлтэй бохирдолд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байна.

6.6.1 Бэлчээрийн доройтолтой тэмцэх нь

Вайт (White)-ийн судалснаар (2000) Монголын бэлчээрийн талбай нь дэлхийн нийт бэлчээрийн 2.5 орчим хувийг эзэлдэг. НҮБ-ын ХХААБ-ын статистик мэдээгээр (2021 он) бэлчээрийн талбай нь Монголын нийт газар нутгийн 71.5%, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 98.9 хувийг эзэлдэг. Хэдийгээр газрын доройтлын асуудал нь тодорхой байгаа ч бэлчээрийн доройтолд антропоген буюу "байгалийн" хүчин зүйл давамгайлж байгаа эсэх талаар судалсан шинжлэх ухааны нийтлэг ойлголт байдаггүй. Бао нарын (2014) судлаачид эдгээр өөрчлөлтүүд нь температурын өсөлт, ган гачиг, элсэн шуурганы идэвхжил, хур тунадас багасах, өвлийн эрс тэс уур амьсгал гэх мэт байгалийн хүчин зүйлстэй холбоотой гэж үздэг. Лю нарын (2013) судлаачид мөн ургамлын индексийн бууралтын 60% нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гэж тооцоолжээ. Харин эсрэгээр Хилкер (2014) ургамлын ногоон масс болон нягтаршлын индексийн (NDVI) шинжилгээгээр⁴⁹ газрын доройтлын 80% нь бэлчээрийн даац хэтэрсэнтэй холбоотой гэж үзжээ.

Антропоген хүчин зүйлсээс хамгийн их дурдагдсан нь ямааны тоо толгой өссөн явдал юм. Зарим бүс нутагт хүн амын суурьшил ихсэх хандлагатай байна. Хүн амын төвлөрөн суурьших нэг шалтгаан нь эдийн засгийн асуудал юм. Социализмын үед нүүх, шилжих асуудлыг нэгдэл төлөвлөн, нэгдсэн байдлаар зохион байгуулдаг байв. Харин өнөө цагт малчид өөрсдөө шийдэн, дан дангаараа нүүдэллэдэг болсон. Орлого багатай ядуу өрхөд нүүх, шилжих тээврийн хэрэгсэл, зардал мөнгө байдаггүй. Мөн зарим нутагт (үүнийг Төв аймагт дурдсан бөгөөд Мардесик, 2018 онд мөн тайландаа тусгаж байв) малчид болон газар тариалан эрхлэгчдийн дунд (албан болон албан бус газар тариалангийн газрын зөвшөөрөлтэй) газар ашиглалтын маргаан, өрсөлдөөн үүсэж болзошгүй байна.

Бэлчээрийн газрыг газар тариалангийн зориулалтаар ангилал өөрчилж буй нь тариалангийн талбайд шөнийн цагаар мал орох, хортон шавж устгалын бодис их хэрэглэх, хөрсний доройтол бий болгох гэх мэт бусад асуудлыг үүсгэж болзошгүй юм. Ямар ч шалтгаантай байлаа гэсэн бэлчээрийн доройтол хурдацтай явагдаж буйг үгүйсгэх аргагүй. Дэнсамбуугийн (2018) судалснаар нийт бэлчээрийн 10.3% нь эргэж

⁴⁹ Ургамлын хялбаршуулсан ялгааны индекс (NDVI) нь хиймэл дагуулын мэдээллийг ашиглан ургамлын ногоон масс, нягтралыг тодорхойлоход өргөн хэрэглэгддэг хэмжүүр юм. Үүнийг улаан ба ойрын хэт улаан туяаны гэсэн хоёр тусгай зурвасын спектрометрийн өгөгдлөөр тооцдог. Спектрометрийн өгөгдлийг ихэвчлэн хиймэл дагуул гэх мэт алсын мэдрэгчээс авдаг.

сэргэхгүйгээр доройтсон байна. Энэ 2016 оноос хойш 2 жилийн хугацаанд даруй 3 нэгжээр өссөн байна.

Бэлчээрийн доройтлын эхэн шатанд ургамлын төрөл зүйлд өөрчлөлт ордог. Өөрөө хэлбэл малд идэмжтэй ургамлын оронд идэмжгүй хог ургамал ихэсдэг байна. Доройтлын дунд шатанд ургамлын навчин бүрхүүл буурдаг. Энэ нь эрчимтэй үргэлжилбэл улмаар цөлжилт болж хөрсний физик бүтцийг өөрчилж, шим тэжээл авах, ус шингээх үндсэн горим алдагддаг. Бэлчээрийн доройтлын энэ үе шатууд тус бүр эргэн сэргэх үе шатуудтай. Анхан шатны доройтлын үед бэлчээрийг хэдхэн жил амраахад дорхноо нөхөн сэргэх боломжтой байдаг. Харин доройтлын дунд шат буюу ургамлын навчин бүрхүүл буурсан үед эргэж сэргэх, нөхөн төлжихдөө нэлээд урт хугацаа шаарддаг байна. Харин хөрсний механик бүтэц өөрчлөгдөж, үржил шимээ алдсан үед эргэж сэргэх боломжгүй гэж үздэг. Бэлчээрийн энэ доройтлын үе шатыг мэдсэнээр зохих зохицуулалтыг хийж чадвал бид доройтлыг бууруулах боломжтой болох юм. (Хишигбаяр, 2015). Үүнээс үзвэл доройтсон бэлчээрийн дийлэнх нь зохистой менежмент хийж чадвал хэдхэн жилийн хугацаанд эргэн сэргэх боломжтой аж.

Бүлэг 5.2-т өгүүлсэнчлэн 2002 оны Газрын тухай хуульд бэлчээрийн болон тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх зүйл заалтыг шинэчлэн нэмэлт өөрчлөлт оруулсан нь үүний ач холбогдлыг нэмэгдүүлж өгсөн юм. Энэ нэмэлт өөрчлөлтийг их хурлаар хэлэлцэх шатанд яваа бөгөөд хэрэв батлагдсан тохиолдолд өртгийг сүлжээний хүрээнд үйл ажиллагаа явуулж буй олон байгууллагуудад үр нөлөө үзүүлэх юм.

Малын тоо, толгойн татварын хууль 2021 оноос хэрэгжиж байна. Энэ хуулиар малчид малын тоо, толгой тутамд 2000 төгрөгөөр тооцон жилийн татвар төлөх ба үүнийг жилд 2 удаа (7, 12 саруудад) төлөхөөр зохицуулсан байна.

Улмаар ямаан тоо толгойг аажмаар бууруулах бодлого энэ татварын тогтолцооны ард бий. Ямаа бэлчээрийн ургамлыг үндсээр нь сугалж иддэг, эргэж ургах боломжгүй болгодог гэсэн яг нотолгоо баримттай судалгаа одоогоор байхгүй байна. (Хишигбаяр 2015). Малын тоо толгойн татварыг ногдуулахдаа өмнөх жилийн мал тооллогын дүн дээр үндэслэдэг. Сумын тамгын газраас малчин өрх бүрийн малын А данс буюу мал тооллогын бүртгэлийн татварын байцаагчид өгч ногдуулах татварын хэмжээг тогтоодог. Гэвч бидэнд өгсөн мэдээллээр зарим нэг төрийн үйлчилгээний доголдоос шалтгаалан татварын энэ шинэчлэлийн хэрэгжилтэд бэрхшээл учирч байна. Тухайлбал, мал тооллогын ажлын хүндрэл, хуулийн талаарх мэдлэг дутмаг, татвар төлөлтийн бүртгэл санхүүгийн хайхрамжгүй байдал гэх мэт. Татварын энэ хуулийн хэрэгжилтийг орон нутагт хэрэгжүүлэх чадавхыг сайжруулах хэрэгтэй.

Мөн нэг малчин хэлснээр ажилтай, арчаатай айлын мал өсдөг гэж хэлсэн. Хэн их хөдөлмөрлөж, хэн сайн ажилласан нь мал ихтэй байдаг гэж хэлснийг бас анхаарууштай.

Сайн малчны нэг шалгуур нь малын тооны үзүүлэлт болсон төдийгүй ихэнх малчид үнийн өсөлт, байгалийн гамшиг, нүүдлийн мал аж ахуйн эмзэг байдлыг бууруулах үүднээс малын тоогоо өсгөх нь их байдаг.

Олон улсын болон дотоодын байгууллагууд бэлчээрийн нөөцийн менежментийг сайжруулах үүднээс бэлчээр ашиглалтын хэсгүүдийг байгуулан дэмжин ажиллаж байна. Энэ санаачилгыг Ногоон алт төслөөс эхлүүлэн 5 суманд туршиж байсан бол

улам өргөжин өнөөгийн байдлаар Монгол улсын нийт сумдын 50 хувийг хамарч байна. Эдгээр БАХ-ийг нэгтгэсэн үндэсний хэмжээний Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоог 2015 онд байгуулан ажиллаж байна. 2018 онд БАХ ажиллаж байгаа сумд, БАХ байхгүй сумдын бэлчээр ашиглалтын мониторингийн судалгаа хийсэн. (Мардэсик, 2018). Харамсалтай нь БАХ байгуулан ажилласан ч бэлчээрийн менежмент сайжирсан гэсэн байдал ажиглагдаагүй. Амжилтгүй болсон шалтгааныг сайтар судалж гаргах нь зүйтэй.

6.6.2 Янз бүрийн түвшинд хүлэмжийн хийн ялгарлыг сааруулах нь

Бүх салбарт ХХЯ-ыг бууруулах нь чухал асуудал болж байна. АХБ-ны 2014 оны тайлангаар Монгол улсын агаарын хэм 1940 оноос хойш 2.1°C-аар нэмэгдсэн нь дэлхийн дунджаас (1.3°C) өндөр байна. Энэ нь уур амьсгал өөрчлөгдөж, цаг агаарын эрс тэс үзэгдлүүдийн давтамж нэмэгдэхэд нөлөөлж байна. Өмнө дурдсанчлан, уур амьсгалын өөрчлөлт нь бэлчээрийн доройтлын гол хүчин зүйлүүдийн нэг юм. Бэлчээрт үзүүлж буй сөрөг нөлөөллөөс гадна малчид уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой байгалийн янз бүрийн үзэгдэл болж буйг нотолдог. Ялангуяа зун богино болж, өвөл уртсаж, малын өвч тэжээлийн нөөц багасаж байна гэж ярьдаг. Түүгээр ч барахгүй ойрын жилүүдэд ойр ойрхон зуд болж, цаашид ч улам эрчимжих хандлагатай байна.

Боловсруулах үйлдвэрлэлийн шатанд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах нь

Ноолуурын өртгийн сүлжээний боловсруулах үйлдвэрүүд хэдийгээр шууд түүхий нүүрс шатаадаггүй ч ихэнх боловсруулах үйлдвэр төвийн эрчим хүч хэрэглэж байгаа ч төв эрчим хүчний үйлдвэрлэлийн (93 хувь) нь нүүрс хэрэглэж байгаа учраас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө өндөртэй гарч байна. Дэлхий дахинаа эрчим хүч үйлдвэрлэлд түүхий нүүрс хэрэглэхээс татгалзаж, нүүрсний уурхайн тэлэлтийг хумих замаар ХХЯ-ыг бууруулах, сааруулахаар зорин ажиллаж байна. (Браун, Шпигель, 2019). Монгол Улс нүүрснээс бүрэн хамааралтай бөгөөд түүнийг халах хугацаа хол байна. Азийн чөлөөт радио (RFA)⁵⁰-оос мэдээлснээр Монгол Улс 2021 онд 32.3 сая тонн нүүрс үйлдвэрлэж, олборлолтоо 22 хувиар нэмэгдүүлсэн байна. Украин-Оросын дайны улмаас байгалийн хийн үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан үүнийг засгийн газрын албан тушаалтнууд экспортыг нэмэгдүүлэх “боломжийн цонх” гэж үзэж байна.

Нүүрс бол эрчим хүчний хамгийн их бохирдол ялгаруулагч эх үүсвэр юм. Нүүрс шатаах нь хүлэмжийн хийн бохирдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бидний амьсгал буй агаарт хортой олон хоргүй хавдар үүсгэгч бодис ялгаруулж, ус, хөрсний бохирдлыг бий болгож, уурхайчид, ажилчид болон ойр орчмын иргэдийн эрүүл мэндэд ноцтой нөлөө үзүүлдэг. Улаанбаатар хотын иргэд үүний сөрөг нөлөөнд үргэлж өртөж байгаа. Хахир хатуу өвлийн улиралд агаарын температур –20 хэмээс дээш гарч хүйтрэх өдрүүдэд агаарын бохирдлын хэмжээ ДЭМБ-аас тогтоосон аюулгүй түшингээс 80 дахин их болдог (Бадарч нар, 2021). Бохирдлын хамгийн гол эх үүсвэр нь гэр хорооллын нүүрс түлдэг зуухнаас үүдэлтэй ч үйлдвэрүүдийн эрчим хүчний хэрэглээ ч үүнд тодорхой хувь нэмэр оруулдаг.

Малын тэжээлийн чанарыг нэмэгдүүлэх техникийн шинэчлэлийг судалж, сурталчлах

⁵⁰ <https://www.benarnews.org/english/news/indonesian/mongolia-coal-open-pit-mine-climate-change-fossil-fuel-08132023093718.html>

Ихэнх нутагт бэлчээрийн даацаас шалтгаалсан тэжээлийн хомсдол бий болсон. Тэжээлийн хомсдол гэдэг нь тоон биш чанарын хувьд доройтсоныг олон судалгаа гэрчилж байна. Тухайлбал, Мардесик (2018) нь судалгааны 2 бүсэд NDVI буюу ургамлын ногоон масс нэмэгдсэн боловч малчид малын идэмжтэй ургамал цөөрсөн гэж ярьж байна. Иймээс бодит байдал дээр бэлчээр нь биомасс нэмэгдсэн мэт харагдавч ургамлын бүтэц, төрөл зүйлийн хувьд доройтсон байдаг (МБАНХ-ны тайланг үзнэ үү). Энэ дүгнэлт нь Баянхонгор аймагт цуглуулсан 1993-2013 оны мэдээллийг харьцуулан үзэхэд биологийн төрөл зүйл буурч, бүтэц нь өөрчлөгдсөн хэдий ч уулархаг хээрийн бүсэд биомасс нэмэгдсэн гэсэн дүгнэлттэй нийцэж байна.

Тэжээлийн чанар муудах нь ноолуурын хэмжээ болон чанарт аль алинд нь сөргөөр нөлөөлдөг. Зарим судалгаагаар малд нэмэлт тэжээл өгөх нь ноолуурын хэмжээ болон чанарт сайнаар нөлөөлдөг тухай дурджээ. (Жонсон, 1994; МакГрегор, 1998; Момем нар, 2021; Ван нар, 2023). Ярилцлагаас харахад малчдын дийлэнх нь малдаа нэмэлт тэжээл өгдөг, ялангуяа өвлийн хатуу ширүүн улиралд малаа тэжээхээс өөр аргагүй байдаг байна. Нэмэлт тэжээлийн дийлэнх нь байгалийн хадлан, хивэг байдаг ба эцэнхий ядруу малдаа түлхүү өгдөг. Тэжээлийн чанар нь сайн байх нь хоёр чухал ач холбогдолтой. Ноолуурын үйлдвэрлэлийн тоо хэмжээ, чанарыг сайжруулахаас гадна малаас ялгарах метан (CH₄) хийн ялгарлыг бууруулахад хувь нэмэр оруулна. Учир нь тэжээл нь шингэц сайтай байх тусам малын гэдсэнд дотор исэлдэж боловсрох явцад CH₄ бага ялгардаг байна. (Христов нар, 2013).

Тийм учраас малын тэжээлийн шимт чанарыг сайжруулах техник, эдийн засаг, байгаль орчны боломжийг бүрдүүлж бие даасан байдлыг хангах нь маш чухал байна. Тухайлбал, Өвөр Монголд малыг хэт тэжээлээс хараат болгож, дан тэжээлээр бордох болсон нь эргээд малчин өрхийн орлогод нөлөөлж, малын тоо хэт өсөх улсаар бэлчээрийн хүрэлцээ хангамж муудах гэх мэт сөрөг үр дагавар авчирсан.

6.6.3 Ноолуур боловсруулах шатны ус ба химийн бодисын тогтвортой хэрэглээг дэмжих нь

Монгол улсад томоохон гол мөрний бохирдол анхаарал татахуйц хэмжээнд хүрсэн. (Алтансүх, Даваа, 2011, Баттогтох 2014; Батсайхан 2017, Голубкина 2018 нарын судалгааны тайланг харна уу). Өнөөдрийг хүртэл Монголд ноолуураас үүдэлтэй ус бохирдсон тухай шууд нотлох баримт байхгүй ч ноолуурын салбарын будах үе шат нь ашиглаж байгаа будгийг усны нөөцийн хомсдолын улмаас шууд байгальд хаяж байгаа нь байгаль орчинд болоод хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Чен нарын судлаачид (2021) Байгальд будгийг хаях нь **усны эвтрофикаци** (химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ, нийт фосфор, нийт азот ба NH₃-N-ийн ялгаралтаас шалтгаалж), **усны хорт чанарт** (хром, анилин, шингээх боломжтой органик галоген ялгадас зэргээс шалтгаална) нөлөөлдөг болохыг тогтоожээ.

Өнгөрсөн хугацаанд дээрх бохирдлыг бууруулахын тулд хэд хэдэн төсөл, санаачилга хэрэгжсэн. Тухайлбал, Тогтвортой ноос, ноолуурын эвсэл (ТННЭ) нь ноолууран боловсруулалтын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, ялангуяа угаах, ялгах шатны химийн хорт бодис, тухайлбал алкилфенол этоксилатыг (APEOs)

бохирдлыг хянах стандарт⁵¹ боловсруулсан. 2021 онд STeP EcoLab болон Монголын ноос ноолуурын холбоо хамтран “Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн сайн дурын үйл ажиллагааны дүрэм”-ийг боловсруулсан. Нийт 18 компани энэ санаачилгад нэгдсэн бөгөөд дээрх тогтвортой үйлдвэрлэлийн дүрмийн нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч, байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай тогтвортой үйлдвэрлэл явуулахаа илэрхийлсэн ямар ч компанид гишүүнчлэл нь нээлттэй. Сайн дурын үйл ажиллагааны дүрэм нь өртгийн тогтвортой сүлжээг бий болгох, нөөцийг үр ашигтай ашиглах, ногоон санхүүжилтийн болзлыг хангахад чиглэгдсэн гурван гол шалгуураас бүрддэг⁵².

Монголын стандарт хэмжил зүйн газраас Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийг эрхлэхэд баримтлах үндсэн зарчим, шаардлагуудыг тогтоох, тэдгээрийг үнэлэх, баталгаажуулах зорилготой MNS 6926: 2021 стандартыг баталсан.

Тус стандартын гол шаардлагуудаас дурдвал:

- Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус түүний чанар нь холбогдох “MNS 6390:2013 Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутга татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус Техникийн шаардлага” стандартын шаардлагыг хангасан байна.
- Бохир ус цэвэрлэх байгууламж нь “MNS 4288:1995 Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага” стандартыг шаардлагыг хангасан байна.
- Олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн ногоон гэрчилгээтэй будаг болон химийн бодисуудыг сонгож хэрэглэнэ⁵³
- MNS 6458:2014 стандартын шаардлага хангасан химийн бодисын агуулахтай байна.

Энэ стандарт шаардлагууд нь олон улсын жишигтэй нийцвэл хэд хэдэн үйлдвэрүүд хаягдал устай холбоотой стандартын шалгуурыг хангаж чадахгүй. Стандартыг мөрдлөг болгохын тулд байнгын хяналт, баталгаажуулалт хийх нь маш чухал. Бүтээгдэхүүний чанараас гадна байгаль орчинд ээлтэй байх, нийгэмд ээлтэй байдал, ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх нь чухал. Мөн томоохон компаниуд тогтвортой менежментийг баримталж ажиллахад ихээхэн анхаарч байна. Тиймээс дээрх стандарт хэрэгжилтийг хяналтыг жижиг үйлдвэр, нэгжүүд уруу чиглүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

7. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

7.1 Хамрах гол асуултуудын хариулт

Өртгийн сүлжээ нь эдийн засгийн хувьд тогтвортой эсэх асуултад эерэг, сөрөг аль аль хариулт гарч байна. Малчид ноолуурын ямаа өсгөхөд харьцангуйгаар тийм ч их зардал гаргадаггүй. Ноолуур нь тэдний өрхийн орлогод маш их нэмэр болдог хэдий ч тогтмол орлого болж чаддаггүй, зөвхөн улирлын чанартай байна. Ноолуур самнах үед түүхий эдээ хангалттай бэлдэж авахын тулд үйлдвэрүүдэд санхүүгийн эх үүсвэр

⁵¹ <https://sustainablefibre.org/>

⁵² <https://en.avsfmongolia.org/>

⁵³ REACH, ZDHC, MRSL, RSL, Blue sign, GOTS, GreenScreen Certified, OEKO-TEX зэрэг Олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн ногоон гэрчилгээтэй будаг болон химийн бодисууд

шаардлагатай болдог. Тиймээс зээл авч түүхий эдээ бэлддэг нь үйлдвэрүүдийн санхүүгийн ашиг орлого буурахад мөн нөлөөлдөг. Энэ нь салбарын цаашдын хөгжлийг хязгаарлаж байна. Ялангуяа Хятадын хөрөнгө оруулалттай ноолуур экспортлох үйлдвэр, бизнесүүд давамгайлсан, санхүүгийн хямд эх үүсвэрээр ноолуур бэлтгэж байгаа үед дотоодын үйлдвэрүүдийн хөгжлийн асуудалд төрөөс анхаарах ёстой.

Үүнээс гадна ноолуурын салбар нь нэмүү өртөг өндөртэй, цалин сайтай, ажиллах таатай орчныг бүрдүүлсэн ажлын байр ихээр бий болгодог, тэр дундаа орон нутгийн ажилгүй иргэд, эмэгтэйчүүд зэрэг нийгмийн эмзэг бүлгийг хүртээмжтэйгээр хамардаг эдийн засгийн чухал салбар юм. Боловсруулалтын түвшинд эрэгтэй, эмэгтэй ажилчдын цалингийн зөрүү маш бага байгаа нь сайшаалтай. Гэвч орлогын хуваарилалт, цалин, ажлын байрны хүртээмжтэй байдал нь Улаанбаатар хотод хэт төвлөрсөн, алслагдсан бүс нутагт хүрч чадахгүй байгаад анхаарах хэрэгтэй.

Ноолуурын өртгийн сүлжээ нь нийгмийн хувьд тогтвортой эсэх асуудал нь ноолуур бэлдэх буюу малчдын үе шат, боловсруулалтын үе шат нь нийгмийн шинж чанарын хувьд асар ялгаатай байдлаас шалтгаалан төвөгтэй байдлууд бий болгодог хэдий ч ерөнхийдөө нийгмийн үзүүлэлтүүд нь VCA4D шинжилгээ хийсэн орлоготой улс орнуудтай харьцуулахад эерэг байна. Боловсруулах салбарт хөдөлмөрийн нөхцөл илэрхий сайжирч байгаа нь МХҮАҮЭ болон ажил олгогчдын зүгээс хэрэгжүүлж буй олон талт үйл ажиллагааны үр дүн юм. Энэ салбар нь Монголын албан эдийн засгийн бусад салбартай харьцуулахад ажиллах хүчний сонирхлыг, ялангуяа эмэгтэйчүүдийн сонирхлыг их татдаг.

Мал аж ахуйн салбарын гол асуудал нь жендерийн тэгш бус байдал, залуу үе, ялангуяа охид мал маллах сонирхолгүй болж байгаа явдал юм. Хоол тэжээлийн олон янз байдлын дутагдалтай байдлыг зөвхөн өртгийн сүлжээ гэлгүйгээр нийтэд нь арга хэмжээ авах шаардлагатай. Малчид, БАХ, малчдын хоршоод гэх мэт малчдын олон нийтэд тулгуурласан байгууллагууд хөгжиж байгаа ч олонхыг хамарч чадахгүй хэвээр байна. Бэлчээрийн менежментийн асуудал парламентаар хэмжээнд яригдаж шийдвэр гаргагч нарын анхааралд хүрсэн нь сайшаалтай. Нийгмийн дүн шинжилгээ нь олон улсын хөгжлийн байгууллагууд, донорууд ноолуурын өртгийн сүлжээнд хөрөнгө оруулахад садаа болох ноцтой хүчин зүйл байхгүйг баталж байгаа ба харин ч ийм хөрөнгө оруулалт нь өртгийн сүлжээний тоглогчдын хөгжлийг тэлэх маш сайн дэмжлэг болох юм.

Ноолуурын өртгийн сүлжээ нь хүний эрүүл мэнд, экосистем, байгалийн нөөцийн хомсдолд тодорхой хэмжээний нөлөөлөл үзүүлж байна. МАА-н салбар нь байгаль орчны болон экосистемийн нөлөөллийн ихэнх буюу 70% орчмыг эзэлж байгаа бол хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл нь 40% байна. Байгалийн экосистемд үзүүлж буй нөлөөлөл нь голчлон бэлчээрийн даац хэтэрсэн доройтлоос шалтгаалж байна. Ноолуур будах үе шат нь байгалийн нөөцийн хомсдолд 36%, хүний эрүүл мэндэд 26%-ийн нөлөөг тус тус үзүүлж байна. Ноолуурын ямааны байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөө нь метан хийн ялгарал ба бэлчээрийн доройтол гэдгийг илүү ухамсарлан ойлгох нь чухлаар тавигдаж байна. Ноолуур будах үйл явцын тухайд усны хаягдал, эрчим хүчний хэрэглээ, ялангуяа нүүрсний хэрэглээнээс үүдэлтэй

МННХ нь нэхмэлийн салбарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг үнэлэх зорилгоор сайн дурын Тогтвортой Нэхмэл (Sustainable Textile, MNS 6926:2021) стандартыг боловсруулсан. Энэхүү үндэсний стандартыг Стандартчилал, Хэмжил Зүйн Газрын Нэхмэлийн Техникийн Хорооноос албан ёсоор зөвшөөрсөн юм. Стандартыг боловсруулах гол зорилго нь байгаль орчинд ээлтэй, нийгэмд хариуцлагатай, ёс зүйтэй нэхмэлийн салбарыг хөгжүүлэхэд оршдог.

Монголын Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ)

Монголын Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ) нь Монголын бизнесийг дэмжин ажилладаг гол байгууллага юм. Энэ нь бизнес эрхлэгчдийн эрх ашиг, сонирхлыг төлөөлж, бизнесийн үйл ажиллагааг дэмжин, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн үйлчилгээг үзүүлдэг. МҮХАҮТ нь дотоод болон олон улсын хэмжээнд худалдаа, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх зорилгоор сурталчилгаа, сүлжээ үүсгэх зэрэг төрөл бүрийн үйлчилгээг санал болгодог.

Тус танхим нь төр болон аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцаа холбоог сайжруулж, бизнес хөгжих таатай орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулдаг бөгөөд Монгол Улсын эдийн засгийн хөгжил, дэлхийн зах зээл дээрх өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн, МҮХАҮТ нь экспортлогчдод, ялангуяа ноолуурын салбарын экспортлогчдод зориулан тусгай хөтөлбөрүүдийг боловсруулж, Ноос, Ноолуурын Зөвлөл-ийг байгуулсан нь тус салбарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн томоохон алхам болсон.

Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо

Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (МСБХ) нь 2017 оны 12-р сард Монголын Банкуудын Холбооноос (МБХ) санаачлан байгуулсан бөгөөд санхүүгийн тогтолцоог байгаль орчинд ээлтэй, нийгмийн хувьд хариуцлагатай болгох зорилгоор ажилладаг. Энэхүү холбоо нь гишүүн санхүүгийн байгууллагууд болон аж ахуйн нэгжүүдийг тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг. 2022 оны 10-р сарын байдлаар МСБХ нь арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагууд, даатгалын компаниуд зэрэг төрөл бүрийн санхүүгийн

байгууллагуудыг нэгтгэдэг.

МСБХ нь гишүүд болон түншүүдтэйгээ хамтран Монгол Улсын ногоон хөгжлийн зорилтуудыг олон улсын тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдуулан бодлого, санаачилга боловсруулж, хэрэгжүүлэхээр ажилладаг. Тус холбоо нь сайн дурын тогтвортой байдлын гэрчилгээтэй малчид, хоршоод болон боловсруулах үйлдвэрүүдэд ногоон зээл олгохыг дэмжиж, байгаль орчинд ээлтэй санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулдаг.⁵⁵

Монголын Үндэсний Хоршоодын Холбоод

Монголын Үндэсний Хоршоодын Холбоод (МҮХХ) нь нийгмийн янз бүрийн салбар дахь хамтын ажиллагаа, хамтын үйл ажиллагааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр холбоод нь Монгол Улсын хэмжээнд хоршооллын зарчмуудыг сурталчлан таниулах, эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих, хоршооллын аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлдэг. Тус холбоод нь хоршоодын эрх ашгийг хамгаалахаас гадна нөөц, сургалт, техникийн туслалцаагаар ханган, нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж, олон нийтийг чадавхижуулж, тогтвортой үйл ажиллагааг дэмжихийг зорьдог.

МҮХХ нь дээвэр байгууллагын хувьд хувийн малчдын хоршоодын холбоог ч мөн багтаж, тус салбарын хөгжлийг дэмжихэд оролцдог.

2022 оныг “Хоршоодыг дэмжих жил” болгон зарласан. Засгийн газар хоршооны тухай шинэ хууль боловсруулсан бөгөөд НӨАТ-тай холбоотой зарим өөрчлөлтүүд гарчээ. Урьд нь хоршоод бусад аж ахуйн нэгжүүдийн адил (10%) нэмэгдсэн өртгийн албан татвар төлдөг байсан бол одоо борлуулалтын орлого нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгддөг болсон. Мөн хоршоод нь төлөөлөгчөөр ажилладаг учир бүтээгдэхүүнд нь татвар ногдуулдаггүй (Кимура нар, 2022⁵⁶). Түүнчлэн, хоршоод гишүүдийнхээ ноос, арьс ширний борлуулалтаас ашиг олдоггүйг анхаарах хэрэгтэй. НӨАТ-ын төлбөрийг зөвхөн хоршоогоор дамжуулан борлуулж буй гишүүн бус бүтээгдэхүүнүүдэд ногдуулдаг (Өнөрзул, 2023).

Олон улсын хөгжлийн байгууллагууд

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь “Ногоон түүхий эд”-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцдаа ноолуурын салбарыг илүү тогтвортой болгохын чухлыг олж харсан. Тэд Монгол Улсыг ноолуурын тогтвортой үйлдвэрлэлээр тэргүүлэгч орон болгох үүднээс Тогтвортой ноолуурын платформыг⁵⁷ эхлүүлсэн. Стандарт бий болгох, нийлүүлэлтийн сүлжээг сайжруулах зэрэгт ахиц дэвшил гарсан ч, тогтолцооны хувьд томоохон өөрчлөлт хийхэд саад болж буй олон асуудлууд гарч байна. Тиймээс тус платформын эрхэм зорилго нь Монгол Улсын ноолуурын үйлдвэрлэлийг тогтвортой болгохын тулд уялдаа холбоо бүхий хүчирхэг хууль эрх зүйн болон институцийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Азийн хөгжлийн банк

⁵⁵ ХААН банктэй ярилцахад тэд 2022 онд ХХААХҮ-ээр баталгаажсан хоршоодыг хөнгөлөлттэй хүүтэй ногоон зээлээр санхүүжүүлэх туршилтын төсөл хэрэгжүүлжээ. Энэхүү санаачилга нь ноолуурын тогтвортой үйлдвэрлэлийг дэмжихээс гадна Монголын боловсруулах үйлдвэрүүдэд бүтээгдэхүүн нийлүүлэх орон нутгийн хоршоодыг дэмжих зорилготой байсан.

⁵⁶ МУ-н Засгийн газар. 2021. НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Улаанбаатар

⁵⁷ <http://sustainablecashmereplatform.com/>

Азийн хөгжлийн банк нь Монгол Улсад хүртээмжтэй, уур амьсгалын мэдрэмжтэй хөгжлийг бий болгож, дэд бүтцийг сайжруулах замаар эдийн засгийг солонгоруулах, тогтвортой болгох зорилготой. Түүнчлэн ЕХ, Европын хөрөнгө оруулалтын банк, Ногоон уур амьсгалын сан, Японы тусгай сан зэрэг байгууллагуудтай нягт хамтран ажилладаг. АХБ нь Аймаг, сумдын ногоон бүсийн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж түүндээ нүүрстөрөгчийн ялгарал багатай бэлчээрийн менежментийн асуудлыг багтаасан (№49430-005). Мөн ХАА-н нэмүү өртгийн сүлжээний чадавхийг бэхжүүлэх хөнгөлөлттэй зээлийн төслийг (№55218-003) батлав. Мөн "Говь" ноолуурын компанид 30 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл(№57156-001) гэх мэт АХБ-наас 1992-2023 оны 69 төслийг баталсан юм.

Европын холбоо

Европын холбоо нь 2017 оноос хойш Монгол Улсад байнгын төлөөлөгчийн газартай ажиллаж байгаа бөгөөд Европын Холбоог төлөөлөн Монгол Улсын Засгийн газартай харилцах, ЕХ-ны орнуудын үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй. 2022-2024 онд ЕХ нь ГТХАН болон ХХААБ (STREAM төсөл)-тэй хамтран экосистемийн тогтвортой байдлыг хангах, туслах малчдын хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, AVSF-ийн тогтвортой нэхмэлийн үйлдвэрлэл (STeP EcoLab төслийн мэдээллийг доор харна уу), ЖДҮ-ийн хөгжил зэрэг чухал салбаруудад анхаарахн дэмжлэг үзүүлж ирсэн. Үүний зэрэгцээ ЕХ болон Монгол Улс 2022 оноос эхлэн Газар зүйн үзүүлэлтийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах хэлэлцээр байгуулах шатандаа явж байна. 2024 онд Европын холбооноос Зудын хохиролыг бууруулах зорилгоор 500,000 еврогийн буцалтгүй тусламж үзүүлэв. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” аяны санаачилгыг дэмжиж, Европын хөрөнгө оруулалтын банк, Монгол Улсын Засгийн газар хооронд Ойн түншлэлийн тухай санамж бичгийг санаачилан байгуулсан.

Дэлхийн Банк

Дэлхийн банк нь 2021-2025 оны үйл ажиллагааны стратегийнхаа хүрээнд Монгол Улстай харилцах хамтын ажиллагааны түншлэлийн баримт бичгээ 2021 онд баталсан. Энэхүү төлөвлөгөө нь Монгол Улсад COVID-19 тахлын улмаас тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд туслахын зэрэгцээ тогтвортой, хүртээмжтэй, даван туулах чадамжтай хөгжлийг дэмжих зорилготой юм. Дэлхийн Банк нь гурван үндсэн чиглэлээр дэмжлэг үзүүлдэг. Үүнд (i) Эдийн засгийн засаглалыг бэхжүүлэх, (ii) Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, (iii) Амьдралын чанарыг сайжруулах гэсэн гурван үндсэн чиглэл багтана. Дэлхийн банкны ноолууртай холбоотой 2 төслийг дурдах нь зүйтэй. Үүнд малын эрүүл мэнд, ашиг шимийг сайжруулах зорилготой Монгол Улсын Хөдөө аж ахуйн маркетингийн төсөл (P125964) болон Мал арилжааны төсөл (P165945) багтана.

Дэлхийн байгаль орчны сан

Дэлхийн байгаль орчны сан (ДБСБХ) нь дэлхийн байгаль орчны сорилтуудыг шийдвэрлэх зорилготой олон улсын байгууллага юм. 1992 онд байгуулагдсан ДДБОС нь уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын доройтол, газрын талхагдал зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлийн түншлэл хамтын ажиллагааг дэмждэг. Тус сангийн хүрээнд ENSURE төслийг санхүүжүүлж, улмаар НҮБХХ-ийн Тогтвортой ноолуурын платформыг хамтран хэрэгжүүлэв. Мөн малчин өрхөд чиглэсэн бэлчээрийн доройтол, нөхөн сэргээлт зэрэг асуудлуудыг дэмжихээр төлөвлөж байна.










НҮБ-ХХААБ

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага нь хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх замаар ядуурал, хоол тэжээлийн дутагдлыг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газартай олон жил амжилттай хамтран ажиллаж байна. Нэмж дурдахад НҮБ-ын ХХААБ нь улсын хэмжээнд байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжлийг дэмжих, тэр дундаа гамшгийн эрсдэлийн менежментийн стратегийг дэмжих чиглэлээр засгийн газартай нягт хамтран ажиллаж ирсэн. Үүний зэрэгцээ, амьтны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх (ДБ-ны дэмжлэгтэй), Биологийн олон янз байдлыг хамгаалах (ДБС-ын дэмжлэг), сонгогдсон мал, хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээнд ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх (ЕХ-ны дэмжлэг) зэрэг төслүүд дээр хамтран ажилласан.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)

Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь үндсэн гурван салбарт анхаарлаа хандуулдаг: (i) албан болон албан бус салбарт ажлын байр бий болгох/нэмэгдүүлэх замаа хүмүүсийн орлогыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах; (ii) Нийгэм, эдийн засгийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхийн тулд засгийн газар, ажил олгогч, хөдөлмөр эрхлэгчдийн хамтын ажиллагааг сайжруулах; (iii) Хүүхдээр хөдөлмөр эрхлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, албадан хөдөлмөрт өртсөн хүмүүс зэрэг эмзэг бүлгийнхний эрхийг хамгаалах гэсэн асуудлыг нэн тэргүүн анхаарах албар болгон ажиллаж байна.

Хоёр орны хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааг доорх зурагт үзүүлэв.

	Mongolia – Federal Republic of Germany <ul style="list-style-type: none"> Technique and technological renovation of agriculture Empowering human resources 		Mongolia – Japan <ul style="list-style-type: none"> Food supplies and production Improving rural water supply Increase crop production Empowering human resources
	Mongolia – The French Republic <ul style="list-style-type: none"> Import highly beneficial livestock Establish a laboratory of livestock inseminator Animal health, well-being and registration 		Mongolia – Korea <ul style="list-style-type: none"> Veterinary Improve quality of livestock genetics and livestock Produce and harvest seeds of elk elite Increase feed production Empowering human resources
	Mongolia – The Czech Republic <ul style="list-style-type: none"> Improving rural water supply Mark livestock, make a registration animals into a unified database Empowering human resources 		Mongolia – China <ul style="list-style-type: none"> Improve genetic resources for livestock, Fighting meat exports and trans-boundary animal diseases Agricultural products Produce new varieties of vegetables Technique of crop farming Empowering human resources
	Mongolia – EU <ul style="list-style-type: none"> Capacity building of Veterinary Laboratories Supporting Meat and Milk farming and production Reinforcement of small-scale plant equipment European Union standardization of the tanning industry Empowering human resources Producing and introducing organic "Mongol brand" to the European market 		Mongolia – Vietnam <ul style="list-style-type: none"> Meat, meat product exports
	Mongolia – Russia <ul style="list-style-type: none"> Eliminate some export commodities tariffs Meat exports Healthy animals Produce and adapt new varieties of the plant Technique of crop farming 		

МОНГОЛ УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТҮНШҮҮД, ТЭДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Эх сурвалж: Амар (2019).

Иргэний нийгмийн байгууллага

Хил хязгааргүй малын эмч нар болон агрономчид ТББ-AVSF

Хил хязгааргүй малын эмч нар болон агрономчид ТББ (AVSF) нь эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн хөдөө аж ахуй, мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх зорилготой олон улсын төрийн бус байгууллага юм. AVSF нь чадавхи бэхжүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх, мэдлэг хуваалцах замаар орон нутгийн тариаланчдад хүнсний аюулгүй байдал, тогтвортой амьжиргаа, уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлдэг. НҮБХХ-ийн тогтвортой ноолуурын санаачилгын нэг түнш төдийгүй Монгол Улсад оролцооны арга барил, агроэкологийн зарчмуудыг хөгжүүлэх, ноолуурын өртгийн сүлжээний тогтвортой байдлыг хангах чиглэлээр ажиллаж байна. STeP EcoLab⁵⁸ төсөл нь өртгийн сүлжээг өргөжүүлэх, нэхмэлийн үйлдвэрлэлийн тогтвортой ханган нийлүүлэлт, үйлдвэрлэлийн сайн туршлагыг нэвтрүүлэх, тогтвортой бүтээгдэхүүний брэндийг хөгжүүлэх, зардал хэмнэлтийн зарчмыг оновчтой болгох, уур амьсгалын санхүүжилт авах, худалдан авагчдын төрлийг олшруулах зэрэг олон чиглэлд үйл ажиллагаа явуулдаг. Малчид болон боловсруулах аж ахуйн нэгжүүдийн талаар AVSF-аас мэдээлэл нь өртгийн сүлжээний талаар үнэлж баршгүй мэдээлэл, ойлголт өгсөн юм.

Тогтвортой ноос ноолуурын эвсэл (ТТНЭ)

Тогтвортой ноос ноолуурын эвсэл (ТТНЭ) нь ашгийн бус гишүүнчлэлтэй байгууллага бөгөөд ноолуурын салбарын урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилготой. ТТНЭ нь өртгийн сүлжээний оролцогчид, оролцогч талууд, салбарын мэргэжилтнүүдийн дэлхийн холбоог төлөөлж байна. Тус байгууллага нь сайн дурын стандартын гэрчилгээнүүдийг (SFA Cashmere Standard, Cashmere Standard, Clean

⁵⁸ <https://www.switch-asia.eu/project/step-ecolab/>

Fiber Processing Standard) олгодог. Мөн ТТНЭ нь Хятад болон Монголд үйл ажиллагаа явуулдаг шилэн хяналтын систем (Chain of Custody) боловсруулан хэрэгжүүлж байна.

Дэй Нэйчэ консерванси (TNC) нь хүн байгалийн зохист тэнцвэрийг хангах зорилготой олон улсын ашгийн бус байгууллага юм. 1951 онд Америкийн Нэгдсэн Улсад үүсгэн байгуулагдсан Дэй Нэйчэ консерванси байгууллага нь байгаль орчны доройтол, сорилтод байгальд суурилсан шийдлүүдийг бий болгох шинжлэх ухаанд тулгуурласан арга барилаар зургаан тивийн 70 гаруй улс оронд үйл ажиллагаа явуулдаг. Сая гаруй гишүүн, 400 гаруй эрдэмтдийн багтайгаар 37 улсын байгаль хамгаалалд шууд нөлөөлж, бусад 42 улсад түншүүдээ дэмжин ажилладаг. Дэй Нэйчэ Консерванси Монгол дахь төлөөлөгчийн газар нь 2008 оноос хойш байгаль хамгаалах чиглэлийн төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэн ажиллаж байна. 2030 он гэхэд Монгол улсын 30%-ийг тусгай хамгаалалттай болгохын тулд Монголын засгийн газартай хамтран ажиллаж байна. Үүний зэрэгцээ, Дэй Нэйчэ Консерванси нь Монгол орны хэмжээнд экологийн бүс нутгийн үнэлгээг холбогдох талуудтай хамтран гүйцэтгэж, экологийн ач холбогдолтой, хамгаалах шаардлагатай газруудыг тогтоосон. Зүүн бүсийн Тосон Хулстайн байгалийн нөөц газарт хамтын менежментийг нэвтрүүлж, олон зуун менежер, малчдыг сургасан.

TNC-ийн нэгэн адил **Зэрлэг ан амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS)** нь биологийн олон янз байдал, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, хүмүүст байгаль эх дэлхийгээ хайрлах зориг өгөх зорилготой олон улсын байгууллага юм. Монголд Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS) нь говь, тал хээрийн иргэдтэй хамтран ажилладаг. Малчдын орлогын гол эх үүсвэр болсон ноолуур нь мал аж ахуйн тогтвортой үйл ажиллагааг хангаж, байгальд ээлтэй үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг татан оролцуулах гол үндэс юм. WCS нь малын эрүүл мэнд, үржил, тэжээлийн чанар, бэлчээрийн менежмент, ан амьтдыг хамгаалах чиглэлээр техникийн туслалцаа үзүүлдэг. Нэмж дурдахад тэд малчдыг тансаг хувцас загварын Керинг групптэй холбож өгдөг.

Хөдөө аж ахуйн Их Сургууль (ХААИС) нь хөдөө аж ахуй, байгаль орчны шинжлэх ухаанд боловсрол, судалгаа, инновацид төвлөрсөн нэр хүндтэй сургууль юм. Тус сургуулийнхан хөдөө аж ахуйн туршлага, хөдөөгийн хөгжил, байгаль орчны тогтвортой байдлыг сайжруулах чиглэлээр дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг. Мөн ХААИС нь ноолуурын салбартай холбоотой үндэсний болон олон улсын төслүүдэд оролцож, салбарын хөгжилд хувь нэмэр оруулдаг.

Шинжлэх ухаан техникийн их сургууль (ШУТИС) нь өргөн хүрээний салбарт мэргэжилтнүүдийг бэлтгэдэг политехникийн их сургууль юм. Ноолуурын салбарын сургалтын үйл ажиллагааны гол хэсэг болсон 2 төв тус сургуулийн дэргэд бий. Шима Сейки сургалтын төв нь ноолуурын үйлдвэрт хэрэглэгддэг автомат сүлжмэлийн машинуудын загвар, тооцоо, програмчлалыг ашиглах мэргэжилтнүүдийг бэлтгэж ур чадвар олгодог. Хувцас судлалын төв нь үндсэн болон дагалдан ажилтан бэлтгэх сургалт явуулахын зэрэгцээ хувцас үйлдвэрлэлийн технологийн судалгааг гүнзгийрүүлэхэд анхаарч ажилладаг. 2023 онд ШУТИС нь НҮБ-ын Хөгжлийн

хөтөлбөр, Европын Холбооны дэмжлэгтэйгээр ноолуурын нэхмэл, сүлжмэлийн мэргэжлээр 13 оюутны тэтгэлэгийг санхүүжүүлсэн.

ХАВСРАЛТ 3: Эдийн засгийн дүн шинжилгээ хийхэд ашигласан нэмэлт мэдээлэл

Цөөн малтай өрхийн санхүүгийн тооцоо (үндэсний дундаж)

100 ямаанд, цөөн малтай (600-аас доош мал)		Үнэ	Нэгж	Жил / Харьцаа	Эцсийн зардал/ Орлого
Үйлдвэрлэл	Ноолуур (87% goats)	102,000	35.1	1	3,580,200
	Арьс	35,000	7	1	245,000
	Мал борлуулалт	90,000	11	1	990,000
	Өөрийн хэрэглээ	90,000	8	1	720,000
	Сүү (литр) - зарагдсан	2,417	3.4	1	8,121
	Сүү (литр) - ашигласан	2,417	80.6	1	194,907
	Ямааны борлуулсан бусад зүйлс	649	100	1	64,900
Татаас	Шууд бус татаас (мал эмнэлэгийн үйлчилгээг оруулаад)	900	100		90,000
Нийт үйлдвэрлэл					5,893,128
Хэрэглээний материал	бензин	14,651	11.55	1	169,217
	тэжээл	36,109	11.55	1	417,054
	ус, урсгал зардал, цахилгаан	289	11.55	1	3,340
Үйлчилгээ	Мал эмнэлэг	3,028	11.55	1	34,977
	Мал угаалга	200	100	1	20,000
	Даатгал	165	11.55	1	1,906
Цалин	Цалин	3,876	11.55	1	44,762
Зээлийн хүү	Малчны болон бусад бизнесийн зээл	54,133	11.55	0.12	75,029
Татвар	Малын толгойн татвар	617	100	50%	30,850
	ХАОАТ	4,675,262	1.00%		46,753
	Нийгмийн даатгал	68,750	1	24%	16,500
Элэгдэл хорогдол	Ухна	350,000	0.8	7	40,000
	Машин	76,773	11.55	5	177,346
	Мотоцикл	20,536	11.55	3	79,064
	Ачааны машин	55,326	11.55	5	127,803
	Өвөлжөөний байр(200 толгой мал)	7,000,000	50%	15	233,333
Нийт зардал					1,517,932
Ашгийн харьцаа					
Бохир ашиг					5,032,742
Цэвэр ашиг					4,375,196
Цэвэр нэмүү өртөг					5,246,635
Ашгийн зөрүү					74%

Ямааны нэмүү өртөг (Монгол, 2022) тэрбум төгрөгөөр	850.10
ХАА-. Нийт нэмүү өртөг (Монгол, 2022) тэрбум төгрөгөөр	7,003
ХАА-н Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх % (одоогийн үнээр)	12.1%

Олон малтай өрхийн санхүүгийн тооцоо (үндэсний дундаж)

100 ямаа тутамд (11.55 нэгж)		Үнэ	Нэгж	Жил	Эцсийн зардал/орлого
Үйлдвэрлэл	Ноолуур (86% ямаа)	102,000	35.1	1	3,580,200
	Арьс	35,000	6	1	210,000
	Мал борлуулалт	90,000	10	1	900,000
	Өөрийн хэрэглээ	90,000	3	1	270,000
	Сүү (литр) - зарагдсан	2,417	0.9	1	2,127
	Сүү (литр) - ашигласан	2,417	43.1	1	104,221
	Ямааны борлуулсан бусад зүйлс	350	100	1	35,000
Татаас	Шууд бус татаас (мал эмнэлэгийн үйлчилгээг оруулаад)	900	100	1	90,000
Нийт үйлдвэрлэл					5,191,548
Хэрэглээний материал	бензин	9,752	11.55	1	112,640
	тэжээл	21,991	11.55	1	254,000
	ус, урсгал зардал,цахилгаан	463	11.55	1	5,350
Үйлчилгээ	Мал эмнэлэг	2,200	11.55	1	25,410
	Мал угаалга	200	100	1	20,000
	Даатгал	260	11.55	1	3,003
Цалин	Цалин	15,516	11.55	1	179,210
Зээлийн хүү	Малчны болон бусад бизнесийн зээл	42,371	11.55	0.12	58,726
Татвар	Малын толгойн татвар	617	100	0.5	30,850
	ХАОАТ	68,750	1	20%	13,750
	Нийгмийн даатгал	4,215,707	1.56%		65,765
Элэгдэл хорогдол	Ухна	350,000	1	7	50,000
	Машин	41,291	11.55	3	158,970
	Мотоцикл	8,646	11.55	3	33,287
	Ачааны машин	41,770	11.55	5	96,489
	Өвөлжөөний байр(200 толгой мал)	7,000,000	50%	15	233,333
	Туслах малчны гэр	8,298	11.55	15	6,389
Нийт зардал					1,347,173
Ашгийн харьцаа					
Бохир ашиг					4,422,844
Цэвэр ашиг					3,844,375
Цэвэр нэмүү өртөг					4,771,145
Ашгийн зөрүү					74%
Ямааны нэмүү өртөг (Монгол, 2022) тэрбум төгрөгөөр					542
ХАА-. Нийт нэмүү өртөг (Монгол, 2022) тэрбум төгрөгөөр					7,003
ХАА-н Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх % (одоогийн үнээр)					7.7%

Малын тоо толгойн татвар аймгаар

Аймаг	Бүс	Тоо толгойн татвар	Цуглуулах ёстой
Дархан Уул	Төвийн бүс	2,000.0	205,200,000.0
Дорноговь	Төвийн бүс	400.0	511,328,000.0
Дундговь	Төвийн бүс	400.0	641,368,000.0
Говьсүмбэр	Төвийн бүс	650.0	116,883,000.0
Өмнөговь	Төвийн бүс	400.0	659,852,000.0
Сэлэнгэ	Төвийн бүс	1,800.0	1,127,988,000.0
Төв	Төвийн бүс	650.0	1,058,655,000.0
Улаанбаатар	Ulaanbaatar	0.0	0.0
Дорнод	Зүүн бүс	800.0	718,736,000.0
Хэнтий	Зүүн бүс	700.0	1,155,161,000.0
Сүхбаатар	Зүүн бүс	600.0	889,458,000.0
Архангай	Хангай	550	839,789,500.0
Баянхонгор	Хангай	550.0	1,200,485,000.0
Булган	Хангай	600.0	713,700,000.0
Хөвсгөл	Хангай	520.0	1,165,486,400.0
Орхон	Хангай	500.0	29,300,000.0
Өвөрхангай	Хангай	1,250.0	2,134,700,000.0
Баян-Өлгий	Баруун бүс	500.0	483,695,000.0
Говь-Алтай	Баруун бүс	600.0	1,192,368,000.0
Ховд	Баруун бүс	500.0	922,950,000.0
Увс	Баруун бүс	500.0	676,640,000.0
Завхан	Баруун бүс	450.0	579,015,000.0
НИЙТ		617 (дундаж)	17,022,757,900.0

Малын татвар, аймгаар,
Эх сурвалж МБАНХ 2021

ӨРТГИЙН СУЛЖЭЭНИЙ НЭГДСЭН ТООН МЭДЭЭЛЭЛ

Operating accounts per actor and for the value chain

Actor	Production	Subsidy	IGS	Wages	Taxes	Interest on loan	Land Fee	Depreciation	Net Operating Profit	VA	VA/Product	Nb of Actors
Eastern small HH	288 564	2 132	159 101	1 221	1 629	1 778	0	4 500	122 467	129 463	45%	24 651
Central small HH	481 054	3 804	266 900	2 179	2 717	3 171	0	12 959	196 932	214 154	45%	43 974
Khangai small HH	574 826	4 711	320 089	2 698	3 261	3 927	0	16 049	233 512	254 737	44%	63 018
Western small HH	524 113	3 936	289 278	2 254	2 944	3 281	0	13 408	216 883	234 835	45%	45 539
Eastern Large HH	180 791	1 496	97 109	2 979	1 435	976	0	3 232	76 556	83 682	46%	4 915
Central Large HH	298 864	2 668	161 364	5 313	2 376	1 741	0	9 225	121 513	137 500	46%	8 767
Khangai Large HH	355 440	3 305	192 507	6 581	2 828	2 156	0	11 425	143 247	162 933	46%	12 652
Western Large HH	327 731	2 761	176 165	5 498	2 604	1 802	0	9 545	134 879	151 565	46%	9 074
East Middleman	129 558	0	157 570	187	0	0	0	130	-28 328	-28 012	-22%	99
Central Middleman	271 570	0	252 228	392	1 868	0	0	272	16 810	19 342	7%	186
Khangai Middleman	288 823	0	294 802	417	0	0	0	289	-6 685	-5 979	-2%	291
West Middleman	315 892	0	285 736	182	3 056	0	0	316	26 602	30 156	10%	193
Washing EXP	899 610	7 302	772 423	11 683	15 503	62 973	0	2 191	42 139	127 187	14%	39
Dehaired EXP	279 070	1 528	166 185	5 196	8 715	39 439	0	19 719	41 345	112 886	40%	46
TEXTILE	186 253	247	100 730	27 938	9 810	26 075	0	11 362	10 585	85 524	46%	24
Retail	256 922	0	190 083	7 708	27 269	20 554	0	2 569	8 739	66 839	26%	81
TEXTILE small	125 114	166	50 587	13 781	7 304	17 342	0	8 770	27 497	74 527	60%	84
VALUE CHAIN	2 108 676	34 056	257 338	96 206	93 319	185 215	0	125 960	1 384 693	1 851 338	88%	213 634

Дэд сүлжээний нэгдсэн мэдээ дүн

	Экспортын дэд сүлжээ		Босоо хамааралт дэд сүлжээ		Нийт өртгийн сүлжээ
Түүхий ноолуурын нийлүүлэлт	7,303	76%	2,369	24%	9,672
Үйлдвэрлэл	1,302,371	62%	806,305	38%	2,108,676
Газар зүйн индикатор	129,867	50%	127,471	50%	257,338
Цалин	34,262	36%	61,944	64%	96,206
Татвар	34,168	37%	59,151	63%	93,319
Зээлийн хүү	77,199	42%	108,016	58%	185,215
Элэгдэл хорогдол	63,615	51%	62,345	49%	125,960
ҮА-ны цэвэр ашиг	989,298	71%	395,395	29%	1,384,693
Шууд нэмүү өртөг	1,172,504	63%	678,834	37%	1,851,338
Нэмүү өртөг/бүтээгдэхүүн	90%		84%		88%
ӨС-ний тоглогчдын тоо	161,140	75%	52,493	25%	213,634

Монгол ноолуурын дэд сүлжээний нэгдсэн дүн (2022)

ХАВСРАЛТ 4: Нийгмийн дүн шинжилгээнд ашигласан материал

Газрын хуулинд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналын нэгтгэл

2002 оны газрын тухай хуулинд оруулах нэмэлт өөрчлөлтийн заалт	Нэмэлт өөрчлөлтийн хураангуй
3	Үндсэн нэр томъёоны өөрчлөлт
6	Нийтийн хэрэгцээний газрыг тодотгохдоо дамжин өнгөрөх зурвас нутаг, гадаргын задгай устай бэлчээр, байгалийн усны цэгүүдийг хамруулна. Бэлчээрийн үндсэн ангиллын менежментийг “Гэрээний зохицуулалт”-ын үндсэн дээр зохион байгуулах
11	Бэлчээрийн ангиллын тодорхойлолт; БАХ-д гэрээгээр ашиглах улирлын бэлчээр, малчин өрхийн гэрээгээр ашиглах отрын бэлчээр, “иргэн, хуулийн этгээд”-ийн эрчимжсэн мал аж ахуйн бэлчээрийг гэрээгээр ашиглах, дамжин өнгөрөх болон эрэг орчмын бэлчээрийг нийтийн хэрэгцээнд нээлттэй болгох.
18	Аймаг хоорондын отрын бүс нутгийн заагийг засгийн газраас тогтоох
19	Аймаг дундын отрын бүс нутгийн зохицуулалт, зааг нутгийн бэлчээрийн даацыг тодорхойлох үүргийг ХХААХҮЯ хариуцах
20 and 21	<p>Аймаг, сумын түвшний эрх мэдлийн хүрээ:</p> <ul style="list-style-type: none"> • Сум доторх улиралын бэлчээрийн хил зааг, отрын бүс нутаг, дамжин өнгөрөх бэлчээр, эрчимжсэн МАА-н бүсийг сумын ИТХ-р тогтоож, аймгийн ИТХ-аар батлана. • БАХ-ийн бэлчээр гэрээгээр ашиглах хүсэлтийг сумын ЗД батлана. БАХэсэгт шинээр гишүүн өрх элсүүлэх, отрын бүс нутаг ашиглах зөвшөөрөл зэргийг баг, сумын хурлаар батлана. • Аймаг дундын отрын бүс нутгийг аймгийн засаг дарга зохицуулна. • Тухайн нутгийн харьяа засаг захиргааы удирдлага, Засаг дарга нар дамжин өнгөрөх бэлчээрийн хил заагийг батлах, бэлчээрийн сар, улирлын хуваарь батлах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ (тарималжуулах, бордох гэх мэт) авах, бусад Засаг дарга нартай хамтран мал сүргийг онцгой байдлын үед түр нэвтрүүлэх, • Үүссэн асуудлыг хамтран шийдвэрлэх, хэрэв орон нутгийн хүрээнд харилцан шийдэлд хүрч чадахгүй бол үндэсний түвшний төрийн захиргааны удирдах дээд байгууллагат хандана
21	Намар, өвлийн бэлчээрийг амрааж сэлгэх зохицуулалтыг сумын ЗДТГ хийх
22	БАХ-ээс гэрээгээр ашиглах хүсэлт гаргасан бэлчээрийн хил заагийг багийн ИНХ-аар тогтооно. Сар, улиралын бэлчээр ашиглах хуваарь, отрын бэлчээрийг мөн багийн ИНХ-аар тогтооно
23	Бэлчээрийн зураг боловсруулах, газрын мэдээллийн санд бүртгэх, гэрээгээр ашиглаж буй бэлчээрийн фото мониторинг хийх, бэлчээрийн чанарын судалгаа хийх ажлыг сумын газрын мэргэжилтэн, аймгийн Газрын харилцааны, геодези, зураг зүйн газар хийнэ.
29	Баг, сумын ИНХ-ын санал дээр үндэслэн нэг малчин өрхөд 1 га хүртэл газрыг малын тэжээл тариалах зориулалтаар олгож

	болно.
52	<p>Одоогийн хуулинд оруулж буй өөрчлөлт:</p> <ul style="list-style-type: none"> • Бэлчээр ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтэд тухайн бэлчээрт нутаглаж буй хүн бүр ижил тэгш эрхтэйгээр оролцоно • Аймаг, сум багийн нийт бэлчээрийн 10 хувийг отрын бэлчээр болгож нөөцлөнө • Бэлчээр ашиглах гэрээнд бэлчээрийн хил зааг, ашиглах хугацаа, даацын мэдээлэл, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө, гамшгийн үед бусдад ашиглуулах нөхцөл зэргийг багтаана • Шинээр гишүүн элсүүлэх, шилжин ирэгсдийг элсүүлэх эсэх асуудлыг БАХ шийднэ

	<ul style="list-style-type: none"> • Бэлчээр ашиглах гэрээ нь 15 жилээр хийгдэнэ, дахин нэг удаа 15 жилээр сунгах боломжтой • Малын толгойн татварын хуулийн дагуу татвараа баг, эсвэл сумын төсөвт төлнө • Дараах ажлыг урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр хэрэгжүүлэхийг хориглоно: Малын байр, хашаа барих, зам тавих, хөрс бохирдуулах эвдэх, эмийн ургамал тариалах, худаг гаргах, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас отроор ирэгсдийг дамжин өнгөрөөхгүй байх гм. <p>Уул, уурхайгаас шалтгаалан малчдыг нүүлгэн шилжүүлэх тохиолдолд хариуцагч этгээд нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө гаргана</p>
53	<p>БАХ-ийн эрх үүрэг (шинэ зүйл заалт)</p> <ul style="list-style-type: none"> • Хуулийн дагуу бэлчээр ашиглах, гэрээ хийх, гомдол гаргах, маргаан шийдүүлэх, бэлчээрийн хохирол нэхэмжлэх эрхтэй • БАХ-ийн гишүүнээр элсэх, гарах эрхтэй • Бэлчээр ашиглах гэрээг даган мөрдөх үүрэгтэй. Бэлчээрийн даацад тохирсон тооны мал адгуулах үүрэгтэй. Улиралын хувиарт бэлчээрийн болон отрын нөөц нутгийн менежментийг даган мөрдөх, өвөл, хаврын бэлчээрээ зун, намарт нь амрааж, нөхөн сэргэх боломж олгох үүрэгтэй. • Бэлчээрийг мэрэгч амьтдаас хамгаалах, отрын нөөц бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, байгалийн тогтцоор бий болсон гол, горхи, нуур, цөөрөм, хужир, мараа, уст цэг бүхий бэлчээрийн газрыг ашиглах бусдын хууль ёсны сонирхолыг хүндлэх, бэлчээр талхалсан бол нөхөн төлбөр төлөх, бэлчээр, ус, хөрсийг доройтуулах бохирдуулахаас сэргийлэх, дурсгалт газар, зэрлэг ан амьтдыг хамгаалах үүрэгтэй.

Эх сурвалж: МБАНХ

Бэлчээрийн менежмент ба бэлчээрийн мал аж ахуйн нүүдлийн талаар хийсэн ярилцлагын үр дүн

<p><i>Төв аймаг, Өндөр Ширээт сум</i></p> <p>(Хоршооны дарга) Тус суманд 2007 онд байгуулагдсан 8 БАХ байдаг ба нэг багт 2-4 БАХ байдаг. БАХ бүр ахлагчтай бөгөөд сумын хэмжээний 8 ахлагч нийлээд сумын түвшний удирдах зөвлөлийг бүрдүүлдэг. Тус сумын малчин өрхүүд бүгд БАХ-ийн гишүүн бөгөөд нийтдээ 400 орчим өрх байна. БАХ-үүд маркетингийн үйл ажиллагаа явуулах боломжгүй байсан тул 2009 онд давхар гишүүнчлэлтэй хоршоо байгуулсан. Хоршоо нь нэг удирдах зөвлөлтэй ч малчин өрхийн 70 орчим хувь нь л хоршоонд элссэн байна. Бүх БАХ-д зориулсан Бэлчээрийн ашиглалтын гэрээ (БАГ) байдаг бөгөөд эдгээр нь 11-15 жилийн хүчинтэй. БАГ-д малын бэлчээр, нүүдэл, шилжилт хөдөлгөөний зохицуулалт, хязгаарлалтыг нарийвчилан заасан таван хавсралттай. Малчин өрх бүрийн эхнэр, нөхөр гарын үсэг зурах ёстой. Нэг БАХ-д Бэлчээрийн нүүрстөрөгчийг шингээлтийг нэмэгдүүлэх УАНС-ийн санхүүжилттэй төсөл хэрэгжиж байна. (Малчин) Малчид жилд 4-өөс доошгүй удаа, зарим тохиолдолд 5 удаа нүүдэллэдэг. 7-р сард бидний ярилцсан айл өвөлжөөнөөсөө 10 км-ийн зайд амьдарч байв.</p>
<p><i>Хэнтий аймаг, Биндэр сум</i></p>

(Сумын ЗДТГ) Сумын засаг захиргаа дөрвөн улирлын хувиарт бэлчээр сэлгэх, амраах, нүүх хэлбэрийг (хавар, намрын улиралд нэг бэлчээр ашиглах) хэвээр байлгахыг хичээж байгаа боловч иргэд хоёр улирлын системд шилжих хандлагатай байна. Малын тоо толгойг бэлчээрийн даацаас хэтэрсэн гэж сумын удирдлагууд үзэж, энэ нь бэлчээрийн доройтолд хүргэж байна гэж харж байна. Нэг багийн даац хэтэрсэн, дөрвөн багийн даац их байна. Бэлчээрийн тухай хууль мөрдөгдөөгүй, тоо толгойг цөөрүүлэх төлөвлөгөө байхгүй байна. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг жил бүр малчдын саналд үндэслэн сумын ЗДТГ-аас шинэчлэн боловсруулж, сумын ИТ хурлаар баталдаг. ЕХ-ны ИМПАКТ төслөөр байгуулагдсан Бэлчээр ашиглах хэсэг (БАХ) нь бэлчээрийн менежментийг хариуцдаг бөгөөд БАХ-ын бүх гишүүд хоршооны гишүүн болоогүй байна. Хүмүүс бэлчээрийн менежментийн зөвлөмжийг дагаж чадахгүй байна.

Баянхонгор аймаг, Шинэжинст сум

(Сумын ЗДТГ) Ногоон алт төслийн хүрээнд 19 БАХ байгуулагдсан. Сумаас баталсан журмаар 6-р сарын 1 гэхэд айл бүр өвөлжөөнөөсөө гарах ёстой. (Хоршооны дарга) Сумын 3 БАХ-ын бүх малчид, өөр 3 БАХ-н зарим малчид нийлээд хоршоонд нэгдсэн бөгөөд 89 гишүүнтэй. (Малчин) 2017 онд бэлчээр ашиглах гэрээ хийсэн. Хэвийн жилүүдэд малчид гэрээгээ дагаж мөрддөг. Жирийн жилд энэ малчин таван удаа, хүнд хэцүү жилд арав гаруй удаа нүүдэллэдэг.

Архангай аймаг Өлзийт сум

(Сумын ЗДТГ) Малчдыг НҮБХХ-ийн ENSURE төслөөс 4 малчин өрхөөс бүрдсэн 28 Малчны Бүлэг (МБ) болгон зохион байгуулсан. Бүх малчин өрх бэлчээр ашиглах гэрээтэй. Бэлчээрийн даацыг зохицуулахад хүндрэлтэй, ихэнх малчид нүүдэллэдэггүй ч төслөөс бүлгийн ахлагч нартай хамтран малын тоо толгойг бууруулах чиглэлээр ажиллаж байна. Өрхүүд малынхаа тоо толгойг жилд 5%-иар бууруулж, 2-3 дахин нүүдэллэх ёстой гэж ОБГ-аас заажээ. (Малчин, БАХ-ийн ахлагч) Тэрээр малчдын бүлгэгдийг нэгдэж БАХ болох нь зүйтэй гэж үздэг. Хариуцлагатай нүүдэлчдийн стандартыг мөрдүүлэхийн тулд 42 өрх албан бусаар БАХ байгуулаад байна. Энэ жилээс эхлэн өвөлжөөний бэлчээрийг амраах гэж байгаа бөгөөд долоодугаар сар гэхэд нийт өрхийн 25 хувь нь нүүгээгүй байна. Малчид голоос малаа услах шаардлагатай байдаг тул зун, хаврын бэлчээрийг амраахад хүндрэлтэй байдаг. Тэр өвөлжөөний бэлчээрийг зуны улиралд ашиглахгүй байгаад сайтар хяналт тавьдаг.

Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сум

(Сумын ЗДТГ) Малын тоо толгой даацаас хэтэрснээс үүдэн бэлчээрийн асуудалтай тулгардаг. Сумын захиргаа бэлчээрийн төлөв байдалд хяналт тавьдаг. Анх дөрвөн улирлын бэлчээр сэлгэх горимтой байсан бол одоо хоёр баг гурван улирал, хоёр баг хоёр улиралаар сэлгэж байна. Таван багт есөн БАХ байдгаас дөрөв нь сайн ажиллаж байна. БАХ-ийн үйл ажиллагаа манлайлалаас хамаардаг. Хир ажиллаж байгаа нь угсаатны бүлэгтэй холбоотой байж болох ч БАХ бүр нь холимог ястан, угсаатантай байна.

Хоёр БАХ-д бэлчээр ашиглах гэрээ байгаа бөгөөд энэ нь малчид болон сумын засаг захиргаа хооронд тогтоосон хугацаанд нүүгээгүй хүмүүст оногдуулах шийтгэлийг тодорхойлсон зохицуулалт юм. Яг хуулийн зохицуулалт байхгүй учраас сумын удирдлага бусад бүлгүүдийг яаж ч чаддаггүй. БАХ нь бэлчээрийн менежментээс илүү сарлагийн түүхий эдийн зах зээл дээр төвлөрч ажиллаж байна.

Сумын хэмжээнд албан ёсоор цаасаар гарсан журам бий. Жишээлбэл, 6-р сарын 15-наас өмнө зусландаа нүүс ёстой ч хэн ч үүнийг дагадаггүй. Мөн өвлийн цагт аймгаас малтай хүмүүс ирж өвөлждөг, үүнийг сайн ойлгодоггүй. Учир нь энэ отрын нутаг биш.

Төв аймаг, Баянхангай сум

(Малчидтай бүлгийн ярилцлага) Тэд 2008 оноос БАХ-тай байсан ч өнгөрсөн өвлөөс эхлэн ойр орчмын Тусгай хамгаалалттай цогцолбор газраас санхүүжүүлэн, зах зээлд мах нийлүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах хоршоо байгуулан ажиллаж байгаа. Бэлчээрийн менежмент нь сумын бодлогод нийцэж байгаа. Ер нь 5-р сарын 15-ны өдөр бэлчээлээ чөлөөлж зусландаа нүүх өдөр бөгөөд сумын ИТХ-

аас өөрчлөлт оруулж болно. Багийн хурлаар бэлчээрийн асуудлыг хэлэлцэн эцсийн шийдийг сумын ИТХ-аар баталдаг.

Эх сурвалж: Судлаачдын ярилцлагын тэмдэглэл

Ортын бүсийн малчидтай хийсэн ярилцлагын үр дүн

<i>Хэнтий аймаг, Биндэр сум</i>
(Сумын ЗДТГ) Сумын иргэдэд зориулсан отрын гурван газар байдаг. Нэг нь ОХУ-ын хилтэй маш ойрхон,
<i>Баянхонгор аймаг, Шинэжинст сум</i>
(Сумын ЗДТГ) Заримдаа малчид “богино отроор” явах хэрэгтэй болдог. 2020 онд тэд Хэнтий хүртэл (1000 км орчим) нүүсэн. Ойролцоох дархан цаазат газрыг аймгийн Засаг даргын захирамжаар дөрөвдүгээр сарын 1-нийг хүртэл нээх боломжтой. (Малчин) Ган зудын цагт “хил хязгаарыг тооцохгүй”. Энэ хэсэгт цас бага ордог ч зун гантай үед 2 см цас орвол бэлчээрийн хомсдол үүсдэг. 2020 онд Баянхонгорын өөр суманд 250 км-т очсон. Ийм тохиолдолд эхлээд бэлчээрийг шинжиж, сумын Засаг дарга, нутгийн малчдаас зөвшөөрөл авахаар очдог - энэ нь долоо, найм хоног болдог. Зарим жил бусад аймгаас хүмүүс ирдэг.
<i>Архангай аймаг, Өлзийт сум</i>
(Малчин) Мал ихтэй учир отрын нөөцгүй. 2016 онд тус аймгийн өөр сумын тусгай хамгаалалттай газарт очсон.
<i>Хөвсгөл аймаг, Алаг Эрдэнэ сум</i>
(Малчин) Одоо бол отрын бүс байхгүй, отрын бэлчээртэй болмоор байна, тэгэхгүй бол зөвхөн хадлан өвс худалдаж л авна.

Эх сурвалж: Судлаачдын ярилцлагын тэмдэглэл

Ховд аймгийн Мөст сумын Бүтээмжийн жөндөрийн баг

Үйл ажиллагаа ба жөндөр	Үйл ажиллагаа
Дан эсвэл ихэвчлэн эрчүүд хийдэг ажил	Тэмээ ноослох, тэмээний ноос худалдах, мал (амьд мал), мах худалдах, тэжээл тариалах, малын тэжээл бэлтгэх, хадлан бэлтгэх, гар урлалын үйлдвэрлэл, тэмээ (морь, хонь, ямаа, үхэр, сарлаг) бэлчээрлүүлэх, мал услах, бэлчээр усжуулах, отор нүүдэл хийх, төөрсөн/хулгайлсан мал хайх, уналга болон ахуйн зориулалтаар мал сургах ашиглах
Эмэгтэйчүүдийн оролцоотойгоор гүйцэтгэдэг эрчүүдийн ажил	Малын хашаа хороог засварлах, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, сарлаг, ямаа самнах, ямааны арьс, хонины ноос, арьс шир худалдах, эмийн ургамал түүж худалдах, мал угаах (паразит туулга хийх), мал тэжээх
Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд адил хөдөлмөр, цаг зарцуулдаг ажил	Гэрээ засаж янзлах, барих/өвөлжилтийн бэлтгэл, адуу саах, хонь хусах, сүү цагаан идээ худалдах, ноос ноолуур худалдах, мал төллүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ (голчлон хорхой/шимэгч хорхойн тарилга туулга), малын тамгалах, мал нядлах, малын сэг зэм цэвэрлэх, малыг хөнгөлөх, улирлын чанартай өрхийн нүүдэл (боож баглах, нүүлгэх, буурь сэлгэх)
Эрчүүдийн тусламжтайгаар голдуу эмэгтэйчүүд хийдэг ажил	Үнээ, сарлаг, ямаа, хонь саах, малын хашаа хороо цэвэрлэх
Дан эсвэл ихэвчлэн эмэгтэйчүүд хийдэг ажил	Сүүн бүтээгдэхүүн боловсруулах, төл мал тэжээх

Эх сурвалж: Волтолини нар 2015,

Орон нутгийн олон нийтийн байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцоо ямар байдаг тухай ярилцлагын үр дүн

<i>Төв аймаг, Өндөрширээт сум</i>
Борлуулалтын хоршоо, ТББ, ХЗХ-ны бүх ажилтнууд эмэгтэйчүүд байдаг. Удирдах зөвлөл анхандаа эрэгтэй хүмүүс байсан бол одоо зургаан эмэгтэй, хоёр эрэгтэй болжээ. Эрэгтэйчүүд олон нийтийн ажил гэхээсээ илүү морь уралдуулахыг илүүд үздэг гэж эмэгтэйчүүд ярив.
<i>Хэнтий аймаг, Биндэр сум</i>
Хоршооны 32 гишүүний 50 хувь нь эмэгтэйчүүд, Удирдах зөвлөл нь хоёр эмэгтэй, хоёр эрэгтэй, санхүүгийн хяналтын хэсэг нь нэг эмэгтэй, хоёр эрэгтэй байна.
<i>Баянхонгор аймаг, Шинэжинст сум</i>
Удирдах хороонд хоёр эмэгтэй, гурван эрэгтэй, санхүүгийн хяналтын хэсэгт нэг эмэгтэй, хоёр эрэгтэй ажиллаж байна.
<i>Архангай аймаг, Өлзийт сум</i>
Хоршооны Удирдах хорооны есөн гишүүн бүгд эрэгтэй. Энэ хоршоо нь Удирдах хорооны гишүүдтэй, хувьцаа эзэмшигчидтэй хувийн компанитай төстэй байсан.

Хавсралт 5 – Байгаль орчны шинжилгээнд ашигласан боловсруулалтын үе шатны анхдагч өгөгдөл

Боловсруулалтын янз бүрийн үе шатны ус, эрчим хүчний хэрэглээ (боловсруулахад ашиглах нийт хэрэглээний%) болон үе шат бүрт усны алдагдал (гол төлөв ууршилтаар) (ус ашиглалтын%)

Боловсруулах үе шатууд	Ус ашиглалтын хувь(%)	Усны алдагдал (%)	Эрчим хүчний хэрэглээ(%)
Угаах	33	25	12
Үс ялгах	0	0	4
Будах	37	25	48
Ээрэх	11	25	16
Сүлжих	11	25	13
Эсгэх, Оёх	8	1	7

Угаах үйл явцад ашигласан үндсэн параметрууд ба өгөгдөл

Дата мэдээлэл	Параметр	Нэгж	Үнэ	Эх сурвалж
Тоног төхөөрөмж	Нүүрсээр ажилладаг ДЦС	нэгж	.a	Өөр өөр эх сурвалж
	Аж үйлдвэрийн бүс	м2	1,343	Ажиглалт
Техносферийн орцууд	Түүхий ноолуур	тонн	9,672	Үндэсний статистикийн газар
	Тээвэрлэлт	км/ц	7,050,888	Өөрийн тооцоолол
	Цэнгэг ус	м3	.a	StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
	Нүүрс	кг	.a	StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
	Цахилгаан	Кватт	.a	StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
	Саван	литер	9,672	Ярилцлага
Техносферийн гаралт	Угаасан ноолуур	тонн	8,085	
	Шороо	тонн	1,209	
Emissions to water	Нийт	кг	447	MNS 6561:2015
	Тосны хүчил	кг	11,171	MNS 6561:2015
Emissions to air	Ууршилт	м3	.a	Simapro®-ийн өгөгдмөл утгууд
Waste	Усны хаягдал	м3	.a	Simapro®-ийн өгөгдмөл утгууд

a Нууцын зэрэглэлтэй дата

b (i) ноос, ноолуур боловсруулагч үйлдвэрүүдийн тоо (n=78), (ii) 2/3 төвлөрсөн эрчим хүчнээс авсан цахилгаан, эрчим хүчний хэрэглээ (эх сурвалж: ярилцлага); (iii) угаахад зарцуулсан эрчим хүчний харьцаа (StepEcoLab төсөл)

c GIS дата дээр үндэслэн (аймгуудын төвөөс УБ хүрэх зай), ҮСХ-оос авсан дата (аймаг бүрийн ноолуур бэлтгэлийн хэмжээ)

d угаахад зарцуулсан эрчим хүчний харьцаа (StepEcoLab төсөл)

e нэг тонн түүхий ноолуур тутамд 1 литр саван,

f 25% ууршилтаар алдсан усны алдагдал, төвийн нэгдсэн шугаманд холбогдсон үйлдвэрүүд

Үс хялгас ялгах үйл явцад ашигласан үндсэн параметрууд ба өгөгдөл

Дата мэдээлэл	Параметр	Нэгж	Үнэ	Эх сурвалж
Тоног төхөөрөмж	Нүүрсээр ажилладаг ДЦС	нэгж		.a Өөр өөр эх сурвалж
	Аж үйлдвэрийн бүс	м ²	115	Ажиглалт
Техносферийн орцууд	Угаасан ноолуур	Тонн	1,658	
	Нүүрс	Кг		StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
	Цахилгаан	Кватт		StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
	Уут	Кг	24,870	StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
Техносферийн гарц	Ялгасан нарийн ноолуур	Тонн	1,244	Ярилцлага ^d
	Бүдүүн ширхэгт	Тонн	415	Ярилцлага ^d

^a Нууцын зэрэглэлтэй дата

^b (i) ноос, ноолуур боловсруулагч үйлдвэрүүдийн тоо (n=78), (ii) 2/3 төвлөрсөн эрчим хүчнээс авсан цахилгаан, эрчим хүчний хэрэглээ (эх сурвалж: ярилцлага); (iii) ялгахад зарцуулсан эрчим хүчний харьцаа (StepEcoLab төсөл)

^c Дундажаар 50 кг ноолуур багтдаг уутны өөрийн жин 1 кг

^d Нэг кг ноолуур боловсруулахад 75% нь цэвэр нарийн ноолуур, 25% нь бүдүүн ширхэгт, ; 5% хорогдол

Будах үйл явцад ашигласан үндсэн параметрууд ба өгөгдөл

Дата мэдээлэл	Параметр	Нэгж	Үнэ	Эх сурвалж
Тоног төхөөрөмж	Үйлдвэрийн орчим	м ²	6,76	Ecoinvent 3 database ^a
Техносферийн орцууд	Ээрсэн ноолуур		417	
	Цэвэр ус	м ³		StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
	Эрчим хүч	Кватт		.b
	Химийн бодис	Литр	413,000	StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
Техносферийн гарц	Нэхсэн ноолуур	тонн	413	Interviews ^d
Усанд ялгарч буй бодис	Нитроген			.b MNS 6561:2015
	Сульфат			.b MNS 6561:2015
	Зэс			.b MNS 6561:2015
	Цайр			.b MNS 6561:2015
	Фосфор			.b MNS 6561:2015
Агаарт ялгарч буй бодис	Ууршилт	м ³		Simapro®-ийн өгөгдмөл утгууд
Хог хаягдал	Хаягдал ус	м ³		Simapro®-ийн өгөгдмөл утгууд

^a Түүхий ноос ноолуур цйаруулах, будах процесст үндэслэсэн дата

^b Нууцын зэрэглэлтэй мэдээлэл

^c Нэг кг хувцсанд 1 кг будаг (Lanaset and Lanazol)

^d 1% хорогдол

^e 25% ууршилтаар алдсан усны алдагдал, төвийн нэгдсэн шугаманд холбогдсон үйлдвэрүүд

Ээрэх үйл явцад ашигласан үндсэн параметрууд ба өгөгдөл

Дата мэдээлэл	Параметр	Нэгж Үнэ	Эх сурвалж
Тоног төхөөрөмж	Нүүрсээр ажилладаг ДЦС Аж үйлдвэрийн бүс	Нэгж м ²	-a Өөр өөр эх сурвалж 6,57 Ecoinvent 3 мэдээллийн сан с
Техносферийн орцууд	Ялгасан ноолуур Тээвэр	кМТ	444 2,220 ярилцлага ^d
	Цэвэр ус	м ²	-a StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
	Нүүрс	кг	-a StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
Техносферийн гарц	Цахилгаан эрчим хүч	кВт	-a StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
	Ээрсэн ноолуур	тонн	422 Ярилцлага ^f
Агаарт ялгарч буй бодис	Ууршилт	м ³	-a Simapro®-ийн өгөгдмөл утгууд
Хог хаягдал	Хаягдал ус	м ³	-a Simapro®-ийн өгөгдмөл утгууд

a Нууцын зэрэглэлтэй дата

b (i) ноос, ноолуур боловсруулагч үйлдвэрүүдийн тоо (n=78), (ii) 2/3 төвлөрсөн эрчим хүчнээс авсан цахилгаан,эрчим хүчний хэрэглээ (эх сурвалж: ярилцлага); (iii) ээрэхэд зарцуулсан эрчим хүчний харьцаа (StepEcoLab төсөл)

c Хөвөн даавуу ээрэх,нэхэх процесст үндэслэв

d 10 тонн ачааны машин 50 км явах

e ээрэхэд зарцуулсан эрчим хүчний харьцаа (StepEcoLab төсөл)

f 5% хорогдол

g 25% ууршилтаар алдсан усны алдагдал, төвийн нэгдсэн шугаманд холбогдсон үйлдвэрүүд

Сүлжих үйл явцад ашигласан үндсэн параметрууд ба өгөгдөл.

Дата мэдээлэл	Параметр	Нэгж Үнэ	Эх сурвалж
Тоног төхөөрөмж	Үйлдвэрийн орчим	м ²	16 Ecoinvent 3 мэдээллийн сан a
	Ээрсэн ноолуур		422
Техносферийн орцууд	Цэвэр ус	м ³	-b StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
Техносферийн гарц	Цахилгаан эрчим хүч	кватт	-b StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
	Knitted cashmere	тонн	417 Ярилцлага ^c

Агаарт ялгарч буй бодис	Ууршилт	м3	Simapro®-ийн -b өгөгдмөл утгууд
Хог хаягдал	Хаягдал ус	м3	Simapro®-ийн -b өгөгдмөл утгууд

^a Хөвөн нэхмэл сүлжих процесст үндэслэв

^b Нууцын зэрэглэлтэй мэдээлэл

^c 1% хорогдол

^d 25% ууршилтаар алдсан усны алдагдал, төвийн нэгдсэн шугаманд холбогдсон үйлдвэрүүд

Эсгэх, оёх үйл явцад ашигласан үндсэн параметрууд ба өгөгдөл.

Дата мэдээлэл	Параметр	Нэгж	Үнэ	Эх сурвалж
Тоног төхөөрөмж	Үйлдвэрийн орчим	м ²		28 Ажиглалт
Техносфери йн орцууд	Будсан ноолуур Тээвэр	тонн км.т		413 826 Ярилцлага ^a
	Цэвэр ус	м ³		.b StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
Техносфери йн гарц	Цахилгаан эрчим хүч	кватт		.b StepEcoLab төслөөс тооцоолсон мэдээлэл
Техносфери йн орцууд	Бэлэн хувцас эдлэл	тонн		413
Агаарт ялгарч буй бодис	Ууршилт	м ³		.b Simapro®-ийн өгөгдмөл утгууд
Хог хаягдал	Хаягдал ус	м ³		.b Simapro®-ийн өгөгдмөл утгууд

^a 10 тоннын ачааны машин 50 км явах

^b Нууцын зэрэглэлтэй мэдээлэл

^c 10% ууршилтаар алдсан усны алдагдал, төвийн нэгдсэн шугаманд холбогдсон үйлдвэрүүд